АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Шударга ёс, хөгжил дэвшилд

СУДАЛГААНЫ ТАЙЛАН ЭМХЭТГЭЛ

2012-2015 он

II БОТЬ

ННА 72
ДАА 001.4
Т-594

Хянасан:

Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасанням

Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албаны дарга, ахлах комиссар Ц.Шинэбаяр

Боловсруулсан:

Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албаны ажилтан, комиссар Ц.Бадам

Цаасны хэмжээ: А4
Хэвлэсэн тоо: 300

“УРАНГАР ПРЕСС” ХХК-д хэвлэв.

ISBN 978-9919-22-715-9

ӨМНӨХ ҮГ

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан судалгааны тайлангуудыг эмхэтгэн Та бүхэнд толилуулж байна.

Тус газар нь 2007 онд байгуулагдсан цагаасаа эхлэн авлигын шалтгаан нөхцөл, цар хүрээ, үр дагавар, хэлбэр болон эдгээртэй холбоотой олон тооны үзүүлэлтийг тооцоолох, хэмжих зорилготой судалгааны ажлыг жил бүр зохион байгуулж ирсэн. Эдгээр судалгааны ажлын зорилго нь авлигын нөхцөл байдлыг тодорхойлж, хэмжсэний үндсэн дээр авлигатай тэмцэх бодлогыг боловсруулахад ашиглах, авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох явдал юм.

Энэхүү эмхэтгэл нь тус газраас зохион байгуулсан давтамжит судалгааны үр дүнгийн тайлангуудаас бүрдэж байгаа бөгөөд эдгээрийг гурван боть болгон эмхэтгэлээ. Тухайлбал 2008 оноос 2018 онд зохион байгуулсан Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгаа, 2009, 2011, 2013 онуудад зохион байгуулсан Авлигын индексийн судалгаа, 2010, 2012, 2014 онуудад зохион байгуулсан Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ, 2015, 2016, 2018 онд зохион байгуулсан Шударга байдлын үнэлгээ, 2010 оноос 2019 онд зохион байгуулсан Хүүхдийн шударга байдлын судалгаа, 2018 онд зохион байгуулсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт хандлагыг тодорхойлох судалгаа зэрэг судалгааны тайлангуудыг эмхэтгэлд багтаан нийтийн хүртээл болгож байна.

Бид судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулахдаа олон улсын аргачлал, арга зүй, туршлагыг судлан үзэж, мөн манай улсад энэ чиглэлээр хийгдсэн судалгаа, бусад холбогдох мэдээлэлд дүн шинжилгээ хийж, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагууд, эрдэмтэн судлаачидтай хамтран ажилладаг. Өөрөөр хэлбэл судалгаа шинжилгээний ажлыг Авлигатай тэмцэх газар дангаараа бус харин олон тооны байгууллага, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор гүйцэтгэдэг юм.

Судалгааны ажлын үр дүнгийн тайлангууд нь өргөн хүрээтэй, чухал ач холбогдолтой олон тооны мэдээ, мэдээлэл агуулсан бөгөөд бодлого боловсруулагчид, төрийн байгууллагын албан хаагчид, олон улсын байгууллагын ажилтнуудад авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөр үйл ажиллагааг боловсруулах, төлөвлөх, үнэлж дүгнэхэд шаардлагатай мэдээллийг хүргэх, эрдэмтэд, судлаачдад судалгаа, мэдээллийн эх сурвалж болгох зорилгоор эмхэтгэлийг боловсруулаа.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас Монгол Улс дахь авлигатай тэмцэх үйл ажиллагааг үнэлсэн үнэлгээний 2019 оны тайланд судалгааны чиглэлээр хийгдэж байгаа ул суурьтай, хэвшиж тогтсон үйл ажиллагааг сайшаахын зэрэгцээ судалгааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд өнгөрсөн хугацаанд бий болсон их хэмжээний судалгааны мэдээллийг бүрэн хэмжээгээр ашиглах, судалгаагаар тогтоогдсон илэрхий дүгнэлт, нотолгоонд дүн шинжилгээ

хийж, стратегийн төлөвлөлт болон үнэлгээний үйл ажиллагаанд хамтатган ашиглахыг уриалсан байдаг. Энэхүү зөвлөмж нь бидний санаа бодолтой бүрэн дүүрэн нийцэж байгааг илэрхийлэх нь зүйтэй.

Тус газраас зохион байгуулсан давтамжит судалгааны ажлыг анх удаагаа эмхэтгэн хүргэж байгаа юм. Иймд энэхүү эмхэтгэлийг та бүхэн өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглахын зэрэгцээ бидэнд хандан санал, зөвлөмжөө ирүүлбэл хүлээн авч хамтран ажиллахад бэлэн байна.

Судалгааны ажлуудыг зохион байгуулахад хамтран ажиллаж үнэтэй санал, дэмжлэг, туслалцаа үзүүлсэн эрдэмтэн судлаачид, төрийн болон төрийн бус байгууллага, судалгааны мэргэжлийн байгууллагууд, судалгаанд хамтран оролцож байсан бүх хүмүүст талархлаа илэрхийлье.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР З.ДАШДАВАА

ГАРЧИГ

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ 2012 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН 7-52

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ 2012 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН 53-70

УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН 2012 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН 71-100

МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ИНДЕКСИЙН 2013 ОНЫ СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН 101-108

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ 2013 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН 109-130

УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН 2013 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН 131-164

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ 2014 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН 165-212

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ 2014 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН 213-232

УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН 2014 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН 233-262

ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ-2015 263-332

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ 2015 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН 333-354

УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН 2015 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН 355-378

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ 2012 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ 2012 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Авлигатай тэмцэх газар авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.7.17- д заасны дагуу “Төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд хоёр жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийг хэрэгжүүлж төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний судалгааг хоёр дахь удаагаа амжилттай зохион байгуулж явууллаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж тодорхойлсны дагуу төрийн байгууллага, албан хаагч төрийн чиг үүргийг олон нийтэд хүргэхдээ шударга, хуулийн хүрээнд, ил тод, нээлттэй, тэгш байдлыг ханган ажиллах ёстой бөгөөд шударга байдлын түвшинг үнэлж, дүгнэн, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах нь төрийн байгууллагын хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж буй нэг хэлбэр болох юм.

Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ нь үйлчлүүлэгчдийн төрийн байгууллагын шударга байдлын талаарх үнэлгээний цаг, хугацаа, орон зайн өөрчлөлтийг харуулах үзүүлэлт болохын хувьд энэ удаагийн судалгааны тайланг тухайн байгууллагууд үйл ажиллагаандаа ашиглах, түүний ил тод, тунгалаг байдлыг хангах боломжийг бүрдүүлэх, цаашид төрийн үйлчилгээг хүргэж буй төрийн байгууллагын шударга, ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

Иймд төрийн үйлчилгээг иргэд, үйлчлүүлэгчид хүргэдэг эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр, халамжийн зэрэг 10 салбар байгууллагын шударга байдлын түвшинг үнэлж дүгнэсэн нь онцгой ач холбогдолтой үйл ажиллагаа юм. Төрийн үйлчилгээний дээрх салбаруудын шударга байдлын түвшний үнэлгээ 2012 оны байдлаар дунджаар 3.38 (1-5 хүртэлх үнэлгээгээр) буюу 2010 оны судалгааны үр дүнгээс 0.61 пунктээр өссөн байна. Энэ нь сүүлийн хоёр жилд төрийн байгууллагын шударга байдлын түвшин дээшилснийг илэрхийлж байгаа үзүүлэлт юм. Гэвч төрийн байгууллагын шударга байдлын түвшин нь салбар бүрийн хувьд харилцан адилгүй байгаа нь төрийн байгууллагууд үзүүлэлтээрээ тэргүүлэгч байгууллагуудын эгнээнд орохын төлөө өрсөлдөн өөрсдийн шударга байдлын түвшинг нэмэгдүүлэн ажиллах шаардлагатайг харуулж байна.

ДАРГА, ТЭРГҮҮН КОМИССАР **Н.ГАНБОЛД**

БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 Судалгааны зорилго, ач холбогдол

Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” нь Авлигатай тэмцэх газрын үндсэн чиг үүргийн нэг юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасны дагуу төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг олон нийтэд хүргэхдээ шударга, хуулийн хүрээнд, ил тод, нээлттэй, тэгш байдлыг хангаж ажиллах ёстой.

“Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх судалгааны аргачлал”-ыг Авлигатай тэмцэх газрын даргын 2010 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 59 дүгээр тушаалаар батлуулан 2010 онд анхны судалгааг явуулж байсан бол энэ удаагийн судалгаа нь дээрх аргачлалын дагуу зохион байгуулж байгаа 2 дахь удаагийн судалгаа юм.

Төрийн үйл ажиллагаанд ямар ч нөхцөлд заавал удирдлага болгох нэг үндсэн зарчим бол Үндсэн хуульд тунхагласан шударга ёсны зарчим юм. Хэдийгээр шударга ёс нь өргөн утгаараа ёс суртахуун, улс төр, эрх зүйн шинжтэй асуудал мөн боловч арга зүйн хүрээнд буюу төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх шалгуур хэмжүүрийн анхдагч буюу суурь ухагдахуун нь Үндсэн хуулийн дээрх зарчим байх ёстой. Иймээс төрийн байгууллагын шударга байдлын тухай ойлголтыг юуны өмнө Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд авч үзэх нь арга зүйн хувьд зүйтэй юм.

Энэхүү судалгааны зорилго нь хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу төрийн үйлчилгээ үзүүлж буй тухайн төрийн байгууллагын хувьд иргэдэд үзүүлж буй үйлчилгээний шударга байдлын түвшин, түүний дотор ил тод байдал болон хариуцлагатай байдлын түвшинг төрийн үйлчилгээний салбарын түвшинд харьцуулан судалж, олон нийтэд мэдээлэх явдал юм.

Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх нь нэг талаас Авлигатай тэмцэх газар хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, нөгөө талаас төрийн албаны ард түмэнд шударгаар үйлчлэх зарчим хэрхэн хангагдаж байгаад төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгааны үр дүнгээр үнэлгээ өгөх, цаашид төрийн үйлчилгээг хүргэж буй төрийн байгууллагуудын шударга байдал, түүний дотор ил тод байдал болон хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд олон нийтийн оролцоог дээшлүүлэх зэрэг ач холбогдолтой.

1.2 Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлсэн арга зүй

Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ нь дараах үзүүлэлт, дэд үзүүлэлтээс бүрдэж байгаа болно (Зураг 1).

Зураг 1. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний үзүүлэлт, дэд үзүүлэлтүүд

Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ (I)

Үзүүлэлт: Ил тод байдлын үзүүлэлт (Т)

Дэд үзүүлэлт:
1. Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн энгийн ойлгомжтой байдал (T_1)
2. Төрийн байгууллага, албан хаагчид иргэд, үйлчлүүлэгчдэд алагчлалгүй хандаж буй байдал (T_2)
3. Төрийн байгууллага, албан хаагчдын нийтийн эрх ашгийг эрхэмлэх байдал (T_3)
4. Иргэдийн санал, хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (T_4)
5. Төрийн үйлчилгээг хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиодог байдал (T_5)
6. Төсөв, санхүүгийн холбогдолтой мэдээллийн ил тод, нээлттэй байдал (T_6)
7. Үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (T_7)

Үзүүлэлт: Хариуцлагатай байдлын үзүүлэлт (А)

Дэд үзүүлэлт:
1. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (A_1)
2. Албан хаагчдын мэдлэг чадвар, асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэж буй байдал (A_2)
3. Албан хаагчдын ёс зүй (A_3)
4. Албан хаагчдын харилцааны соёл (A_4)
5. Хариуцлага тооцох тогтолцооны хэрэгжилт (A_5)
6. Байгууллагын удирдлагын хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж буй байдал (A_6)

Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх судалгааны хүрээний мэдээллийн эх үүсвэр нь “Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2012 оны судалгаа”-ны үр дүн бөгөөд төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэхдээ юуны өмнө төрийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдээр тухайн төрийн байгууллагаас иргэдэд төрийн үйлчилгээг шударгаар үзүүлэхэд дээр дурдсан дэд үзүүлэлт тус бүрээр ач холбогдлын түвшин, тухайн байгууллагаас үйлчилгээ авахад дээрх дэд үзүүлэлтийн үнэлгээгээр ямар түвшинд байсныг үнэлүүлсэн. Үүний дараа дэд үзүүлэлт тус бүрийн үнэлгээ (Т1-7 болон А1-6)-г тухайн дэд үзүүлэлтийн ач холбогдлын түвшний хувийн жингээр үнэлэн үзүүлэлт тус бүрийн үнэлгээ (Т болон А)-г ; дэд үзүүлэлт (Т болон А) тус бүрийн үнэлгээг тухайн үзүүлэлтийн ач холбогдлын түвшний хувийн жингээр үнэлэн төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ (I)-г тооцлоо.

Аргачлалын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл АТГ-ын www.iaac.mn вэб хуудаснаас үзнэ үү.

1.3 Төрийн үйлчилгээ авсан иргэдийн судалгааны түүвэрлэлт

Төрийн үйлчилгээ авсан иргэдийн судалгааны түүвэрлэлтийг дараах гурван түвшинд хийв. Үүнд:

Түүвэрлэлтийн эхний шатанд: Төрийн үйлчилгээний төрөл буюу салбарыг тодорхойлж, Монгол Улсын иргэний анхдагч үндсэн эрх, эрх чөлөөг хангахын тулд төрөөс үзүүлж буй дараах төрлийн төрийн үйлчилгээг хамруулав. Нөгөө талаар эдгээр төрийн үйлчилгээ нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрт төлөөлөлтэй байх, үйлчилгээ нь шууд иргэдэд хүрдэг байх гэсэн шалгуурыг давхар авч үзлээ. Үүнд:

1. Төрийн өмнөөс эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй байгууллага (цаашид "Эрүүл мэндийн байгууллага" гэх),
2. Төрийн өмнөөс боловсролын үйлчилгээ үзүүлж буй байгууллага (цаашид "Боловсролын байгууллага" гэх),
3. Төрийн өмнөөс хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлж буй байгууллага (цаашид "Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллага" гэх),
4. Төрийн өмнөөс нийгмийн даатгалын харилцаатай холбоотой үйлчилгээг үзүүлж буй байгууллага (цаашид "Нийгмийн даатгалын байгууллага" гэх),
5. Төрийн өмнөөс газрын харилцаатай холбоотой үйлчилгээ үзүүлж буй байгууллага (цаашид "Газрын алба" гэх),
6. Татварын харилцаатай холбоотой үйлчилгээ үзүүлж буй байгууллага (цаашид "Татварын алба" гэх),
7. Төрийн өмнөөс улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээ үзүүлж буй байгууллага (цаашид "Улсын бүртгэлийн байгууллага" гэх),
8. Төрийн өмнөөс гаалийн хилээр бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй холбоотой үйлчилгээг үзүүлж буй байгууллага (цаашид "Гаалийн байгууллага" гэх),
9. Төрийн захиргааны хяналт шалгалтын үйлчилгээг үзүүлж буй байгууллага (цаашид "Мэргэжлийн хяналтын байгууллага" гэх),
10. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах үйлчилгээг үзүүлж буй төрийн захиргааны байгууллага (цаашид "Цагдаагийн байгууллага" гэх).

Судалгааны түүвэрлэлтийг хийхийн тулд дээр дурдсан салбаруудаар 2011 онд үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн тоог аймаг, нийслэл болон байгууллагын түвшин тус бүрээр нь гаргуулан авсан бөгөөд салбар тус бүрийн төрийн захиргааны төв байгууллагаас 2011 онд үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн тоог гаргуулан авахад 2011 онд дээрх 10 салбарын төрийн байгууллагуудаар давхардсан тоогоор нийт 26.8 сая иргэд үйлчлүүлсэн байна (Хүснэгт 1).

*Хүснэгт 1. Сонгосон төрийн үйлчилгээний байгууллагуудаар 2011 онд үйлчлүүлсэн иргэдийн тоо, давхардсан тоогоор**

д/д	Салбар	Иргэдийн тоо (мян. хүн)	Дүнд эзлэх хувь
1	Эрүүл мэндийн байгууллага	14 382.9	53.5
2	Боловсролын байгууллага	904.3	3.4
3	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллага	3 583.0	13.3
4	Нийгмийн даатгалын байгууллага	2 716.3	10.1
5	Газрын алба	123.9	0.5

6	Татварын байгууллага	104.6	0.4
7	Улсын бүртгэлийн байгууллага	2 548.3	9.5
8	Гаалийн байгууллага	21.9	0.1
9	Мэргэжлийн хяналтын байгууллага	433.8	1.6
10	Цагдаагийн байгууллага	2 042.9	7.6
	Дүн	**26 861.9**	**100.0**

**-Эх сурвалж: Төрийн байгууллага тус бүрээс авсан мэдээлэл болно.*

Түүвэрлэлтийн хоёрдахь шатанд: Салбар доторх байгууллагыг сонгож, салбарын байгууллагуудыг түвшингээр нь ангилан гаргав. Тухайлбал, Эрүүл мэндийн байгууллагын хувьд төрийн захиргааны төв байгууллага буюу Эрүүл мэндийн яам, агентлаг буюу Эрүүл мэндийн газар, тэдгээрийн салбар нэгж буюу аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, сумын эмнэлэг, өрхийн эмнэлэг, клиникийн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүд гэх мэт. Байгууллагын түүвэрлэлтийг нийслэлийн болон аймгийн гэсэн хоёр түвшинд хийв.

Аймгийн түвшинд байгууллагын түүвэрлэлтийг хийхдээ түүвэрлэлтийн эхний шатанд сонгогдсон салбаруудаар болон аймгаар 2011 онд үйлчлүүлсэн нийт үйлчлүүлэгчдийн тоог гаргаж, үйлчлүүлэгчдийн тоогоор нь таван бүлэгт хуваасан. Үүний нэгдүгээр бүлэг 450 мянга хүртэл тооны үйлчлүүлэгч; хоёрдугаар бүлэг 450-550 мянган үйлчлүүлэгч; гуравдугаар бүлэг 550-650 мянган үйлчлүүлэгч; 650-800 мянган үйлчлүүлэгч; тавдугаар бүлэг 800 мянга ба түүнээс дээш тооны үйлчлүүлэгч үйлчлүүлсэн гэсэн байдлаар бүлэглэн ангилсан. Дээрх байдлаар төрийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоогоор аймгуудыг бүлэглэсний дараа бүлэг тус бүрээс нэг аймгийг санамсаргүй байдлаар сонгосон бөгөөд мөн Авлигын индексийн 2011 оны судалгаагаар доогуур үнэлгээтэй гарсан байдлыг харгалзан “Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2012 оны судалгаа”-нд Дундговь, Завхан, Дорнод, Төв, Дархан-Уул аймгуудыг хамруулсан болно (Хүснэгт 2).

*Хүснэгт 2. Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2012 оны судалгаанд хамрагдсан аймгийн сонголт**

Аймаг	Иргэдийн тоо (мян. хүн)	Бүлэг	Сонголт	Сонгогдсон аймгийн нэр
Булган	396.3	1	0	
Дундговь	313.3	1	1	Дундговь
Говьсүмбэр	416.1	1	0	
Баянхонгор	482.2	2	0	
Говь-Алтай	471.7	2	0	
Завхан	497.2	2	1	Завхан
Өвөрхангай	510.9	2	0	
Сүхбаатар	477.2	2	0	
Увс	508.5	2	0	
Хэнтий	518.7	2	0	
Архангай	567.4	3	0	Дорнод
Дорнод	582.0	3	1	
Дорноговь	633.5	3	0	
Ховд	642.1	3	0	

Баян-Өлгий	689.6	4	0	Төв
Өмнөговь	779.2	4	0	
Сэлэнгэ	787.1	4	0	
Төв	753.6	4	1	
Хөвсгөл	941.1	5	0	Дархан-Уул
Дархан-Уул	1 083.6	5	1	
Орхон	829.9	5	0	

**-Эх сурвалж: Төрийн байгууллага тус бүрээс аймгаар авсан мэдээлэлд үндэслэн тооцов*

Салбаруудын аймаг дахь хэлтэс, газар, албадыг нэлэнхүй байдлаар, аймгийн төвийн бусад нэгжүүдийг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгов. Тухайлбал, Дархан- Уул аймгийн Эрүүл мэндийн байгууллагын хувьд Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газар, аймгийн нэгдсэн эмнэлгийг шууд, аймгийн төвийн өрхийн эмнэлгүүдээс түүвэрлэх байдлаар сонгож судалгаанд хамруулсан. Судалгаанд хамрагдах нэгжийн тоог нийт үйлчлүүлэгчдийн тоонд пропорционалиар хуваарилсан (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2012 оны судалгаанд оролцох түүврийн хэмжээ, аймгийн түвшинд

д/д	Аймаг	Эх олонлогийн хэмжээ (мян. хүн)	Дүнд эзлэх хувь	Түүврийн хэмжээ (хүн)
1	Дундговь	313.3	9.7	116
2	Завхан	497.2	15.4	185
3	Дорнод	582.0	18.0	216
4	Төв	753.6	23.3	280
5	Дархан-Уул	1 083.6	33.6	402
	Дүн	**3 229.8**	**100.0**	**1 199**

Нийслэлийн түвшинд түүвэрлэлтийг хийхдээ салбарын байгууллагуудыг түвшингээр нь ангилан, түвшин бус бүрийн байгууллагын тоо гурваас доош байх тохиолдолд тухайн түвшний байгууллагуудыг нэлэнхүй байдлаар, бусад тохиолдолд санамсаргүй түүврийн аргаар байгууллагуудыг сонгов. Тухайлбал, Эрүүл мэндийн байгууллагуудын хувьд Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн газар, Улсын клиникийн төв эмнэлэг, Клиникийн нэгдсэн II эмнэлэг, Клиникийн нэгдсэн III эмнэлэг, Нийслэлийн эрүүл мэндийн газар зэрэг байгууллагыг нэлэнхүй байдлаар, бусад төвүүд, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, өрхийн эмнэлгүүдийг санамсаргүй түүврийг аргаар сонгов. Судалгаанд хамрагдах нэгжийн тоог нийт үйлчлүүлэгчдийн тоонд пропорционалиар хуваарилсан болно.

Түүвэрлэлтийн гурав дахь шатанд: Сонгогдсон төрийн байгууллагын үйлчлүүлэгчдээс судалгаанд хамрагдах нэгж буюу үйлчлүүлэгчийг сонгон судалгааг явуулав. Судалгааны мэдээлэл цуглуулах хугацаанд буюу 2012 оны 10 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд сонгогдсон төрийн байгууллагаар үйлчлүүлсэн үйлчлүүлэгчид түүвэрлэлтийн гурав дахь шатны нэгж болсон. Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2012 оны судалгаанд нийт 2499 нэгж буюу иргэнийг хамруулаа.

1.4 Судалгааны зохион байгуулалт

Судалгааны мэдээллийг 2012 оны 10 дугаар сарын 15-19-ний хооронд цуглуулсан бөгөөд “Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх”-

ны зохион байгуулалтын үйл ажиллагааг дараах ерөнхий дараалын дагуу хийж гүйцэтгэв. Үүнд:

- Судалгааны хүрээ, түүвэрлэлт, хуваарийг гаргав.
- Судалгааны ярилцлага авагч нарыг сонгон, тэдэнд зориулсан сургалтыг зохион байгуулав.
- Судалгааны ярилцлага авагч нарт судалгааны асуулга, заавар, судалгаанд хамрагдах нэгжийн жагсаалтыг хүлээлгэн өгөв.
- Судалгааны ярилцлага авагч нар сонгогдсон нэгжүүдээс ярилцах байдлаар судалгааны асуулгыг бөглүүлэв.
- Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг Дундговь, Завхан, Дорнод, Төв, Дархан-Уул аймаг болон нийслэлд хянаж, холбогдох заавар зөвлөмжийг өгч ажиллав.
- Цуглуулсан мэдээллийг асуулгын дагуу бөглөсөн эсэхэд хяналт тавьж, компьютерт шивж оруулахаар операторуудад хүлээлгэн өгөв.

1.5 Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2012 оны судалгаанд нийслэлд 21, орон нутагт 17, нийт 38 ярилцлага авагч ажиллав.

Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2012 оны судалгааны мэдээллийг оруулах загварыг АНУ-ын Тооллогын товчооноос боловсруулсан CSPro 5.1 (Census and Survey Program) програмаар боловсруулсан бөгөөд уг мэдээлэл оруулах загвар нь асуулга дээрх мэдээллийн алдааг оруулах үед хянах, операторын зүгээс алдаатай мэдээлэл оруулах эрсдлийг бууруулах зэрэг боломжийг олгож өгч байгаа юм.

Мэдээллийг оруулж дууссаны дараа CSPro 5.1 програмын “Export Data” хэрэгслийг ашиглан SPSS 16.0 (Statistical Package for the Social Sciences) програмд хөрвүүлсэн. Мэдээллийн баазыг бэлтгэсний дараа мэдээллийн баазаас энгийн давтамжийн хүснэгтүүдийг гаргаж мэдээллийг шалгаж холбогдох засвар, өөрчлөлтийг хийж, SPSS 16.0 програмыг ашиглан үр дүнгийн хүснэгтүүдийг гарган авч тайлан бэлтгэхэд ашигласан болно.

БҮЛЭГ II. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ШИНЖ БАЙДАЛ

2.1 Төрийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн ерөнхий байдал

Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх судалгаанд оролцогч иргэдийн 53.5 хувь нь өөрийгөө төлөөлж, 36.7 хувь нь өрх болон өрхийн гишүүдээ төлөөлж, 9.8 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагаа төлөөлж төрийн үйлчилгээ авахаар төрийн байгууллагад хандсан байна. Судалгаанд оролцогчдыг насны бүлгээр авч үзвэл тэдний 32.7 хувь нь 30 хүртэлх насны, 26.9 хувь нь 31-40 насны, 21.8 хувь нь 41-50 насны, 12.9 хувь нь 51-60 хүртэл насны, 5.7 хувь нь 61 болон түүнээс дээш насны хүмүүс, харин хүйсийн 38.8 хувийг эрэгтэйчүүд, 61.2 хувийг нь эмэгтэйчүүд эзэлж байна (Зураг 2).

Зураг 2. Судалгаанд хамрагдсан иргэдийн нас, хүйсийн суврага, дүнд эзлэх хувиар



Судалгаанд хамрагдсан иргэдийн өөрсдийнх нь өрхийн амьжиргааны түвшинг бусад дундаж орлоготой өрхүүдтэй харьцуулахад ямар түвшинд байгааг өөрсдийн төсөөллөөр нь үнэлүүлэв. Энэхүү үнэлэмжээр судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 64.9 хувь нь дундаж түвшинд, 21.2 хувь нь дунджаас доогуур түвшинд, 8.2 хувь нь дунджаас дээгүүр түвшинд, 3.8 хувь нь доод түвшинд гэж үнэлсэн бол зөвхөн 0.6 хувь нь дээд түвшинд байна гэж үзжээ. Төрийн байгууллагаар ихэвчлэн (нийт үйлчлүүлэгчдийн 86.1 хувь нь) дундаж болон түүнээс доогуур түвшний гэсэн ангилалд хамрагдаж байгаа амьжиргаатай өрхийг төлөөлсөн иргэд үйлчлүүлсэн байна (Зураг 3). Энэ нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад дундаж болон түүнээс доогуур түвшний амьжиргаатай өрхийг төлөөлсөн иргэд 1.7 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 3. Судалгаанд оролцогчдын амьжиргааны түвшний үнэлгээ, судалгаанд оролцогчдын дүнд эзлэх хувиар



Төрийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн бүтцийг боловсролын түвшингээр нь авч үзэхэд 44.7 хувь нь бүрэн дунд болон түүнээс доош, 5.0 хувь нь техник мэргэжлийн анхан болон тусгай мэргэжлийн дунд шатны, 36.8 хувийг дипломын болон бакалаврын дээд, 3.5 хувийг магистр болон түүнээс дээш боловсролтой иргэд эзэлж байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2012 оны судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн тоо, бүтэц, дүнд эзлэх хувь, боловсролын түвшингээр

Боловсролын түвшин	2010		2012	
	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
Боловсролгүй	28	1.1	15	0.6
Бага боловсролтой	55	2.2	47	1.9
Бүрэн бус дунд	325	13.0	297	11.9
Бүрэн дунд	696	27.8	758	30.3
Техник мэргэжлийн анхан шатны	121	4.8	125	5.0
Тусгай мэргэжлийн дунд	298	11.9	249	10.0
Дипломын болон бакалаврын дээд	860	34.4	920	36.8
Магистр болон түүнээс дээш	120	4.8	88	3.5
Дүн	**2 503**	**100.0**	**2 499**	**100.0**

Түүнчлэн төрийн үйлчилгээ авсан иргэдийн бүтцийг ажил эрхлэлтийн байдлаар нь авч үзэхэд үйлчилгээ авсан иргэдийн 20.6 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 18.8 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр ажиллагчид, 18.3 хувийг төрийн албан хаагчид, 6.4 хувийг оюутан/сурагчид, 7.3 хувийг ажилгүй (ажил идэвхтэй хайж байгаа) иргэд, 12.8 хувийг гэртээ байдаг иргэд, 10.0 хувийг тэтгэврийн өндөр настнууд, 5.7 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч эзэд эзэлж байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2012 оны судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн тоо, бүтэц, дүнд эзлэх хувь, ажил эрхлэлтийн байдлаар

Ажил эрхлэлтийн байдал	2010		2012	
	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
Төрийн албан хаагч	407	16.3	458	18.3
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр ажиллагч	522	20.9	470	18.8
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч эзэн	126	5.0	142	5.7
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	564	22.5	516	20.6
Оюутан / сурагч	295	11.8	159	6.4
Ажилгүй (ажил идэвхтэй хайж байгаа)	248	9.9	182	7.3
Гэртээ байдаг	191	7.6	321	12.8
Тэтгэвэрт	150	6.0	251	10.0
Дүн	**2 503**	**100.0**	**2 499**	**100.0**

2.2 Төрийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн үйлчлүүлж буй давтамж

Иргэд үйлчлүүлэгчдээр төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлүүлэхдээ юуны өмнө тэдний тухайн төрийн байгууллагаар үйлчлүүлж буй давтамж, төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд тохиолддог хүндрэл бэрхшээл, нийт төрийн байгууллагын шударга ажилладаг эсэх талаарх ерөнхий үнэлгээ зэргийг тодруулсан болно. Тухайн төрийн байгууллагаар үйлчлүүлэхээр хамгийн сүүлд хэзээ хандсныг судалгаанд оролцогчдоос асуухад анх удаа хандаж байгаа иргэд 20.5 хувийг эзэлж байгаа нь 2010 оны судалгааны үр дүнтэй ижил байгаа бол, нэг долоо хоногийн өмнө хандсан иргэд 19.2 хувийг, хоёр долоо хоногийн өмнө хандсан иргэд

10.0 хувийг, нэг сарын өмнө хандсан иргэд 19.2 хувийг, гурван сарын өмнө хандсан иргэд 13.0 хувийг, хагас жилийн өмнө хандсан иргэд 7.8 хувийг, жил ба түүнээс дээш хугацааны өмнө хандсан иргэд 10.2 хувийг эзэлж байна. Нийт үйлчлүүлэгчдийн дунджаар 36 хоногийн дараа буюу нэг сар, нэг долоо хоногийн дараа тухайн төрийн байгууллагаар үйлчлүүлэхээр дахин ирсэн байна. Энэ нь өмнөх судалгааны үр дүнтэй ижил түвшинд байна.

Тухайн төрийн байгууллагаар үйлчлүүлэхээр хандсан давтамжийг үзвэл 1-2 удаа хандаж байгаа иргэд 38.2 хувийг, 3-6 удаа хандаж байгаа иргэд 35.4 хувийг, 7-8 удаа хандаж байгаа иргэд 8.8 хувийг, 9 ба түүнээс дээш удаа хандаж байгаа иргэд 17.7 хувийг эзэлж байна. Судалгаанд оролцогчдын дунджаар сүүлийн 12 сарын хугацаанд тухайн төрийн байгууллагад 4.7 удаа хандсан байгаа нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулбал 0.5 пунктээр нэмэгдсэн байна.

БҮЛЭГ III. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

3.1 Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Төрийн үйлчилгээний сонгогдсон салбаруудын шударга байдлын түвшний үнэлгээ 2012 оны байдлаар дунджаар 3.38 (1-5 хүртэлх үнэлгээгээр) буюу 2010 оны судалгааны үр дүнгээс 0.61 пунктээр өссөн байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Салбар	Шударга байдлын түвшний үнэлгээ		Зөрүү
	2010	2012	
Эрүүл мэндийн байгууллага	2.70	3.24	0.54
Боловсролын байгууллага	2.88	3.54	0.66
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллага	2.84	3.40	0.56
Нийгмийн даатгалын байгууллага	2.91	3.61	0.70
Газрын алба	2.70	3.22	0.52
Татварын байгууллага	2.99	3.58	0.59
Улсын бүртгэлийн байгууллага	2.73	3.36	0.63
Гаалийн байгууллага	2.89	3.83	0.94
Мэргэжлийн хяналтын байгууллага	2.80	3.32	0.52
Цагдаагийн байгууллага	2.70	3.19	0.49
Төрийн байгууллагуудын дундаж	2.77	3.38	0.61

Төрийн үйлчилгээний сонгогдсон салбаруудын шударга байдлын түвшний үнэлгээ 3.19-3.83 хооронд үнэлэгджээ. Сонгогдсон бүх салбаруудын хувьд дээрх үзүүлэлт 2010 оныхоос 0.49-0.94 пунктээр өссөн байна.

Энэ нь сүүлийн хоёр жилд төрийн байгууллагын шударга байдлын түвшин нэмэгдэж байгааг илэрхийлэх үзүүлэлт юм. Гэвч төрийн байгууллагын шударга байдлын түвшин нь салбар бүрийн хувьд харилцан адилгүй байгааг анхаарах шаардлагатай байна.

Сонгогдсон салбаруудын шударга байдлын түвшний үнэлгээ 3.19 – 3.83 хооронд үнэлэгджээ. Сонгогдсон бүх салбаруудын хувьд дээрх үзүүлэлт 2010 оныхоос 0.49-0.94 пунктээр өссөн байна. Тухайлбал, хамгийн өндөр өсөлттэй буюу Гаалийн байгууллага (0.94), Нийгмийн даатгалын байгууллага (0.70) байгаа бол хамгийн бага өсөлттэй нь Цагдаагийн байгууллага (0.49), Газрын алба, Мэргэжлийн хяналтын

байгууллага (0.52) байна.

Судалгаанд оролцогчдын 24.0 хувь нь төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд хүндрэл бэрхшээл тохиолддоггүй гэж хариулсан нь 2010 оны судалгааны үр дүнтэй харьцуулбал 13.9 пунктээр нэмэгдсэн байна. Харин үлдсэн 76.0 хувь нь төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд хүндрэл бэрхшээл тохиолддог гэжээ. Төрийн байгууллагаар үйлчүүлэхэд голчлон тохиолддог бэрхшээлээр бүрдүүлэх бичиг баримт хэт олон гэж 19.4 хувь нь, төрийн албан хаагчид хүнд суртал ихтэй гэж 15.3 хувь нь, төрийн үйлчилгээний шат дамжлага олон гэж 13.1 хувь нь, хаана, хэнд хандаж, ямар материал бүрдүүлэх нь тодорхой бус гэж 12.2 хувь нь, төрийн албан хаагчдын харилцааны соёл тааруу гэж 7.3 хувь нь, төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар тааруу гэж 6.3 хувь нь, 2.5 хувь нь бусад хүндрэл бэрхшээлүүд тохиолддог гэж үзсэн байна (Зураг 4.). Үүнийг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулбал төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд учирч буй хүндрэл бэрхшээлээс төрийн албан хаагчдын хүнд суртал 9.8 пунктээр, төрийн албан хаагчдын харилцааны соёл тааруу байх явдал 5.0 пунктээр буурч, харин хаана, хэнд хандаж, ямар материал бүрдүүлэх нь тодорхой бус, төрийн албан хаагчдын мэдлэг ур, чадвар тааруу байх явдал 0.5-1.5 пунктээр нэмэгдсэн гэж судалгаанд оролцогчид хариулжээ.

Зураг 4. Төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд голчлон тохиолддог хүндрэл бэрхшээлүүд, судалгаанд оролцогчдын дүнд эзлэх хувиар



Нийт төрийн байгууллага, албан хаагчид шударга ажилладаг эсэхэд дээр судалгаанд оролцогчдын 7.6 хувь нь санал огт нийлэхгүй байна, 7.9 хувь нь санал бага зэрэг нийлж байна, 37.7 хувь нь санал дунд зэрэг нийлж байна, 36.9 хувь нь санал нийлж байна, 9.8 хувь нь санал бүрэн нийлж байна гэж хариулсан байна.

Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг хариуцлагатай байдлын болон ил тод байдлын үзүүлэлт, тэдгээрийг бүрдүүлэгч 13 дэд үзүүлэлтээр үнэлсэн болно. Төрийн байгууллага, албан хаагчид төрийн үйлчилгээг шударгаар үзүүлэхэд эдгээр дэд үзүүлэлтүүд хэр чухал ач холбогдолтой болохыг судалгаанд оролцогчдоор ач холбогдолгүйгээс маш их ач холбогдолтой хүртэлх (1-5) таван шкалаар үнэлүүлэв.

Иргэд үйлчлүүлэгчид төрийн байгууллага, албан хаагчид төрийн үйлчилгээг шударгаар үзүүлэхэд төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан

гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.37), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.33), албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.30), албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.28) зэрэг дэд үзүүлэлтийг хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ (Зураг 5). Энэ нь 2010 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад төрийн байгууллага, албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал, соёлтой, боловсон үйлчлэх, албан хаагчдын ёс зүйтэй байдал зэргээс илүүтэйгээр төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг үзүүлэхдээ хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх явдалд судалгаанд оролцогчдын өгсөн ач холбогдлын үнэлгээ 0.11 пунктээр нэмэгдэж хамгийн ач холбогдолтой гэж судалгаанд оролцогчид үзсэн байна.

Сонгон авсан 13 дэд үзүүлэлтийн дунджаар ач холбогдлын түвшний үнэлгээ 4.18 (2010 онд 4.13 байсан) буюу “ач холбогдолтой” байгаа нь төрийн байгууллага, албан хаагчид үйл ажиллагаагаа шударгаар явуулахад ач холбогдолтой гэж үзэж буй үзүүлэлтүүдийг үнэлгээ, судалгаанд сонгон авч чадсан болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, иргэд, үйлчлүүлэгчдийн төрийн байгууллагын үйл ажиллагаанаас хүлээж буй үзүүлэлтүүдийг төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх загварт оруулсан байна гэдгийг дахин баталлаа.

Үзүүлэлтийн түвшинд хариуцлагатай байдлын үзүүлэлтийн ач холбогдлын үнэлгээ 4.25, ил тод байдлын үзүүлэлтийн ач холбогдлын үнэлгээ 4.11 гэсэн дүнтэй байна. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллага шударгаар ажиллахад хариуцлагатай байх нь ил тод байхаас илүү ач холбогдолтой гэж иргэд үзэж байна.

Зураг 5. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдэд судалгаанд оролцогчдын өгсөн ач холбогдлын үнэлгээ



Нийт төрийн байгууллагын дунджаар төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 3.38 буюу дунджаас дээгүүр түвшинд гарсан байна. Үүний дотор хариуцлагатай байдлын үзүүлэлт 3.54, ил тод байдлын үзүүлэлт 3.23 гэж үнэлэгдсэн байна (Зураг 6). Төрийн байгууллагын шударга байдлын ерөнхий үнэлгээ иргэдийн хүлээлтээс 0.8 пунктээр, үүний дотор хариуцлагатай байдлын үзүүлэлтийн үнэлгээ 0.71 пунктээр, ил тод байдлын үзүүлэлтийн үнэлгээ 0.88 пунктээр доогуур байна. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ аль ч үзүүлэлтийнхээ хувьд иргэдийн хүлээлтээс доогуур байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна.

Зураг 6. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон үнэлгээ



Дэд үзүүлэлтийн түвшинд хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (3.68), албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.64), албан хаагчдын соёлтой боловсон үйлчилж буй байдал (3.62), албан хаагчдын мэдлэг, чадвар, түргэн шуурхай үйлчилж буй байдал (3.52) зэрэг дэд үзүүлэлтүүд харьцангуй өндөр үнэлгээтэй гарсан бол төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (2.71), иргэдийн санал хүсэлтийг төрийн байгууллага, албан хаагч үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (3.17) зэрэг дэд үзүүлэлтийн үнэлгээ харьцангуй доогуур гарсан байна (Зураг 7).

Эдгээрийг 2010 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал харьцангуй доогуур хэвээр гарсан нь өнгөрсөн хоёр жилийн хугацаанд төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой мэдээллийн нээлттэй байдал дээшлээгүй гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Зураг 7. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ



Дэд үзүүлэлтийн түвшинд бүх үзүүлэлт дээр иргэдийн хүлээлтээс бодит байдлын үнэлгээ доогуур байгаа бөгөөд энэ хэмжээгээр төрийн байгууллагуудад иргэдэд хүссэн хэмжээнд үйлчилж чадахгүй байгааг илтгэн харуулж байна. Төрийн байгууллага, албан хаагч иргэд, үйлчлүүлэгчдийн санал, хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (зөрүү -1.07), төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиох (-0.95), төрийн байгууллагын төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийг нээлттэй болгох (-0.95) тал дээр ихээхэн учир дутагдалтай байгааг иргэд үйлчлүүлэгчид өөрсдийн үнэлгээгээр харууллаа (Зураг 8).

Зураг 8. Төрийн байгууллагын үйл ажиллагааны шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын болон бодит байдлын үнэлгээний зөрүү



Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2012 оны судалгаагаар төрийн байгууллагын шударга байдлын түвшнийн үнэлгээг бүрдүүлэгч 13 дэд үзүүлэлт тус бүрийг үнэлүүлэн, төрийн байгууллагын шударга байдлын ерөнхий түвшинг үнэлүүлсний зэрэгцээ “Энэ удаа танд үйлчилгээ үзүүлсэн төрийн байгууллага, албан хаагч шударга ажилласан гэдэгтэй санал нийлж байна уу?” гэж шууд үнэлүүлсэн. Шууд үнэлгээгээр төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 3.63 гарсан нь төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх аргачлалын дагуу тооцсон үнэлгээнээс 0.25 пунктээр нэмэгдсэн байна.

Дээрх зөрүү гаалийн байгууллага (зөрүү 0.37), нийгмийн даатгалын байгууллага (зөрүү 0.26), улсын бүртгэлийн байгууллага (зөрүү 0.25)-д өндөр гарсан байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Төрийн байгууллагын шударга байдалд өгсөн шууд үнэлгээ болон төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ, тэдгээрийн зөрүү, салбараар

Салбар	Шууд үнэлгээ	Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	Зөрүү
Эрүүл мэндийн байгууллага	3.42	3.25	0.18
Боловсролын байгууллага	3.65	3.55	0.10
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллага	3.56	3.42	0.14
Нийгмийн даатгалын байгууллага	3.87	3.61	0.26
Газрын алба	3.40	3.23	0.17
Татварын байгууллага	3.80	3.59	0.22
Улсын бүртгэлийн байгууллага	3.61	3.36	0.25
Гаалийн байгууллага	4.20	3.83	0.37
Мэргэжлийн хяналтын байгууллага	3.39	3.32	0.07
Цагдаагийн байгууллага	3.40	3.19	0.21
Төрийн байгууллагуудын дундаж	3.63	3.38	0.25

Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээнд хамрагдсан төрийн үйлчилгээний салбар тус бүрээр төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээг авч үзье.

3.1.1 Эрүүл мэндийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Эрүүл мэндийн байгууллагаар 2011 онд давхардсан тоогоор 14.4 сая иргэд үйлчлүүлсэн байна. Эрүүл мэндийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 3.24 гарсан нь үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын дунджаас 0.14 пунктээр доогуур гарчээ. Эрүүл мэндийн байгууллагын хувьд шударга байдлын бүх дэд үзүүлэлтүүдийн үнэлгээгээр судалгаанд хамрагдсан төрийн байгууллагын дунджаас доогуур байна. Үүнээс төсөв санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (зөрүү -0.20); хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (-0.19); байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал (-0.18); албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (-0.17); төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал (-0.15); албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (-0.14); Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал (-0.11); хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (-0.10); Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (-0.10) зэрэг дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ төрийн байгууллагуудын дунджаас 0.09-0.20 пунктээр доогуур байгаа нь энэхүү салбарын шударга байдлын түвшний үнэлгээ нийт төрийн байгууллагын дунджаас доогуур гарахад нөлөөлсөн байна (Хүснэгт 8).

Хэдийгээр эрүүл мэндийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад дээшилсэн ч төрийн байгууллагын дунджаас болон бусад салбарын дунд доогуур хэвээр байна.

Хүснэгт 8. Эрүүл мэндийн байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ болон төрийн байгууллагын дундаж, тэдгээрийн зөрүү

Үзүүлэлт	Эрүүл мэндийн байгууллага	Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	3.59	3.68	-0.10
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	3.35	3.52	-0.17
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	3.55	3.64	-0.09
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	3.48	3.62	-0.14
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	3.23	3.29	-0.05
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	3.28	3.46	-0.18
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	3.37	3.48	-0.11
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	3.25	3.44	-0.19
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	3.19	3.34	-0.15
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	3.07	3.17	-0.10
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	3.16	3.25	-0.08
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал	2.51	2.71	-0.20
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал	3.06	3.20	-0.14
Эрүүл мэндийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	3.24	3.38	-0.14

Эрүүл мэндийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдээс хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (3.59), албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.55), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (3.48) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй өндөр үнэлгээтэй байгаа бол үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (2.51), байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (3.06), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (3.07) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй доогуур үнэлгээтэй байна (Хүснэгт 8).

Иргэд, үйлчлүүлэгчид эрүүл мэндийн байгууллага шударгаар ажиллахад төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж

буй байдал (4.41), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.37), албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.36), албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.32), зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ.

Эрүүл мэндийн байгууллага, албан хаагчид иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (зөрүү -1.20), төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (-1.16), төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийг нээлттэй болгох (-1.07), төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиох (-1.06) зэрэг асуудалд иргэд, үйлчлүүлэгчдийн хүлээсэн хэмжээнд хүрч ажиллаж чадахгүй байна (Зураг 9).

Зураг 9. Эрүүл мэндийн байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон бодит үнэлгээ хоорондын харьцуулалт



3.1.2 Боловсролын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Боловсролын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 3.54 гарсан нь үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын дунджаас 0.16 пунктээр дээгүүр гарсан байна.

Боловсролын байгууллагын хувьд иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (зөрүү 0.32); иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (0.31); албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (0.27); төрийн байгууллагын төсөв санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (зөрүү 0.25); төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг байдал болон албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (0.20) зэрэг дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ төрийн байгууллагуудын дунджаас 0.20-0.32 пунктээр дээгүүр байгаа нь салбарын шударга байдлын түвшний үнэлгээ нийт төрийн байгууллагын дунджаас дээгүүр гарахад нөлөөлсөн байна (Хүснэгт 9.).

Хүснэгт 9. Боловсролын байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ болон төрийн байгууллагын дундаж, тэдгээрийн зөрүү

Үзүүлэлт	Боловсролын байгууллага	Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	3.81	3.68	0.13
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	3.79	3.52	0.27
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	3.75	3.64	0.12
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	3.83	3.62	0.20
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	3.60	3.29	0.31
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	3.55	3.46	0.09
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	3.57	3.48	0.09
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	3.53	3.44	0.09
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	3.39	3.34	0.05
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	3.49	3.17	0.32
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	3.44	3.25	0.20
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал	2.96	2.71	0.25

Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал	3.36	3.20	0.16
Боловсролын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	3.54	3.38	0.16

Боловсролын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдээс албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (үнэлгээ 3.83), хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (үнэлгээ 3.81), албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (3.79), албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.75), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог байдал (3.60), төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал (3.57) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй өндөр үнэлгээтэй байгаа бол үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (2.96), байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (3.36), төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал (3.39) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй доогуур үнэлгээтэй байна (Хүснэгт 9).

Иргэд, үйлчлүүлэгчид боловсролын байгууллага шударгаар ажиллахад төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.32), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.27), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (4.23) зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ (Зураг 10). Багш, сурган хүмүүжүүлэгч нар нь суралцагчдыг ялгаварлалгүй тэгш, соёлтой боловсон хандах нь боловсролын байгууллагын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой гэж судалгаанд оролцогчид үзсэн хэвээр байна. Түүнчлэн хүүхэд, залуучууд, эцэг, эхчүүдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах явдал чухал гэж үзжээ.

Боловсролын байгууллага, албан хаагчид хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (зөрүү -0.79), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (-0.74), олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавих, боловсролын үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг байх болон үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (-0.70) зэрэг асуудалд иргэд, үйлчлүүлэгчдийн хүлээсэн хэмжээнд хүрч ажиллаж чадахгүй байна (Зураг 10).

Зураг 10. Боловсролын байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон бодит үнэлгээ хоорондын харьцуулалт



3.1.3 Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 3.40 гарсан нь үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын дунджаас 0.02 пунктээр дээгүүр гарсан байна. Хөдөлмөр, халамжийн байгууллагын хувьд албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (зөрүү 0.10); тус байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал, үйл ажиллагааны талаарх (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал (0.08) зэрэг дэд үзүүлэлтийн үнэлгээ төрийн байгууллагуудын дунджаас 0.02-0.10 пунктээр дээгүүр байгаа нь салбарын шударга байдлын түвшний үнэлгээ нийт төрийн байгууллагын дунджаас дээгүүр гарахад нөлөөлсөн байна (Хүснэгт 10). Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллага, тэдгээрийн албан хаагчид олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж ажиллаж буй байдал (-0.01),

байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (-0.04) зэрэг үзүүлэлтийн хувьд төрийн байгууллагуудын дунджаас доогуур байна.

Хүснэгт 10. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ болон төрийн байгууллагын дундаж, тэдгээрийн зөрүү

Үзүүлэлт	Хөдөлмөр халамж, үйлчилгээнийн байгууллага	Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	3.71	3.68	0.03
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	3.62	3.52	0.10
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	3.68	3.64	0.04
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	3.65	3.62	0.03
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	3.32	3.29	0.03
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	3.51	3.46	0.05
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	3.56	3.48	0.08
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	3.52	3.44	0.08
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	3.33	3.34	-0.01
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	3.17	3.17	0.00
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	3.25	3.25	0.00
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал	2.68	2.71	-0.04
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал	3.16	3.20	-0.04
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	3.40	3.38	0.02

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдээс хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (үнэлгээ 3.71), албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.68), албан хаагчдын соёлтой,

боловсон үйлчилж буй байдал (3.65) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй өндөр үнэлгээтэй байгаа бол үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (2.68), байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (3.16), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (3.17) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй доогуур үнэлгээтэй байна (Хүснэгт 10).

Иргэд, үйлчлүүлэгчид хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллага шударгаар ажиллахад хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.33), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.31), албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.29), албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.23) зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ (Зураг 11).

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (зөрүү -1.06), иргэдийн саналыг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (-1.01), төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (-0.91), олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал болон иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (-0.83) зэрэг асуудлын хувьд иргэд, үйлчлүүлэгчдийн хүлээсэн хэмжээнд хүрч ажиллаж чадахгүй байна (Зураг 11).

Зураг 11. Хөдөлмөр, халамжийн байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон бодит үнэлгээ хоорондын харьцуулалт



3.1.4 Нийгмийн даатгалын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Нийгмийн даатгалын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 3.60 гарсан нь үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын дунджаас 0.22 пунктээр дээгүүр гарсан байна. Нийгмийн даатгалын байгууллага, албан хаагчийн хувьд хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (зөрүү 0.40); байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (0.35), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал болон олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал (0.30) зэрэг дэд үзүүлэлтийн үнэлгээ төрийн байгууллагуудын дунджаас 0.30-0.40 пунктээр дээгүүр байгаа нь салбарын шударга байдлын түвшний үнэлгээ нийт төрийн байгууллагын дунджаас дээгүүр гарахад нөлөөлсөн байна (Хүснэгт 11). Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчид иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (-0.10) гэсэн үзүүлэлтийн хувьд төрийн байгууллагуудын дунджаас доогуур байсан бол энэ удаагийн судалгааны үр дүнгээр бүх дэд үзүүлэлтээр төрийн байгууллагын дунджаас дээгүүр байна.

Хүснэгт 11. Нийгмийн даатгалын байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ болон төрийн байгууллагын дундаж, тэдгээрийн зөрүү

Үзүүлэлт	Нийгмийн даатгалын байгууллага	Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	3.96	3.68	0.28
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	3.80	3.52	0.28
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	3.83	3.64	0.19
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	3.93	3.62	0.30
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	3.42	3.29	0.13
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	3.60	3.46	0.14
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	3.67	3.48	0.19
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	3.84	3.44	0.40
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	3.64	3.34	0.30
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	3.32	3.17	0.15

Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	3.40	3.25	0.15
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал	3.06	2.71	0.35
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал	3.33	3.20	0.13
Нийгмийн даатгалын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	3.60	3.38	0.22

Нийгмийн даатгалын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдээс хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (үнэлгээ 3.96), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (3.93), хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (3.84), албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.83) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй өндөр үнэлгээтэй байгаа бол үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (3.06), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (3.32), байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (3.33) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй доогуур үнэлгээтэй байна (Хүснэгт 11). Харьцангуй доогуур үнэлгээтэй гарсан шударга байдлын түвшний дэд үзүүлэлтүүд өмнөх судалгааны үр дүнгээр мөн л доогуур үнэлгээтэй байсныг анхаарах хэрэгтэй юм.

Иргэд, үйлчлүүлэгчид нийгмийн даатгалын байгууллага шударгаар ажиллахад хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.32), албан хаагчид нь мэдлэг чадвар, түргэн шуурхай болон соёлтой боловсон үйлчилж буй байдал (4.26), албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.22) зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ (Зураг 12).

Нийгмийн даатгалын байгууллага, албан хаагч иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах байдал (зөрүү -0.84), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (-0.73), төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (-0.70), байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (-0.69) зэрэг асуудлын хувьд иргэд, үйлчлүүлэгчдийн хүлээсэн хэмжээнд хүрч ажиллаж чадахгүй байна (Зураг 12).

Зураг 12. Нийгмийн даатгалын байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон бодит үнэлгээ хоорондын харьцуулалт



3.1.5 Газрын албаны шударга байдлын түвшний үнэлгээ

Газрын албаны шударга байдлын түвшний үнэлгээ 3.22 гарсан нь үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын дунджаас 0.16 пунктээр доогуур гарсан байна. Газрын албаны хувьд шударга байдлын бараг бүх дэд үзүүлэлтийн үнэлгээ төрийн байгууллагын дунджаас доогуур, эдгээрээс албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (зөрүү -0.26), албан хаагчдын ёс зүйтэй байдал болон төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (-0.23) зэрэг дэд үзүүлэлтийн үнэлгээ төрийн байгууллагуудын дунджаас 0.26 хүртэл пунктээр доогуур байгаа нь салбарын шударга байдлын түвшний үнэлгээ нийт төрийн байгууллагын дунджаас доогуур гарахад нөлөөлсөн байна (Хүснэгт 12).

Хүснэгт 12. Газрын албаны шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ болон төрийн байгууллагын дундаж, тэдгээрийн зөрүү

Үзүүлэлт	Газрын алба	Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	3.52	3.68	-0.16
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	3.26	3.52	-0.26
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	3.41	3.64	-0.23
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	3.44	3.62	-0.18
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	3.15	3.29	-0.14
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	3.34	3.46	-0.12
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	3.34	3.48	-0.14
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	3.21	3.44	-0.23
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	3.25	3.34	-0.09
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	3.02	3.17	-0.15
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	3.11	3.25	-0.14
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал	2.61	2.71	-0.10
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал	3.20	3.20	0.00
Газрын албаны шударга байдлын түвшний үнэлгээ	3.22	3.38	-0.16

Газрын албаны шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдээс хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (үнэлгээ 2.61), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (3.02), байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (3.11) зэрэг үзүүлэлтүүд хамгийн бага үнэлгээтэй байна (Хүснэгт 12).

Иргэд, үйлчлүүлэгчид Газрын алба шударгаар ажиллахад албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.46), байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.45), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.42), хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэх болон төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (4.40) зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ (Зураг 13).

Газрын албаны хувьд төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэхдээ иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах (зөрүү -1.37), байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийг нээлттэй байлгах (-1.36),

байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийх (-1.29), байгууллага, албан хаагчид хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (-1.24), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог байх (-1.23) зэрэг асуудалд иргэд, үйлчлүүлэгчдийн хүлээсэн хэмжээнд хүрч ажиллаж чадахгүй байна (Зураг 13).

Зураг 13. Газрын албаны шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон бодит үнэлгээ хоорондын харьцуулалт



3.1.6 Татварын албаны шударга байдлын түвшний үнэлгээ

Татварын албаны шударга байдлын түвшний үнэлгээ 3.58 гарсан нь үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын дунджаас 0.20 пунктээр дээгүүр гарсан байна. Татварын албаны хувьд төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (зөрүү 0.32); албан хаагчдын соёлтой боловсон үйлчилж буй байдал (0.30); албан хаагчдын ёс зүйтэй байдал (0.27); хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (0.26); үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (0.25); төрийн байгууллагын

үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (0.24) зэрэг дэд үзүүлэлтийн үнэлгээ төрийн байгууллагуудын дунджаас 0.24-0.32 пунктээр дээгүүр байгаа нь салбарын шударга байдлын түвшний үнэлгээ нийт төрийн байгууллагын дунджаас дээгүүр гарахад нөлөөлсөн байна (Хүснэгт 13.).

Хүснэгт 13. Татварын албаны шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ болон төрийн байгууллагын дундаж, тэдгээрийн зөрүү

Үзүүлэлт	Татварын байгууллага	Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	3.94	3.68	0.26
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	3.72	3.52	0.20
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	3.91	3.64	0.27
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	3.93	3.62	0.30
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	3.39	3.29	0.10
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	3.66	3.46	0.20
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	3.67	3.48	0.19
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	3.77	3.44	0.32
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	3.44	3.34	0.10
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	3.31	3.17	0.14
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	3.40	3.25	0.16
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал	2.95	2.71	0.24
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал	3.45	3.20	0.25
Татварын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	3.58	3.38	0.20

Татварын албаны шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдээс хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (үнэлгээ 3.94), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (3.93), албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.91), төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (3.77), албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (3.72) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй өндөр үнэлгээтэй байгаа бол үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал

(2.95), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (3.31), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (3.39) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй доогуур үнэлгээтэй байна (Хүснэгт 13).

Иргэд, үйлчлүүлэгчдийн үзэж байгаагаар татварын алба шударгаар ажиллахад хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.37), албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.32), албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.29), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчлэх болон иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (4.27) зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой байна (Зураг 14).

Татварын албаны хувьд иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах (зөрүү -0.95), татварын байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийх болон төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийг нээлттэй байлгах (-0.82), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (-0.81), байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал (-0.70) зэрэг асуудал дээр иргэд, үйлчлүүлэгчдийн хүлээлтэд хүрч ажиллаж чадахгүй байна (Зураг 14).

Зураг 14. Татварын албаны шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон бодит үнэлгээ хоорондын харьцуулалт



3.1.7 Улсын бүртгэлийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Улсын бүртгэлийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 3.35 гарсан нь үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын дунджаас 0.03 пунктээр доогуур гарсан байна. Улсын бүртгэлийн байгууллагын хувьд иргэдийг чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (-0.14), төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (- 0.06), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (-0.04), байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (-0.03), хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэх (-0.02), байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах (- 0.02), байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал (-0.02) зэрэг дэд үзүүлэлтийн үнэлгээ төрийн байгууллагуудын дунджаас 0.02-0.14 пунктээр доогуур байгаа нь салбарын шударга байдлын түвшний үнэлгээ нийт төрийн байгууллагын дунджаас доогуур гарахад нөлөөлсөн байна (Хүснэгт 14).

Хүснэгт 14. Улсын бүртгэлийн байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ болон төрийн байгууллагын дундаж, тэдгээрийн зөрүү

Үзүүлэлт	Бүртгэлийн байгууллага	Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	3.67	3.68	-0.02
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	3.54	3.52	0.02
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	3.64	3.64	0.00
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	3.64	3.62	0.01
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	3.14	3.29	-0.14
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	3.44	3.46	-0.02
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	3.47	3.48	-0.01
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	3.47	3.44	0.03
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	3.33	3.34	-0.02
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	3.13	3.17	-0.04
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	3.18	3.25	-0.06
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал	2.68	2.71	-0.03

Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал	3.23	3.20	0.03
Улсын бүртгэлийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	3.35	3.38	-0.03

Улсын бүртгэлийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдээс үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (2.68), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (3.13), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (3.14) зэрэг үзүүлэлтүүд хамгийн бага үнэлгээтэй байна (Хүснэгт 14).

Иргэд, үйлчлүүлэгчид улсын бүртгэлийн байгууллага шударгаар ажиллахад хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.47), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.41), албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.36), албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.34) зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ (Зураг 15).

Улсын бүртгэлийн байгууллагын хувьд иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах (зөрүү -1.13), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (-1.12), байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиож ажиллах (-1.09), төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (-0.99), төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал (-0.91), зэрэг асуудал дээр иргэд, үйлчлүүлэгчдийн хүлээсэн хэмжээнд хүрч ажиллаж чадахгүй байна (Зураг 15).

Зураг 15. Улсын бүртгэлийн байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон бодит үнэлгээ хоорондын харьцуулалт



3.1.8 Гаалийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Гаалийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 3.72 гарсан нь үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын дунджаас 0.34 пунктээр дээгүүр гарсан байна. Гаалийн байгууллагын хувьд төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал (зөрүү 0.52); албан хаагчдын соёлтой боловсон үйлчилж буй байдал (0.48); албан хаагчдын ёс зүйтэй байдал (0.47); албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (зөрүү 0.46); хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (0.44); төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (0.43) зэрэг дэд үзүүлэлтийн үнэлгээ төрийн байгууллагуудын дунджаас 0.43-0.52 пунктээр дээгүүр байгаа нь салбарын шударга байдлын түвшний үнэлгээ нийт төрийн байгууллагын дунджаас дээгүүр гарахад нөлөөлсөн байна (Хүснэгт 15).

Хүснэгт 15. Гаалийн байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ болон төрийн байгууллагын дундаж, тэдгээрийн зөрүү

Үзүүлэлт	Гаалийн байгууллага	Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	4.13	3.68	0.44
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	3.98	3.52	0.46
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	4.11	3.64	0.47
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	4.10	3.62	0.48
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	3.39	3.29	0.11
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	3.79	3.46	0.33
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	3.77	3.48	0.29
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	3.88	3.44	0.43
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	3.86	3.34	0.52
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	3.52	3.17	0.35
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	3.48	3.25	0.23
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал	2.84	2.71	0.13
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал	3.55	3.20	0.35
Гаалийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	3.72	3.38	0.34

Гаалийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдээс хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (4.13), албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.11), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.10), албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (үнэлгээ 3.98) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй өндөр үнэлгээтэй байгаа бол үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (2.84), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (3.39), байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (3.48) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй доогуур үнэлгээтэй байна (Хүснэгт 15).

Иргэд, үйлчлүүлэгчдийн үзэж байгаагаар гаалийн байгууллага шударгаар ажиллахад байгууллагын удирдлага хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж буй байдал (4.57), байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.55), албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.55), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.54), албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.52) зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ (Зураг 16).

Гаалийн байгууллагын хувьд байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил зохиож ажиллах (зөрүү -0.95), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (-0.95), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцох (-0.84), байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал (-0.79) зэрэг асуудал дээр иргэд, үйлчлүүлэгчдийн хүлээлтэд хүрч ажиллаж чадахгүй байна (Зураг 16).

Зураг 16. Гаалийн байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон бодит үнэлгээ хоорондын харьцуулалт



3.1.9 Мэргэжлийн хяналтын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Мэргэжлийн хяналтын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 3.32 гарсан нь үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын дунджаас 0.06 пунктээр доогуур гарсан байна. Мэргэжлийн хяналтын байгууллагын хувьд хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (зөрүү -0.17); иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (-0.13); төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (-0.12); төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (-0.09); төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал (-0.07) зэрэг 13 дэд үзүүлэлтийн 9 дэд үзүүлэлтийн үнэлгээ төрийн байгууллагуудын дунджаас 0.04-0.14 пунктээр доогуур байгаа нь салбарын шударга байдлын түвшний үнэлгээ нийт төрийн байгууллагын дунджаас доогуур гарахад нөлөөлсөн байна (Хүснэгт 16.).

Хүснэгт 16. Мэргэжлийн хяналтын байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ болон төрийн байгууллагын дундаж, тэдгээрийн зөрүү

Үзүүлэлт	Мэргэжлийн хяналтын байгууллага	Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	3.51	3.68	-0.17
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	3.57	3.52	0.05
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	3.65	3.64	0.01
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	3.58	3.62	-0.04
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	3.24	3.29	-0.05
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	3.47	3.46	0.01
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	3.41	3.48	-0.07
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	3.33	3.44	-0.12
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	3.30	3.34	-0.04
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	3.04	3.17	-0.13
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	3.16	3.25	-0.09
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал	2.76	2.71	0.05
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал	3.14	3.20	-0.06

Мэргэжлийн хяналтын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	3.32	3.38	-0.06

Мэргэжлийн хяналтын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдээс албан хаагчдын ёс зүйтэй байдал (үнэлгээ 3.65), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (3.58), албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (3.57), хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (3.51) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй дээгүүр үнэлгээтэй байгаа бол төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (үнэлгээ 2.76), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (3.04) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй доогуур үнэлгээтэй байна (Хүснэгт 16).

Иргэд, үйлчлүүлэгчдийн үзэж байгаагаар мэргэжлийн хяналтын байгууллага шударгаар ажиллахад байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.09), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.01), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (3.97), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (3.97), албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (3.97) зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой байна (Зураг 17). Мэргэжлийн хяналтын байгууллагын хувьд иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж ажиллах (зөрүү -0.93), байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (-0.82), байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (-0.79), хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (-0.77) зэрэг асуудал дээр иргэд, үйлчлүүлэгчдийн хүлээлтэд хүрч ажиллаж чадахгүй байна (Зураг 17).

Зураг 17. Мэргэжлийн хяналтын байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон бодит үнэлгээ хоорондын харьцуулалт



3.1.10 Цагдаагийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Цагдаагийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 3.19 гарсан нь үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудын дунджаас 0.19 пунктээр доогуур гарсан байна. Цагдаагийн байгууллагын хувьд албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (зөрүү -0.35); албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (-0.33); хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (-0.26); хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (-0.24); албан хаагчдын ёс зүйтэй байдал (- 0.24) зэрэг дэд үзүүлэлтийн үнэлгээ төрийн байгууллагуудын дунджаас 0.24-0.35 пунктээр доогуур байгаа нь салбарын шударга байдлын түвшний үнэлгээ нийт төрийн байгууллагын дунджаас доогуур гарахад нөлөөлсөн байна (Хүснэгт 17).

Хүснэгт 17. Цагдаагийн байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ болон төрийн байгууллагын дундаж, тэдгээрийн зөрүү

Үзүүлэлт	Цагдаагийн байгууллага	Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	3.44	3.68	-0.24
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	3.19	3.52	-0.33
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	3.40	3.64	-0.24
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	3.28	3.62	-0.35
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	3.17	3.29	-0.11
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	3.47	3.46	0.01
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	3.31	3.48	-0.16
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	3.18	3.44	-0.26
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	3.25	3.34	-0.09
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	3.03	3.17	-0.14
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	3.18	3.25	-0.07
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал	2.53	2.71	-0.18
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал	3.06	3.20	-0.14
Цагдаагийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ	3.19	3.38	-0.19

Цагдаагийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дэд үзүүлэлтүүдээс үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (2.53), иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (3.03), байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (3.06), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (3.17) зэрэг үзүүлэлтүүд харьцангуй доогуур үнэлгээтэй байна (Хүснэгт 17).

Иргэд, үйлчлүүлэгчид цагдаагийн байгууллага шударгаар ажиллахад албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.39), хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (4.34), албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (4.34), албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.33), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (4.33) зэрэг дэд үзүүлэлт хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ (Зураг 18).

Цагдаагийн байгууллагын хувьд иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж ажиллах (зөрүү -1.22), хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчлэх (- 1.16), иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (-1.15), албан хаагчид нь мэдлэг чадвартай байж түргэн шуурхай үйлчлэх (-1.15), албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (-1.11) зэрэг асуудал дээр иргэд, үйлчлүүлэгчдийн хүлээлтэд хүрч ажиллаж чадахгүй байна (Зураг 18).

Зураг 18. Цагдаагийн байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин болон бодит үнэлгээ хоорондын харьцуулалт



СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх 2012 оны судалгаа болон Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Судалгаанд оролцогчдын 24.0 хувь нь төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд хүндрэл бэрхшээл тохиолддоггүй гэж хариулсан нь 2010 оны судалгааны үр дүнтэй харьцуулбал 13.9 пунктээр нэмэгдсэн байна. Төрийн байгууллагаар үйлчлүүлж буй дөрвөн хүн тутмын гурав нь нь ямар нэгэн хүндрэл бэрхшээлтэй тулгардаг байна. Төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд төрийн албан хаагчид хүнд суртал ихтэй; төрийн үйлчилгээ авахад бүрдүүлэх бичиг баримт, шат дамжлага хэт олон, төрийн албан хаагчдын харилцааны соёл тааруу; хаана, хэнд хандаж, ямар материал бүрдүүлэх нь тодорхой бус зэрэг хүндрэл бэрхшээлүүд иргэд, үйлчлүүлэгчдэд голчлон тохиолддог байна. Үүнийг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулбал төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд учирч буй хүндрэл бэрхшээлээс төрийн албан хаагчдын хүнд суртал 9.8 пунктээр, төрийн албан хаагчдын харилцааны соёл тааруу байх явдал 5.0 пунктээр буурч, харин хаана, хэнд хандаж, ямар материал бүрдүүлэх нь тодорхой бус, төрийн албан хаагчдын мэдлэг ур, чадвар тааруу байх явдал 0.5-1.5 пунктээр нэмэгджээ. Хэдийгээр төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ дээшилсэн ч Эрүүл мэнд, Цагдаагийн байгууллага, Газрын албаны үнэлгээ бусад судалгаанд хамрагдсан салбартай харьцуулахад харьцангуй доогуур хэвээр байна.
- Энэхүү судалгааны үр дүн нь үйлчлүүлэгчдийн тухайн төрийн үйлчилгээнээс хүсч буй үр дүн буюу хүлээлтийг үйлчилгээний гүйцэтгэл буюу үйлчлүүлэгчдийн үнэлгээтэй харьцуулан төрийн байгууллагын шударга байдлын түвшинг нэмэгдүүлэх чиглэлээр цаашид анхаарах асуудлаа тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх боломж олгож байна. Энэ удаагийн судалгаагаар сонгогдсон төрийн үйлчилгээний гүйцэтгэл хангалтгүй байгаагийн шалтгааныг тухайн үйлчилгээг авсан иргэд, байгууллагаас тодруулсан онцлогтой судалгаа болсныг дурдах нь зүйтэй юм.
- Сонгосон төрийн үйлчилгээний салбаруудын дунджаар төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 3.38 буюу дунджаас дээгүүр гарсан ч иргэдийн хүлээлтээс 0.80 пунктээр доогуур байна.
- Иргэд, үйлчлүүлэгчид төрийн байгууллагаас төрийн үйлчилгээг шударгаар үзүүлэхэд албан хаагчдын мэдлэг ур чадвар, түргэн шуурхай байдал, соёлтой боловсон үйлчлэх, ёс зүйтэй байх, хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй тэгш хандаж үйлчлэх нь илүү чухал холбогдолтой гэж үзсэн хэвээр байна.
- Үзүүлэлтийн түвшинд хариуцлагатай байдлын үзүүлэлтийн ач холбогдлын үнэлгээ 4.25, ил тод байдлын үзүүлэлтийн ач холбогдлын үнэлгээ 4.11 гэсэн дүнтэй байна. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллага шударгаар ажиллахад хариуцлагатай байх нь ил тод байхаас илүү ач холбогдолтой гэж иргэд үзэж байна.
- Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ аль ч үзүүлэлтийнхээ хувьд иргэдийн хүлээлтээс доогуур байгаа бөгөөд ялангуяа төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал дээр ихээхэн зөрүүтэй байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна. Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлж буй дэд үзүүлэлтүүдээс төрийн байгууллагын төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийг нээлттэй

болгох асуудал өнгөрсөн 2 жилийн хугацаанд төдийлөн ахиц гараагүй, учир дутагдалтай байгааг иргэд, үйлчлүүлэгчид өөрсдийн үнэлгээгээр харууллаа.

- Төрийн байгууллагаар үйлчлүүлэгчид “Нийт төрийн байгууллага шударга ажилладаг уу” гэсэн асуултад 3.33 гэсэн үнэлгээ өгсөн нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулбал 0.04 пунктээр буурсан, “Энэ удаа танд үйлчилсэн төрийн байгууллага албан хаагч шударга ажилласан уу” гэсэн асуултад 3.63 гэсэн үнэлгээ өгсөн нь 0.65 пунктээр өссөн бол батлагдсан аргачлалын дагуу Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 3.38 гарчээ.
- “Төрийн байгууллага иргэд, үйлчлүүлэгчдийн өмнө хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнаж хариуцлагатайгаар үйл ажиллагаа явуулахад салбарын үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх статистик мэдээлэл, тухайлбал, үйлчлүүлэгчдийн тооны талаарх мэдээлэл хангалтгүй байна. Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх статистик мэдээлэл салбар, байгууллага бүр дээр харилцан адилгүй, хангалтгүй байна. Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүний тэн хагасыг зарцуулдаг, нийт ажиллагчдын 15 орчим хувь нь ажиллаж байгаа төрийн байгууллагын салбарын үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь зөвхөн төсвийн зарцуулалт, ажилтны тоогоор хязгаарлагдаж байгаад дүгнэлт хийх хэрэгтэй байна.” гэж өмнөх судалгааны тайланд дурдсан байхад 2 жил өнгөрөхөд энэ байдал өөрчлөгдөөгүй байгаад дүгнэлт хийж цаашид салбар, байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулах арга хэмжээг төлөвлөх нь зүйтэй гэж үзэж байна.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ, САЛБАРААР

Салбар	Шударга байдлын түвшний үнэлгээ		Хариуцлагатай байдлын үзүүлэлт		Ил тод байдлын үзүүлэлт		Дэд үзүүлэлтийн ач холбогдлын дундаж үнэлгээ		Үйлчлүүлэгчдийн хүлээлт болон бодит байдлын үнэлгээний зөрүү		Төрийн байгууллагын дундажтай харьцуулсан зөрүү	
	2010	2012	2010	2012	2010	2012	2010	2012	2010	2012	2010	2012
Эрүүл мэндийн байгууллага	2.70	3.24	2.87	3.41	2.55	3.10	4.13	4.19	-1.43	-0.95	-0.07	-0.14
Боловсролын байгууллага	2.88	3.54	3.02	3.72	2.76	3.40	4.02	4.52	-1.14	-0.98	+0.11	+0.16
Хөдөлмөр, халамжийн, үйлчилгээний газар	2.84	3.40	2.98	3.58	2.71	3.25	4.12	4.15	-1.28	-0.75	+0.07	+0.02
Нийгмийн даатгалын байгууллага	2.91	3.61	3.04	3.76	2.79	3.47	4.12	4.14	-1.21	-0.53	+0.14	+0.23
Газрын алба	2.70	3.22	2.82	3.35	2.60	3.11	4.11	4.35	-1.41	-1.13	-0.07	-0.16
Татварын байгууллага	2.99	3.58	3.16	3.77	2.85	3.45	4.19	4.18	-1.20	-0.60	+0.22	+0.20
Улсын бүртгэлийн байгууллага	2.73	3.36	2.86	3.51	2.62	3.23	4.08	4.22	-1.35	-0.86	-0.04	-0.02
Гаалийн байгууллага	2.89	3.83	3.11	3.92	2.68	3.58	4.12	4.33	-1.23	-0.50	+0.10	+0.45
Мэргэжлийн хяналтын байгууллага	2.80	3.32	2.98	3.50	2.64	3.17	4.16	3.90	-1.36	-0.58	+0.03	-0.06
Цагдаагийн байгууллага	2.70	3.19	2.85	3.32	2.56	3.09	3.97	4.19	-1.27	-1.00	-0.07	-0.19
Төрийн байгууллагын дундаж	2.77	3.38	4.21	4.25	4.05	4.11	4.13	4.18	-1.36	0.80		

ХАВСРАЛТ 2. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТИЙН АЧ ХОЛБОГДЛЫН ҮНЭЛГЭЭ, САЛБАРААР

Байгууллага / Үзүүлэлт	Эрүүл мэнд	Боловсрол	Хөдөлм өр халамжийн үйлчилгээ	Нийгмийн даатгал	Газрын алба	Татвар	Улсын бүртгэл	Гааль	Мэргэжлийн хяналт	Цагдаа	Улсын дундаж
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	4.07	3.92	4.13	4.15	4.40	4.12	4.17	4.32	3.83	4.23	4.13
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	4.36	4.15	4.29	4.26	4.37	4.32	4.36	4.52	3.97	4.34	4.30
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	4.32	4.14	4.23	4.22	4.46	4.29	4.34	4.55	3.93	4.33	4.28
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	4.37	4.27	4.31	4.26	4.42	4.27	4.41	4.54	4.01	4.39	4.33
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	4.27	4.12	4.15	4.14	4.38	4.20	4.27	4.23	3.97	4.33	4.22
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	4.24	4.14	4.14	4.19	4.35	4.24	4.25	4.57	3.94	4.27	4.22
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	4.14	4.11	4.12	4.14	4.34	4.13	4.20	4.41	3.87	4.17	4.15
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	4.41	4.32	4.33	4.32	4.45	4.37	4.47	4.55	4.09	4.34	4.37
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	4.21	4.09	4.16	4.15	4.38	4.14	4.23	4.18	3.78	4.19	4.18
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	4.27	4.23	4.19	4.16	4.39	4.27	4.26	4.46	3.97	4.24	4.24
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	4.22	4.15	4.16	4.10	4.40	4.23	4.27	4.43	3.88	4.16	4.20
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал	3.58	3.67	3.73	3.75	3.97	3.77	3.56	3.46	3.58	3.50	3.66
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал	4.03	3.94	3.95	3.96	4.23	4.00	4.09	4.00	3.93	3.95	4.01
Дүн	4.19	4.10	4.15	4.14	4.35	4.18	4.22	4.33	3.90	4.19	4.18

ХАВСРАЛТ 3. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ДЭД ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ, САЛБАРААР

Байгууллага / Үзүүлэлт	Эрүүл мэнд	Боловсрол	Хөдөлмөр халамж, үйлчилгээ	Нийгмийн даатгал	Газрын алба	Татвар	Улсын бүртгэл	Гааль	Мэргэжлийн хяналт	Цагдаа	Улсын дундаж
Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал	3.59	3.81	3.71	3.96	3.52	3.94	3.67	4.13	3.51	3.44	3.68
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	3.35	3.79	3.62	3.80	3.26	3.72	3.54	3.98	3.57	3.19	3.52
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	3.55	3.75	3.68	3.83	3.41	3.91	3.64	4.11	3.65	3.40	3.64
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	3.48	3.83	3.65	3.93	3.44	3.93	3.64	4.10	3.58	3.28	3.62
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	3.23	3.60	3.32	3.42	3.15	3.39	3.14	3.39	3.24	3.17	3.29
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	3.28	3.55	3.51	3.60	3.34	3.66	3.44	3.79	3.47	3.47	3.46
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	3.37	3.57	3.56	3.67	3.34	3.67	3.47	3.77	3.41	3.31	3.48
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	3.25	3.53	3.52	3.84	3.21	3.77	3.47	3.88	3.33	3.18	3.44
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	3.19	3.39	3.33	3.64	3.25	3.44	3.33	3.86	3.30	3.25	3.34
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	3.07	3.49	3.17	3.32	3.02	3.31	3.13	3.52	3.04	3.03	3.17
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	3.16	3.44	3.25	3.40	3.11	3.40	3.18	3.48	3.16	3.18	3.25
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал	2.51	2.96	2.68	3.06	2.61	2.95	2.68	2.84	2.76	2.53	2.71
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал	3.06	3.36	3.16	3.33	3.20	3.45	3.23	3.55	3.14	3.06	3.20
Дүн	3.24	3.54	3.40	3.60	3.22	3.58	3.35	3.72	3.32	3.19	3.38

ХАВСРАЛТ 4. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ХАРЬЦАНГУЙ ӨНДӨР БОЛОН ДООГУУР ҮНЭЛГЭЭТЭЙ ДЭД ҮЗҮҮЛЭЛТ, САЛБАРААР

Салбар	Үнэлгээ харьцангуй өндөр гарсан дэд үзүүлэлт	Үнэлгээ харьцангуй доогуур гарсан дэд үзүүлэлт
Эрүүл мэндийн байгууллага	1. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (3.59), 2. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.55), 3. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (3.48)	1. Байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (2.51), 2. Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (3.06), 3. Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (3.07)
Боловсролын байгууллага	1. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (үнэлгээ 3.83), 2. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (үнэлгээ 3.81), 3. Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (3.79), 4. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.75)	1. Байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (2.96), 2. Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (3.36), 3. Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал (3.39)
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллага	1. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (үнэлгээ 3.71), 2. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.68), 3. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (3.65)	1. Байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (2.68), 2. Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (3.16), 3. Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (3.17)
Нийгмийн даатгалын байгууллага	1. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (үнэлгээ 3.96), 2. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (3.93), 3. Хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (3.84), 4. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.83)	1. Байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (3.06), 2. Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (3.32), 3. Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (3.33)
Газрын алба	1. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (3.52), 2. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (3.44) 3. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.41)	1. Байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (үнэлгээ 2.61), 2. Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (3.02), 3. Байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (3.11)

Татварын байгууллага	1. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (үнэлгээ 3.94), 2. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (3.93), 3. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.91), 4. Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал (3.77),	1. Байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (2.95), 2. Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (3.31), 3. Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (3.39)
Улсын бүртгэлийн байгууллага	1. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (3.94) 2. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (3.93) 3. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.91)	1. Байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (2.68), 2. Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (3.13), 3. Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (3.14)
Гаалийн байгууллага	1. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (4.13), 2. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (4.11), 3. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал (4.10),	1. Байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (2.84), 2. Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх (3.39), 3. Байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (3.48)
Мэргэжлийн хяналтын байгууллага	1. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (үнэлгээ 3.65), 2. Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (3.58), 3. Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал (3.57), 4. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (3.51)	1. Байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (үнэлгээ 2.76), 2. Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (3.04)
Цагдаагийн байгууллага	1. Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал (3.47) 2. Хууль зөрчилгүй асуудлыг шийдвэрлэж буй байдал (3.44) 3. Албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.40)	1. Байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан, мэдээллийн нээлттэй байдал (2.53), 2. Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (3.03), 3. Байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (3.06),

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ 2012 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ 2012 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

1. Судалгааны зорилго, товч үр дүн

Монгол Улсын ирээдүй болсон хүүхдүүдийн дунд зан үйлийн зөв төлөвшил, ёс суртахуун ямар түвшинд байгааг судлах, цаашид шударга бус явдлын өмнө нугарахгүй зогсож чадах хүмүүсийг төлөвшүүлэхийн тулд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэрээрүүлэх ажлыг чиглүүлэхэд энэхүү судалгааны зорилго оршиж байгаа юм.

Хүүхдүүдийн шударга байдлын ерөнхий үнэлгээ 2.93 гарсан бөгөөд 2010 оны үнэлгээнээс 0.36 пунктээр буурсан байна (Зураг 1).

Зураг 1: Хүүхдийн шударга байдал судалгааны үр дүн, (2008, 2010, 2012 он)



2. Хүүхдийн шударга байдал-2012 судалгааны арга зүй, түүвэрлэлт

Судалгааг 2008 онд БНСУ-ын Транспарэнси интернэшнл байгууллагаас арваад орны эрдэмтэн судлаачдын боловсруулсан аргачлалын дагуу Энэтхэг, БНСУ, Бангладеш, Монгол зэрэг оронд зохион байгуулсан судалгааны асуулга, тооцоолох арга зүйг ашиглан явуулсан. Уг асуулга нь хүүхдүүдийн шударга байдал, ёс суртахууны төлөвшил, авлига болон гэмт хэргийг үл тэвчих байдал, аливаа асуудалд хандах хандлага, хууль, дүрэм, журам сахин биелүүлэх явдлыг хүүхдүүдээс маш энгийн, тэдэнд ойлгомжтой байдлаар асууж тодруулах боломж олгосноороо онцлог юм.

Хүснэгт 1: Хүүхдийн шударга байдлын түвшинг тодорхойлох дэд үзүүлэлтүүдийг илэрхийлэх асуултуудын дугаар

	Ёс зүй / Ёс суртахуун	Зөв төлөвшил	Хууль ягштал сахих	Авлигыг /үл/ тэвчих
Танин мэдэхүйн	3	4	1	2
Нөлөөллийн	6	5	7	8
Зан үйлийн	9	11	10	12

Хүүхдийн шударга байдлын түвшинг Хүснэгт 1-д байгаа асуулт – дэд үзүүлэлтээр тодорхойлж гаргаж ирсэн. Асуултуудаар илэрхийлсэн үзэл санаатай хүүхдүүдийн үзэл бодол нийлж байгаа эсэхийг “Санал бүрэн нийлж байна” гэдгээс эхлэн “Санал огт нийлэхгүй байна” хүртэл үнэлгээ хийлгэсэн. Шударга байдлын түвшингийн үзүүлэлт нь 1-10 гэсэн утгаар илэрхийлэх ба 10 руу ойртох тусам маш сайн, 1 рүү ойртох тусам маш муу гэсэн утгыг илэрхийлнэ. Хүүхдийн шударга байдлын түвшинг тодорхойлох мэдээллийн эх үүсвэр нь “Хүүхдийн шударга байдал 2012” судалгааны үр дүн байв.

7-11 дүгээр ангид суралцаж буй хүүхдийн тоогоор аймгуудыг бүлэглэж, бүлэг тус

бүрээс нэг аймгийг санамсаргүй байдлаар сонгосон. “Хүүхдийн шударга байдал 2012 судалгаа”-нд Дорноговь, Дундговь, Завхан, Сэлэнгэ, Хэнтий, Орхон, Хөвсгөл аймаг, Нийслэлийн Чингэлтэй, Сонгино-Хайрхан, Налайх дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн 851 сурагчдыг хамруулсан.

3. Судалгааны зохион байгуулалт, мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Судалгааны ажлыг АТГ-ын Судалгаа шинжилгээний алба зохион байгуулж явуулсан бөгөөд мэдээлэл цуглуулах ажлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө газартай хамтран 2012 оны 03 дугаар сарын 09-аас 15-ны хооронд хийсэн юм.

Хүүхдийн шударга байдал 2012 оны судалгааны мэдээллийг оруулах загварыг АНУ-ын Тооллогын товчооноос боловсруулсан CSPro 4.0 (Census and Survey Program) программ дээр боловсруулсан. Мэдээллийг оруулж дуусаны дараа CSPro 4.0 программын Export Data хэрэгслийг ашиглан SPSS 16.0 (Statistical Package for the Social Sciences) программ руу хөрвүүлсэн. SPSS 16.0, EXSEL программыг ашиглан үр дүнгийн хүснэгтүүдийг гарган авч тайлан бэлтгэхэд ашигласан.

4. Хүүхдийн шударга байдал 2012 судалгааны үр дүн

4.1 Судалгаанд оролцогчдын бүтэц

Хүүхдийн шударга байдал судалгаанд оролцогчдыг байршлаар нь авч үзвэл 36.8 хувь нь нийслэлийн, 63.2 хувь нь аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчид байлаа (Зураг 2).

Зураг 2: Хүүхдийн шударга байдал 2012 судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо, байршлаар (дүнд эзлэх хувиар)



Хүүхдийн шударга байдал судалгаанд оролцогчдын бүтцийг хүйсээр авч үзвэл 45.4 хувийг эрэгтэй сурагчид, 54.6 хувийг эмэгтэй сурагчид эзэлж байна. (Зураг 3).

Зураг 3: Судалгаанд оролцогчдын бүтэц (хүйсээр)



Судалгаанд оролцсон хүүхдүүдийг насны бүтцээр авч үзвэл 11 настай сурагчид 0.1 хувийг, 12 настай сурагчид 2.0 хувийг, 13 настай сурагчид 8.5 хувийг, 14 настай сурагчид 20.4 хувийг, 15 настай сурагчид 25.2 хувийг, 16 настай сурагчид 19.4 хувийг, 17 настай сурагчид 16.6 хувийг, 18 настай сурагчид 1.2 хувийг тус тус хүүхдүүд эзэлж байна.

Судалгаанд оролцогчдын бүтцийг сурч байгаа ангиар авч үзвэл 14.92 хувь нь 7 дугаар ангид, 30.08 хувь нь 8 дугаар ангид, 18.33 хувь нь 9 дүгээр ангид, 19.86 хувь нь 10 дугаар ангид, 16.8 хувь нь 11 дүгээр ангид тус тус суралцаж байна (Зураг 4).

Зураг 4: Судалгаанд оролцсон хүүхдүүдийн бүтэц (анги бүлгээр)



4.2 Хүүхдийн шударга байдлын үнэлгээ (2012 он)

Хүүхдийн шударга байдлын үнэлгээг 2010 оныхтой харьцуулбал нийслэлд оршин суудаг хүүхдүүдийн шударга байдлын үнэлгээ 0.23, орон нутагт оршин суудаг хүүхдүүдийн шударга байдлын үнэлгээ 0.33-аар тус тус буурсан байна. (хүснэгт 5)

Зураг 5: Хүүхдүүдийн шударга байдал 2008, 2010, 2012 оны үнэлгээ (байршлаар)

Хүүхдүүдийн шударга байдлын үнэлгээг хүйсээр үзвэл эрэгтэй хүүхдийн шударга байдлын үнэлгээ эмэгтэй хүүхдийнхээс 0.29 пунктээр илүү байна (Зураг 6). Уг үзүүлэлтийг 2010 оны дүнтэй харьцуулбал эрэгтэй хүүхдийн шударга байдлын үнэлгээ 0.35, эмэгтэй хүүхдийн шударга байдлын үнэлгээ 0.39-аар тус тус буурсан байна. 2010 судалгааны дүнгээр эмэгтэй хүүхдийн шударга байдлын үнэлгээ эрэгтэй хүүхдийнхээс бага байсан бол энэ удаагийн судалгаагаар мөн давтагджээ.

Зураг 6: Хүүхдүүдийн шударга байдлын 2008, 2010, 2012 оны үнэлгээ (хүйсээр)



Хүүхдийн шударга байдлын үнэлгээг хүүхдийн насны ангиллаар авч үзвэл, 16 насныхны шударга байдлын үнэлгээ (3.20) бусад насныхнаас өндөр гарчээ (Зураг 7).

Зураг 7: Хүүхдийн шударга байдлын үнэлгээ (насны ангилалаар)



Хүүхдүүдийн суралцаж буй ангиар авч үзвэл 10 дугаар ангийн сурагчдын шударга байдлын үнэлгээ (3.3) харьцангуй өндөр гарсан байна (Зураг 8).

Зураг 8: Хүүхдийн шударга байдлын үнэлгээ (суралцаж буй ангиар)



Хүүхдийн шударга байдлын түвшинг тодорхойлох дэд үзүүлэлтүүдийн үзүүлэлтүүдийн үнэлгээг Хүснэгт 2-д харуулав. Хууль биелүүлэх зан үйлийн үзүүлэлт (-0,82), Хууль биелүүлэх танин мэдэхүйн дэд үзүүлэлт (-0.81), Хүүхдийн ёс суртахууны талаарх танин мэдэхүйн дэд үзүүлэлт (-0.48), Авлигыг үл тэвчих нөлөөллийн дэд үзүүлэлт (-0,48)-үүд нь бусад үзүүлэлтээс илүү нэмэгдсэн.

Хүүхдүүдийн зөв төлөвшлийн танин мэдэхүй (1.85) болон нөлөөллийн дэд үзүүлэлт (1.94), хууль ягштал биелүүлэх зан үйлийн дэд үзүүлэлт (1.98)-ийн үнэлгээ харьцангуй доогуур гарсан. Авлигыг үл тэвчих нөлөөллийн дэд үзүүлэлт (6.23)-ийн үнэлгээ харьцангуй сайн гарсан.

Хүснэгт 2. Хүүхдийн шударга байдлын түвшинг тодорхойлох дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ

д/д			Дэд үзүүлэлт	Үнэлгээ	
				2010	**2012**
1	Ёс суртахуун	Танин мэдэхүй	Сурагчид гэрийн даалгавар хийхдээ интернет болон бусад хүмүүсийн бичсэн зүйлийг хуулчихаад багшдаа би бичсэн гэж хэлэх нь буруу зүйл биш	3.2	2.72
2	Ёс суртахуун	Нөлөөлөл	Баян байх нь шударга байхаас илүү чухал зүйл	2.7	2.49
3	Ёс суртахуун	Зан үйлийн	Урт дараалалд хүлээж байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээнэ	3.2	2.99
			Бүлгийн дундаж	3.03	2.73
1	Зөв төлөвшил	Танин мэдэхүй	Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш	2.2	1.85
2	Зөв төлөвшил	Нөлөөлөл	Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга	2.2	1.94
3	Зөв төлөвшил	Зан үйлийн	Авлига авсан, хулгай хийсэн, хүн зодсон гэх мэт гэмт хэрэг үйлдсэн хүнийг би эрх бүхий байгууллагад нь хэлнэ.	3.1	3.10
			Бүлгийн дундаж	**2.51**	**2.29**
1	Хууль ягштал сахих	Танин мэдэхүй	Миний сайн найз шалгалтан дээрээ хуулж болно. Энэ буруу зүйл биш	4.42	3.61

2	Хууль ягштал сахих	Нөлөөлөл	Төрийн албан хаагч үйлчилгээ үзүүлснийхээ төлөө хариу шан харамж хүсэж болно	3.4	2.96
3	Хууль ягштал сахих	Зан үйлийн	Ойр хавьд цагдаа байхгүй тохиолдолд би хууль, дүрэм зөрчиж болно.	2.8	1.98
			Бүлгийн дундаж	**3.54**	**2.85**
1	Авлигыг үл тэвчих	Танин мэдэхүй	Миний амьдралд сайнаар нөлөөлж байвал томчууд хууль зөрчиж болно. Энэ бол буруу зүйл биш	2.7	2.34
2	Авлигыг үл тэвчих	Нөлөөлөл	Шалгалтандаа хуулсан л бол сайн найз байсан ч энэ тухай би багш, эцэг, эх, ах эгчдээ хэлнэ.	6.71	6.23
3	Авлигыг үл тэвчих	Зан үйлийн	Манай аав ээж, ах эгч төрийн байгууллагад ажилладаг. Тэд албан тушаалаа ашиглан баян болох нь буруу зүйл биш	2.9	2.97
			Бүлгийн дундаж	**4.1**	**3.84**

4.3 Хүүхдийн ёс суртахууны үнэлгээ (2012 он)

Хүүхдийн шударга байдал 2012 оны судалгаанд оролцсон хүүхдүүдийн ёс суртахууны үнэлгээг ёс суртахууны талаарх ойлголт, ёс зүй, суртахуунд нөлөөлөх нөлөөлөл, одоо тус дэд үзүүлэлт ямар түвшинд байгааг дараах гурван асуудалтай санал нийлж буй эсэхээр тодорхойлсон.

- Ёс суртахууны талаарх танин мэдэхүйг нь - Сурагчид гэрийн даалгавар хийхдээ интернет болон бусад хүмүүсийн бичсэн нийтлэлийг шууд өөрөө бичсэн мэт ашиглах нь буруу зүйл биш.
- Ёс суртахуунд нөлөөлөх нөлөөллийг - Баян байх нь шударга байхаас илүү чухал зүйл.
- Ёс суртахууны зан үйл нь - Урт дараалалд хүлээж байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээнэ.

Хүүхдүүдийн өнөөдрийн ёс суртахууны төлөв байдал, ёс зүйн байдлын хэм хэмжээ, стандарт ямар байгаад үнэлгээ өгч байгаа тус бүлгийн дундаж үнэлгээ 2.73 байна. 2010 оны судалгаатай харьцуулахад 0.3 хувиар буурсан. (Зураг 9)

Зураг 9. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ



Нийслэлийн хүүхдүүд (2.84) орон нутагт оршин суудаг хүүхдүүдээс (2.59) ёс зүйн, ёс суртахуун 0.25 пунктээр, эрэгтэй хүүхдүүд (2.99) эмэгтэй хүүхдүүдээс (2.52) 0.47 пунктээр тус тус өндөртэй байна (Зураг 10, 11).

Зураг 10. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ (байршлаар)





Зураг 11. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ (хүйсээр)

Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ 11 наснаас (1.50) бага багаар дээшилсээр 18 насанд (3.34) болжээ. (хүснэгт 12)

Зураг 12. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлт (насны ангилалаар)



Хүүхдүүдийн ёс зүйн хэм хэмжээ ямар байгааг харуулж буй тус дэд үзүүлэлтийн үнэлгээг хүүхдүүдийн сурч буй ангиар авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд: Хамгийн доогуур үнэлгээ 8 ба 9 ангид (2.35, 2.22), хамгийн дээд үнэлгээ 10 ангид (2.97) байж байгаад 11 дүгээр ангид доошилж 2.74 болжээ. (хүснэгт 13)

Зураг 13. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ (суралцаж буй ангиар)



4.4 Хүүхдийн зөв төлөвшлийн үнэлгээ (2012 он)

Хүүхдийн шударга байдал 2012 оны судалгаанд оролцсон хүүхдүүдийн зөв төлөвшлийн үнэлгээг хүүхдүүдийн зөв буруу ялгах байдал, нөлөөлөх нөлөөлөл, хэрхэн илэрч байгааг дараах гурван асуудалтай санал нийлж буй эсэхээр тодорхойлсон.

- Зөв төлөвшлийг танин мэдэхүй нь - Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш.
- Зөв төлөвшилд нөлөөлөх нөлөөллийг - Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга.
- Зөв төлөвшлийн илэрч буй зан үйл нь - Авлига авсан, хулгай хийсэн, хүн зодсон гэх мэт гэмт хэрэг үйлдсэн хүнийг би эрх бүхий байгууллагад нь хэлнэ.

Хүүхдүүдийн зөв буруу ялгаж салган ойлгох чадвар ямар байгаад үнэлгээ өгч байгаа тус бүлгийн дундаж үнэлгээ 2.3 байна. (Зураг 14) Энэ нь хүүхдүүдийн ёс суртахуун, буруу зөв сайн мууг ойлгох чадвар, нийгмээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг дагаж мөрдөх чадвар, авлигыг үл тэвчих гэсэн дэд үзүүлэлтүүд дотор хамгийн доод үнэлгээ бөгөөд хүүхдүүд өнөөдөр сайн муу, буруу зөвийг ялгах чадвар харьцангуй муу байгааг харуулж байна.

Зураг 14. Хүүдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ



Нийслэлд оршин сууж буй хүүхдүүд (2.43) орон нутагт оршин сууж буй хүүхдүүдээс 0.23 пунктээр илүүтэйгээр зөв бурууг ялган ойлгох чадварын үнэлгээ өндөр байна (Зураг 15). Зөв бурууг ялгах чадварын үнэлгээ эрэгтэй хүүхдүүд (2.36) охидоос (2.24) 0.12 пунктээр илүү гарчээ (Зураг 16).

Зураг 15. Хүүдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ (байршлаар)





Зураг 16. Хүүхдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ (насны ангилалаар)

Одоогийн хүүхдүүдийн зөв буруу, сайн мууг ялгаж салгаж ойлгох чадварыг хүүхдүүдийн насны хувьд авч үзвэл хамгийн дээд үнэлгээ 12 насныхан 2.49 байгаад доошилсоор 14 настай 2.14 болж буураад, 18 насанд 2.45 болж өссөн байна. (Зураг 17).

Зураг 17. Хүүхдийн зөв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ (насны ангилалаар)



Суралцаж буй ангиар нь авч үзвэл 8 дугаар ангид (2.01) байснаа 10, 11 дүгээр ангид 2.42 болж өссөн байна. (Зураг 18).

Зураг 18. Хүүхдийн төв төлөвшлийн дэд үзүүлэлтийн үнэлгээ (суралцаж буй ангиар)



4.5 Хүүхдүүдийн хууль, дүрэм, журам сахин биелүүлэх байдлын үнэлгээ (2012 он)

Хүүхдийн шударга байдал 2012 оны судалгаанд оролцсон хүүхдүүдийн нийгмээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг сахин биелүүлэхэд өөрсдийгөө хэрхэн хянах чадвартайг харуулж буй дэд үзүүлэлтийг хэрхэн илэрч байгааг дараах гурван асуудалтай санал нийлж буй эсэхээр тодорхойлсон.

- Хууль ягштал сахих явдлыг танин мэдэхүй нь - Миний сайн найз шалгалтан дээрээ хуулж болно. Энэ буруу зүйл биш.
- Хууль ягштал сахих явдалд нөлөөлөх нөлөөллийг - Төрийн албан хаагч үйлчилгээ үзүүлснийхээ төлөө хариу шан харамж хүсэж болно.
- Хууль ягштал сахих явдал илэрч буй зан үйл нь - Ойр хавьд цагдаа байхгүй тохиолдолд би хууль, дүрэм зөрчиж болно.

Өсвөр насныхны ихэвчлэн зан байдал төлөвшөөгүй байдаг ба олон нийтээр хүлээн зөвшөөрөн дагаж мөрдөж буй хууль, дүрэм, журмыг хүндэтгэн дагах явдлыг төлөвшүүлэх нь чухал асуудал юм. Хүүхдийн шударга байдал 2012 оны судалгааны үр дүнгээр энэхүү хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг хүүхдүүд дагаж мөрдөх, өөрсдийгөө хянах чадварыг илтгэх тус дэд үзүүлэлтийн бүлгийн дундаж үнэлгээ 2.85 байна. (Зураг 19) Хүүхдийн шударга байдал 2010 оны судалгаатай харьцуулахад хүүхдүүдийн хууль, дүрэм, журам сахих үнэлгээ бусад дэд үзүүлэлтүүдийн үнэлгээнээс хамгийн их хувиар буюу 0.68%-аар буурчээ.

Зураг 19. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ



Нийслэлд оршин сууж буй хүүхдүүд (3.11) орон нутагт амьдарч байгаа хүүхдүүдээс (2.65) 0.46 пунктээр хууль сахих чадвар өндөр байна. (Зураг 20)

Эрэгтэй хүүхдүүд (3.40) охидоос (2.73) 0.67 пунктээр илүү хууль, дүрэм, журам сахих чадвартай байна (Зураг 21).

Зураг 20. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ (байршлаар)



Зураг 21. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ (хүйсээр)



Хүүхдүүдийн насны хувьд тус дэд үзүүлэлтийг аваад үзвэл хамгийн доод үнэлгээ 13, 14 настай (2.66), хамгийн дээд үнэлгээ 15, 16 насанд буюу 3.05 тус тус байна. (хүснэгт 22)

Зураг 22. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ (насны ангиллаар)



Тус дэд үзүүлэлтийн үнэлгээг хүүхдүүдийн суралцаж буй ангиар авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд: 7 дугаар ангиас (2.79) буурч 10 ангид (3.30) болж өсөөд 11 ангид 2.84 болж 0.46 пунктээр буурсан байна. (хүснэгт 23)

Зураг 23. Хүүхдийн хууль ягштал сахих чадварын дэд үзүүлэлтийн үнэлгээ (суралцаж буй ангиар)



4.6 Авлигыг (үл) тэвчих байдлын үнэлгээ (2012 он)

Хүүхдийн шударга байдал 2010 оны судалгаанд оролцсон хүүхдүүдийн авлигын гэмт хэргийг үл тэвчих чадварыг хэмжих дэд үзүүлэлтийг дараахь гурван асуудалтай санал нийлж буй эсэхээр тодорхойлсон.

- Авлигыг үл тэвчих явдлыг танин мэдэхүй нь - Миний амьдралд сайнаар нөлөөлж байвал томчууд хууль зөрчиж болно. Энэ бол буруу зүйл биш.
- Авлигыг үл тэвчих явдалд нөлөөлөх нөлөөллийг - Шалгалтандаа хуулсан л бол сайн найз байсан ч энэ тухай би багш, эцэг, эх, ах эгчдээ хэлнэ..
- Авлигыг үл тэвчих явдлын илэрч буй зан үйл нь - Манай аав ээж, ах эгч төрийн байгууллагад ажилладаг. Тэд албан тушаалаа ашиглан баян болох нь буруу зүйл биш

Хүүхдүүдийн авлигын гэмт хэргийг үл тэвчих явдлыг илэрхийлэх дэд үзүүлэлийн бүлгийн дундаж үнэлгээ 3.85 гарсан. (Зураг 24) Хүүхдүүдийн авлигыг үл тэвчих байдлын үнэлгээ бусад дэд үзүүлэлтүүдийн үнэлгээнээс хамгийн их хувиар буюу 0.68%-аар буурсан. Гэвч хүүхдийн суртахуун, зөв төлөвшил, хууль ягштал сахих дэд үзүүлэлтээс өндөр байна.

Зураг 24. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ



Нийслэлд оршин суудаг хүүхдүүд (4.21) орон нутаг оршин суудаг хүүхдүүдээс (3.60) илүүтэйгээр авлигыг үл тэвчих явдал 0.61 пүнктээр өндөр байна. (Зураг 25) Хүүхдүүдийн аливаа гэмт хэрэг шударга бус явдлыг үл тэвчих явдалд эрэгтэй хүүхдүүд (4.0) охидоос (3.72) 0.28 пунктээр өндөр чадвартай байна (Зураг 26).

Зураг 25. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ (байршлаар)



Зураг 26. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ (хүйсээр)



Хүүхдүүдийн авлигыг үл тэвчих чадварыг насны хувьд авч үзвэл 11 наснаас (3.11) бага багаар 17 нас хүртэл (4.31) тогтворгүй өсч байгаад 18 насанд 3.90 болж буурчээ. (Зураг 27).

Зураг 27. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ (насны ангилалаар)



Тус дэд үзүүлэлтийг хүүхдүүдийн суралцаж буй ангиар авч үзвэл анги ахих тутам хүүхдүүд аливаа гэмт хэргийг үл тэвчих чадвар дээшилж байна (Зураг 28).

Зураг 28. Хүүхдийн авлигыг үл тэвчих явдлын дэд үзүүлэлтийн үнэлгээ (суралцаж буй ангиар)



5. Дүгнэлт

“Ирээдүйд бид авлигатай амжилттай тэмцэхийн тулд өнөөдөр урьдчилан сэргийлэх хэрэгтэй, шударга ёсны хүмүүжил бол ёс зүйн маш нарийн эмзэг асуудал” гэж анхлан санаачлагч Транспаренси-Кореа байгууллага үзэж энэхүү судалгааны ажлыг эхлүүлсэн.

Хүүхдүүдийн шударга байдлын түвшингийн ерөнхий үнэлгээ 2.93 гарсан бөгөөд 2010 оны үнэлгээнээс 0.36 пунктээр буурсан байна. Бүх дэд үзүүлэлтийн үнэлгээ буурсан, орон нутагт оршин сууж буй хүүхдүүдийн ёс суртахууны байдал, зөв бурууг ойлгох явдал, хууль, дүрэм журам сахин биелүүлэх чадвар, авлигыг үл тэвчих зэрэгт нийслэлд оршин сууж буй хүүхдүүдээс, түүнчлэн охид хөвгүүдээс тус тус доогуур гарлаа.

Өнөөгийн хүүхдүүдийн ёс суртахууны үнэлгээ, ёс суртахууны талаархи ойлголт, ёс зүйн хэм хэмжээ, стандарт, сайн муу буруу зөвийг ялгаж салгаж ойлгох чадвар, нийгмээр хүлээн зөвшөөрөн сахиж биелүүлэх хууль дүрэм журмыг сахин биелүүлэх хүүхдүүдийн чадвар, авлигыг үл тэвчих зэрэг дэд үзүүлэлтээс хүүхдүүд сайн муу, буруу зөвийг ялгах чадвар хамгийн доогуур үнэлгээтэй байна. Авлигын гэмт хэргийг үл тэвчих дэд үзүүлэлтийн үнэлгээ бусад дэд үзүүлэлтийн үнэлгээтэй харьцуулахад хамгийн өндөр байлаа.

УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН 2012 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН 2012 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ӨМНӨХ ҮГ

Монгол Улс Мянганы хөгжлийн зорилтын 24 дэх зорилтод “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх” гэж дэвшүүлсэн бөгөөд УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоолоор энэхүү зорилтын хэрэгжилтийг үнэлэх шалгууруар “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөлөл” гэсэн үзүүлэлтийг тодорхойлон, холбогдох судалгааг явуулж, үр дүнг гаргаж мэдээлэх үүргийг Авлигатай тэмцэх газарт даалгасан юм.

Энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор “Мянганы хөгжлийн 9 дэх зорилтод дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн багийн боловсруулсан арга зүйн дагуу Авлигатай тэмцэх газраас “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөлөл”-ийн судалгааг тав дахь жилдээ явуулан үр дүнг нэгтгэн гаргаж Та бүхэнд хүргэж байна.

Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаанд хууль тогтоох байгууллага, эрдэм шинжилгээ, судалгаа, хэвлэл, мэдээлэл, бизнесийн, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл 13 шинжээчийг, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаанд хууль хяналтын, иргэний нийгмийн болон судалгаа шинжилгээний зэрэг байгууллагын төлөөлөл 13 шинжээчийг тус тус сонгож оролцууллаа. Тооны хувьд цөөн боловч чанарын хувьд өргөн хүрээтэй мэдлэг, мэдээлэл бүхий шинжээчдийг оролцуулсан нь нөхцөл байдлыг илүү бодитойгоор үнэлэх, дүгнэх боломжийг бүрдүүллээ. Энэхүү судалгаанд хамрагдаж, үнэтэй мэдээлэл өгсөн шинжээч нартаа талархал илэрхийлье.

Тус судалгааг таван жил дараалан явуулснаар улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын цар хүрээ, тархалт, эрсдэл, шалтгаан, нөхцөл, төрөл хэлбэрийн өөрчлөлт, хандлагыг тодорхойлон үнэлэлт, дүгнэлт өгөх боломжийг нэмэгдүүлж байгаагийн зэрэгцээ шинжээчдийн зүгээс өгсөн авлигыг бууруулах чиглэлээр нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааны үнэлгээний талаар өргөн хүрээтэй мэдээллийг Та бүхэн тайлангаас олж унших бөгөөд цаашдын үйл ажиллагаандаа уг тайланг ашиглана гэдэгт итгэж байна.

Судалгааны арга зүй, зохион байгуулалт, тайлантай холбоотой бүхий л асуудлаар бидэнд санал, шүүмжлэлээ харамгүй ирүүлэн, хамтран ажиллаж, цаашдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ гэдэгт найдаж байна.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮН КОМИССАР Н.ГАНБОЛД

1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

1.1. Судалгааны үндэслэл, зорилго

Монгол Улсын Их хурлаас 2005 онд Мянганы хөгжлийн зорилтуудыг батлахдаа үндсэн найман зорилгоос гадна Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх, авлигын эсрэг тэмцэхэд чиглэсэн Мянганы хөгжлийн 9 дэх зорилгыг нэмж баталсан билээ.

Энэхүү зорилгын хүрээнд "Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх" гэсэн 24 дэх зорилтыг дэвшүүлсэн бөгөөд УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоолоор энэхүү зорилтын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтээр "Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөлөл" гэсэн үзүүлэлтийг тодорхойлж, холбогдох судалгааг явуулж, үр дүнг гаргаж мэдээлэх үүргийг Авлигатай тэмцэх газарт даалгасан болно.

Энэ чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор "Мянганы хөгжлийн 9 дэх зорилгод дэмжлэг үзүүлэх төсөл"-ийн багийн боловсруулсан арга зүйн дагуу Авлигатай тэмцэх газраас "Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөлөл"-ийн судалгааг тав дахь жилдээ явуулан үр дүнг нэгтгэн гаргалаа.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа нь улс төрийн болон хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг шинжээчдийн үнэлгээгээр тодорхойлж, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлж дүгнэхэд шаардлагатай мэдээллийг өгөх ач холбогдолтой судалгаа юм.

1.2. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт, түүнийг тооцсон арга зүй

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт нь дараах агуулгыг илэрхийлэх тоон үзүүлэлтүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Авлигын цар хүрээ, тархалт;
- Авлигад өртөх эрсдэл бүхий түвшин, салбар, байгууллага;
- Авлигын шалтгаан, нөхцөл;
- Авлигын төрөл, хэлбэр, хэмжээ.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийг "Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн судалгаа"-ны дүнд үндэслэн тооцсон.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн үзүүлэлтийн үнэлгээг гаргахдаа, бүрдүүлэгч дэд үзүүлэлт тус бүрийн үнэлгээг 5 онооны хэмжээсээр гаргаж (1-огт үгүй, 5-маш их), дэд үзүүлэлтүүдийн энгийн арифметикийн дунджаар тооцсон болно.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийг: улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт; хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт гэсэн байдлаар тус тусад нь тооцов.

Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийг 7 бүлэг, 42 дэд үзүүлэлтээр, Хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийг 6 бүлэг, 30 дэд үзүүлэлтээр тодорхойлов.

1.3. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн үзүүлэлт, судалгааны хамрах хүрээ

Судалгааны явцад *Улс төрийн хүрээ* гэдэгт бүх шатны сонгуулийн үр дүнд байгуулагдсан байгууллага, албан тушаалтан, төрийн өндөр, дээд албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой нийгмийн харилцааг авч үзсэн бол *Хууль, хяналтын байгууллагын хүрээ* гэдэгт шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийгмийн харилцааг авч үзсэн болно.

Судалгаанд оролцох шинжээчдийг сонгохдоо улс төрийн болон хууль хяналтын байгууллагад ажилласан туршлага, тухайн хүрээний талаарх мэдээ, мэдээлэлтэй ажиллаж буй эсэх, тэдгээрт тулгуурласан судалгаа дүн шинжилгээний ажил хийдэг эсэх, түүнчлэн өмнөх судалгаанд оролцож байсан эсэх зэрэг шалгуурыг харгалзан үзсэн болно. Энэ удаагийн судалгаанд улс төрийн хүрээг үнэлэх 13, хууль хяналтын байгууллагын хүрээг үнэлэх 13, нийт 26 шинжээч оролцов.

2. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2.1. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт (үнэлгээ)-ийн ерөнхий үр дүн

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн 2012 оны үнэлгээ 3.93 (1-огт үгүй, 5-маш их) болж, 2011 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад 0.14 пунктээр буурсан байна. Энэ нь улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлига түгээмэл байгаа хэдий ч төсөөллийн түвшин буурсан болохыг харуулж байна (Зураг 1).

Зураг 1. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн үнэлгээ, оноор



Үзүүлэлт бүрээр авч үзвэл улс төрийн хүрээний авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн үнэлгээ 2012 онд 4.16 болж өмнөх оныхоос 0.02 пунктээр өссөн бол хууль хяналтын байгууллага дахь авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн үнэлгээ 3.58 болж өмнөх оныхоос 0.37 пунктээр буурсан байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн хүрээний авлигын үнэлгээний түвшин өмнөх онтой харьцуулахад нэмэгдэж илүү түгээмэл болсон байхад хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига түвшин буурсан байгааг харуулж байна (Зураг 2). Мөн улс төрийн хүрээний авлигын талаарх төсөөллийн үнэлгээний түвшин 2009-2012 оны дунджаар 4.17 гарсан нь хууль

хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үнэлгээнийхээс 0.37 пунктээр өндөр буюу улс төрийн хүрээний авлига, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигаас илүү түгээмэл байгааг илэрхийлж байна.

Зураг 2. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн үнэлгээ, оноор



2.2. "Улс төрийн хүрээний авлигын талаарх шинжээчдийн төсөөлөл"- ийн судалгааны дүн

Авлигад өртөмтгий байдлын үнэлгээ

Улс төрийн хүрээн дэх авлигад өртөмтгий байдлын үнэлгээгээр Засгийн газар, яам, төрийн бусад байгууллага 4.25 (1-огт үгүй, 5-маш их), бүх шатны Засаг дарга, Засаг даргын Тамгын газар 4.08, улс төрийн намууд 3.69, нутгийн өөрөө удирдах байгууллага буюу аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, баг, хорооны ИНХ 3.67, Улсын Их хурал 3.27 гэж үнэлэгджээ. Эдгээр улс төрийн институцуудын авлигад өртөмтгий байдлын дундаж үнэлгээ 2012 онд 3.52 гарч өмнөх оныхоос 0.30 пунктээр буурсан нь авлигад өртөмтгий байдлын төсөөллийн түвшин буурсан болохыг харуулж байна.

Авлигад өртөмтгий байдлын 2012 оны үнэлгээ өмнөх оныхоос Засгийн газар, яам, төрийн бусад байгууллага, бүх шатны ИТХ болон ИНХ-ын хувьд 0.12-0.25 пунктээр нэмэгдсэн бол Улсын Их хурал, улс төрийн намуудын хувьд 0.48-0.58 пунктээр буурчээ. Харин бүх шатны Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын авлигад өртөмтгий байдлын үнэлгээ өмнөх оны түвшинд байна (Хүснэгт1).

Хүснэгт 1. Авлигад өртөмтгий байдлын үнэлгээ, оноор

	2008	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Засгийн газар, яам, төрийн бусад байгууллага	4.38	4.29	4.40	4.00	4.25	0.25
Бүх шатны Засаг дарга, Засаг даргын Тамгын газар	4.14	4.23	3.83	4.08	4.08	0.00
Улс төрийн намууд	4.36	3.92	4.00	4.27	3.69	-0.58

Нутгийн өөрөө удирдах байгууллага /Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, баг, хорооны ИНХ/	3.77	3.62	3.25	3.55	3.67	0.12
Улсын Их хурал	3.71	4.46	4.00	3.75	3.27	-0.48
Ерөнхийлөгч	-	2.91	3.75	3.27	2.18	-1.09
Дундаж	**4.07**	**3.91**	**3.87**	**3.82**	**3.52**	**-0.30**

Албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Авлигад өртөмтгий байдлын үнэлгээ өндөр байгаа төрийн захиргааны байгууллага дахь албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдлийг албан тушаалын түвшингээр нь авч үзвэл 2012 оны байдлаар төрийн захиргааны байгууллагын удирдлагын буюу сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарын түвшинд

4.17 гэсэн үнэлгээтэй буюу авлигад өртөх эрсдэл хамгийн өндөр байгаа бол төрийн захиргааны байгууллагын дунд шатны албан хаагчдын буюу яам, агентлагийн газар, хэлтсийн болон салбар нэгжийн удирдлагуудын түвшинд 3.46 гэсэн үнэлгээтэй байна (Зураг 2). Албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ өмнөх оныхоос төрийн захиргааны байгууллагын удирдлагын түвшинд

0.09 пунктээр өссөн бол төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх, туслах албан хаагчийнх 0.81 пункт, төрийн байгууллагын захиргааны байгууллагын дунд шатны албан хаагчийнх 0.77 пункт, төрийн үйлчилгээний албан хаагчийнх 0.55 пунктээр буурчээ.

Зураг 3. Төрийн байгууллагын холбогдох албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ, оноор



Авлигыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийн үнэлгээ

Улс төрийн хүрээн дэх авлигыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийн үнэлгээгээр нам доторх болон төрийн албан дахь улс төрийн томилгоо, улс төрийн хүрээн дэх бизнесийн бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчлийн үнэлгээ тус бүр (4.69), намын санхүүжилтийн механизм (4.58), сонгуулийн санхүүжилтийн механизм (4.23), УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил (4.08) зэрэг хүчин зүйлс хүчтэй нөлөөлж байна (Хүснэгт 2). Гэхдээ улс төрийн хүрээн дэх авлигыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлийн үнэлгээний дундаж түвшин өмнөх оныхоос 0.01 пунктээр буурахад сонгуулийн санхүүжилтийн механизм өмнөх оныхоос 0.27 пункт, УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчлийнх 0.17 пунктээр тус тус буурсан нь нөлөөлжээ.

Хүснэгт 2. Улс төрийн хүрээн дэх авлигыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийн үнэлгээ, оноор

Хүчин зүйлс	2008	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Улс төрийн томилгоо (нам дотор болон төрийн албанд)	4.71	4.80	4.42	4.46	4.69	0.23
Улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил	-	-	4.75	4.69	4.69	0.00
Намын санхүүжилтийн механизм	4.57	4.40	4.25	4.38	4.58	0.20
Сонгуулийн санхүүжилтийн механизм	4.50	4.20	4.42	4.50	4.23	-0.27
УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.79	4.30	3.83	4.33	4.08	-0.25
ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.79	3.90	3.50	4.00	3.83	-0.17
Одоогийн сонгуулийн тогтолцоо	4.14	4.10	3.83	3.45	3.64	0.18
Дундаж	**4.25**	**4.28**	**4.14**	**4.26**	**4.25**	**-0.01**

Улс төрийн хүрээнд өөрт болон бусдад ашигтай давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахын тулд хийдэг үйлдлийн давтамжийн үнэлгээ

Улс төрийн хүрээнд өөрт болон бусдад ашигтай давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахдаа хийдэг үйлдлийн давтамжийн үнэлгээний дундаж түвшин 2012 онд 4.09 болж өмнөх оныхоос 0.24 пунктээр нэмэгдэж эдгээр үйлдлийг ашиглах давтамж өссөн байна. Үйлдэл тус бүрээр авч үзвэл шийдвэр гаргуулахдаа мөнгө /хөрөнгө/ өгөх (давтамжийн үнэлгээ 4.67), бэлэг өгөх (4.58), олсон ашиг, орлогоо хуваахаар амлах (4.54), гадаад арга хэмжээний зардал даах (4.45) зэрэг үйлдлийг харьцангуй олон давтамжтайгаар ашигладаг байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Улс төрийн хүрээнд өөрт болон бусдад ашигтай давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахдаа хийдэг үйлдлийн давтамжийн үнэлгээ, оноор

Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Мөнгө /хөрөнгө/ өгөх	4.07	4.70	4.42	4.15	4.67	0.52
Бэлэг өгөх	3.73	4.70	4.45	4.00	4.58	0.58
Олсон ашиг, орлогоо хуваахаар амлах	3.80	4.20	4.36	4.00	4.54	0.54
Гадаад арга хэмжээний зардал даах	-	3.80	4.33	4.08	4.45	0.37
Аялал, жуулчлалын зардал даах	3.33	3.90	4.09	4.08	4.36	0.28
Баяр ёслолын үеэр өндөр үнэтэй бэлэг өөрт нь өгөх, авах	-	4.30	4.11	3.83	4.33	0.50
Албан тушаалд томилох	-	4.40	4.67	4.38	4.23	-0.15
Гэр бүлийнхэнд нь өндөр үнэтэй бэлэг өгөх, авах	-	3.60	3.56	3.73	4.20	0.47
Өндөр цалинтай, сул ажилд оруулах	-	4.10	3.89	3.92	4.18	0.26
Сургалтын зардал даах	-	3.80	3.83	3.77	4.10	0.33
Өрийг нь төлөх	-	2.80	3.45	3.22	4.00	0.78
Хэн нэгэнд зориулж ажлын байр шинээр бий болгох	-	4.00	4.00	4.00	3.77	-0.23
Эмчилгээ, сувилгааны зардал даах	-	3.60	3.82	3.60	3.75	0.15
Гадаадын банкинд данс нээж өгөх /мөнгө өгөх/	-	2.90	3.63	3.33	3.75	0.42
Хувьцаа өгөх	-	2.70	3.33	3.36	3.67	0.31
Төрийн одон, медаль, салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнах	-	3.80	4.36	4.25	3.50	-0.75
Өндөр бооцоо тавьж тоглоомд санаатайгаар хожигдох	-	3.50	3.56	3.80	3.50	-0.30
Дундаж	**3.73**	**3.81**	**3.99**	**3.85**	**4.09**	**0.24**

Улс төрчид өөрсдийн сонирхлоор болон бусдын захиалгаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд оролцож нөлөөлөх үйлдлийн тархцын үнэлгээ

Улс төрчид өөрсдийн сонирхлоор болон бусдын захиалгаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд оролцож нөлөөлөхдөө түгээмэл хэрэглэдэг үйлдлийн тархцыг шинжээчдийн төсөөллөөр үнэлсэн бөгөөд албан тушаалтны зөрчлийг илрүүлж, түүгээр нь дарамтлах (тархцын үнэлгээ 4.17), бусдын хооронд зуучлах нэрийдлээр мөнгө нэхэх (4.10) зэрэг үйлдэл түгээмэл байна. Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд оролцож нөлөөлөх үйлдлүүдийн тархцын дундаж үнэлгээ 2012 онд 3.89 болж 2011 оныхоос 0.04 пунктээр өссөн байна (Хүснэгт 4).

Хүснэгт 3 болон 4-т гарсан судалгааны үр дүнгээр улс төрийн хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаас нөлөөлөх байдал нэмэгдсэн болохыг харуулж байна.

Хүснэгт 4. Улс төрчид өөрсдийн сонирхлоор болон бусдын захиалгаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд оролцож нөлөөлөх үйлдлийн тархцын үнэлгээ, оноор

Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Албан тушаалтны зөрчлийг илрүүлж түүгээр нь дарамтлах	-	4.40	4.09	4.00	4.17	0.17
Бусдын хооронд зуучлах нэрийдлээр мөнгө нэхэх	-	3.90	3.70	3.75	4.10	0.35
Хууль бус шаардлага тавих	-	3.60	3.67	3.92	3.92	0.01
Хууль бусаар дотоод үйл ажиллагаанд нь оролцох	-	3.70	3.67	3.91	3.82	-0.09
Шан харамж нэхэх	3.43	3.90	3.27	3.50	3.70	0.20
Дарамт шахалт үзүүлэх /ажлаас нь хална, арга хэмжээ авна г.м./	3.64	4.00	3.83	4.00	3.62	-0.38
Дундаж	**3.54**	**3.92**	**3.71**	**3.85**	**3.89**	**0.04**

Улс төрчдийн зүгээс төрийн зарим үйл ажиллагаанд нөлөөлж буй үйл ажиллагааны давтамжийн үнэлгээ

Шинжээчдийн үзсэнээр улс төрчдийн зүгээс 2012 онд төрийн зарим үйлчилгээг давуу байдлаар хүртэх, ажил, албан тушаалын томилгоонд нөлөөлөх, шүүх, хяналтын байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх зэрэг нөлөөлөл их байсан байна. Улс төрчдийн зүгээс төрийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх давтамжийн дундаж үнэлгээ 2012 онд 4.22 болж өмнөх оноос 0.21 пунктээр буурсан боловч төрийн үйлчилгээг давуу байдлаар хүртэх хэлбэрийн үнэлгээ 0.27 пунктээр өсчээ. Татвартай холбогдох асуудлыг хувийн ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэрлүүлэх нөлөөллийн үнэлгээ 0.43 пункт, хэрэг бүртгэх, мөрдөн байцах үйл ажиллагаанд нөлөөлөх зэрэг нөлөөлөл 0.41 пунктээр буурсан нь хамгийн их бууралт болсон байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Улс төрчдийн төрийн байгууллагын зарим үйл ажиллагаанд нөлөөлж буй давтамжийн үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Төрийн үйлчилгээг давуу байдлаар хүртэх	4.00	4.30	4.36	4.15	4.42	0.27
Ажил, албан тушаалд томилох ажиллагаанд нөлөөлөх	4.79	4.60	4.64	4.67	4.38	-0.29
Хяналтын байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх	3.79	4.00	4.27	4.50	4.33	-0.17
Шүүхийн үйл ажиллагаанд нөлөөлөх	3.67	3.90	4.20	4.50	4.27	-0.23
Хууль, эрх зүйн шинжтэй шийдвэр гаргах үйл ажиллагаанд нөлөөлөх	4.00	3.90	4.18	4.33	4.27	-0.06
Тусгай зөвшөөрөл авах, сунгуулах	4.57	4.50	4.45	4.58	4.23	-0.35
Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд нөлөөлөх	4.00	4.10	4.09	4.50	4.09	-0.41
Татварын асуудлыг явцуу ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэрлүүлэх	3.47	3.60	4.56	4.18	3.75	-0.43
Дундаж	**4.04**	**4.11**	**4.34**	**4.43**	**4.22**	**-0.21**

Улс төрийн хүрээний авлига голлон чиглэгдэж буй үйл ажиллагааны үнэлгээ

Улс төрийн хүрээний авлига голлон чиглэгдэж буй үйл ажиллагааны үнэлгээний дундаж 3.40 болж өмнөх оныхоос 0.13 пунктээр буурчээ. Энэ бууралтад бизнест эрх мэдлээ тогтоох 0.27, дэд бүтцийн бүтээн байгуулалт 0.15 пунктээр өссөн ч хэвлэл мэдээллийн хэрэгсэл 0.87, уул уурхай 0.21, өмч хувьчлал 0.20 пунктээр тус тус буурсан нь нөлөөлжээ. Улс төрийн хүрээний авлига хамгийн их чиглэгдэж буй байдлаар нь авч үзвэл дэд бүтцийн бүтээн байгуулалт (4.45), уул уурхайн салбар (4.33), намд эрх мэдлээ тогтоох (4.20), бизнест эрх мэдлээ тогтоох (4.18), орон сууц, барилга байгууламж барих (4.08), өмч хувьчлах үйл ажиллагаа болон гадаадын хөрөнгө оруулалт (4.00) зэрэг үйл ажиллагаа болж байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Холбогдох үйл ажиллагаануудад улс төрийн хүрээний авлига чиглэгдэж буй байдлын үнэлгээ, оноор

Үзүүлэлт / үнэлгээ	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Дэд бүтцийн бүтээн байгуулалт	4.50	4.17	4.30	4.45	0.15
Уул уурхайн салбар	4.67	4.42	4.54	4.33	-0.21
Намд эрх мэдлээ тогтоох	4.55	4.42	4.33	4.20	-0.13
Бизнест эрх мэдлээ тогтоох	4.27	4.45	3.92	4.18	0.27
Орон сууц, барилга байгууламж барихад	4.08	3.92	4.23	4.08	-0.15
Өмч хувьчлал	3.73	4.10	4.20	4.00	-0.20
Гадаадын хөрөнгө оруулалт	3.82	3.92	4.17	4.00	-0.17
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	4.38	4.27	4.54	3.67	-0.87
Газар тариалан	3.60	3.00	3.25	3.40	0.15
Дундаж	**4.18**	**4.07**	**4.16**	**4.04**	**-0.13**

Авлигын хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

Улс төрийн хүрээнд 2012 онд улс төрийн зорилгоор хууль бус хандив өргөх, авах, (тархцын үнэлгээ 4.50), намд хандив авах (4.50), ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулахаар лоббидох (4.50), төсвийн мөнгийг зориулалтын бусаар, өөрийн ашиг сонирхлоор зарцуулах (4.17), өөрийн өмчийн компани, аж ахуйн нэгжид давуу байдал бий болгох (4.15), өөрийн эрх мэдлээ худалдах (4.09) зэрэг авлигын хэлбэрүүд илүү өргөн тархсан гэж шинжээчид үзжээ (Хүснэгт 7). Харин 2011 онд мөнгө угаах, намд хандив авах, улс төрийн зорилгоор хууль бус хандив өгөх, авах, бизнесийн бүлэглэлийн нөлөөнд автах, тэдний төлөө үйлчилж хууль санаачлан батлуулах, сонгогчдын саналыг худалдан авах зэрэг хэлбэрүүд илүү өргөн тархсан байжээ. Улс төрийн хүрээн дэх авлигын хэлбэрүүдийн тархцын дундаж үнэлгээ өмнөх оныхоос 0.13 пунктээр буурсан нь дээрх авлигын хэлбэрүүдийн тархац буусан болохыг харуулж байна. Энэ бууралтад нь мөнгө угаахтай холбоотой авлигын хэлбэрийн үнэлгээ 1.07 пунктээр буурсан нь голлон нөлөөлжээ.

Сүүлийн дөрвөн жилийн хугацаан дахь ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулахаар лоббидох авлигын хэлбэрийн үнэлгээний дундаж хамгийн өндөр буюу 4.46 байна. Үүний дараа улс төрийн зорилгоор хууль бус хандив өргөх, авах авлигын хэлбэр болон намд хандив авах авлигын хэлбэрүүд 4.45 дундаж үнэлгээтэй байна. Сонгогчдын саналыг худалдан авах авлигын хэлбэр 4.35, бизнесийн бүлэглэлийн нөлөөнд автах, тэдний төлөө үйлчилж хууль санаачлан батлуулах авлигын хэлбэр 4.32 гэсэн дундаж үнэлгээтэй байна. Хууль бусаар

дампууруулах хэлбэрийн үнэлгээ 2009-2012 оны дунджаар хамгийн бага буюу 3.60 байлаа.

Хүснэгт 7. Улс төрийн хүрээн дэх авлигын хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Улс төрийн зорилгоор хууль бус хандив өгөх, авах	4.42	4.50	4.38	4.50	0.12
Ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулахаар лоббидох	4.54	4.58	4.23	4.50	0.27
Намд хандив авах	4.42	4.25	4.62	4.50	-0.12
Төсвийн мөнгийг зориулалтын бусаар, өөрийн ашиг сонирхлоор зарцуулах	4.15	4.36	4.08	4.17	0.09
Өөрийн өмчийн компани, аж ахуйн нэгжид давуу байдал бий болгох	4.46	3.25	4.15	4.15	0.00
Өөрийн эрх мэдлээ худалдах	4.00	4.17	3.91	4.09	0.18
Бизнесийн бүлэглэлийн нөлөөнд автах, тэдний төлөө үйлчилж хууль санаачлан батлуулах	4.33	4.64	4.33	4.00	-0.33
Төрийн өмчийг шамшигдуулах, хувьдаа завших	4.00	4.00	4.08	3.92	-0.17
Сонгогчдын саналыг худалдан авах	4.69	4.50	4.31	3.91	-0.40
Хувийн байгууллага, санд хандив авах	3.75	3.64	3.73	3.90	0.17
Мөнгө угаах	4.00	3.80	4.67	3.60	-1.07
Хууль бусаар дампууруулах	3.56	3.56	3.78	3.50	-0.28
Дундаж	**4.19**	**4.10**	**4.19**	**4.06**	**-0.13**

Авлигын үед хэрэглэдэг аргуудын тархцын үнэлгээ

Улс төрийн хүрээнийхний хээл хахууль өгөх, авах аргуудын тархцыг үнэлсэн шинжээч нар үйл ажиллагааны зардал болгож өгөх, зуучлагчаар дамжуулах, эд зүйлийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах, худалдан авах, мөрийтэй тоглож, санаатай алдах, ойр дотнын хүн, тэдний гэр бүлийн гишүүд, тэдний өмчлөлийн компанид давуу байдал олгох зэрэг аргуудыг 2012 онд илүү өргөн тархалттай байна гэж үзжээ. Энэ нь 2011 оныхоос хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх, үйл ажиллагааны зардал болгож өгөх, аргуудын тархцын үнэлгээ 0.74 - 0.83 пунктээр нэмэгджээ (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Улс төрийн хүрээнийхний хээл хахууль өгөх, авах аргын тархцын үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Үйл ажиллагааны зардал болгож өгөх	3.36	4.27	3.5	4.33	0.83
Зуучлагчаар дамжуулах	4.10	4.09	4.00	4.11	0.11
Эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах	3.50	3.45	3.78	4.11	0.33
Мөрийтэй тоглож санаатай алдах	3.44	3.75	3.90	4.08	0.18
Ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдгээрийн компанид давуу байдал олгох	4.20	4.08	3.90	4.08	0.18
Хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх	4.08	4.22	3.18	3.92	0.74

Ойр дотны хүмүүсээр дамжуулах	3.89	3.75	3.75	3.90	0.15
Эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах	3.56	3.55	3.80	3.90	0.10
Шууд өөрт нь өгөх	3.45	3.8	3.33	3.67	0.34
Мөнгө зээлдүүлээд мартах	3.00	3.56	3.40	3.38	-0.03
Дундаж	**3.66**	**3.85**	**3.65**	**3.95**	**0.29**

Авлигын улмаас бий болсон хөрөнгө, орлогын зарцуулалтын хэлбэрийн тархцын үнэлгээ

Улс төрийн хүрээнийхэн авлигаар олсон хөрөнгөө ихэвчлэн орон сууц худалдан авахад, өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулахад, гадаад болон дотоодод үл хөдлөх худалдаж авахад болон зугаа цэнгэлд илүүтэй зарцуулдаг гэж шинжээчид 2012 онд үзсэн байна.

Өмнөх оны судалгааны дүнтэй харьцуулахад дотоодын банкинд хадгалах хэлбэрийн тархац 1.67 пункт, гадаадад үл хөдлөх хөрөнгө худалдаж авах хэлбэрийн тархац 1.53 пункт, гадаадын банкинд хадгалах хэлбэрийн тархац 0.86 пункт, дараагийн сонгуульд зарцуулах хэлбэрийн тархац 0.83 пунктээр нэмэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлтүүд болж байна. Хүүхдийн сургалтын төлбөрт зарцуулдаг гэсэн хэлбэрийн тархцын үнэлгээ 0.80 пунктээр буурсан нь хамгийн их бууралт болж байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Улс төрийн хүрээнийхэн авлигаар олсон хөрөнгөө зарцуулдаг хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

Хэлбэрүүд / хариулт	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Орон сууц худалдан авдаг	4.82	4.45	4.82	5.00	0.18
Өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулдаг	4.60	4.27	4.78	5.00	0.22
Гадаадад үл хөдлөх хөрөнгө худалдаж авдаг	3.40	3.44	3.25	4.78	1.53
Үл хөдлөх хөрөнгө худалдан авдаг	4.82	4.45	4.80	4.75	-0.05
Зугаа цэнгэлд зарцуулдаг	4.40	4.20	4.45	4.75	0.30
Өдөр тутмынхаа хэрэгцээнд зориулах	4.33	4.64	4.40	4.67	0.27
Дотоодын банкинд хадгалдаг	4.00	3.67	3.00	4.67	1.67
Машин худалдан авдаг	4.45	4.45	4.80	4.50	-0.30
Дараагийн сонгуульд зарцуулах	3.25	4.00	3.60	4.43	0.83
Хүүхдийнхээ сургалтын төлбөрт зориулдаг	4.60	4.82	4.80	4.00	-0.80
Гадаадын банкинд хадгалдаг	3.44	4.00	3.00	3.86	0.86
Хувьцаа худалдан авдаг	3.00	3.67	3.22	2.75	-0.47
Дундаж	**4.09**	**4.17**	**4.08**	**4.43**	**0.35**

Улс төрийн хүрээнийхний авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын хэлбэрүүдийн тархцын 2009-2012 оны 4 жилийн үнэлгээний дунджийг тооцоход орон сууц худалдан авах хэлбэрийн тархац 4.77, үл хөдлөх хөрөнгө худалдан авах хэлбэрийн тархац 4.71, өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулдаг гэсэн хэлбэрийн тархац 4.66, хүүхдийн сургалтын төлбөрт зарцуулах хэлбэр болон машин худалдан авч зарцуулдаг хэлбэрийн тархац 4.55, өдөр тутмын хэрэгцээнд зарцуулах хэлбэрийн тархац 4.51, зугаа цэнгэлд зарцуулах хэлбэрийн тархац 4.45 гэсэн дундаж үнэлгээтэй байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Үлдсэн хэлбэрүүдийн тархцын 4 жилийн үнэлгээний дундаж нь 3.16–3.83 байгаа юм. Энэ

нь авлигаар олсон хөрөнгийг нэн тэргүүнд амьдралын наад захын хэрэгцээгээ хангахад, үүнд орон сууц, автомашин, үл хөдлөх хөрөнгө худалдан авах, хүүхдийн сургалтын төлбөр төлөх, өдөр тутмын хэрэгцээгээ хангах болон зугаацаж цэнгэхэд зарцуулдаг болох нь харагдаж байна. Тархцын 4 жилийн үнэлгээний дундаж нь бага гарсан хэлбэрүүд болох дотоод, гадаадын банкинд хадгаламж болгох, гадаадад үл хөдлөх хөрөнгө худалдаж авах, хувьцаа худалдан авах, сонгуульд зарцуулах зэрэг хэлбэр нь хөрөнгө оруулалтын шинж чанартай байна.

Авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын хэлбэрүүдийн үнэлгээний хэлбэлзлийн хэмжээгээр нь авч үзвэл өдөр тутмын хэрэгцээнд зарцуулах хэлбэрийн тархцын үнэлгээний хэлбэлзэл 0.34, үл хөдлөх хөрөнгө худалдан авах хэлбэрийн тархцын үнэлгээний хэлбэлзэл 0.37 байгаа нь хамгийн бага үзүүлэлт болж байна. Эдгээрийн дараа 0.55, 0.73, 0.82 хэлбэлзэлтэй орон сууц худалдан авах, зугаа цэнгэлд зарцуулах, өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулах, хүүхдийн сургалтын төлбөрт зарцуулах гэсэн хэлбэрүүд орж байна (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Улс төрийн хүрээнийхэн авлигаар олсон хөрөнгөө зарцуулдаг хэлбэрүүдийн тархцын 2009-2012 оны үнэлгээний дундаж болон хэлбэлзэл

Хэлбэр	2009-2012 оны байдлаар			Хамгийн өндөр болон бага үзүүлэлт ийн зөрүү
	Дундаж	Хамгийн өндөр	Хамгийн бага	
Орон сууц худалдан авдаг	4.77	5.00	4.45	0.55
Үл хөдлөх хөрөнгө худалдан авдаг	4.71	4.82	4.45	0.37
Өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулдаг	4.66	5.00	4.27	0.73
Хүүхдийнхээ сургалтын төлбөрт зориулдаг	4.55	4.82	4.00	0.82
Машин худалдан авдаг	4.55	4.80	4.45	0.35
Өдөр тутмынхаа хэрэгцээнд зориулах	4.51	4.67	4.33	0.34
Зугаа цэнгэлд зарцуулдаг	4.45	4.75	4.20	0.55
Дотоодын банкинд хадгалдаг	3.83	4.67	3.00	1.67
Дараагийн сонгуульд зарцуулах	3.82	4.43	3.25	1.18
Гадаадад үл хөдлөх хөрөнгө худалдаж авдаг	3.72	4.78	3.25	1.53
Гадаадын банкинд хадгалдаг	3.57	4.00	3.00	1.00
Хувьцаа худалдан авдаг	3.16	3.67	2.75	0.92

Бизнес эрхлэгчид төрийн байгууллага, албан тушаалтантай хэлцэл хийхдээ авлигад зарцуулдаг хөрөнгийн тухайн хэлцлийн нийт үнийн дүнд эзлэх хувь

Шинжээчдийн үзэж байгаагаар 2012 онд бизнес эрхлэгчид өмч хувьчлах шийдвэр гаргуулахдаа хувьчлах хөрөнгийн үнийн дүнгийн 20.0 хувийг, төсөл, хөтөлбөрт хамрагдахдаа төсөл хөтөлбөрийн төсвийн 13.5 хувийг, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхдээ дунджаар татвар ногдох дүнгийн 13.5 хувийг, төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шалгаруулалтад ялахын тулд тендерийн дүнгийн 12.5 хувийг, өр төлбөр, иргэний нэхэмжлэлийг шийдвэрлүүлэхдээ нэхэмжлэлийн дүнгийн 12.5 хувийг, зээл авахдаа зээлийн дүнгийн 8.93 хувийг авлигатай холбоотойгоор зарцуулсан байна (Хүснэгт 11).

Судалгааны дүнг 2011 оныхтой харьцуулахад бизнес эрхлэгчид төрийн байгууллага, албан тушаалтантай хэлцэл хийхдээ авлигад зарцуулдаг хөрөнгийн

дүнгийн нийт үнийн дүнд эзлэх хувь нь өмч хувьчлах шийдвэр гаргуулахад 3.06 пункт, төсөл, хөтөлбөрт хамрагдахад 1.50 пунктээр нэмэгдэж, өр төлбөр, иргэний нэхэмжлэл шийдвэрлүүлэх, татвараас чөлөөлүүлэх, зээл авахад хувь нь буурчээ.

Хүснэгт 11. Бизнес эрхлэгчид төрийн байгууллага, албан тушаалтантай хэлцэл хийхдээ авлигад зарцуулдаг хөрөнгийн тухайн хэлцлийн нийт үнийн дүнд эзлэх хувь

Ажил үйлчилгээ / Үнийн дүнгийн хувь	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Өмч хувьчлах шийдвэр гаргуулах	15.78	15.83	16.94	20.00	3.06
Төсөл, хөтөлбөрт хамрагдахад	12.45	12.91	12.00	13.50	1.50
Татвараас чөлөөлүүлэх	15.50	11.39	15.28	13.50	-1.78
Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шалгаруулалтад ялах	16.50	13.41	12.50	12.50	0.00
Өр төлбөр, иргэний нэхэмжлэл шийдвэрлүүлэх	11.08	11.00	14.64	12.50	-2.14
Зээл авах	11.50	10.00	11.00	8.93	-2.07

Авлигын өртөг

Ажил, албан тушаалд ороход дунджаар 9.1 сая /2011 онд дунджаар 16.1 сая/ төгрөгийг, тусгай зөвшөөрөл авахад дунджаар 15.1 сая /2011 онд дунджаар 15.5 сая/ төгрөгийг, ашиг сонирхолдоо нийцсэн хууль, шийдвэр гаргуулахад дунджаар 21.1 сая төгрөгийг /2011 онд 22.1 сая/ төгрөгийг тус тус авлигад зарцуулдаг гэж шинжээчид 2012 онд үзжээ. Улс төрийн хүрээн дэх авлигын өртөг 2011 оныхоос буурсан байна.

Авлигын тархцын үнэлгээ

Төрийн байгууллагын тодорхой үйл ажиллагаанууд дахь авлигын тархцыг үнэлсэн шинжээчид 2012 онд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах (авлигын тархцын үнэлгээ 4.69), төрийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгох (4.31) зэрэг үйл ажиллагаанд авлига их тархсан гэж үзэж байна (Хүснэгт 12).

Хүснэгт 12. Төрийн байгууллагын зарим үйл ажиллагаан дахь авлигын тархцын үнэлгээ

Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах	4.80	4.54	4.75	4.54	4.69	0.15
Төрийн өмч, төсвийн хөрөнгийг захиран зарцуулах	4.27	4.38	4.42	3.67	4.58	0.92
Ажил, албан тушаалд томилох	4.53	4.46	4.50	4.31	4.38	0.08
Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажиллагаа	3.80	4.00	4.20	3.85	4.33	0.49
Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа	4.80	4.69	4.83	4.46	4.31	-0.15
Төсөл, хөтөлбөрт хамруулан хэрэгжүүлэх ажиллагаа	4.13	4.08	4.25	3.85	4.25	0.40
Өмч хувьчлал	3.87	3.82	4.50	4.00	4.00	0.00
Дундаж	**4.31**	**4.28**	**4.49**	**4.10**	**4.36**	**0.27**

Улс төр, хууль хяналтын байгууллага болон бусад бүлэглэл (дотоодын бизнесийн, гадаадын бизнесийн болон улс төрийн бүлэглэл, гэмт бүлэглэл)-ийн хоорондын харилцааны үнэлгээ

Шинжээчдийн үзэж байгаагаар улс төрийн хүрээнд улс төр, бизнесийн бүлэглэл нэгдэх, улс төрчид хууль хяналтын болон цагдаагийн байгууллагатай хууль бус ашиг сонирхлоор нийлэх, бизнесийн бүлэглэл улс төрчдийг гартаа оруулах, гаднын бизнесийн бүлэглэл улс төрчдийг гартаа оруулах, тэдэнтэй улс төрийн нам, бүлэглэл нэгдэх явдал хүчтэй болж, улс төрийн авлига далд хэлбэрт байсаар байна (Хүснэгт 13).

Хүснэгт 13. Монгол улс дахь улс төр болон бизнес, хууль хяналтын байгууллага, гэмт бүлэглэл, гадаадын улс төр, бизнесийн бүлэглэлийн хоорондын харилцааны үнэлгээ

Үзүүлэлт	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Улс төр, бизнесийн бүлэглэл нэгдсэн	4.67	4.67	4.33	4.54	0.21
Улс төрчид хууль хяналтын болон цагдаагийн байгууллагатай хууль бус ашиг сонирхлоор нийлсэн	4.08	4.50	4.54	4.50	-0.04
Улс төрийн авлига нь илүү далд хэлбэрт шилжсэн	4.67	5.00	4.23	4.23	0.00
Бизнесийн бүлэглэл улс төрчдийг гартаа оруулсан	4.69	4.50	4.69	4.20	-0.49
Гаднын бизнесийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-тэй нэгдсэн	-	-	2.0	4.00	2.00
Улс төрчид бизнесийн бүлэглэлийг гартаа оруулсан	2.23	3.50	2.83	3.60	0.77
Гадны бизнесийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг гартаа оруулсан	4.11	3.91	2.64	3.00	0.36
Улс төрийн нам /бүлэглэл/ гэмт бүлэглэл /мафи/-ийг гартаа оруулсан	2.40	2.78	2.11	2.71	0.60
Гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг гартаа оруулсан	3.18	3.73	3.00	2.27	-0.73
Гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-тай нэгдсэн	2.78	3.60	2.00	2.25	0.25
Улс төрийн нам /бүлэглэл/-ыг гэмт бүлэглэл /мафи/ гартаа оруулсан	2.80	3.40	2.83	2.00	-0.83
Монголын улс төрийн нам /бүлэглэл/ гадны бизнесийн бүлэглэлийг гартаа оруулсан	1.22	1.40	1.55	1.00	-0.55
Монголын улс төрийн нам /бүлэглэл/ гадны улс төрийн нам /бүлэглэл/-ыг гартаа оруулсан	1.20	3.00	3.20	1.00	-2.20
Дундаж	**3.17**	**3.67**	**3.07**	**3.02**	**-0.05**

Улс төрийн бүлэглэлүүдийн хүчний үнэлгээ

Монгол Улс дахь улс төрийн бүлэглэлүүдийн хүчний үнэлгээгээр 2012 онд хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нам тойрсон хүрээлэл болон бизнесийн хүрээлэл, мөн хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан нэг нутаг, нэг аймагт хамаарах этгээдүүдийн хүрээлэл эрчимтэй байна. Шинжээчдийн 2010 оны үнэлгээгээр нам

тойрсон хүрээллийн үйл ажиллагаа хүчтэй байсан бол 2011 онд буурч 2012 онд эргээд үйл ажиллагаа нь эрчимжсэн байна. Улс төрийн хүрээн дэх хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан бизнесийн хүрээлэл 2010 оноос эхлэн үйл ажиллагаа нь аажим боловч буурч байгаа нь үнэлгээгээр харагдаж байна. Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан найз нөхдийн хүрээллийн үйл ажиллагаа судалгааны нийт хугацаанд маш тогтвортой түвшинд байна. Нийтийн эрх ашгийн төлөө бий болсон хүрээллийн үйл ажиллагаа маш сул хэвээр байна (Хүснэгт 14).

Хүснэгт 14. Монгол улс дахь улс төрийн бүлэглэлүүдийн хүчний үнэлгээ

Бүлэглэл	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нам тойрсон хүрээлэл	4.31	4.75	4.08	4.46	0.38
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, бизнесийн хүрээлэл	4.42	4.58	4.31	4.15	-0.15
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нэг нутаг / аймаг/ тойрсон хүрээлэл	4.00	4.08	4.31	4.08	-0.23
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нам дамжсан хүрээлэл /намуудын нэгдэл/	4.38	4.42	4.08	4.00	-0.08
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, нэг хүнийг тойрсон хүрээлэл	3.77	4.00	3.69	3.77	0.08
Хувийн эрх ашгийг түрүүнд тавьсан, найз нөхдийн хүрээлэл	3.92	3.75	3.77	3.69	-0.08
Нийтийн эрх ашгийн төлөө бий болсон хүрээлэл	1.82	2.27	2.08	2.25	0.17
Дундаж	**3.80**	**3.98**	**3.76**	**3.77**	**0.01**

Төрийн байгууллага дахь авлигыг бий болгоход нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ

Төрийн байгууллага дахь авлигыг бий болгоход нөлөөлж буй хүчин зүйлсийг үнэлсэн шинжээчдийн үнэлгээгээр 2012 онд хуулийн хэрэгжилтэд тавих хяналт дутагдалтай, олон шат дамжлага, давхардал, төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын ур чадварын дутагдал зэрэг хүчин зүйл илүү хүчтэй нөлөөлжээ (Хүснэгт 15).

Хүснэгт 15. Төрийн байгууллага дахь авлигыг бий болгоход нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ

Үзүүлэлт	2008	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт дутагдалтай	4.40	4.15	4.75	4.46	4.69	0.23
Олон шат дамжлага, давхардал	4.33	4.54	4.75	4.31	4.54	0.23
Төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын ур чадвар дутагдалтай	4.27	4.08	4.33	4.15	4.50	0.35
Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал	4.53	4.62	4.33	4.54	4.46	-0.08
Шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг	4.67	4.38	4.58	4.00	4.38	0.38

Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих төсвийн ерөнхийлөн захирагчид тавих хяналт сул	4.00	4.17	4.58	4.23	4.38	0.15
Хүнд суртал	4.47	4.75	4.67	4.00	4.38	0.38
Төрийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй, шударга бус байдал	3.73	4.38	4.58	4.08	4.33	0.26
Албан хаагчийн цалин, орон сууц, нийгмийн баталгаа хангалтгүй	3.47	4.00	4.17	4.00	4.23	0.23
Албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж хязгаарлагдаагүй байдал	4.86	4.23	4.33	4.23	4.23	0.00
Дундаж	**4.27**	**4.33**	**4.51**	**4.20**	**4.41**	**0.21**

Авлигыг бууруулахын тулд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааны үнэлгээ

Авлигыг бууруулахад ямар арга хэмжээ нэн тэргүүнд шаардлагатай талаарх асуултад шинжээчдийн 46.2 хувь нь сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн тогтолцоог өөрчлөх болон хээл хахууль өгсөн этгээдийг хариуцлагаас чөлөөлж, хээл хахууль авсан этгээдэд хариуцлага оноодог болох гэж, 38.5 хувь нь шийдвэр гаргахад нийтийн ашиг сонирхлыг харгалзан үзэх механизм бий болгох болон иргэдийн эрх зүйн ухамсрыг нэмэгдүүлэх гэж үзсэн нь хамгийн олонх болж байна (Хүснэгт 16).

Хүснэгт 16. Авлигыг бууруулахын тулд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагаа

Авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээ	Хувь
Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн тогтолцоог өөрчлөх	46.2
Хээл хахууль өгсөн этгээдийг хариуцлагаас чөлөөлж, хээл хахууль авсан этгээдэд хариуцлага оноодог болох	46.2
Иргэдийн эрх зүйн ухамсрыг нэмэгдүүлэх	38.5
Шийдвэр гаргахад нийтийн ашиг сонирхлыг харгалзан үзэх механизм бий болгох	38.5
Намын санхүүжилтийн зарчмыг өөрчлөх	30.8
Авлигчдад хүлээлгэх эрүүгийн болон захиргааны хариуцлагыг чангатгах	30.8
Улс төрийн намын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх	23.1
УИХ, орон нутгийн ИТХ-ын сонгуулийн тогтолцоог өөрчлөх	15.4
Улс төрчдийн ёс зүйн хэм хэмжээг бий болгож мөрдүүлэх	15.4
Улс төрчдийн авлигатай тэмцэх хүсэл зоригийг нэмэгдүүлэх	7.7
Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх	7.7

Түүнчлэн судалгаанд оролцсон шинжээчид авлигыг бууруулахад дээр дурдсан арга хэмжээнүүдээс гадна дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- ✓ Авлига төсвийн мөнгийг завшихад чиглэдэг аливаа тендер, худалдан авалт гэх мэт үйл ажиллагааг дээд зэргээр нээлттэй явуулдаг болох;
- ✓ Бодлого боловсруулах, шийдвэр гаргах төвшинд төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх;
- ✓ Иргэдийн бэлэнчлэх сэтгэлгээ, танил талаараа дамжуулж асуудлыг шийдэх гэж оролддог байдлыг халах;
- ✓ Мөнгө санхүүгийн урсгалыг хянадаг тогтолцоог Тагнуулийн ерөнхий газар,

эсвэл Авлигатай тэмцэх газарт бий болгох;
- ✓ Цалин хангамжийг нэмэгдүүлэх;
- ✓ Тансаг хэрэглээний татварыг нэмэгдүүлж, улс төрийн албан хаагч, төрийн албан хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналтын сайжруулах, гэр бүл, хамаатан саданг хамааруулах;
- ✓ Улс төрийн намын үйл ажиллагааг шүүхийн хяналтад оруулах;
- ✓ Улс төрийн намын сонгуулийн санхүүжилтийг төрөөс санхүүжүүлдэг болох;
- ✓ Төрийн үйл ажиллагааг стандартчлан хэрэгжүүлэх;
- ✓ Төрийн байгууллагын үйл ажиллагааг илүү нээлттэй болгох;
- ✓ Төрийн ажилтнуудаар дамжуулж олгодог бүх төрлийн халамж, тусламжийн үйлчилгээг багасгах;
- ✓ Хууль бүх иргэнд тэгш үйлчлэх.
- ✓ Авлига ихтэй салбар бүрийг нарийвчлан судалж, гарцыг олох, хууль шийдвэрүүдийг уялдуулах;
- ✓ Бизнесийн үйл ажиллагаанд төрөөс зөвшөөрөл /бүх төрөл/ өгдөг байдлыг халж, зөвхөн бүртгэдэг системд шилжих;
- ✓ Бодлогын хэрэгжилтийг хянах, мониторинг хийх зарим эрхийг төрийн бус байгууллагад шилжүүлэх;
- ✓ Захиргааны процессын тухай хуультай болох;
- ✓ Улс төрийн нам, сонгууль, төрийн байгууллагуудын нээлттэй, ил тод, тунгалаг байдлыг нэмэгдүүлэх;
- ✓ Улс төрийн томилгоог /улс төрийн намууд/ хязгаарлах;
- ✓ УМХГ-ын үйл ажиллагааг шинэ шатанд гарган өөрчлөх;
- ✓ Төрийн үйлчилгээний хүнд суртал, дарамтыг арилгах;
- ✓ Төрийн байгууллага бараа үйлчилгээ худалдан авах, тендер, хөрөнгө оруулалтыг нээлттэй болгох, шалгаруулалт, санхүүжилт, үр дүнг заавал нээлттэй мэдэгдэж байх, хяналт тавих;
- ✓ Хууль, дүрэм, журмаа ягштал хэрэгжүүлэх.
- ✓ Албан бус секторын хэмжээг бууруулах, бүхий л мөнгөн гүйлгээ, хөрөнгийн бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох;
- ✓ Иргэдийн хууль, ёс зүйн болон сахилга батын соёл мэдлэгийг дээшлүүлэх;
- ✓ Улс төрийн албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэх хуулийн заалтыг чангатгах;
- ✓ УМБГ, ЦЕГ-ын ажилтнуудын үүрэг хариуцлагыг чангатгах;
- ✓ Төрийн үзүүлж буй үйлчилгээний бүх хэлбэрийг олон нийтэд нээлттэй ил тод болгох;
- ✓ Төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох орчин бүрдүүлэх;
- ✓ Төрийн албаны дархлааг сайжруулах, улс төрийн намын удирдлагад байсан хүмүүс томилгоонд бага оролцох;
- ✓ Төсвийн мөнгөний зарцуулалтыг маш ойлгомжтой энгийн хэлбэрээр байнга, ил тод харуулдаг байх;
- ✓ Авлигын эсрэг сургалт, сурталчилгааг тасралтгүй явуулж байх.

Эдгээр үйл ажиллагааг явуулах хэрхэн хэрэгжүүлэх талаар шинжээч нар дараах санал гаргав.

- ✓ Дансны урсгал, орлого, зарлагын гүйлгээг хянадаг нэгдсэн бүртгэлийн тогтолцоог бий болгох;

- ✓ Иргэдийг соён гэгээрүүлэх;
- ✓ Олон шатлал бүхий үйлчилгээ, илүү зардлууд гаргахаас урьдчилан сэргийлэх, улс төрийнхөн болон төр байгууллага, иргэдийн хооронд шударга ёсны гэрээ байгуулах;
- ✓ Хариуцлагын тогтолцоог сайжруулах, ялангуяа олон нийтийн дунд яригдаад байгаа хэргүүдийг шийдэх, нотлох, нотолж чадахгүй байгаа бол түүнийгээ мэдээлэх, олон нийтээс туслалцаа хүсэх;
- ✓ Улс төрийн албан тушаалтнуудад үйл ажиллагаандаа дагаж мөрдөх кодексийн сургалт тогтмол явуулах;
- ✓ Төрийн үйл ажиллагааг ил тод, шуурхай болгох;
- ✓ Төрийн үйлчилгээний ажлуудыг мэргэжлийн холбоод болон хувийн сектор дахь мэргэжлийн байгууллагуудад шилжүүлэх;
- ✓ Төрийн зарим чиг үүргийг ТББ-д шилжүүлэх замаар хүнд суртал, авлигыг багасгах боломжтой;
- ✓ Хууль, Засгийн газрын тогтоол, захиргааны бусад дүрэм, журмыг нарийвчлах, олны эргэлзээ төрөхөөргүй тодорхой болгох;
- ✓ Хуулийн дагуу тууштай ажиллах, дээрээс доошоо шударгаар ажиллах;
- ✓ Шударга шүүх засаглалыг бий болгох;
- ✓ Авлигатай тэмцэх газрын бие даасан байдлыг бэхжүүлэн, нам улс төрийн бүлэглэлээс ангид байлгах;
- ✓ Бизнес эрхлэгчдийг авлигын эсрэг хамтдаа тууштайгаар тэмцэхийг дэмжих;
- ✓ Аливаа үйл ажиллагаа ил явагдах нөхцлийг хангах;
- ✓ Иргэдийн хуулийн боловсролыг дээшлүүлэх, үзэл суртлын ажлыг зохион байгуулах, сургалт, мэдээлэл, сурталчилгааг нэмэгдүүлэх хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулах;
- ✓ УМХГ-аас тодорхой чиглэлийг холбогдох яамдад өгөх;
- ✓ Төрийн байгууллагуудын дэргэдэх иргэний хяналтыг хэрэгжүүлэх субьектын эрх үүргийг нэмэгдүүлэх, хариуцлагыг нь өндөрсгөх;
- ✓ Төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагыг цөөлж, шаардлагатай бол олон нийтийн хэлбэрт шилжүүлэх;
- ✓ Аливаа хууль, эрх зүйн актыг боловсруулахад мэргэжлийн ТББ-уудын санал, дүгнэлтийг заавал авдаг байх;
- ✓ Цагдаагийн ажилтнуудын цалин хангамжийг сайжруулж, хариуцлагыг өндөржүүлэх;
- ✓ Холбогдох хуулийн төслүүд боловсруулж батлуулах;
- ✓ Төр зааварладаг, зөвшөөрдөг бус зохицуулдаг механизмыг боловсронгуй болгох;
- ✓ Төрийн албан хаагчдын чадавх, сахилга батыг дээшлүүлэх;
- ✓ Төрөөс гаргах гэж буй хууль, журам, шийдвэрийн төслийг төрийн албан хаагч бус мэргэжлийн байгууллага боловсруулах нөхцөл боломжийг бүрдүүлэ.

Судалгааны талаарх шинжээчдийн санал бодол

- ✓ АТГ улирал бүр судалгаа гаргаж анализ хийн холбогдох газруудад санал зөвлөмж хүргүүлж байх;
- ✓ Сайн судалж байнга тогтмолжуулах хэрэгтэй;
- ✓ Судалгааг үргэлжлүүлэх, ялангуяа дан улс төрчид болон төрийн байгууллагынхны өөрсдийнх нь санаа бодлыг тусгайлсан судалгаагаар гаргах.

2.3. “Шүүх, хууль хяналтын байгууллага”[1]-ын хүрээн дэх авлигын төсөөлөл”-ийн судалгааны дүн

Шүүх, хуулийн байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Шинжээчдийн үнэлгээгээр 2012 онд шүүхийн авлигад өртөх эрсдлийн үнэлгээ 2.89 болж, 2011 оныхоос 0.73 пунктээр, прокурорын байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ 2.86 болж, өмнөх оныхоос 0.54 пунктээр, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагынх 3.02 болж, өмнөх оныхоос 0.48 пунктээр, цагдаагийн байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ 3.35 болж, өмнөх оныхоос 0.18 пунктээр тус тус буурсан байна (Хүснэгт 17).

Хүснэгт 17. Шүүх, хуулийн байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ, байгууллагаар

Байгууллага	2008	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Шүүх	4.20	3.49	3.46	3.62	2.89	-0.73
Прокурорын байгууллага	4.15	3.12	3.75	3.40	2.86	-0.54
Цагдаагийн байгууллага	4.29	3.50	3.48	3.53	3.35	-0.18
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	3.73	3.21	3.30	3.50	3.02	-0.48

Энэ удаагийн судалгааны асуулгад шүүхийн талаарх асуултуудыг шүүхийн тогтолцооны дагуу өөрчлөн найруулсан. Ингэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн

48 дугаар зүйлийн 48.1 зүйл, Шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Шүүхийн үндсэн тогтолцоо нь Монгол Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэнэ” гэснийг баримталснаас гадны нэмж захиргааны хэргийн шүүх гэж оруулж өгсөн болно.

Хүснэгт 18. Шүүх, хуулийн байгууллага дахь авлигад өртөх эрсдлийн үнэлгээ, байгууллагын түвшин шатлалаар (2009-2011оны байдлаар)

Түвшин	2009	2010	2011	Өсөлт, бууралт (2011-2010)
Анхан шатны шүүх	3.64	3.58	3.64	0.05
Хяналтын шатны шүүх	3.45	3.75	3.67	-0.08
Давж заалдах шатны шүүх	3.44	3.67	3.64	-0.03
Дээд шүүх	3.44	2.85	3.56	0.71
Шүүхийн дундаж үнэлгээ	3.49	3.46	3.62	0.16
Сум /сум дундын/, дүүргийн прокурор	3.18	3.75	3.55	-0.20
Аймаг, нийслэлийн прокурор	3.27	3.92	3.55	-0.37
Улсын Ерөнхий прокурорын газар	2.91	3.58	3.10	-0.48
Прокурорын байгууллагын дундаж үнэлгээ	3.12	3.75	3.40	-0.35
Мөрдөн байцаагч	3.82	3.75	3.73	-0.02
Хэрэг бүртгэгч	3.55	3.50	3.89	0.39
Эрүүгийн цагдаагийн газар	3.82	3.50	3.70	0.20
Хэв журмын цагдаа	2.91	3.45	3.30	-0.15
Замын цагдаагийн газар	3.82	3.83	3.91	0.08
Цагдаагийн ерөнхий газар	3.09	2.82	2.63	-0.19

1 “Шүүх, хууль хяналтын байгууллага” гэдэгт бүх шатны шүүх болон бусад хуулийн байгууллагыг хамруулан ойлгоно.

Цагдаагийн байгууллагын дундаж үнэлгээ	3.50	3.48	3.53	0.05
Аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	3.45	3.70	3.80	0.10
Хорих ял эдлүүлэх алба	3.36	3.20	3.70	0.50
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	2.82	3.00	3.00	0.00
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дундаж үнэлгээ	3.21	3.30	3.50	0.20

Шүүхийн авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Иймд шүүхийн авлигад өртөх эрсдлийн үнэлгээ аймаг, нийслэлийн шүүхэд харьцангуй өндөр (авлигад өртөх эрдслийн үнэлгээ 3.08), сум, буюу сум дундын болон дүүргийн шүүх (3.00), дээд шүүх (2.75) болон захиргааны хэргийн шүүх (2.73) авлигад өртөх эрсдэл шүүхийн түвшинд хуулийн байгууллагынхаас харьцангуй доогуур байна. Шүүхийн авлигын эрсдлийн дундаж үнэлгээ 2.89 гарсан нь өнгөрсөн оны судалгааны үр дүнтэй харьцуулахад -0.73 пунктээр буурсан нь сайн үзүүлэлт болж байна.

Хүснэгт 19. Шүүхийн авлигад өртөх эрсдлийн үнэлгээ, шатлалаар, 2012 он

Шатлал	2012
Сум буюу сум дундын, дүүргийн шүүх	3.00
Аймаг, нийслэлийн шүүх	3.08
Захиргааны хэргийн шүүх	2.73
Дээд шүүх	2.75
Шүүхийн дундаж үнэлгээ	2.89

Хуулийн байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Прокурорын байгууллагын хувьд авлигад өртөх эрсдэл 2012 онд харьцангуй доогуур (авлигад өртөх эрсдлийн үнэлгээ 2.86) байсан бол аймаг, нийслэлийн прокурор болон сум (сум дундын), дүүргийн прокурорын (3.00 болон 3.08) байгууллагад авлигад өртөх эрсдэл өндөр байна. Харин цагдаагийн байгууллагын хувьд Замын цагдаагийн газар (3.67), Цагдаагийн ерөнхий газар (3.36), хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах газар, хэв журмын алба зэрэгт (тус бүр 3.33) авлигад өртөх эрсдэл харьцангуй өндөр байгаа бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хувьд нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, хорих ангиуд (тус бүр 3.08) авлигад өртөх эрсдэл харьцангуй өндөр байна (Хүснэгт 20).

Хүснэгт 19. Хуулийн байгууллага дахь авлигад өртөх эрсдлийн үнэлгээ, байгууллагын түвшин шатлалаар (2009-2012 оны байдлаар)

Байгууллага	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Сум /сум дундын/, дүүргийн прокурор	3.18	3.75	3.55	3.08	-0.46
Аймаг, нийслэл, тээврийн прокурор	3.27	3.92	3.55	3.00	-0.55
Улсын Ерөнхий прокурорын газар	2.91	3.58	3.10	2.50	-0.60
Прокурорын байгууллагын дундаж үнэлгээ	3.12	3.75	3.40	2.86	-0.54
Мөрдөн байцаах газар	3.82	3.75	3.73	3.33	-0.39
Хэрэг бүртгэлт	3.55	3.50	3.89	3.33	-0.56
Эрүүгийн цагдаагийн газар	3.82	3.50	3.70	3.17	-0.53

Хэв журмын алба	2.91	3.45	3.30	3.33	0.03
Замын цагдаагийн газар	3.82	3.83	3.91	3.67	-0.24
Аймаг, Нийслэл, ТЗ-ын цагдаагийн газар, хэлтэс	-	-	-	3.25	-
Цагдаагийн ерөнхий газар	3.09	2.82	2.63	3.36	0.74
Цагдаагийн байгууллагын дундаж үнэлгээ	3.50	3.48	3.53	3.35	-0.18
Аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	3.45	3.70	3.80	3.00	-0.80
Хорих ангиуд	3.36	3.20	3.70	3.08	-0.62
Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар	-	-	-	3.08	3.08
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	2.82	3.00	3.00	2.91	-0.09
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дундаж үнэлгээ	3.21	3.30	3.50	3.02	-0.48

Хуулийн байгууллагын авлигын эрдслийн үнэлгээ дунджаар 2012 онд өмнөх оныхоос 0.18-0.48 пунктээр буурсан нь эдгээр байгууллагын түвшинд авлигын эрсдэл буурч байгааг илтгэж байна. Дээрх байгууллагууд дотор Цагдаагийн байгууллага (дундаж үнэлгээ 3.35), шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага (3.02) нь авлигын эрсдэл прокурорын байгууллагынхаас өндөр байжээ.

Хуулийн байгууллага дахь тодорхой үйл ажиллагааны авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Хуулийн байгууллага дахь тодорхой үйл ажиллагаа тус бүрээр нь авлигад өртөх эрсдлийн үнэлгээг авч үзвэл 2012 онд прокурорын байгууллага эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох (авлигад өртөх эрсдлийн үнэлгээ 3.75), өр барагдуулах (3.73), эрүүгийн хэрэг үүсгэх үйл ажиллагаа (3.67), шүүхийн шийдвэр хурдан гүйцэтгэх (3.64) зэрэг үйл ажиллагаанд авлигад өртөх эрсдэл харьцангуй өндөр байсан байна (Хүснэгт 21).

Хүснэгт 20. Хуулийн байгууллагын үйл ажиллагааны авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Үйл ажиллагаа	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Ялтныг урамшуулах /шагналын хоног олгох/	3.11	3.62	4.44	3.10	-1.34
Өр барагдуулах	-	4.00	4.20	3.73	-0.47
Эрүүгийн хэргийг хяналтын шатны шүүх хянан шийдвэрлэх	-	3.78	4.11	3.36	-0.75
Ялын хэмжээг бууруулах	3.60	4.00	4.11	3.45	-0.66
Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах	3.58	4.00	4.10	3.36	-0.74
Хорих ял эдлэх хугацаанаас нь өмнө тэнсэн суллах, дэглэм бууруулах	-	4.13	4.00	3.09	-0.91
Шүүхийн шийдвэрийг хурдан гүйцэтгэх	3.56	3.71	4.00	3.64	-0.36
Прокурорын байгууллага эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох	3.64	4.40	3.91	3.75	-0.16
Хорих ангид ялтан хуваарилах	3.25	3.67	3.90	3.18	-0.72
Эрүүгийн хэргийг анхан шатны шүүх хянан шийдвэрлэх	3.64	3.90	3.89	3.36	-0.53
Эрүүгийн хэргийг давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэх	3.27	3.88	3.89	3.27	-0.62
Эрүүгийн хэрэг яллахаас татгалзах	3.18	3.45	3.80	3.50	-0.30

Прокурорын байгууллага эрүүгийн хэргийг хянах	3.22	4.09	3.78	3.40	-0.38
Эрүүгийн хэрэг үүсгэх үйл ажиллагаа	3.90	3.92	3.67	3.67	0.00
Албадан дуудлага худалдаанд оруулах	3.22	3.13	3.67	3.10	-0.57
Торгууль ногдуулах	3.36	3.75	3.63	3.36	-0.26
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх	3.40	3.50	3.55	3.36	-0.18
Хорих ял эдлүүлэх	-	3.30	3.50	2.64	-0.86
Тодорхой хугацаагаар эрх хасах	-	3.83	3.44	3.09	-0.35
Захиргааны хэргийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх	3.00	3.38	3.44	2.73	-0.72
Прокурорын байгууллага яллах дүгнэлт үйлдэх	3.33	3.70	3.44	3.55	0.10
Эрүүгийн хэрэг үүсгэх санал гаргах	3.27	3.44	3.22	3.45	0.23
Дундаж үнэлгээ	3.38	3.75	3.80	3.33	-0.48

Хуулийн байгууллагын дээрх үйл ажиллагааны авлигын эрсдлийг өмнөх оны судалгааны үр дүнтэй харьцуулахад 0.48 пунктээр буурсан байгаа боловч, эрүүгийн хэрэг үүсгэх санал гаргах (0.23), прокурорын байгууллага яллах дүгнэлт үйлдэх (0.10) зэрэг үйл ажиллагаанд өмнөх оныхоос өссөн байгаа нь авлигын эрсдэл нэмэгджээ.

Авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ

Хуулийн байгууллагад авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлохыг зорьсон юм. Хуулийн байгууллагын хувьд 2012 онд албан хаагчийн ёс зүй, хариуцлага тооцох механизмын дутагдалтай байдал (хүчин зүйлийн нөлөөллийн үнэлгээ 4.09), хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил (3.55), хуулийн байгууллагын албан хаагчийн цалин хангамж, ажиллах нөхцлийн хангалтгүй байдал (3.45) зэрэг нь байгууллагуудын хүрээнд авлига үүсгэхэд голлон нөлөөлж буй хүчин зүйлс болж байна (Хүснэгт 22).

Хүснэгт 21. Хуулийн байгууллагын хүрээн дэх авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ

Хүчин зүйлс	2008	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	-	3.64	3.75	3.92	3.55	-0.37
Хуулийн байгууллагын шийдвэр гаргах ажиллагааны журмын иж бүрэн хуульчлагдаагүй байдал	-	3.42	3.64	4.00	2.91	-1.09
Хуулийн байгууллагын үйл ажиллагааны давхардал, чирэгдэл, үр өгөөжгүй, хяналтгүй байдал	-	3.67	4.00	4.40	3.45	-0.95
Хуулийн байгууллагын албан хаагчийн цалин хангамж, ажиллах нөхцөл хангалтгүй	3.64	4	4.00	4.27	3.30	-0.97
Хуулийн байгууллагын албан хаагчийн ёс зүй, хариуцлага тооцох механизм дутагдалтай	4.2	3.73	4.00	4.33	4.09	-0.24
Дундаж үнэлгээ	**3.92**	**3.69**	**3.88**	**4.18**	**3.46**	**-0.72**

Хуулийн байгууллагын албан тушаалтан бусад албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөн оролцож буй хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

Хуулийн байгууллагын албан тушаалтан бусад албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөн оролцож буй хэлбэрүүдийн тархцын хэлбэрээр авч үзвэл дарамт шахалт үзүүлэх (тархцын үнэлгээ 3.83), хууль бус шаардлага тавих (3.73), хууль бусаар дотоод үйл ажиллагаанд нь оролцох (3.60) байдал хуулийн байгууллагад нэлээд тархсан арга хэлбэр болж байна (Хүснэгт 23).

Хүснэгт 22. Хуулийн байгууллагын албан тушаалтан бусад албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөн оролцож буй хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

Оролцох нөлөөлөх хэлбэр / тархац	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Албан тушаалтны зөрчлийг илрүүлж түүгээр нь дарамтлах	4.00	4.22	4.33	3.58	-0.75
Дарамт шахалт үзүүлэх	3.64	3.58	3.82	3.83	0.02
Хууль бус шаардлага тавих	3.67	3.85	3.70	3.73	0.03
Хууль бусаар дотоод үйл ажиллагаанд нь оролцох	3.42	3.83	3.70	3.60	-0.10
Шан харамж нэхэх	3.00	3.13	3.38	3.27	-0.10
Дундаж үнэлгээ	**3.55**	**3.72**	**3.79**	**3.60**	**-0.18**

Дээрх байгууллагуудад хууль бус шаардлага тавих, дарамт шахалт үзүүлэх байдлын үнэлгээ өмнөх оныхоос нэмэгдсэн гэж шинжээчид үзжээ (Зураг 4).

Зураг 4. Шүүх, хуулийн байгууллагын албан тушаалтан бусад албан тушаалтны үйл ажиллагаанд /дарамт шахалт үзүүлэх/ нөлөөлөх байдлын тархцын үнэлгээ, 2010-2012 онд



Ашигтай, давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахын тулд хэрэглэдэг үйлдлүүдийн давтамжийн үнэлгээ

Шүүх, хуулийн байгууллагын хүрээнд өөрт болон бусдад ашигтай, давуу байдал бий болгох, шийдвэр гаргуулахдаа бэлэг, мөнгө, хөрөнгө өгөх (давтамжийн үнэлгээ 4.18-4.09), олсон ашиг орлогоо хуваахаар амлах (3.80), зориуд ажлын байр шинээр эсвэл шаардлагагүй албан тушаал бий болгох (3.78), улс төрийн хамгаалалтад авах (3.60), албан тушаалд томилох (3.55) зэрэг аргуудыг голчлон хэрэглэдэг байна (Хүснэгт 24).

Хүснэгт 23. Шүүх, хуулийн байгууллагын хүрээнд өөрт ашигтай, давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахад хэрэглэдэг үйлдлүүдийн давтамжийн үнэлгээ

	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Мөнгө /хөрөнгө/ өгөх	4.08	4.08	4.44	4.09	-0.35
Улс төрийн хамгаалалтад авах	2.83	4.14	4.29	3.60	-0.69
Төрийн одон, медаль, салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнах	3.14	3.71	4.00	3.10	-0.90
Хэн нэгэнд зориулж ажлын байр шинээр бий болгох	3.00	3.25	4.00	3.78	-0.22
Бэлэг өгөх	4.08	4.09	3.90	4.18	0.28
Өндөр бооцоо тавьж тоглоомд санаатайгаар хожигдох	2.89	4.22	3.88	3.11	-0.76
Олсон ашиг, орлогоо хуваахаар амлах	3.30	4.00	3.86	3.80	-0.06
Албан тушаалд томилох	3.60	3.73	3.80	3.55	-0.25
Гадаад банкинд данс нээж өгөх /мөнгө өгөх/	1.67	2.50	3.67	2.14	-1.52
Баяр ёслолын үеэр өндөр үнэтэй бэлэг өөрт нь өгөх, авах	3.70	3.00	3.50	-	-3.50
Өрийг нь төлөх	3.33	3.75	3.44	3.00	-0.44
Гэр бүлийнхэнд нь өндөр үнэтэй бэлэг өгөх, авах	3.11	3.83	3.38	3.00	-0.38
Өндөр цалинтай, сул ажилд оруулах	2.50	3.40	3.33	-	-3.33
Гадаад арга хэмжээний зардал даах	2.50	3.75	3.17	3.45	0.29
Хувьцаа өгөх	2.00	3.00	3.00	1.71	-1.29
Сургалтын зардал даах	2.63	3.25	2.86	3.00	0.14
Эмчилгээ, сувилгааны зардал даах	2.63	3.17	2.71	3.10	0.39
Аялал, жуулчлалын зардал даах	2.91	3.38	2.57	3.40	0.83
Зээл өгөх	-	-	-	3.40	-
Шаардлагагүй албан тушаал бий болгох	-	-	-	3.78	-
Дундаж үнэлгээ	**2.99**	**3.57**	**3.54**	**3.25**	**-0.29**

Өөрт болон бусдад ашигтай, давуу байдал бий болгох, шийдвэр гаргуулахдаа түгээмэл ашигладаг үйлдлүүдээс аялал, жуулчлалын зардал даах (0.83), эмчилгээ, сувилгааны (0.39), гадаад арга хэмжээний зардал даах (0.29), бэлэг өгөх (0.28) явдал өмнөх оныхоос нэмэгдсэн гэж шинжээчид үзэж байна.

Шүүх, хуулийн байгууллагын хүрээн дэх авлигын өртөг

Ажил, албан тушаалд ороход дунджаар 31.4 сая төгрөгийн, ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргуулахад дунджаар 16.7 сая төгрөгийн, эрүүгийн хэрэг үүсгүүлэхэд дунджаар 14.3 сая төгрөгийн, шүүхэд хэрэг хэрэгсэхгүй болгоход дунджаар 13.2, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хэргийг хэрэгсэхгүй болгоход дунджаар 12.7 сая төгрөгийн хээл хахууль өгдөг гэж шинжээчид үзжээ.

Авлигын хэлбэрийн үнэлгээ

Шүүх, хуулийн байгууллагын албан тушаалтнууд хээл хахууль өгөхдөө өмгөөлөгчөөр дамжуулах (4.10), ойр дотны хүмүүсээр дамжуулах (3.90) хэлбэрийг илүү түгээмэл хэрэглэдэг байна (Хүснэгт 25). Мөн ойр дотны хүмүүсээр дамжуулах, хувьцаа эд хөрөнгө өмчлүүлэх хэлбэр 2009 оноос хойш тогтмол нэмэгдсээр байна.

Хүснэгт 24. Шүүх, хуулийн байгууллагын албан тушаалтан авлигын хэлбэрийн үнэлгээ

Хэлбэр	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Өмгөөлөгчөөр дамжуулах	3.80	3.82	4.11	4.10	-0.01
Зуучлагчаар дамжуулах	3.60	3.73	4.20	3.82	-0.38
Мөрийтэй тоглож санаатайгаар алдах	2.78	3.63	3.75	3.14	-0.61
Мөнгө зээлдүүлээд мартах	3.44	3.57	3.63	2.86	-0.77
Ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдгээрийн компанид давуу байдал олгох	3.33	3.33	3.88	3.75	-0.13
Ойр дотны хүмүүсээр дамжуулах	3.00	3.22	3.67	3.90	0.23
Эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах	3.00	3.17	3.86	3.86	0.00
Шууд өөрт нь өгөх	2.90	3.17	3.64	3.56	-0.08
Эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах	3.00	3.14	3.63	3.10	-0.53
Хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх	2.29	2.80	2.86	3.43	0.57
Дундаж үнэлгээ	**3.11**	**3.36**	**3.72**	**3.55**	**-0.17**

Авлигын улмаас бий болсон хөрөнгө, орлогын зарцуулалтын үнэлгээ

Шүүх, хуулийн байгууллагын албан тушаалтнууд авлигын улмаас бий болгосон хөрөнгөө голчлон өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулах (үнэлгээ 5.00), өдөр тутмынхаа хэрэгцээнд зориулах (4.80) байдлаар зарцуулдаг байна (Хүснэгт 26).

Хүснэгт 25. Авлигаар бий болсон хөрөнгийг зарцуулдаг хэлбэрийн үнэлгээ

Хэлбэр	2009	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Өдөр тутмынхаа хэрэгцээнд зориулах	4.75	4.78	5.00	4.80	-0.20
Зугаа цэнгэлд зарцуулдаг	5.00	4.78	4.50	4.40	-0.10
Машин худалдан авдаг	5.00	4.56	4.78	4.00	-0.78
Орон сууц худалдан авдаг	3.33	4.56	4.78	4.00	-0.78

Хүүхдийнхээ сургалтын төлбөрт зориулдаг	3.33	4.50	5.00	4.25	-0.75
Үл хөдлөх хөрөнгө худалдан авдаг	5.00	4.25	1.00	4.11	3.11
Өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулдаг	3.00	3.67	4.43	5.00	0.57
Дотоодын банкинд хадгалдаг	3.25	3.00	4.00	3.00	-1.00
Гадаадын банкинд хадгалдаг	2.64	3.00	3.80	3.67	-0.13
Хувьцаа худалдан авдаг	2.83	3.00	3.86	2.43	-1.43
Дундаж үнэлгээ	**3.81**	**4.01**	**4.11**	**3.97**	**-0.15**

Авлигаар бий болсон хөрөнгийг зарцуулдаг хэлбэрүүдээс үл хөдлөх хөрөнгө худалдан авах (4.11), өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулах (5.00) хэлбэрүүд 2009 оноос хойш тасралтгүй нэмэгдсээр байгаагаас гадна 2011 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад үл хөдлөх хөрөнгө худалдан авах явдал 3.11 пунктээр нэмэгдсэн гэж шинжээчид үзжээ.

Шүүх, хуулийн байгууллагын хүрээн дэх авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээний ач холбогдлын түвшин

Шинжээчид шүүх, хуулийн байгууллагын ил тод байдлыг нэмэгдүүлэх (4.92), албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх механизмыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх (4.91), ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх (4.75) зэрэг хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна (Хүснэгт 27).

Хүснэгт 26. Шүүх, хуулийн байгууллага дахь авлигыг бууруулахад авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийн ач холбогдлын түвшин

Арга хэмжээ / ач холбогдлын түвшин	2010	2011	2012	Өсөлт, бууралт (2012-2011)
Албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх механизмыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх	4.67	4.45	4.91	0.46
Ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх	4.64	4.58	4.75	0.17
Ур чадварт үндэслэн томилгоо хийх	4.62	4.55	4.67	0.12
Байгууллагын ил тод байдлыг нэмэгдүүлэх	4.58	4.67	4.92	0.25
Албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх	4.55	4.42	4.08	-0.34
Хуулийн байгууллагын албан хаагчдын хууль зүйн баталгааг сайжруулах	4.50	4.45	-	-
Албан хаагчдыг чөлөөлөх, өөрчлөх, халах, шударга ил тод механизм бий болгох	4.42	4.73	4.58	-0.15
АТГ-ын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх	4.38	4.83	4.08	-0.75
Авлигын гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын арга хэмжээг чангатгах	4.36	4.67	3.82	-0.85
Хуулийн байгууллагын чадавхийг сайжруулах	4.33	4.82	4.58	-0.24
Иргэний нийгмийг өргөн хүрээнд оролцуулах	4.09	4.08	4.17	0.09
Хуулийн байгууллагын албан хаагчдыг сэлгэн ажиллуулах	4.00	4.36	3.91	-0.45
Тогтвортой ажиллах баталгааг сайжруулах	-	-	4.42	-
Дундаж үнэлгээ	**4.43**	**4.55**	**4.41**	**-0.15**

Түүнчлэн судалгаанд оролцсон шинжээчид Монгол Улсад авлига түгээмэл байгааг дараах асуудалтай холбоотой гэж үзсэн байна. Үүнд:

- ✓ Албан тушаалтан, иргэдийн эрх зүйн ухамсар, нийгмийн хариуцлага сул, цалин орлого бага, нийгэмд авлигын талаар тогтсон буруу ойлголт, ёс заншлийн, эрх зүйн зохицуулалт хангалтгүй, ёс зүйн төлөвшил, шударга бус өрсөлдөөн, даярчлал, гадаадын хөрөнгө оруулагчдын ашиг сонирхол.
- ✓ Төр, бизнес хэт хутгалдсан, хууль биелүүлэхгүй явдал, улс төрчид хууль биелүүлэхгүй байх явдлыг манлайлан удирдаж байна.
- ✓ Сэтгэлгээний хоцрогдол (асуудлыг цагийг нь тулгаж байгаад хялбараар шийдвэрлүүлэх гэдэг), иргэдийн хууль эрх зүйн мэдлэг муу, хуулийг өөртөө ашиглах, хэрэглэх талаар судалдаггүй.
- ✓ Хүнд суртал чирэгдэл ихтэй, хүмүүсийн амьдралын түвшин хэт ялгаатай, цөөн хэдэн хүмүүс хэт богино хугацаанд огцом баяжсан (төрийн мөнгөөр), ингэж болдог юм байна гэж үздэг.
- ✓ Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо муу, олон шат дамжлагатай, шаардах бичиг баримт нь олон гэх зэрэг байдал нь аливаа ажлаа түргэн бүтээхийг бодсон этгээд авлигад өртөх үндэс болж байна.
- ✓ Төрийн албан хаагчдын шударга бус байдал, цалин хангамж хангалттай бус, улс төрчид болон албан хаагчдын зүй бус нөлөө.
- ✓ Төрийн албанд шийдвэр гаргах шат дамжлага хэт олон, үйл ажиллагаа нээлттэй бус.
- ✓ Хуучин тогтолцооны үйлдэл, гадаад улс орнуудын нөлөөлөл (өөгшүүлэл)
- ✓ Хууль эрх зүйн орчинг боловсронгуй бус, хуулийн заалтыг яаж ч хэрэглэж болох боломжтой байдал нь авлига түгээмэл байх нөхцлийг бүрдүүлдэг гэсэн байна.

Судалгаанд оролцсон шинжээчид авлигыг бууруулахад нэн тэргүүнд шаардлагатай дараах арга замуудыг илэрхийлсэн. Үүнд:

- ✓ УИХ-д бизнесийнхний нөлөөг багасгах, хууль боловсруулах механизмыг эрс сайжруулах, ил тод байдлыг дээшлүүлэх
- ✓ Улс төрчдийг төрийн жинхэнэ болон тусгай албан хаагчдын үйл ажиллагаанд нөлөөллийг хязгаарласан хууль тогтоомжийн заалтыг хэрэгждэг болгох, төрийн албан хаагчийн тогтвортой ажиллах баталгааг хангах, цалин хангамжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ тавих хяналт шаардлага хариуцлагыг чангатгах
- ✓ Эрүүгийн хуульд хээл, хахууль авах өгөх гэмт хэргийн шинжийг өөрчлөн найруулах, албан тушаалын гэмт хэргийн шинжийг өөрчлөн найруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол явуулах, төрийн байгууллагын ил тод байдлыг нэмэгдүүлэх
- ✓ Маш их хөрөнгөжсөн төрийн албан тушаалтны орлогыг үнэн зөвөөр тогтоох механизмыг олон улсын туршлага дээр үндэслэн бий болгож хянадаг байх, эрэн сурвалжлах сэтгүүл зүйг алагчлалгүй бий болгох
- ✓ Ёс зүйн үр нөлөөтэй сургалт явуулах
- ✓ Соён гэгээрүүлэх, лоббийг зохицуулах хууль гаргах
- ✓ Аливаа байгууллагын ил тод байдал, эрхлэх асуудал, гаргаж буй шийдвэр ямагт ил тод байх (нээлттэй), байгууллагын хоорондын элдэв бичиг цаас шаардах, давхардал хийдлийг арилгах, хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх
- ✓ АТГ-ын үйл ажиллагааг эрчимжүүлэх, ил тод байх, цогцоор шийдэх
- ✓ Зөвшөөрөл, лицензийг аль болох цөөлөх, удирдах ажилтан, гүйцэтгэх ажилтны шийдэх асуудлын хүрээг нарийн тогтоох, энэ байгууллагын (хууль хяналтын) хүрээнд үйлчилж байгаа хууль тогтоомжийг шинэчлэх,

боловсронгуй болгох
- ✓ Санхүүгийн бүртгэлийн тогтолцоог бий болгох, мөнгөний урсгалыг хянах явдлыг Татварын ерөнхий газарт бүртгүүлэх
- ✓ Соён гэгээрүүлэх ажлыг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, бусад орнуудын туршлага судлах
- ✓ Хариуцлага тооцох болон улсад төлбөр төлдөг тогтолцоог бий болгох
- ✓ Төрийн албан хаагчдын ажиллах эрх зүйн орчинг тодорхой болгох нийгмийн баталгааг нь нэмэгдүүлэх үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад чиглэгдсэн үндэсний хөтөлбөр боловсруулж гаргах

Шүүх, хуулийн байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгаанд оролцсон шинжээчдийн хувьд судалгааг тогтмол явуулж байх, судалгааны үр дүнг олон нийтэд мэдээлж, ярилцлага зохиож, цаашид нэн тэргүүнд авах арга хэмжээг тодорхойлох, олон нийт судалгааны үр дүнг хэрхэн хүлээн авч байгаад дүгнэлт хийх шаардлагатай гэж үзэж байна.

3. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүн гагцхүү судалгаанд оролцсон шинжээчдийн үнэлэлт, төсөөлөл бөгөөд судалгааны мэдээлэлд үндэслэн дараах дүгнэлт, зөвлөмжийг өгч байна.

- ✓ Улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үнэлгээ 2012 онд 3.93 (1-огт үгүй, 5-маш их) болж, 2009 оныхоос 0.02 пункт, 2010 болон 2011 оныхоос 0.14 пунктээр буурчээ. Энэ нь улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлига түгээмэл байгаа ч төсөөллийн түвшин буурсан байна.
- ✓ Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үнэлгээ болон хуулийн байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн үнэлгээний хоорондын харьцаа нь 2009 онд 54:46, 2010 онд 51:49, 2011 онд 51: 49, 2012 онд 54:46 болсноос үзвэл улс төрийн хүрээн дэх авлига хуулийн байгууллагын хүрээн дэх авлигаас илүү түгээмэл байгаа байдал 2012 онд ч хэвээр байна.
- ✓ Засгийн газар, яамдын болон цагдаагийн байгууллагын авлигад өртөмтгий байдал 2012 онд харьцангуй өндөр түвшинд байна. Түүнчлэн эдгээр байгууллага дотроо удирдлагын түвшинд, өөрөөр хэлбэр сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга нарын түвшинд болон замын цагдаагийн албаны авлигад өртөх эрсдэл өндөр байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна.
- ✓ Авлигад нөлөөлөх хүчин зүйлсээс нам доторх болон төрийн албан дахь улс төрийн томилгоо, улс төрийн хүрээн дэх бизнесийн бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил, намын санхүүжилтийн болон сонгуулийн санхүүжилтийн механизм, УИХ дахь ашиг сонирхлын зөрчил, хуулийн байгууллагын □с зүйгүй байдал, хариуцлага тооцох сул тогтолцоо зэрэг байдал түгээмэл байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна. Иймд улс төр, хуулийн байгууллагын хүрээний ашиг сонирхлын зөрчлийг таслан зогсоох, үүний тулд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, мөн сонгуулийн санхүүжилтийн механизмыг ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг авах шаардлагатай байна.
- ✓ Улс төрчид болон хуулийн байгууллагын албан тушаалтнууд өөртөө болон бусдад давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахын тулд шууд буюу шууд

бус байдлаар албан тушаалтны зөрчлийг илрүүлж түүгээр нь дарамтлах, мөнгө, бэлэг өгөх, ашиг орлого хуваахаар амлах, гадаад арга хэмжээний зардал даах, дарамт шахалт үзүүлэх зэрэг арга хэлбэрүүдийг хэрэглэх нь түгээмэл байдаг байна. Иймд албан тушаалтанд хариуцлага тооцох механизмыг илүү ил тод, шударга байхаар зохицуулах, албан тушаалтны хөрөнгө, орлого, бэлэг, гадаадад зорчихтой холбоотой үйл ажиллагаанд тавих хяналт буюу Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах талаар анхаарах шаардлагатай.

- ✓ Улс төрийн хүрээнд улс төрийн зорилгоор хууль бус хандив өгөх, авах, ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулахаар лоббидох, намд хандив авах, төсвийн мөнгийг зориулалтын бусаар, өөрийн ашиг сонирхлоор зарцуулах зэрэг авлигын хэлбэрүүд тархалт өндөртэй байна. Иймд эдгээр хэлбэрүүдийн тархцыг бууруулах, таслан зогсоохтой холбоотой эрх зүйн зохицуулалт болон холбогдох үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.
- ✓ Улс төрийн хүрээн дэх авлигыг бууруулахын тулд сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн тогтолцоог өөрчлөх, хээл хахууль өгсөн этгээдийг хариуцлагаас чөлөөлж, хээл хахууль авсан этгээдэд хариуцлага хүлээлгэдэг болох, иргэдийн эрх зүйн ухамсрыг нэмэгдүүлэх, шийдвэр гаргахад нийтийн ашиг сонирхлыг харгалзан үзэх механизм бий болгох, намын санхүүжилтийн зарчмыг өөрчлөх, ил тод болгох, авлигын хэрэгт ногдуулах эрүүгийн болон захиргааны хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- ✓ Шүүх, хуулийн байгууллагын хүрээн дэх авлигыг бууруулахын тулд албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх механизмыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх, ур чадварт үндэслэн томилгоо хийх, байгууллагын ил тод байдлыг дээшлүүлэх, албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, албан хаагчдыг чөлөөлөх, өөрчлөх, халах, шударга ил тод механизм бий болгох, хуулийн байгууллагын чадавхийг сайжруулах зэрэг арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ИНДЕКСИЙН 2013 ОНЫ СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН

МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ИНДЕКСИЙН 2013 ОНЫ СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН

1. МОНГОЛ УЛСЫН 2013 ОНЫ АВЛИГЫН ИНДЕКС

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу Монгол Улсын Авлигатай тэмцэх газар (АТГ) авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жил тутам судлан авлигын индексийг тооцон олон нийтэд мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Нөгөө талаас, авлигын индекс нь Монгол Улсын Мянганы хөгжлийн 9 дэх зорилгын "Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх, 24 дүгээр зорилт"-ын "Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх" дэд зорилтын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт болдог.

Авлигын индексийн энэ удаагийн судалгаа нь цаг хугацааны хувьд уг үзэгдэл хэрхэн өөрчлөгдсөнийг тодорхойлж үнэлэлт дүгнэлт өгөх боломжийг олгож байгаагаараа онцлогтой. Судалгааны арга зүйн хувьд:

- Авлигын цар хүрээ болон шалтгааныг төсөөллийн болон баримтын судалгаанд, хэлбэрийг баримтын судалгааны тоо мэдээлэл дээр үндэслэн тооцсон;
- Монгол Улсын 21 аймаг, нийслэл, 330 сум, 9 дүүргийн оршин суугчдыг төлөөлсөн 4000 иргэд, бизнес эрхлэгчид; төрийн захиргааны болон нутгийн захиргаа, өөрөө удирдах байгууллагын ажилтан, албан хаагчдыг төлөөлсөн төрийн 2000 албан хаагч; төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшил зэрэг холбогдох бүх төлөөллийн 352 шинжээчдийн буюу нийт 6352 хүний үзэл бодлыг тусгасан;
- Олон улсын нийтлэг туршлага, судалгаа шинжилгээний арга зүйд үндэслэн авлигын нөхцөл байдлыг нэгдсэн тоон үзүүлэлтээр үндэсний түвшинд хэмжин гаргасан;
- Авлигыг 0 (авлигад автсан)-ээс 1 (огт авлигагүй) хүртэлх тоон үзүүлэлтээр илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, авлигын индекс нь 0-1 хүртэлх утгыг авах бөгөөд индексийн утга 1-д ойртох тусам авлига багасч байна гэж үздэг
- Авлига хэмээх үзэгдлийг цар хүрээ, хэлбэр, шалтгаан гэсэн гурван талаас нь авч үзсэн зэрэг болно.

АТГ-аас авлигын индексийг 2009 оноос гаргаж эхэлсэн бөгөөд энэ удаа 2013 оны индексийг тооцон хураангуй тайланг гаргаад байна.

Монгол Улсын Авлигын индекс 2013 оны байдлаар **0.65**[1] гарсан нь 2011 оныхоос 0.02 пунктээр өссөн эерэг дүнтэй гарлаа. Өөрөөр хэлбэл, сүүлийн хоёр жилийн хугацаанд Монгол Улс дахь авлигын түвшин 0.02 пунктээр буурсан болохыг илэрхийлж байна /Зураг 1./.

1 Авлига хэмээх сөрөг үзэгдлийн цар хүрээ, хэлбэр, шалтгааныг тодорхойлох тоон болон чанарын үзүүлэлтүүдийн нийлбэр цогцыг авлигын индекс гэж ойлгоно.

Зураг 1. Монгол Улсын Авлигын индекс, оноор



Авлигын индексийн тооцоолол нь 1/цар хүрээ болон 2/хэлбэрийн гэсэн хоёр дэд үзүүлэлтээс бүрддэг.

Авлигын цар хүрээний үзүүлэлт 2011, 2013 оны судалгаагаар тогтмол 0.74 гарсан нь авлига хэмээх гэмт үзэгдэл тодорхой хэмжээнд оршсоор байгаа ч цар хүрээ нь өөрчлөгдөөгүй буюу цааш тэлж чадахгүй байгааг харуулж байна.

Авлигын индексийн хэлбэрийн үзүүлэлтийн хувьд 2013 онд 0.55 гарсан байгаа нь 2011 оныхоос 0.03 пунктээр өссөн эерэг дүнтэй байна /Зураг 2./.

Зураг 2. Монгол Улсын авлигын индексийн дэд үзүүлэлт, оноор

2. АВЛИГЫН ЦАР ХҮРЭЭ

Авлигын цар хүрээг 4 дэд үзүүлэлтээр дүгнэдэг. Дэд үзүүлэлт тус бүрээр нь авч үзвэл:

1/ Авлигын цар хүрээний талаарх олон нийт, шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт 2013 онд 0.80 болсон нь судалгаанд хамрагдсан олон нийт, шинжээчдийн 80.0 хувь нь Монгол Улсад авлига түгээмэл гэж үзсэнийг илтгэж байна. Энэ нь өмнөх судалгааны үр дүнгээс 1.0 хувиар нэмэгджээ /Хүснэгт 1./.

2/ Авлигын эдийн засгийн үр дагаврын үзүүлэлт 2013 онд 0.02 буюу өмнөх

судалгааны дүнтэй адил байна. Энэ нь улсын нэгдсэн төсвийн зарлагын 2.0 хувьтай тэнцэх хэмжээний хохирлыг авлигын гэмт хэргийн улмаас учруулсан болохыг баримтын судалгаагаар харуулж байгаа болно.

Хүснэгт 1. Авлигын цар хүрээний үзүүлэлт, дэд үзүүлэлтээр

Үзүүлэлтүүд		2011	2013	Өөрчлөлт
Авлигын цар хүрээний нэгдсэн үзүүлэлт		**0.74**	**0.74**	**0.00**
1	Авлигын цар хүрээний талаарх олон нийт, шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт	0.79	0.80	0.01
2	Авлигын эдийн засгийн үр дагаврын үзүүлэлт	0.02	0.02	0.00
3	Шинжээчдийн төсөөллөөрх авлигын хувь хэмжээ	0.11	0.09	-0.02
4	Олон нийтийн зүгээс төрийн албан хаагчдад өгсөн хээл хахуулийн дундаж хувь хэмжээ	0.13	0.13	0.00

3/ Шинжээчдийн төсөөллөөр авлигын хувь хэмжээний үзүүлэлт 0.09 гарсан нь 2011 оныхоос 0.02 пунктээр буурсан буюу төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт хамрагдах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шалгаруулалтад ялах, өр төлбөр, иргэний нэхэмжлэлийг шийдвэрлүүлэх, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх зэрэг хэлцлүүдийн үнийн дүнгийн дунджаар 9.0 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг 2013 онд авлига, хээл хахууль байдлаар зарцуулсан гэж шинжээчид үзсэнийг харуулж байна /Зураг 3./.

Зураг 3. Авлига, хээл хахуулийн хувь хэмжээ, оноор



4/ Олон нийтийн төсөөллийн судалгаанд хамрагдсан иргэдийн 17.4 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд гэр бүлийн гишүүд төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэж хариулсан байгаа нь өмнөх судалгааны дүнгээс 2.6 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна. Тэдгээр нь өрхийнхөө жилийн орлогын дунджаар 13.0 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийг хээл хахууль байдлаар зарцуулсан гэж үзжээ /Зураг 3./.

3. АВЛИГЫН ХЭЛБЭР

Авлигын хэлбэрийн үзүүлэлт 0.55 гарсан нь өмнөх судалгааны дүнгээс 0.03 пунктээр өссөн байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу АТГ нь Эрүүгийн хуулийн 263/Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах/, 264/Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх/, 265/Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах/, 266/Төрийн

бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх/, 268/ Хээл хахууль авах/, 269/Хээл хахууль өгөх/, 270/Хээл хахуульд зуучлах/, 2701/Хууль бусаар хөрөнгөжих/, 273/Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/ дугаар зүйлд заасан 9 төрлийн гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулдаг. Эрүүгийн хуульд заасан дээрх 9 төрлийн гэмт хэргээс сүүлийн 4 жилийн хугацаанд хамгийн түгээмэл үйлдэгдсэн гэмт хэргийг /Зураг 4./-т харуулав.

Зураг 4. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, /2010-2013 онд, дүнд эзлэх хувиар/



Монгол Улсад АТГ, УЕП-ын дэрэгдэх Мөрдөн байцаах албанд шалгасан авлига, албан тушаалын 9 төрлийн гэмт хэргийн дүнд эзлэх хувиар авч үзвэл 2012-2013 онд шалгагдсан нийт гэмт хэргийн хамгийн их буюу 34.5 хувийг төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу тушаалын байдлаа урвуулах гэмт хэрэг, 15.3 хувийг төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх, 14.6 хувийг хээл хахууль авах, 12.2 хувийг хээл хахууль өгөх, 10.5 хувийг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах, 12.9 хувийг бусад гэмт хэрэг эзэлж байна.

2012-2013 онд шалгагдсан авлига, албан тушаалын гэмт хэргийн хувийн жинг 2010-2011 оныхтой харьцуулахад төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах 8.7 хувиар, хээл хахууль авах 13.3 хувиар тус тус буурсан байхад төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 4.0 хувиар, бусад гэмт хэрэг 4.2 хувиар, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах 5.2 хувиар, хээл хахууль өгөх 8.7 хувиар тус тус нэмэгдсэн болохыг судалгааны дүн харуулж байна.

Өөрөөр хэлбэл, өнгөрсөн 2 жилийн хугацаанд авлига, албан тушаалын гэмт хэргийн дүнд эзлэх хувиар төрийн албан тушаалтантай холбоотой буюу эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулах, хээл хахууль авах гэмт хэргийн хувийн жин

нийлбэр дүнгээрээ 22.0 хувиар буурсан байхад иргэд, аж ахуйн нэгжийн холбогдолтой буюу төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах, хээл хахууль өгөх зэрэг гэмт хэргийн хувийн жин нийлбэр дүнгээрээ 14.0 хувиар нэмэгдсэн байна.

4. ШАЛТГААН НӨХЦӨЛ

Авлигын индексийн судалгааны Шинжээчдийн болон Олон нийтийн төсөөллийн судалгаанд оролцогч шинжээч, иргэд, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчдээс Монгол Улсад авлига үүсгэж буй шалтгаан нөхцөлийг асуухад дараахь шалтгаануудыг гол шалтгаан /Хүснэгт 2/- гэж нэрлэсэн байна.

Хүснэгт 2. Авлигын шалтгаан нөхцөл, шинжээчдийн болон олон нийтийн төсөөллийн судалгаа /хамгийн их нэрлэсэн шалтгаан нөхцөлөөр/

Шинжээч	Иргэд	Төрийн албан хаагч	Бизнес эрхлэгч
Улс төрийн нөлөө их	Улс төрийн нөлөө их	Улс төрийн нөлөө их	Улс төрийн нөлөө их
Ашиг сонирхлын зөрчил их	Ашиг сонирхлын зөрчил их	Ашиг сонирхлын зөрчил их	Ашиг сонирхлын зөрчил их
Төрийн албан хаагчдын цалин, орлого бага	Цалин, орлого бага	Төрийн албан хаагчдын цалин, орлого бага	Цалин, орлого бага
Эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул	Эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул	Эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул	Эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул
Хүмүүсийн сэтгэлгээ, ухамсрын түвшин муу, ёс зүйгүй байдал	Ажлаа хурдан бүтээхийн тулд	Хүмүүсийн сэтгэлгээ, ухамсрын түвшин муу, ёс зүйгүй байдал	Хүмүүсийн сэтгэлгээ, ухамсрын түвшин муу, ёс зүйгүй байдал
Хариуцлага тооцдоггүй, хөндлөнгийн хяналт сул	Ажилгүйдэл, ядуурал	Ажилгүйдэл, ядуурал	Төрийн үйлчилгээний хүртээмж муу

Шинжээч, иргэд, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчдийн үзсэнээр улс төрийн нөлөө их, ашиг сонирхлын зөрчил үүсэх магадлал өндөр, төрийн албан хаагчдын цалин, орлого бага, эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул байгаа нь Монгол Улсад авлига үүсэхэд хамгийн ихээр нөлөөлж буй гол шалтгаан гэж дүгнэж болохоор байна.

Түүнчлэн шинжээч, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчдийн үзэж байгаагаар хүмүүсийн сэтгэлгээ, ухамсрын түвшин муу, ёс зүйгүй байдал нь авлига үүсэх шалтгааны бас нэг гол нөхцөл болохыг харууллаа. Авлига үүсэхэд хамгийн ихээр нөлөөлж буй шалтгааныг шинжээчид хариуцлага тооцдоггүй, хөндлөнгийн хяналт сул явдал гэж дүгнэсэн байхад харин иргэд, төрийн албан хаагчид ажилгүйдэл болон ядуурал, бизнес эрхлэгчид төрийн үйлчилгээний хүртээмж муу байгаа нь авлига үүсэх шалтгаан болж байна гэж үзсэн байна.

5. АВЛИГАД ӨРТӨХ ЭРСДЭЛ /АЙМАГ, НИЙСЛЭЛ, САЛБАРААР/

АТГ-аас авлигын индексийг үндэсний түвшинд тооцон гаргахын зэрэгцээ 1/ аймаг, нийслэлээр буюу нутгийн захиргааны байгууллагаар болон 2/ салбараар / авлигад өртөх эрсдлийг/ тооцон гаргаад байна. Энэ нь аймаг, нийслэл салбаруудад авлигад өртөх эрсдлээр нь үнэлэлт дүгнэлт өгөх боломжийг бүрдүүлж байгаа бөгөөд авлигад өртөх эрсдлийг тооцохдоо авлигыг үүсгэгч хүчин зүйлс болон бодит байдлын талаарх шинжээчид, төрийн албан хаагчид, иргэд, бизнес эрхлэгчдийн санаа бодлыг тусгасан 14 төрлийн шалгуур үзүүлэлтийг ашигласан болно.

Авлигад өртөх эрсдэл өндөртэй аймаг /нийслэл/-т 2013 оны байдлаар Завхан (0.54), Хөвсгөл (0.47), Улаанбаатар хот (0.45), Баян-Өлгий (0.44), Сэлэнгэ (0.42) орсон байхад авлигад өртөх эрсдэл багатай аймагт Сүхбаатар (0.23), Архангай (0.27), Өвөрхангай, Булган, Говь-Алтай аймгууд (0.31) орсон байна /Зураг 5./.

Зураг 5. Авлигын индекс болон авлигад өртөх эрсдэл /аймаг, нийслэлээр, 2013 онд/



Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасан бүтцийн дагуу Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудлын хүрээний салбарын авлигад өртөх эрсдэл, авлигын индексийг тооцон гаргав /Зураг 6/.

Зураг 6. Авлигын индекс болон авлигад өртөх эрсдэл
/ЗГ-ын гишүүдийн эрхлэх асуудлын хүрээгээр, 2013 онд/

2013 оны байдлаар Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын (0.44), Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын эрхлэх асуудлын (0.42), Үйлдвэр, хөдөө аж ахуйн эрхлэх асуудлын (0.38), Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын (0.38), Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын (0.37) салбарууд авлигад өртөх эрсдэл өндөртэй гарч байгаа бол Хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын (0.28), Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын болон Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын салбарууд тус бүр (0.30), Эрчим хүчний сайдын болон Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын салбарууд тус бүр (0.32) үнэлгээ авсан нь бусад салбартай харьцуулахад авлигад өртөх эрсдэл бага байгааг судалгааны дүн харуулж байна.

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ 2013 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ 2013 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

1. Судалгааны зорилго

Монгол Улсын ирээдүй болсон хүүхдүүдийн зан үйлийн зөв төлөвшил, ёс суртахуун, хууль сахих болон авлигыг үл тэвчих байдал ямар түвшинд байгааг судлах, цаашид шударга бус зүйлтэй эвлэрэхгүй, шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд хийгдэх авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг чиглүүлэхэд энэхүү судалгааны зорилго оршиж байна юм.

2. Судалгааны арга зүй, түүвэрлэлт

2.1 Судалгааны арга зүй

Судалгааг БНСУ-ын Транспэрэнси интернэшнл байгууллагаас боловсруулан арга зүйн дагуу анх 2008 онд Энэтхэг, БНСУ, Бангладеш, Монгол зэрэг оронд зохион байгуулсан юм. Манай улс энэхүү аргазүйн дагуу “Хүүхдийн шударга байдал” судалгааг 4 дэх удаагаа зохион байгуулаад байна.

Хүүхдийн шударга байдлын судалгааны асуулга нь нийт 12 асуултаас бүрдэж байгаа бөгөөд Хүснэгт 1-д харуулснаар хүүхдийн ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшил, хууль ягштал сахих, авлигыг үл тэвчих байдлыг 3 түвшинд /танин мэдэхүйн, нөлөөллийн, зан үйлийн/ үнэлсэн юм.

Асуулт тус бүрт тухайн хүүхдийн санал нийлж байгаа эсэхийг үнэлүүлсэн бөгөөд шударга байдлын үнэлгээг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн. Шударга байдлын үнэлгээ 5 руу ойртох тусам шударга, 1 рүү ойртох тусам шударга бус гэсэн утгыг илэрхийлнэ.

Хүснэгт 1. Хүүхдийн шударга байдлыг үнэлсэн асуулт, дугаараар

	Ёс зүй / Ёс суртахуун	Зөв төлөвшил	Хууль ягштал сахих	Авлигыг үл тэвчих
Танин мэдэхүйн	3	4	1	2
Нөлөөллийн	6	5	7	8
Зан үйлийн	9	11	10	12

Дээрх хүснэгтийн мөр, багана тус бүрт байгаа үзүүлэлтүүдээр дугаарласан 12 асуулт бүхий асуулгыг хүүхдүүдээр бөглүүлэх замаар судалгааг авсан.

2.2 Түүвэрлэлт

Судалгааны түүврийн хүрээ нь ерөнхий боловсролын сургуулийн 7-11 дугээр ангид сурч буй хүүхдүүд бөгөөд сонгогдсон 7 аймаг, нийслэлийн 3 дүүргийн 800 хүүхдийг санамсаргүй байдлаар сонгон авч судалгаанд хамруулсан юм.

Судалгаанд Төв, Баянхонгор, Сүхбаатар, Архангай, Дархан-Уул, Говьсүмбэр, Баян-Өлгий аймаг, нийслэлийн Баянгол, Баянзүрх, Багануур дүүргийн хүүхдүүд хамрагдав.

2.3 Судалгааны зохион байгуулалт, мэдээлэл цуглуулалт ба боловсруулалт

Хүүхдийн шударга байдлын түвшинг тодорхойлох мэдээллийн эх үүсвэр нь “Хүүхдийн шударга байдал 2013” судалгаа байв. Судалгааны мэдээлэл цуглуулах

ажлыг АТГ-ын Судалгаа шинжилгээний алба Хүүхдийн төлөө үндэсний газартай хамтран зохион байгуулж явуулсан бөгөөд мэдээлэл цуглуулах ажлыг 2013 оны 06 дугаар сарын 15-аас 08 дугаар сарын 28 -ны хооронд хийсэн. “Хүүхдийн шударга байдал судалгаа”-ны мэдээллийг CSPro 5.0 болон Statistics SPSS 21.0 програмыг ашиглан боловсруулав.

БҮЛЭГ II. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1. Хүүхдийн шударга байдал 2013 судалгаанд оролцогчдын нас, хүйсийн бүтэц

Хүүхдийн шударга байдлын судалгаанд нийт 800 хүүхдийг хамруулсан бөгөөд судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 384 буюу 48.00% нь эрэгтэй, 416 буюу 52.00% нь эмэгтэй байлаа (Зураг 1).

Зураг 1. Хүүхдийн шударга байдал судалгаанд оролцсон хүүхдүүд, хүйсээр



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн ангиар нь авч үзвэл 7 дугаар ангийн сурагч 118 буюу нийт хүүхдийн 14.75%, 8 дугаар ангийн сурагч 144 буюу 18.00%, 9 дүгээр ангийн сурагч 173 буюу 21.63%, 10 дугаар ангийн сурагч 178 буюу 22.25%, 11 дүгээр ангийн сурагч 187 буюу 23.38% байв (Зураг 2).

Зураг 2. Судалгаанд хамрагдсан хүүхдийн дүнд эзлэх хувь, ангиар



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг аймаг /судалгаанд хамрагдсан аймгууд/, нийслэлээр авч үзвэл 492 хүүхэд буюу 61.50% нь аймгаас, 308 хүүхэд буюу 38.50% нь нийслэлээс хамрагдсан байна.

Зураг 3. Судалгаанд хамрагдсан хүүхдийн дүнд эзлэх хувь, аймаг, нийслэлээр



2. Хүүхдийн шударга байдал

Хүүхдийн шударга байдлын түвшинг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд уг үзүүлэлт 2013 онд 3.71 гарсан нь 2010 оныхоос 0.48 пункт, 2012 оныхоос 0.78 пунктээр тус тус өссөн байна. Өөрөөр хэлбэл 2010, 2012 оныхоос хүүхдийн шударга байдлын түвшин нэмэгдсэн байна (Зураг 4).

Зураг 4. Хүүхдийн шударга байдлын үнэлгээ, судалгаа явуулсан оноор



Хүүхдийн шударга байдлын түвшинг мөн хүүхдүүдийн насны ангиллаар тус тус үнэлж Зураг 5-д харуулав. Судалгаагаар 12 настай хүүхдийн шударга байдлын түвшин 3.87 байгаа нь бусад насны хүүхдүүдийнхээс өндөр байсан бол 11 настай хүүхдүүдийн хамгийн бага буюу 3.51 гарсан байна.

Зураг 5. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин, насаар



Хүүхдүүдийн шударга байдлыг мөн суралцаж буй ангиар нь авч үзвэл 8 дугаар ангийн хүүхдийн шударга байдлын түвшин 3.79 гарсан нь бусад ангийн хүүхдийнхээс шударга гарсан байна (Зураг 6). Харин 7 болон 11 дүгээр ангийн хүүхдүүдийн шударга байдлын түвшин бусад ангийн хүүхдүүдийнхээс бага гарсан байна.

Зураг 6. Хүүхдийн шударга байдлын түвшин суралцаж буй ангиар /7-11-р анги/



Хүүхдийн шударга байдлын түвшинг аймаг, нийслэлээр авч үзвэл өндөр оноог Дархан-Уул, Говьсүмбэр аймаг авсан байхад бага оноог Баян-Өлгий, Сүхбаатар аймгийн хүүхдүүд авсан байна (Зураг 7).

Зураг 7. Хүүхдийн шударга байдлын түвшин аймаг, нийслэлээр



Хүүхдийн шударга байдлын түвшин хүйсийн хувьд мөн харилцан адилгүй байна. Эмэгтэй хүүхдийн шударга байдлын түвшин 3.73 байгаа нь эрэгтэй хүүхдийн шударга байдлын түвшний 3.69 гэсэн үзүүлэлтээс 0.04 пунктээр илүү байна.

Зураг 8. Хүүхдийн шударга байдлын түвшин, хүйсээр



3. Хүүхдийн шударга байдал, дэд үзүүлэлтээр

Хүүхдийн шударга байдлын түвшинг ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшил, хууль ягштал сахих, авлигыг үл тэвчих гэсэн 4 бүлэг дэд үзүүлэлт тус бүрийн хүрээнд үнэлгээ хийв. Ёс зүй, ёс суртахууны дундаж үнэлгээ 2013 онд 3.80, зөв төлөвшлийн дундаж үнэлгээ нь 3.88, хууль ягштал сахихын дундаж 3.83 гарч өмнөх оныхоос өссөн байхад авлигыг үл тэвчих байдлын дундаж үнэлгээ 3.35 гарч өмнөх оныхоос 0.49 пунктээр буурсан байна. Эдгээр дэд үзүүлэлт тус бүрт нь авч үзье.

Хүснэгт 2. Хүүхдийн шударга байдлын түвшин, дэд үзүүлэлтээр

Дэд үзүүлэлт	2010	2012	2013
Ёс зүй, ёс суртахуун	3.03	2.73	3.80
Зөв төлөвшил	2.51	2.29	3.88
Хууль ягштал сахих	3.54	2.85	3.83
Авлигыг үл тэвчих	4.10	3.84	3.35

3.1 Хүүхдийн ёс суртахууны үнэлгээ

Хүүхдийн шударга байдал 2013 оны судалгаанд оролцсон хүүхдүүдийн ёс суртахууны үнэлгээг ёс суртахууны талаарх ойлголт, ёс зүй, суртахуунд нөлөөлөх нөлөөлөл, одоо тус дэд үзүүлэлт ямар түвшинд байгааг дараахь гурван асуудалтай санал нийлж буй эсэхээр тодорхойлсон.

- Ёс суртахууны талаарх танин мэдэхүйг нь -Сурагчид гэрийн даалгавар хийхдээ интернет болон бусад хүмүүсийн бичсэн нийтлэлийг шууд өөрөө бичсэн мэт ашиглах нь буруу зүйл биш.
- Ёс суртахуунд нөлөөлөх нөлөөллийг -Баян байх нь шударга байхаас илүү чухал зүйл.
- Ёс суртахууны зан үйл нь -Урт дараалалд хүлээж байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээнэ.

Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ нь 3.80 гэсэн үзүүлэлттэй гарсан бөгөөд 2010, 2012 оны дүнтэй харьцуулахад өссөн байгааг зурагт үзүүлэв (Зураг 9).

Зураг 9. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ

Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээг байршлын хувьд авч үзвэл 2013 онд аймгийн хүүхдүүд 3.84 буюу нийслэлийн хүүхдийнхээс 0.04 пунктээр илүү байна. Өмнөх судалгааны дүнгээс хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ байршлын хувьд нэмэгдсэн ч аймгийн хүүхдүүдийн үнэлгээ илүү нэмэгдсэн байна.

Зураг 10. Хүүхдийн ёс суртахууны дэд үзүүлэлтийн үнэлгээ /байршлаар/



Төрийн байгууллагад авлига бий болоход нөлөөлж буй хүчин зүйлсийг 1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их гэсэн үзүүлэлтээр шинжээчид үнэлсэн бөгөөд 2013 онд судалгааны асуулгад оруулсан хүчин зүйлсийн үнэлгээ бүгд өндөр үзүүлэлттэй байна. Энэ байдал 2008 оноос хойшхи 6 жилийн хугацаанд тогтвортой байгаа учир авлигад нөлөөлж буй эдгээр хүчин зүйлсийг бүгдийг нь анхааран үзэх шаардлагатай гэж үзэж болохоор байна.

Зураг 17. Төрийн байгууллага дахь авлигыг бий болгоход нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ /2012, 2013 он/



Хүснэгт 16. Төрийн байгууллага дахь авлигыг бий болгоход нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ /2008-2013 он/

Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	2011	2012	2013
Хүнд суртал	4.47	4.75	4.67	4.00	4.38	4.67
Олон шат дамжлага, давхардал	4.33	4.54	4.75	4.31	4.54	4.46
Төрийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй, шударга бус байдал	3.73	4.38	4.58	4.08	4.33	4.15
Шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг	4.67	4.38	4.58	4.00	4.38	4.23
Албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж хязгаарлагдаагүй байдал	4.86	4.23	4.33	4.23	4.23	3.92
Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал	4.53	4.62	4.33	4.54	4.46	4.00
Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт дутагдалтай	4.40	4.15	4.75	4.46	4.69	4.23
Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих төсвийн ерөнхийлөн захирагчид тавих хяналт сул	4.00	4.17	4.58	4.23	4.38	4.17
Албан хаагчийн цалин, орон сууц, нийгмийн баталгаа хангалтгүй	3.47	4.00	4.17	4.00	4.23	4.31
Төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын ур чадвар дутагдалтай	4.27	4.08	4.33	4.15	4.50	4.46

Авлигыг бууруулахын тулд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааны үнэлгээ

Шинжээчдийн ихэнх нь авлигыг бууруулахын тулд сонгуулийн тогтолцоог өөрчлөх шаардлагатай гэж үзжээ. Түүнчлэн аливаа шийдвэр гаргахад нийтийн ашиг сонирхлыг харгалзан үзэх механизм бий болгох, сонгуулийн санхүүжилтийн тогтолцоог өөрчлөх зэрэг арга хэмжээ нэн тэргүүнд шаардлагатай болох нь судалгааны дүнгээс харагдаж байна.

Шинжээчдийн зарим хэсэг нь Монгол Улсад авлигыг бууруулахын тулд иргэдийн эрх зүйн ухамсрыг нэмэгдүүлэх, намын санхүүжилтийн зарчмыг өөрчлөх зэрэг арга хэмжээ авах шаардлагатай гэж үзсэн бол цөөн хэсэг нь улс төрийн намын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлагатай гэжээ. Харин улс төрчдийн ёс зүйн хэм хэмжээг бий болгож мөрдүүлэх нь авлигатай тэмцэхэд зайлшгүй шаардлагатай гэж нэг ч шинжээч үзээгүй байгаа нь олон нийтийн зүгээс улс төрчдөд итгэх итгэл, тэднийг өөрчлөгдөнө гэх найдвар алдагдаж байгааг харуулж байна.

Хүснэгт 17. Авлигыг бууруулахад нэн тэргүүнд шаардлагатай үйл ажиллагааны үнэлгээ

Авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээ	%
УИХ, орон нутгийн ИТХ-ын сонгуулийн тогтолцоог өөрчлөх	53.85
Шийдвэр гаргахад нийтийн ашиг сонирхлыг харгалзан үзэх механизм бий болгох	46.15
Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн тогтолцоог өөрчлөх	38.46
Иргэдийн эрх зүйн ухамсрыг нэмэгдүүлэх	30.77
Намын санхүүжилтийн зарчмыг өөрчлөх	30.77
Авлигчдад хүлээлгэх эрүүгийн болон захиргааны хариуцлагыг чангатгах	23.08
Улс төрчдийн авлигатай тэмцэх хүсэл зоригийг нэмэгдүүлэх	23.08
Хээл хахууль өгсөн этгээдийг хариуцлагаас чөлөөлж, хээл хахууль авсан этгээдэд хариуцлага оноодог болох	15.38
Улс төрийн намын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх	15.38
Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх	15.38
Улс төрчдийн ёс зүйн хэм хэмжээг бий болгож мөрдүүлэх	0.00

Шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгааны дүн

Шүүх, хуулийн байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Шүүх эрх мэдлийн хүрээнд хамаарах шүүх, прокурорын байгууллага болон хууль сахиулах байгууллагууд болох цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын авлигад өртөх эрсдлийг 1-огт үгүй, 2-бага зэрэг, 3-дунд зэрэг, 4-их, 5-маш их гэсэн үзүүлэлтээр шинжээчдээр үнэлүүлэв.

Зураг 18. Шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ



2013 онд шүүхийн авлигад өртөх эрсдэл дунд зэрэг байна гэж шинжээчид үзсэн бөгөөд үүнээс аймаг, нийслэлийн шүүхийн авлигад өртөх эрсдэл шүүхүүдийн дунджаас дээгүүр, харин сум буюу сум дундын, дүүргийн шүүх, Захиргааны хэргийн шүүхийн авлигад өртөх эрсдэл шүүхүүдийн дунджаас бага байна. Улсын Дээд шүүхийн авлигад өртөх эрсдлийн хэмжээ шүүхүүдийн дундажтай адил түвшинд байна.

Хүснэгт 18. Шүүх, хуулийн байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Салбар /он	2009	2010	2011	2012	2013
Шүүх /дундаж/	3.49	3.46	3.62	2.89	3.00
Прокурор /дундаж/	3.12	3.75	3.40	2.86	3.00
Цагдаа /дундаж/	3.50	3.48	3.53	3.35	3.15
Шүүхийн шийдвэр гүйцэтгэл /дундаж/	3.21	3.30	3.50	3.02	3.15

Хүснэгт 19. Шүүхийн авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Шүүхүүд	2012	2013
Сум буюу сум дундын, дүүргийн шүүх	3.00	2.92
Аймаг, нийслэлийн шүүх	3.08	3.23
Захиргааны хэргийн шүүх	2.73	2.85
Улсын Дээд шүүх	2.75	3.00
Шүүх /дундаж/	2.89	3.00

Хүснэгт 20. Хуулийн байгууллагуудын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Салбар / он	2009	2010	2011	2012	2013
Сум дунд, дүүргийн прокурорын газар	3.18	3.75	3.55	3.08	3.08
Аймаг, нийслэл, тээврийн прокурорын газар	3.27	3.92	3.55	3.00	3.17
Улсын Ерөнхий прокурорын газар	2.91	3.58	3.10	2.50	2.75
Прокурор /дундаж/	3.12	3.75	3.40	2.86	3.00
Мөрдөн байцаах газар	3.82	3.75	3.73	3.33	3.54
Хэрэг бүртгэлт	3.55	3.50	3.89	3.33	3.08
Эрүүгийн цагдаагийн газар	3.82	3.50	3.70	3.17	3.31
Хэв журмын алба	2.91	3.45	3.30	3.33	2.69
Замын цагдаагийн газар	3.82	3.83	3.91	3.67	3.54
Аймаг, Нийслэл, ТЗ-ын цагдаагийн газар, хэлтэс				3.25	3.00
Цагдаагийн ерөнхий газар	3.09	2.82	2.63	3.36	2.92
Цагдаа /дундаж/	3.50	3.48	3.53	3.35	3.15
Аймгийн шийдвэр гүйцэтгэх албад	3.45	3.70	3.80	3.00	3.08
Хорих ангиуд	3.36	3.20	3.70	3.08	3.31
Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар	3.45	3.70	3.80	3.08	3.30
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	2.82	3.00	3.00	2.91	2.92
Шүүхийн шийдвэр гүйцэтгэл /дундаж/	3.21	3.30	3.50	3.02	3.15

2013 онд прокурорын байгууллагын авлигад өртөх эрсдэл дунд зэрэг байна гэж шинжээчид үзсэн бөгөөд сум дундын, дүүргийн, аймаг, нийслэл, тээврийн прокурорын газруудын авлигад өртөх эрсдэл энэ түвшнээс дээгүүр, Улсын ерөнхий прокурорын газрын авлигад өртөх эрсдэл прокурорын байгууллагын дунджаас доогуур байна.

Цагдаагийн байгууллагын авлигад өртөх эрсдэл 2013 онд дунд зэрэг байна гэж шинжээчид үзсэн ба цагдаагийн байгууллага дотроо Замын цагдаагийн газар, Мөрдөн байцаах газар, Эрүүгийн цагдаагийн газрын авлигад өртөх эрсдэл хамгийн өндөр, Цагдаагийн Ерөнхий газрынх хамгийн бага байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын авлигад өртөх эрсдэл 2013 онд дунд зэрэг байна гэж шинжээчид үзсэн бөгөөд салбар дотроо хорих ангиуд болон нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газрын авлигад өртөх эрсдэл хамгийн өндөр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын авлигад өртөх эрсдэл хамгийн бага байна.

2013 оны үзүүлэлтийг 2012 оныхтой харьцуулбал сум буюу сум дундын, дүүргийн шүүх, цагдаагийн хэрэг бүртгэлт, хэв журмын алба, Замын цагдаагийн газар, аймаг, нийслэл, Төмөр замын цагдаагийн газар, хэлтсүүд, Цагдаагийн ерөнхий газрын авлигад өртөх эрсдэл буурсан байгаагаас цагдаагийн хэв журмын алба болон цагдаагийн төв байгууллагын эрсдэл хамгийн их буурчээ. Авлигын эрсдэл нь өмнөх оныхоос нэмэгдсэн байгууллагууд дотроос Улсын дээд шүүх болон Улсын Ерөнхий прокурорын газрын авлигад өртөх эрсдэл хамгийн их нэмэгдсэн байна.

2009 оноос 2013 он хүртэлх 5 жилийн дунджаар цагдаагийн байгууллагын авлигад өртөх эрсдэл хамгийн өндөр байх бөгөөд шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын авлигад өртөх эрсдлийн дундаж нь ойролцоо түвшинд байна.

Хуулийн байгууллага дахь тодорхой үйл ажиллагааны авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Хуулийн байгууллага дахь тодорхой үйл ажиллагааны авлигад өртөх эрсдлийн үнэлгээг 1-огт үгүй, 2-бага зэрэг, 3-дунд зэрэг, 4-их, 5-маш их гэсэн үзүүлэлтүүдээр үнэлүүлэхэд шинжээчид 2013 онд албадан дуудлага худалдаа, эрүүгийн хэрэг үүсгэх, үүсгэхээс татгалзах, хэрэгсэхгүй болгох, анхан шатны болон давж заалдах шатны шүүхээр хэргийг хэлэлцэх зэрэг эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагааны авлигад өртөх эрсдэл харьцангуй өндөр байна гэж үзжээ.

2013 оны үзүүлэлтийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулж үзвэл албадан дуудлага худалдаа, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, эрүүгийн хэргийг анхан шатны шүүх болон давж заалдан шатны шүүх хянан шийдвэрлэх, захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, хорих ял эдлүүлэх, тодорхой хугацаагаар эрх хасах захиргааны хариуцлага ногдуулахтай холбоотой үйл ажиллагааны авлигын эрсдэл нэмэгдэж, бусад үйл ажиллагааны авлигын эрсдэл буурсан байна.

Зураг 19. Хуулийн байгууллага дахь тодорхой үйл ажиллагааны авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Хүснэгт 21. Хуулийн байгууллага дахь тодорхой үйл ажиллагааны авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Үйл ажиллагаа /он	2009	2010	2011	2012	2013
Эрүүгийн хэрэг үүсгэх	3.90	3.92	3.67	3.67	3.58
Эрүүгийн хэрэг үүсгэх санал гаргах	3.27	3.44	3.22	3.45	3.42
Эрүүгийн хэрэг яллахаас татгалзах	3.18	3.45	3.80	3.50	2.91
Тодорхой хугацаагаар эрх хасах		3.83	3.44	3.09	3.42
Торгууль ногдуулах	3.36	3.75	3.63	3.36	3.27
Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах	3.58	4.00	4.10	3.36	3.50
Прокурор эрүүгийн хэрэг хянах	3.22	4.09	3.78	3.40	3.27
Прокурорын байгууллага эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох	3.64	4.40	3.91	3.75	3.50
Прокурорын байгууллага яллах дүгнэлт үйлдэх	3.33	3.70	3.44	3.55	3.25
Ялын хэмжээг бууруулах	3.60	4.00	4.11	3.45	3.36
Эрүүгийн хэргийг анхан шатны шүүх хянан шийдвэрлэх	3.64	3.90	3.89	3.36	3.45
Эрүүгийн хэргийг давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэх	3.27	3.88	3.89	3.27	3.45
Эрүүгийн хэргийг хяналтын шатны шүүх хянан шийдвэрлэх		3.78	4.11	3.36	3.00
Захиргааны хэргийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх	3.00	3.38	3.44	2.73	3.09
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх /эрүүгийн/	3.40	3.50	3.55	3.36	2.75
Хорих ял эдлүүлэх		3.30	3.50	2.64	2.92
Өр барагдуулах		4.00	4.20	3.73	3.36
Хугацаанаас нь өмнө тэнсэн суллах, дэглэм бууруулах		4.13	4.00	3.09	2.91
Хорих ангид ялтан хуваарилах	3.25	3.67	3.90	3.18	2.83
Ялтныг урамшуулах	3.11	3.62	4.44	3.10	2.50
Албадан дуудлага худалдаа	3.22	3.13	3.67	3.10	4.00
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх /иргэний/	3.56	3.71	4.00	3.64	3.45

Авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ

Хууль хяналтын байгууллагад авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг 1-огт үгүй, 2-бага зэрэг, 3-дунд зэрэг, 4-их, 5-маш их гэсэн үзүүлэлтээр үнэлүүлэхэд 2013 онд хууль хяналтын байгууллагын албан хаагчийн ёс зүйг сахиулах, хариуцлага тооцох механизмын дутагдалтай байдал авлига үүсэхэд хамгийн их нөлөөлсөн гэж шинжээчид үзсэн байна. Нөлөөллийн үзүүлэлтээрээ үүний дараа албан хаагчдын цалин хангамж, ажиллах нөхцөл хангалтгүй байдал орж байна.

2013 оны үзүүлэлтүүд 2012 оныхоос бүгд өссөн байх бөгөөд хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц бүрэн хуульчлагдаагүй байдлын үнэлгээ болон хууль хяналтын байгууллагын албан хаагчийн цалин хангамж, ажиллах нөхцөл хангалтгүй байдал хамгийн ихээр өсчээ. Өөрөөр хэлбэл, эдгээр нөхцөл байдлын авлига үүсэхэд нөлөөлөх нөлөөлөл нь 2013 онд өссөн байна.

2009 оноос 2013 он хүртэлх 5 жилийн дундаж үзүүлэлтээр хууль хяналтын байгууллагын албан хаагчийн ёс зүй, хариуцлага тооцох механизм дутагдалтай байдал, хууль хяналтын байгууллагын албан хаагчийн цалин хангамж, ажиллах нөхцөл хангалтгүй байдал авлига үүсэхэд хамгийн ихээр нөлөөлж байсан нь 2013 оны судалгааны үр дүнтэй адил байна.

Зураг 20. Авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ

Хүснэгт 22. Авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ

Авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ	2009	2010	2011	2012	2013
Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.64	3.75	3.92	3.55	4.08
Хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц бүрэн хуульчлагдаагүй	3.42	3.64	4.00	2.91	4.17
Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааны давхардал, чирэгдэл, үр өгөөжгүй, хяналтгүй байдал	3.67	4.00	4.40	3.45	3.92
Хууль хяналтын байгууллагын албан хаагчийн цалин хангамж, ажиллах нөхцөл хангалтгүй	4.00	4.00	4.27	3.30	4.31
Хууль хяналтын байгууллагын албан хаагчийн ёс зүй, хариуцлага тооцох механизм дутагдалтай	3.73	4.00	4.33	4.09	4.62

Хуулийн байгууллагын албан тушаалтан бусад албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөн оролцож буй хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

Хуулийн байгууллагын албан тушаалтнаас бусад албан тушаалтны үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөн оролцож буй үйл ажиллагааны хэлбэрүүдийн тархацыг 1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их гэсэн үзүүлэлтээр

үнэлүүлэхэд 2013 онд хууль бусаар дотоод үйл ажиллагаанд нь оролцох, шан харамж нэхэх зэрэг үйлдлийг дунд зэрэг хэрэглэсэн, харин албан тушаалтны зөрчлийг илрүүлж түүгээр нь дарамтлах, хууль бус шаардлага тавих, дарамт шахалт үзүүлэх зэрэг хэлбэрүүдийг тэдгээрээс илүү их хэрэглэсэн гэж шинжээчид үзсэн байна.

2013 онд албан тушаалтны гаргасан зөрчлөөр нь дарамт шахалт үзүүлэх хэлбэрийн үзүүлэлт өмнөх оныхоос нэмэгдэж, бусад хэлбэрийн үзүүлэлт буурснаас хууль бусаар дотоод үйл ажиллагаанд нь оролцох үйл ажиллагааны үзүүлэлт хамгийн их буурсан байна.

2009 оноос 2013 он хүртэлх 5 жилийн дунджаар албан тушаалтны зөрчлийн илрүүлж дарамтлах үйл ажиллагаа хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа бөгөөд шан харамж нэхэхтэй холбоотой хэлбэр хамгийн бага үзүүлэлттэй байна.

Зураг 21. Хуулийн байгууллагын албан тушаалтан бусад албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөн оролцож буй хэлбэрүүдийн тархцын үнэлгээ (2012, 2013 он)

Хүснэгт 23. Хуулийн байгууллагын албан тушаалтан бусад албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөн оролцож буй хэлбэрүүдийн тархцын үнэлгээ, 2009-2013 он

Хэлбэр / он	2009	2010	2011	2012	2013
Дарамт шахалт үзүүлэх	3.64	3.58	3.82	3.83	3.42
Шан харамж нэхэх	3.00	3.13	3.38	3.27	2.92
Хууль бусаар дотоод үйл ажиллагаанд оролцох	3.42	3.83	3.70	3.60	3.00
Хууль бус шаардлага тавих	3.67	3.85	3.70	3.73	3.45
Албан тушаалтны зөрчлийг илрүүлж түүгээр нь дарамтлах	4.00	4.22	4.33	3.58	3.73

Ашигтай, давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахын тулд хэрэглэдэг үйлдлүүдийн давтамжийн үнэлгээ

Хуулийн байгууллагын албан тушаалтнаар өөрт ашигтай шийдвэр гаргуулахын тулд хэрэглэдэг үйлдлийн давтамжийг тархацыг 1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их гэсэн үзүүлэлтээр үнэлгээ хийлгэхэд 2013 онд мөнгө хөрөнгө өгөх, өөрт нь болон гэр бүлийхэнд нь бэлэг өгөх, ажилд оруулах зэрэг үйлдлүүдийг илүү их хэрэглэсэн гэж шинжээчид үзсэн байна.

2013 оны үзүүлэлтийг өмнөх оныхтой харьцуулбал хувьцаа өгөх болон гэр бүлийнхэнд нь өндөр үнэтэй бэлэг өгөх үйлдлүүдийн үзүүлэлт нэмэгдэж, бусад үйлдлүүдийн үзүүлэлт буурсан байна.

2009 оноос 2013 он хүртэлх 5 жилийн дундаж үзүүлэлтээр хөрөнгө, мөнгө өгөх,

бэлэг өгөх, улс төрийн хамгаалалтад авах, албан тушаалд томилох зэрэг үйлдлийн үзүүлэлт хамгийн өндөр буюу хамгийн их давтамжтай, хувьцаа өгөх, гадаад банканд данс нээх, эмчилгээ сувилгаа, сургалтын зардал даах үйлдлүүдийн үзүүлэлт хамгийн бага байна.

Зураг 22. Албан тушаалтнаар ашигтай, давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахын тулд хэрэглэдэг үйлдлүүдийн давтамжийн үнэлгээ (2012, 2013)

Хүснэгт 24. Албан тушаалтнаар ашигтай, давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахын тулд хэрэглэдэг үйлдлүүдийн давтамжийн үнэлгээ (2009- 2013)

Үйлдэл /он	2009	2010	2011	2012	2013
Мөнгө /хөрөнгө/ өгөх	4.08	4.08	4.44	4.09	3.82
Хувьцаа өгөх	2.00	3.00	3.00	1.71	2.57
Гадаад банкинд данс нээж өгөх	1.67	2.50	3.67	2.14	2.00
Олсон ашиг, орлогоо хуваахаар амлах	3.30	4.00	3.86	3.80	3.36
Аялал, жуулчлалын зардал даах	2.91	3.38	2.57	3.40	3.11
Гадаад арга хэмжээний зардал даах	2.50	3.75	3.17	3.45	3.13
Бэлэг өгөх	4.08	4.09	3.90	4.18	3.75
Ажилд оруулах	2.50	3.40	3.33	-	3.55
Эмчилгээ, сувилгааны зардал даах	2.63	3.17	2.71	3.10	3.13
Сургалтын зардал даах	2.63	3.25	2.86	3.00	2.78
Шаардлагагүй албан тушаал бий болгох	-	-	-	3.78	3.09
Бооцоот тоглоомд санаатайгаар хожигдох	2.89	4.22	3.88	3.11	3.00
Зээл өгөх	-	-	-	3.40	3.09
Гэр бүлийнхэнд нь өндөр үнэтэй бэлэг өгөх	3.11	3.83	3.38	3.00	3.56
Өр, зээлийг нь төлөх	3.33	3.75	3.44	3.00	2.60
Төрийн одон, медаль, шагналаар шагнах	3.14	3.71	4.00	3.10	3.00
Албан тушаалд томилох	3.60	3.73	3.80	3.55	3.25
Улс төрийн хамгаалалтанд авах	2.83	4.14	4.29	3.60	3.20
Хэн нэгэнд зориулж ажлын байр шинээр бий болгох	3.00	3.25	4.00	3.78	2.99

Шүүх, хуулийн байгууллагын хүрээн дэх авлигын өртөг

Шүүх, хуулийн байгууллагын тодорхой үйл ажиллагааны үе дэх авлигын өртгийн талаарх мөнгөн дүнгээр илэрхийлэгдсэн үзүүлэлт бүхий таамаглал болон төсөөллийн үнэлгээг шинжээчдээр хийлгэв. 2013 оны судалгааны хүрээнд шинжээчдийн төсөөллөөр ажил, албан тушаалд ороход 7.7 сая төгрөг, эрүүгийн хэрэг үүсгэхэд 2.1 сая төгрөг, ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргуулахад 5.3 сая төгрөг, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед хэрэг хэрэгсэхгүй болгоход 10.2 сая төгрөг, шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход 15.8 сая төгрөг авлигад зарцуулагддаг байж болзошгүй байна.

2013 оны үзүүлэлтийг өмнөх оныхтой харьцуулбал шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход зарцуулдаг байж болох авлигын өртгийн хэмжээний төсөөллийн үзүүлэлт 2.6 сая төгрөгөөр нэмэгдэж дурдагдсан бусад үйл ажиллагааны үе дэх авлигын өртгийн хэмжээний төсөөллийн үзүүлэлтүүд буурчээ. Үүнд ажил, албан тушаалд орох үеийн авлигын өртгийн хэмжээний төсөөллийн үзүүлэлт 23.7 сая төгрөгөөр буурсан бол ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргуулахад зарцуулдаг авлигын өртгийн хэмжээний төсөөллийн үзүүлэлт 11.5 сая төгрөгөөр, эрүүгийн хэрэг үүсгэхтэй холбоотой авлигын өртгийн хэмжээний төсөөллийн үзүүлэлт 12.2 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Хэрэг бүртгэх, мөрдөн байцах шатанд хэргийг хэрэгсэхгүй болгохтой холбоотой авлигын өртгийн хэмжээний төсөөллийн үзүүлэлт 2012 оныхоос 2013 онд 2.5 сая төгрөгөөр буурсан нь дээрх үзүүлтүүдээс харьцангуй доогуур байна.

Зураг 23. Шүүх, хуулийн байгууллагын хүрээн дэх авлигын өртөг, сая төгрөгөөр (2012, 2013 он)

Авлигын хэлбэрийн үнэлгээ

Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын албан тушаалтанд хээл хахууль өгөх, авах арга тус бүрийн тархацыг 1-огт үгүй, 2-бага зэрэг, 3-дунд зэрэг, 4-их, 5- маш их гэсэн үзүүлэлтээр үнэлүүлэхэд 2013 онд өмгөөлөгчөөр болон зуучлагчаар дамжуулан хээл хахууль өгөх, эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах, ойр дотнын хүмүүсээр нь дамжуулан хээл хахууль өгөх зэрэг хэлбэрүүд харьцангуй илүү тархалттай байна гэж шинжээчид үзсэн байна.

2013 онд 2013 оны судалгааны дүнг өмнөх оны дүнтэй харьцуулбал мөнгө зээлдүүлээд мартах үйлдлээс бусад хэлбэрийн үзүүлэлт буурсан байна. Үүнд хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх, хахууль авагчид шууд өөрт нь өгөх, ойр дотнын хүмүүсээр нь дамжуулах зэрэг үйлдлүүдийн үзүүлэлт хамгийн их буурчээ.

2009 оноос 2013 оны хоорондох 5 жилийн дундаж үзүүлэлтээр өмгөөлөгчөөр

болон зуучлагчаар дамжуулах, ойр дотнын хүн, гэр бүлийн гишүүд, тэдгээрийн өмчийн компанид давуу байдал олгох зэрэг үйлдлүүд хамгийн өндөр үзүүлэлттэй байхад хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх, эд зүйлийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах зэрэг үйлдлүүд хамгийн бага үзүүлэлттэй байна.

Зураг 24.Авлигын хэлбэрийн үнэлгээ

Хүснэгт 25. Авлигын хэлбэрийн үнэлгээ

Хэлбэр / он	2009	2010	2011	2012	2013
Шууд өөрт нь өгөх	2.90	3.17	3.64	3.56	2.78
Зуучлагчаар дамжуулах	3.60	3.73	4.20	3.82	3.55
Өмгөөлөгчөөр дамжуулах	3.80	3.82	4.11	4.10	3.67
Ойр дотны хүмүүсээр нь дамжуулах	3.00	3.22	3.67	3.90	3.20
Хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх	2.29	2.80	2.86	3.43	2.20
Ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдгээрийн өмчийн компанид давуу байдал олгох	3.33	3.33	3.88	3.75	3.11
Эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах	3.00	3.14	3.63	3.10	2.89
Эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах	3.00	3.17	3.86	3.86	3.33
Мөрийтэй тоглож санаатайгаар алдах	2.78	3.63	3.75	3.14	2.60
Мөнгө зээлдүүлээд мартах	3.44	3.57	3.63	2.86	2.90

Авлигын улмаас бий болсон хөрөнгө, орлогын зарцуулалтын үнэлгээ

Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын албан тушаалтнууд авлигаар олсон хөрөнгөө хэрхэн зарцуулдаг талаарх шинжээчдийн төсөөллийг 5-тийм, 1-үгүй, 3- эргэлзэж байна гэсэн үзүүлэлтээр үнэлүүлэв. 2013 онд өөрийн болон гэр бүлийн бизнест хувь оруулах, өдөр тутмынхаа хэрэгцээнд зориулах, хүүхдийнхээ сургалтын төлбөрт зориулах, зугаа цэнгэлд зарцуулах, орон сууц худалдан авах зэрэг хэлбэр илүү байсан гэж шинжээчид нар үзсэн байна.

2013 оны үзүүлэлтийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулбал үл хөдлөх хөрөнгө худалдан авах, гадаадын банканд хадгалах, машин худалдан авах, зугаа цэнгэлд зарцуулах зэрэг хэлбэрүүдийн үзүүлэлт буурсан бол өдөр тутмын хэрэгцээнд зарцуулах, хүүхдийн сургалтын төлбөрт зарцуулах, хувьцаа худалдан авах, дотоодын банкинд хадгалах зэрэг хэлбэрийн үзүүлэлт өссөн байна.

Зураг 25. Авлигын замаар олсон хөрөнгийн зарцуулалтын хэлбэрийн үнэлгээ

Хүснэгт 26.Авлигын замаар олсон хөрөнгийн зарцуулалтын хэлбэрийн үнэлгээ

Зарцуулалт /он	2009	2010	2011	2012	2013
Өдөр тутмынхаа хэрэгцээнд зориулах	4.75	4.78	5.00	4.80	5.00
Дотоодын банкинд хадгалдаг	3.25	3.00	4.00	3.00	3.29
Гадаадын банкинд хадгалдаг	2.64	3.00	3.80	3.67	2.71
Хувьцаа худалдан авдаг	2.83	3.00	3.86	2.43	3.33
Машин худалдан авдаг	5.00	4.56	4.78	4.00	3.67
Орон сууц худалдан авдаг	3.33	4.56	4.78	4.00	4.00
Үл хөдлөх хөрөнгө худалдан авдаг	5.00	4.25	1.00	4.11	3.67
Өөрийн болон гэр бүлийн бизнест хувь оруулах	3.00	3.67	4.43	5.00	5.00
Зугаа цэнгэлд зарцуулдаг	5.00	4.78	4.50	4.40	4.33
Хүүхдийнхээ сургалтын төлбөрт зориулдаг	3.33	4.50	5.00	4.25	4.75

Шүүх, хуулийн байгууллагын хүрээн дэх авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээний ач холбогдлын түвшин

Шүүх, хуулийн байгууллагын хүрээн дэх авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээний ач холбогдлыг түвшинг шинжээчдээр 1-огт шаардлагагүй, 2-нэг их шаардлагатай биш, 3-эргэлзэж байна, 4-ер нь шаардлагатай, 5-нэн тэргүүнд шаардлагатай гэсэн үзүүлэлтүүдээр үнэлүүлэхэд хууль хяналтын байгууллагын чадавхийг сайжруулах, ур чадварт үндэслэн томилгоо хийх, байгууллагын ил тод байдлыг нэмэгдүүлэх, албан тушаалтныг чөлөөлөх, өөрчлөх, халах шударга, ил тод механизм бий болгох, албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх механизмыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх, тогтвортой ажиллах баталгааг сайжруулах зэрэг арга хэмжээ нэн тэргүүнд шаардлагатай гэж шинжээчид үзсэн байна.

Зураг 26. Авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээний ач холбогдлын түвшин

ДҮГНЭЛТ

- ✓ Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа 2008 оноос хийгдэж эхэлснээс хойшхи 6 жилийн хугацааны хамгийн бага үзүүлэлт буюу 3.68 гэсэн үзүүлэлттэй гарлаа. Ингэж гарахад улс төрийн хүрээний авлигын төсөөллийн 2013 оны үзүүлэлт 2012 оныхоос 0.3 пунктээр буурсан нь голлон нөлөөлсөн байна.
- ✓ Монгол Улс дахь улс төрийн институциудын авлигад өртөмтгий байдлын дундаж үзүүлэлт жил бүр буурч байгаа нь эерэг үзүүлэлт болж байна.
- ✓ Уул уурхай, дэд бүтэц, барилгын салбарт улс төрийн хүрээний авлигын үйл ажиллагаа голлон чиглэгдэж байгаа болон төрийн захиргааны төв байгууллагуудын дээд болон дунд түвшний удирдлагын авлигад өртөх эрсдэл өндөр байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Эндээс уул уурхай, дэд бүтэц, барилга хот байгуулалтыг хариуцсан салбарын яамдын удирдах албан тушаалтнууд авлигад холбогдох эрсдэл ихтэй гэж дүгнэж болохоор байна.
- ✓ Төрийн албан дахь төрийн томилгоо болон бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхол улс төрд нөлөөлж буй байдал нь улс төрийн хүрээний авлигад хүчтэй нөлөөлж буй хүчин зүйлс болоод байна. Эдгээрээс гадна улс төрийн намын санхүүжилтийн механизм, сонгуулийн санхүүжилтийн механизм, сонгуулийн өнөөгийн тогтолцоо зэрэг улс төрийн нам, сонгуультай холбоотой хүчин зүйлс улс төрийн хүрээний авлига үүсэхэд ихээхэн нөлөөлж байна. Улсын Их Хурлын үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил нь мөн улс төрийн авлигад их нөлөөтэй болохыг судалгааны дүн харуулж байна.
- ✓ Улс төрийн авлигын олон хэлбэрүүдээс нам болон сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой, ялангуяа намын болон сонгуулийн санхүүжилтийн

асуудал илүү ноцтой байна.

- ✓ Төрийн албан тушаалтнаар өөрт ашигтай, давуу тал бий болгох шийдвэр гаргуулахын тулд олон янзын арга зам хэрэглэдэг боловч тухайн албан тушаалтанд мөнгө хөрөнгө өгөх, түүнийг албан тушаалд томилох, цалин өндөртэй ажилд оруулах, олсон ашиг орлогоо хуваахаар амлах, өр зээлийг нь төлөх зэрэг арга замуудыг ихээхэн ашигладаг болохыг судалгааны дүн харуулж байна. Албан тушаалын томилгооны асуудал энд мөн дурдагдаж байгаад анхаарал хандуулах шаардлагатай.
- ✓ Улс төрчдийн зүгээс албан тушаалын томилгоо, тусгай зөвшөөрөл, төрийн үйлчилгээ, шүүх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, мэргэжлийн хяналт зэрэг хяналтын үйл ажиллагаа, татвар зэрэг төрийн янз бүрийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс хутгалдан оролцож, нөлөөлөхдөө ихэнхдээ холбогдох албан тушаалтанд дарамт шахалт үзүүлдэг болохыг судалгаа харуулж байна. Энэ байдлаас улс төрчдийн ёс зүйн хэм хэмжээ ихээхэн алдагдсан, тэдэнтэй хариуцлага тооцох механизм сул байгаа гэж дүгнэж болохоор байна.
- ✓ Улс төрийн хүрээний авлига уул уурхай, дэд бүтцийн салбартай ихээхэн холбогдож байгаа нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилд ноцтой хохирол учруулж болзошгүй байна.
- ✓ Улс төрийн хүрээний авлига нь намд хандив авах, хувийн ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, ийм шийдвэр гаргуулахын тулд лоббидох, улс төрийн зорилготой хандив өгөх, авах, сонгогчдын саналыг худалдан авах, төрийн өмчийг ашиглан шамшигдуулах, хувьдаа завших, өөрийн эрх мэдлээ худалдах, бизнесийн бүлэглэлийн нөлөөнд автах зэрэг хэлбэрээр зонхилон илэрч байгаа нь Монгол Улс дахь улс төр болон бизнесийн бүлэглэлүүд хоорондоо нэгдэж нэг ашиг сонирхолтой болсон байж болзошгүй, бизнесийн бүлэглэлүүд улс төрчдийг гартаа оруулж өөрсдийн хүссэн шийдвэрийг гаргуулах боломжтой болсонтой холбоотой байж болох юм.
- ✓ Улс төрийн хүрээн дэх эрх ашгийн эрэмбээр нийтийн эрх ашиг хамгийн доод түвшинд байна.
- ✓ Улс төрийн авлига илүү их зохион байгуулалттай, илүү далд хэлбэртэй болж байгаа нь цаашид ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- ✓ Уул уурхай, дэд бүтэц, барилгын салбарын төрийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтнуудын авлигын өндөр эрсдэлтэй байгааг анхааран холбогдох урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ авах шаардлагатай. Түүнчлэн албан тушаалын томилгоог улс төрийн намын харъяалал, танил тал, нэг аймаг, нэг нутаг, найз нөхөр гэсэн байдлаар хийхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал байна.
- ✓ Улс төрийн авлигын олон хэлбэрүүдээс нам болон сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой, ялангуяа намын болон сонгуулийн санхүүжилтийн асуудал илүү ноцтой байгаад анхаарал хандуулж, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, улс төрийн шинжтэй, намын гишүүнчлэлээр албан тушаалд томилдог байдлыг өөрчлөх шаардлагатай.
- ✓ Нийтийн эрх ашгийг эрхэмлэн дээдлэх, ёс зүйтэй байх, хариуцлага хүлээх чадвартай байх явдал улс төрчдөд дутагдаж байгаад анхаарал хандуулах хэрэгтэй байна. Улс төрийн үйл ажиллагааг бизнесийн үйл ажиллагаанаас зааглах, төрийн үйл ажиллагаанд намчирхдаг, нутгархдаг байдлыг таслан

зогсоох шаардлагатай. Үүний тулд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зохицуулалтыг улам боловсронгуй болгох, уг хуулийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хатуу хяналт тавих, зөрчил бүрд арга хэмжээ авах, улс төрчдөд ёс зүйн хариуцлага хүлээлгэх механизмыг бүрдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

- ✓ Төрийн байгууллага дахь авлига бий болоход голлон нөлөөлж буй хүчин зүйлсийн эсрэг шаардлагатай арга хэмжээ авах, үүнд төрийн албан хаагчдын ёс зүй, ажлын ур чадварыг дээшлүүлэх, тэдний цалин, нийгмийн баталгаатай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх, төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналтыг чангатгах, албан тушаалтан өөрийн үзэмжээр асуудлыг шийдвэрлэдэг байдлыг таслан зогсоох эрх зүй, зохион байгуулалт, хүний нөөцийн холбогдох арга хэмжээ авах, төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, олон шат дамжлагыг цөөлөх шаардлагатай.
- ✓ Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллага дахь авлига, ашиг сонирхлын зөрчлийг арилгахын тулд юуны өмнө тухайн байгууллагын чадавхийг бэхжүүлэх, үүний тулд ур чадварт үндэслэсэн томилгоо хийх, байгууллагын ил тод байдлыг нэмэгдүүлэх, хяналт тавих, хариуцлага хүлээлгэх тогтолцоог боловсронгуй болгох нь зүйтэй.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ 2014 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ 2014 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

1.1. Төрийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн ерөнхий байдал

Судалгаанд оролцогчдыг насны бүтцээр авч үзвэл тэдний 31.0 хувь нь 30 хүртэлх насны, 27.1 хувь нь 31-40 насны, 22.8 хувь нь 41-50 насны, 13.5 хувь нь 51-60 хүртэл насны, 5.6 хувь нь 61 болон түүнээс дээш насны хүмүүс, харин хүйсийн 42.1 хувийг эрэгтэйчүүд, 57.9 хувийг нь эмэгтэйчүүд эзэлж байна (Зураг 1).

Зураг 1. Судалгаанд оролцогчдын нас, хүйсийн суврага, дүнд эзлэх хувиар



Төрийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн бүтцийг боловсролын түвшнээр нь авч үзэхэд 40.7 хувь нь бүрэн дунд болон түүнээс доош, 17.5 хувь нь техник мэргэжлийн анхан болон тусгай мэргэжлийн дунд шатны, 37.6 хувийг дипломын болон бакалаврын дээд, 4.2 хувийг магистр болон түүнээс дээш боловсролтой иргэд эзэлж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2014 оны судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн тоо, бүтэц, дүнд эзлэх хувь, боловсролын түвшнээр

Боловсролын түвшин	2010		2012		2014	
	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
Боловсролгүй	28	1.1	15	0.6	16	0.4
Бага боловсролтой	55	2.2	47	1.9	75	2.0
Бүрэн бус дунд	325	13.0	297	11.9	429	11.4
Бүрэн дунд	696	27.8	758	30.3	1013	26.9
Техник мэргэжлийн анхан шатны	121	4.8	125	5.0	225	6.0
Тусгай мэргэжлийн дунд	298	11.9	249	10.0	432	11.5
Дипломын болон бакалаврын дээд	860	34.4	920	36.8	1416	37.6
Магистр болон түүнээс дээш	120	4.8	88	3.5	159	4.2
Дүн	2503	100.0	2499	100.0	3765	100.0

Судалгаанд хамрагдсан иргэдийн өөрсдийнх нь өрхийн амьжиргааны түвшинг бусад дундаж орлоготой өрхүүдтэй харьцуулахад ямар түвшинд байгааг өөрсдийн төсөөллөөр нь үнэлүүлэв. Энэхүү үнэлэмжээр судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 62.4 хувь нь дундаж түвшинд, 19.9 хувь нь дунджаас доогуур түвшинд, 9.9 хувь нь дунджаас дээгүүр түвшинд, 4.9 хувь нь доод түвшинд гэж үнэлсэн бол зөвхөн 1.1 хувь нь дээд түвшинд байна гэж үзжээ. Төрийн байгууллагаар ихэвчлэн (нийт үйлчлүүлэгчдийн 82.3 хувь нь) дундаж болон түүнээс доогуур түвшний гэсэн ангилалд хамрагдаж байгаа амьжиргаатай өрхийг төлөөлсөн иргэд үйлчлүүлсэн байна (Зураг 2).

Зураг 2.Судалгаанд оролцогчдын амьжиргааны түвшний үнэлгээ, дүнд эзлэх хувиар



Мөн төрийн үйлчилгээ авсан иргэдийн бүтцийг ажил эрхлэлтийн байдлаар нь авч үзэхэд үйлчилгээ авсан иргэдийн 23.0 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 21.2 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр ажиллагчид, 14.9 хувийг төрийн албан хаагчид, 7.8 хувийг оюутан/сурагчид, 8.2 хувийг ажилгүй (ажил идэвхтэй хайж байгаа) иргэд, 9.1 хувийг гэртээ байдаг иргэд, 9.1 хувийг тэтгэврийн насны хүмүүс, 6.6 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч эзэд эзэлж байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2.Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2014 оны судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн тоо, дүнд эзлэх хувь, ажил эрхлэлтийн байдлаар

Ажил эрхлэлтийн байдал	2010		2012		2014	
	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
Төрийн албан хаагч	407	16.3	458	18.3	561	14.9
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр ажиллагч	522	20.9	470	18.8	800	21.2
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч эзэн	126	5.0	142	5.7	249	6.6
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	564	22.5	516	20.6	866	23.0
Оюутан / сурагч	295	11.8	159	6.4	294	7.8
Ажилгүй (ажил идэвхтэй хайж байгаа)	248	9.9	182	7.3	309	8.2
Гэртээ байдаг	191	7.6	321	12.8	343	9.1
Тэтгэвэрт	150	6.0	251	10.0	343	9.1
Дүн	2503	100.0	2499	100.0	3765	100.0

Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх судалгаанд оролцогч иргэдийн 51.7 хувь нь өөрийгөө төлөөлж, 34.3 хувь нь өрх болон өрхийн гишүүдээ төлөөлж, 13.9 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагаа төлөөлж төрийн үйлчилгээ авахаар төрийн байгууллагад хандсан байна.

1.2. Аж ахуйн нэгж, байгууллагаа төлөөлж төрийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн ерөнхий байдал

Төрийн үйлчилгээ авсан аж ахуйн нэгж, байгууллагыг өмчийн төрлөөр авч үзвэл 77.3 хувь нь хувийн өмчийн, 11.6 хувь нь хувийн хамтарсан, 7.4 хувь нь төрийн өмчийн, 1.3 хувь нь төрийн хамтарсан, 1.0 хувь нь гадаадын өмчийн аж ахуйн нэгж, байгууллага байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3.Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2014 оны судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн тоо, дүнд эзлэх хувь, аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн төрлөөр

Аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн төрөл	2010		2012		2014	
	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
Төрийн өмчийн	19	9.8	35	14.1	39	7.4
Төрийн өмчийн оролцоотой	10	5.2	1	0.4	4	.8
Төрийн хамтарсан	4	2.1			7	1.3
Орон нутгийн өмчийн	139	71.6	10	4.0	1	.2
Орон нутгийн өмчийн оролцоотой	10	5.2				
Орон нутгийн өмчийн хамтарсан	3	1.5	2	0.8	2	.4
Хувийн	3	1.5	168	67.7	406	77.3
Хувийн хамтарсан	4	2.1	26	10.5	61	11.6
Гадаадын	2	1.0	6	2.4	5	1.0
Дүн	194	100.0	248	100.0	525	100.0

Төрийн үйлчилгээ авсан аж ахуйн нэгж, байгууллагыг хариуцлагын хэлбэрээр нь авч үзвэл 76.8 хувь нь хязгаарлагдмал хариуцлагатай, 8.6 хувь нь төсөвт байгууллага, 4.0 хувь нь хувьцаат компани, 2.1 хувь нь зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай, бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл, 1.7 хувь нь төрийн бус байгууллага, 1.5 хувь хоршоо болон 5.3 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болон бусад байгууллага эзэлж байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4.Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2014 оны судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн тоо, дүнд эзлэх хувь, аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэрээр

Аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэр	2010		2012		2014	
	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай, бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	56	28.9	6	2.4	11	2.1
Хоршоо	4	2.1	5	2.0	8	1.5
Хувьцаат компани	33	17.0	12	4.8	21	4.0

Хязгаарлагдмал хариуцлагатай компани	65	33.5	166	66.9	403	76.8
Төрийн өмчит үйлдвэрийн газар	5	2.6	2	0.8	1	.2
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	8	4.1	1	0.4	1	.2
Төрийн бус байгууллага			6	2.4	9	1.7
Төсөвт байгууллага	23	11.9	41	16.5	45	8.6
Бусад			9	3.6	26	5.0
Дүн	194	100.0	248	100.0	525	100.0

Аж ахуйн нэгж, байгууллагаа төлөөлөн төрийн үйлчилгээ авахаар хандсан иргэдийн 85.1 хувь нь 1-50 ажилтантай байгууллагын төлөөлөл бол 14.9 хувь нь 50 дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхлэгч нар байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5.Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2014 оны судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн тоо, дүнд эзлэх хувь, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны тооны бүлгээр

Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны тооны бүлэг	2010		2012		2014	
	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
1-5 ажилтан	68	35.2	71	28.6	169	32.2
6-9 ажилтан	28	14.5	49	19.8	79	15.0
10-19 ажилтан	34	17.6	43	17.3	108	20.6
20-50 ажилтан	26	13.5	47	19.0	91	17.3
51-100 ажилтан	16	8.3	19	7.7	40	7.6
100 болон түүнээс дээш	21	10.9	19	7.7	38	7.2
Дүн	193	100.0	248	100.0	525	100.0

1.3. Төрийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн үйлчлүүлсэн давтамж

Иргэд, үйлчлүүлэгчдээр төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлүүлэхдээ юуны өмнө тэдгээрийн тухайн төрийн байгууллагаар үйлчлүүлж буй давтамж, тохиолдсон хүндрэл бэрхшээл, нийт төрийн байгууллагын шударга ажилласан эсэх талаарх ерөнхий үнэлгээ зэргийг тодруулсан болно.

Тухайн төрийн байгууллагаар үйлчлүүлэхээр хамгийн сүүлд хэзээ хандсныг судалгаанд оролцогчдоос асуухад анх удаа хандаж байгаа иргэд 19.6 хувийг эзэлж байгаа нь 2012 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад 0.9 пунктээр буурсан байна. Нэг долоо хоногийн өмнө хандсан иргэд 18.5 хувийг, хоёр долоо хоногийн өмнө хандсан иргэд 9.9 хувийг, нэг сарын өмнө хандсан иргэд 20.1 хувийг, гурван сарын өмнө хандсан иргэд 11.9 хувийг, хагас жилийн өмнө хандсан иргэд 8.3 хувийг, нэг жил ба түүнээс дээш хугацаанаас өмнө хандсан иргэд 11.8 хувийг эзэлж байна (Хүснэгт 6).

Нийт үйлчлүүлэгчдийн дунджаар 39 хоногийн дараа тухайн төрийн байгууллагаар үйлчлүүлэхээр дахин хандсан байна. Энэ нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулбал 3 хоногоор өссөн байна.

Хүснэгт 6. Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2014 оны судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн тоо, дүнд эзлэх хувь, хамгийн сүүлийн хандалтын байдлаар

Хандсан байдал	2010		2012		2014	
	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
Анх удаа	519	20.7	512.0	20.5	739	19.6
1 долоо хоногийн өмнө	360	14.4	480.0	19.2	695	18.5
2 долоо хоногийн өмнө	236	9.4	251.0	10.0	372	9.9
1 сарын өмнө	533	21.3	481.0	19.2	756	20.1
3 сарын өмнө	365	14.6	324.0	13.0	447	11.9
Хагас жилийн өмнө	272	10.9	195.0	7.8	311	8.3
Нэг жил ба түүнээс өмнө	218	8.7	256.0	10.2	445	11.8
Дүн	2503	100	2499	100	3765	100.0

Тухайн төрийн байгууллагаар үйлчлүүлэхээр хандсан давтамжийг үзвэл 1-2 удаа хандаж байгаа иргэд 43.1 хувийг, 3-6 удаа хандаж байгаа иргэд 32.6 хувийг, 7-8 удаа хандаж байгаа иргэд 7.3 хувийг, 9 ба түүнээс дээш удаа хандаж байгаа иргэд 17.7 хувийг эзэлж байна. Судалгаанд оролцогчдын дунджаар сүүлийн 12 сарын хугацаанд тухайн төрийн байгууллагад 4.4 удаа хандсан байгаа нь өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулбал 0.3 пунктээр буурсан байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2014 оны судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн тоо, дүнд эзлэх хувь, үйлчлүүлэхээр хандсан тоогоор

Хандсан тоо	2010		2012		2014	
	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь	Тоо	Дүнд эзлэх хувь
1-2 удаа	949	47.8	760	38.2	1335	43.1
3-6 удаа	584	29.4	703	35.4	1009	32.6
7-8 удаа	175	8.8	174	8.8	227	7.3
9 ба түүнээс дээш удаа	276	13.9	351	17.7	525	17.0
Дүн	1984	100.0	1988	100.0	3096	100.0

БҮЛЭГ II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2.1. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Сонгогдсон салбаруудын шударга байдлын түвшний үнэлгээ 2014 оны байдлаар дунджаар **3.43**[1] буюу 2012 оны судалгааны үр дүнгээс 0.04 пунктээр өссөн байна (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Салбар	Шударга байдлын үнэлгээ			Зөрүү
	2010	2012	2014	
Эрүүл мэндийн байгууллага	2.70	3.25	3.41	0.16
Боловсролын байгууллага	2.88	3.55	3.51	-0.038
Нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага	2.84	3.42	3.54	0.13
Нийгмийн даатгалын байгууллага	2.91	3.61	3.51	-0.10
Газрын алба	2.70	3.23	3.46	0.24
Татварын байгууллага	2.99	3.59	3.42	-0.16
Улсын бүртгэлийн байгууллага	2.73	3.36	3.66	0.31
Гаалийн байгууллага	2.89	3.83	3.43	-0.399
Мэргэжлийн хяналтын байгууллага	2.80	3.32	3.33	0.01
Цагдаагийн байгууллага	2.70	3.19	3.22	0.03
Төрийн байгууллагуудын дундаж	2.77	3.38	3.43	0.05

Салбаруудын шударга байдлын түвшний үнэлгээ **3.22-3.66** хооронд үнэлэгджээ. Энэ нь салбаруудын төрийн байгууллагуудын шударга байдлын түвшин нэмэгдсэн байна. Харин боловсролын салбар, нийгмийн даатгал, татвар, гаалийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 2012 оны үнэлгээтэй харьцуулбал 0.038-0.399 пунктээр буурсан дүнтэй гарчээ.

Бусад салбарын төрийн байгууллагын хувьд гурван удаагийн судалгаагаар бага боловч тогтвортой өсөлт ажиглагдаж байна. Тухайлбал, Улсын бүртгэлийн байгууллагын шударга байдлын үнэлгээ 2012 оны үнэлгээнээс 0.31 пунктээр, Газрын албаны үнэлгээ 0.24 пунктээр, Эрүүл мэндийн байгууллагын үнэлгээ 0.16 пунктээр, Нийгмийн халамж, үйлчилгээний байгууллагын үнэлгээ 0.13 пунктээр, Цагдаагийн байгууллагын үнэлгээ 0.31 пунктээр, Мэргэжлийн хяналтын байгууллагын үнэлгээ 0.01 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх 2014 оны судалгаагаар цагдаагийн байгууллага (3.22), мэргэжлийн хяналтын байгууллага (3.33), эрүүл мэндийн байгууллага (3.41), татварын байгууллага (3.42) зэрэг нь төрийн байгууллагын дунджаас доогуур үнэлэгдсэн бол гаалийн байгууллага (3.43) төрийн байгууллагын дундаж үнэлгээтэй ижил түвшинд, харин газрын алба (3.46), боловсролын байгууллага (3.51), нийгмийн даатгалын байгууллага (3.51), нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага (3.54), улсын бүртгэлийн байгууллага (3.66) үнэлгээгээр төрийн байгууллагын дунджаас дээгүүр байна.

Нийт төрийн байгууллагын дунджаар төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 3.43 буюу дунджаас дээгүүр түвшинд байна. Үүний дотор төрийн байгууллагын шударга байдлын түвшинг бүрдүүлэгч хариуцлагатай байдлын үзүүлэлт 3.58 буюу 2012 оны судалгааны үр дүнгээс 0.04 пунктээр, ил тод байдлын үзүүлэлт 3.30 буюу 0.07 пунктээр өссөн байна.

1 (1 (огт шударга бус) - 5 хүртэлх үнэлгээгээр (шударга))

Зураг 3.Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ болон бүрдүүлэгч Хариуцлагатай байдал, Ил тод байдлын үзүүлэлтүүд, оноор



Судалгаанд оролцогчдын 21.6 хувь нь төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд хүндрэл бэрхшээл тохиолддоггүй гэж хариулсан нь 2012 оны судалгааны үр дүнтэй харьцуулбал 2.4 пунктээр буурсан, харин 2010 оны судалгааны үр дүнтэй харьцуулбал 11.5 пунктээр нэмэгдсэн байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд голчлон тохиолддог бэрхшээл, оноор

Төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд голчлон тохиолддог бэрхшээл	2010	2012	2014
Хүндрэл бэрхшээл тохиолддоггүй	10.1	24.0	21.6
Бүрдүүлэх бичиг баримт хэт олон	19.7	15.3	17.7
Төрийн албан хаагчид нь хүнд суртал ихтэй	25.1	19.4	17.8
Төрийн үйлчилгээний шат дамжлага олон	15.9	13.1	14.4
Хаана, хэнд хандаж, ямар материал бүрдүүлэх нь тодорхой бус	11.7	7.3	9.4
Төрийн албан хаагчдын харилцааны соёл тааруу	12.3	12.2	10.5
Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар тааруу	4.8	6.3	5.6
Бусад	0.4	2.5	3.0

Судалгаанд оролцогчдын 78.4 хувь нь төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд хүндрэл бэрхшээл тохиолддог гэжээ. Төрийн байгууллагаар үйлчүүлэхэд төрийн албан хаагчид хүнд суртал гаргах, бүрдүүлэх бичиг баримт болон төрийн үйлчилгээний шат дамжлага олон, төрийн албан хаагчдын харилцааны соёл тааруу байх явдал ихээхэн түүгээмэл тохиолддог бол хаана, хэнд хандаж, ямар материал бүрдүүлэх нь тодорхой бус, төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар тааруу байх явдал харьцангуй бага тохиолддог гэж үзсэн байна (Зураг 4.). Энэ нь өмнөх судалгааны үр дүнгээс төдийлөн өөрчлөгдөөгүй байна.

Зураг 4. Төрийн үйлчилгээ авсан иргэдийн 2014 оны судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн тоо, дүнд эзлэх хувь, төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд голчлон тохиолддог бэрхшээлээр



Төрийн үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгжийн 2014 оны судалгаагаар төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээг бүрдүүлэгч 13 дэд үзүүлэлт тус бүрийг үнэлүүлэн төрийн байгууллагын шударга байдлын түвшинг тооцож сонгогдсон салбарын байгууллагуудаар гаргадаг. Үүний зэрэгцээ судалгаанд оролцогчдоос "Төрийн байгууллага, албан хаагчид шударга ажилладаг гэдэгтэй та санал нийлэх үү?" гэж шууд асуултаар тодруулдаг. Гурван удаагийн судалгаагаар төрийн байгууллага, албан хаагчид шударга ажилладаг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 2010 онд 6.0 хувь нь, 2012 онд 9.8 хувь нь 2014 онд 12.7 хувь нь бүрэн нийлж байгаа бол санал огт нийлэхгүй байна гэж 2010 онд судалгаанд оролцогчдын 23.2 хувь нь, 2012 онд 7.6 хувь нь, 2014 онд 5.6 хувь нь тус тус үзсэн байна (Зураг 5).

Зураг 5. Төрийн байгууллага, албан хаагч шударга ажилладаг эсэх талаар судалгаанд оролцогчдын дүнд эзлэх хувиар, оноор



Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэхдээ ашигладаг 13 дэд үзүүлэлтүүдээр судалгаанд хамрагдсан төрийн үйлчилгээний салбар тус бүрээр ямар өөрчлөлт гарсныг авч үзье.

2.2.Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ, салбараар

2.2.1. Эрүүл мэндийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Эрүүл мэндийн байгууллагын төрийн байгууллагын шударга байдал 2014 оны судалгааны үр дүнгээр 3.41 үнэлэгдсэн нь төрийн байгууллагуудын дунджаас 0.02 пунктээр доогуур, 2012 оны судалгааны үр дүнгээс 0.17 пунктээр өссөн байна.

Эрүүл мэндийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ 2012 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад 13 үзүүлэлт тус бүрээр өссөн байна. Үүнд: Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал 0.32 пунктээр, байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал 0.26 пунктээр, иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог байдал 0.24 пунктээр, Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал 0.21 пунктээр, Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал 0.20 пунктээр, Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал 0.19 пунктээр, Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал 0.17 пунктээр, Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал болон Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх 0.14 пунктээр, Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал 0.11 пунктээр, Албан хаагчдын ёс зүйтэй байдал 0.10

пунктээр, Хуульд нийцүүлэн асуудлыг шийдвэрлэж буй байдал 0.6 пунктээр, Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал 0.02 пунктээр тус тус өссөн байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Эрүүл мэндийн байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ оноор, төрийн байгууллагын дундаж, 2012 - 2014 оны зөрүү

Үзүүлэлт	Эрүүл мэндийн байгууллага			Төрийн байгууллагын дундаж	Зөрүү
	2010 он	2012 он	2014 он	2014 он	
Хуульд нийцүүлэн асуудлыг шийдвэрлэж буй байдал	2.94	3.59	3.65	3.66	0.06
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	2.78	3.35	3.55	3.56	0.19
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	2.93	3.55	3.65	3.63	0.10
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	2.86	3.48	3.59	3.59	0.11
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	3.00	3.23	3.47	3.47	0.24

Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	2.74	3.28	3.55	3.55	0.26
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	2.87	3.37	3.57	3.58	0.20
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	2.62	3.25	3.46	3.50	0.21
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	2.76	3.19	3.36	3.38	0.17
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	2.57	3.07	3.21	3.26	0.14
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	2.48	3.16	3.30	3.31	0.14
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал	2.23	2.51	2.83	2.92	0.32
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал	2.31	3.06	3.08	3.11	0.02
Дүн	2.70	3.24	3.41	3.43	0.17

Эрүүл мэндийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ бусад төрийн байгууллагын дундаж үнэлгээтэй харьцуулахад доогуур байна. Үүнд Албан хаагчдын ёс зүйтэй байдал (3.65)-ын үнэлгээ төрийн байгууллагын дунджаас (3.63) 0.02 пунктээр дээгүүр бусад үзүүлэлтүүд бүгд доогуур, эсхүл ижил түвшинд байгаа нь нөлөөлсөн байна (Хүснэгт 9).

Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал (2.83), Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал (3.08), Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал (3.21), Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх (3.30) үзүүлэлтүүдийн үнэлгээ бусад үзүүлэлтээс 0.35-0.82 пунктээр доогуур байна (Зураг 6).

Зураг 6. Эрүүл мэндийн байгууллагын шударга байдлын үзүүлэлтүүд, оноор



2.2.2. Боловсролын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх 2014 оны судалгааны үр дүнгээр Боловсролын салбарын төрийн байгууллагын шударга байдлын түвшин 3.51 үнэлэгдэж 2012 оны судалгааны үр дүнгээс 0.03 пунктээр буурсан байна.

Өмнөх судалгааны үр дүнгээс Боловсролын байгууллагын 13 үзүүлэлтийн 10 үзүүлэлт нь буурсан байна. Өөрөөр хэлбэл, Хуульд нийцүүлэн асуудлыг шийдвэрлэж буй байдал, Албан хаагчдын ёс зүйтэй байдал, Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал, Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал, Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх, Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн

хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал, Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал, Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал, Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх, Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийн хүртээмжтэй байдал гэсэн үзүүлэлтүүд 0.01-0.17 пунктээр буурсан нь Боловсролын байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ буурахад нөлөөлжээ (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Боловсролын байгууллагын шударга байдлын дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ оноор, төрийн байгууллагын дундаж, 2012 - 2014 оны зөрүү

Үзүүлэлт	Боловсролын байгууллага			Төрийн байгуулл агын дундаж	Зөрүү
	2010 он	2012 он	2014 он	2014 он	
Хуульд нийцүүлэн асуудлыг шийдвэрлэж буй байдал	3.08	3.81	3.65	3.66	-0.16
Албан хаагчдын мэдлэг чадвар, түргэн шуурхай байдал	2.98	3.79	3.66	3.56	-0.13
Албан хаагчдын ёс зүйтэй байдал	3.07	3.75	3.63	3.63	-0.12
Албан хаагчдын соёлтой, боловсон үйлчилж буй байдал	3.01	3.83	3.66	3.59	-0.17
Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог эсэх	2.99	3.60	3.55	3.47	-0.05
Байгууллагын удирдлага (дарга) хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байдал	2.99	3.55	3.54	3.55	-0.01
Төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагааны талаарх (дүрэм, журам, стандарт) мэдээллийн энгийн, ойлгомжтой байдал	3.07	3.57	3.61	3.58	0.04
Төрийн байгууллага, албан хаагч хэнийг ч ялгаварлан гадуурхалгүй, тэгш хандаж үйлчилж буй байдал	2.81	3.53	3.52	3.50	-0.01
Төрийн байгууллага, албан хаагч олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьж буй байдал	2.77	3.39	3.48	3.38	0.09
Иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж буй байдал	2.69	3.49	3.42	3.26	-0.07
Төрийн байгууллага, албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хялбар, ил тод, боловсронгуй болгох чиглэлээр тогтмол ажил хийдэг эсэх	2.76	3.44	3.42	3.31	-0.02
Төрийн байгууллагын үйл ажиллагааны төсөв, санхүүтэй холбоотой тайлан мэдээллийн нээлттэй байдал	2.54	2.96	3.18	2.92	0.22
Таны санал бага зэрэг нийлж байгаа [4], огт нийлэхгүй [5] байгаа бол яагаад гэдэг талаараа тайлбарлана уу.									

IV.5 ТУХАЙН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ХААГЧИЙН ХУВЬД, доор дурдсан үзүүлэлтийн ач холбогдлын түвшинг үнэлнэ үү.

Д/д	Үзүүлэлт	Огт ач холбог-долгүй	Бага зэрэг	Дунд зэрэг	Ач холбогдолтой	Маш их ач холбогдолтой
1	Асуудлыг хуульд нийцүүлэн шийдвэрлэдэг байх	1	2	3	4	5
2	Үйл ажиллагааны дүрэм, журам тодорхой, ойлгомжтой байх	1	2	3	4	5
3	Ажил үүргээ сайн мэддэг, түргэн шуурхай үйлчилдэг байх	1	2	3	4	5
4	Ёс зүйн ямар нэгэн алдаа гаргахгүй үйлчилгээ үзүүлдэг байх	1	2	3	4	5
5	Соёлтой, боловсон үйлчилдэг байх	1	2	3	4	5
6	Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн бол буруутай албан хаагчид заавал хариуцлага тооцдог байх	1	2	3	4	5
7	Удирдлага (дарга) нь хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байх	1	2	3	4	5
8	Үйл ажиллагааны талаарх мэдээлэл энгийн ойлгомжтой байх	1	2	3	4	5
9	Ялгаварлан гадуурхалгүй, адил, тэгш хандаж үйлчилдэг байх	1	2	3	4	5
10	Олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьдаг байх	1	2	3	4	5
11	Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч ажилдаа тусгадаг байх	1	2	3	4	5

12	Үйлчилгээг иргэдэд илүү хялбар, ил тод хүргэх чиглэлээр тогтмол ажилладаг байх	1	2	3	4	5
13	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой тайлан мэдээлэл нээлттэй байх	1	2	3	4	5
14	Үйл ажиллагаа, шийдвэрийн талаарх мэдээлэл нээлттэй байх	1	2	3	4	5

IV.6 ТАНД ҮЙЛЧИЛСЭН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ХААГЧИЙН ХУВЬД, доорх дүгнэлттэй санал нийлж байна уу.

/Бага зэрэг нийлж байгаа-4, Огт нийлэхгүй гэж хариулсан бол Тайлбар хийнэ үү./

Д/д	Үзүүлэлт	Бүрэн нийлнэ	Нийлж байна	Дунд зэрэг	Бага зэрэг нийлнэ	Огт нийлэхгүй
1	**Асуудлыг хуульд нийцүүлэн шийдвэрлэсэн**	1	2	3	4	5
	Тайлбар:_____					
2	**Үйл ажиллагааны дүрэм, журам тодорхой, ойлгомжтой байсан**	1	2	3	4	5
	Тайлбар:_____					
3	**Ажил үүргээ сайн шуурхай үйлчилсэн мэдэж байсан, түргэн**	1	2	3	4	5
	Тайлбар:_____					
4	**Ёс зүйн ямар нэгэн алдаа гаргахгүй үйлчилгээ үзүүлсэн**	1	2	3	4	5
	Тайлбар:_____					
5	**Соёлтой, боловсон харьцаж үйлчилсэн**	1	2	3	4	5
	Тайлбар:_____					
6	**Иргэдийг үндэслэлгүй чирэгдүүлсэн бол буруутай албан хаагчид заавал хариуцлага тооцдог**	1	2	3	4	5
	Тайлбар:_____					

7	**Удирдлага (дарга) нь хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг**	1	2	3	4	5
	Тайлбар:_____					
8	**Үйл ажиллагааны талаарх мэдээлэл энгийн ойлгомжтой байсан**	1	2	3	4	5
	Тайлбар:_____					
9	**Ялгаварлан гадуурхалгүй, адил, тэгш хандаж үйлчилсэн**	1	2	3	4	5
	Тайлбар:_____					
10	**Олон нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүрт тавьсан**	1	2	3	4	5
	Тайлбар:_____					
11	**Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч ажилдаа байнга тусгадаг**	1	2	3	4	5
	Тайлбар:_____					
12	**Үйлчилгээг иргэдэд илүү хялбар, ил тод хүргэх чиглэлээр тогтмол идэвх санаачилгатай ажилладаг**	1	2	3	4	5
	Тайлбар:_____					
13	**Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой тайлан мэдээлэл нээлттэй байдаг**	1	2	3	4	5
	Тайлбар:_____					
14	**Үйл ажиллагаа, шийдвэрийн талаарх мэдээлэл нээлттэй байдаг**	1	2	3	4	5
	Тайлбар:_____					

V. Төрийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх мэдлэгийн түвшинг тогтоохтой холбоотой асуулт

1. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг хэрхэн үнэлэх вэ?

1.маш сайн 2.сайн 3.дундаж 4.муу 5.маш муу

2. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд хэр зэрэг итгэдэг вэ?

1.Их итгэдэг 2.Итгэдэг 3.Бараг итгэдэггүй 4.Огт итгэдэггүй

3. Та төрийн байгууллагаар үйлчлүүлэх явцдаа авлига, хээл хахуулийн талаар олж мэдсэн мэдээллээ ямар нэгэн байгууллагад мэдээлэх үү?

1.Тийм 2.Үгүй

4. Хэрэв тийм бол хамгийн түрүүнд хаана, ямар байгууллагад хандах вэ?

1. Цагдаа 2.Хэвлэл мэдээллийн байгууллага
3. АТГ 4. Тухайн байгууллагын удирдлагад

5. Та авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах утас ажиллаж байгааг мэдэх үү?

1.Тийм 2.Үгүй

6. Хэрэв тийм бол ямар утсанд хандах вэ?

1. 1969 2.Бусад

7. Төрийн өмнөөс танд үйлчилгээ үзүүлснийхээ төлөө албан тушаалтан танаас төлбөр, бэлэг, хандив авахыг хуулиар хориглосон байдгийг Та мэдэх үү?

1. Тийм 2. Үгүй

БИДНИЙ АЖИЛД ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛСЭН ТАНД БАЯРЛАЛАА

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ 2014 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛ 2014 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ДҮГНЭЛТ

Хүүхдийн шударга байдлын түвшин болон түүний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих болон авлигыг үл тэвчих байдал ямар түвшинд байгааг тодорхойлох, цаашид хүүхдүүдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих, шударга бус хандлагаас нь урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тогтоох зорилгоор 2014 оны "Хүүхдийн шударга байдлын судалгаа"-г Авлигатай тэмцэх газар, Хүүхдийн төлөө үндэсний газартай хамтран зохион байгууллаа. Энэ удаагийн судалгааны дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна.

- Хүүхдийн шударга байдлын түвшин 2014 оны судалгаагаар 4.03[1] гэсэн дүнтэй гарсан нь 2010 оныхоос 0.74 пункт, 2012 оныхоос 1.10 пункт, 2013 оныхоос 0.32 пунктээр тус тус өссөн дүнтэй гарсан нь эерэг үзүүлэлт болж байна.
- Хүүхдийн шударга байдлын түвшний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахууны дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 4.07, зөв төлөвшилт ийн дундаж үнэлгээ 4.32, хууль сахих байдлын дундаж үнэлгээ 4.04, авлигыг үл тэвчих байдлын дундаж үнэлгээ 3.68 байгаа нь өмнөх жилийнхээс 0.21-0.44 пунктээр нэмэгдсэн байна.
- Судалгааны дүнгээс харахад эмэгтэй хүүхдийн шударга байдлын түвшин эрэгтэй хүүхдийнхээс өндөр байна. 2014 оны байдлаар эмэгтэй хүүхдүүдийн шударга байдлын түвшин эрэгтэй хүүхдүүдийнхээс 0.10 пунктээр илүү байлаа.
- Эцэг, эх хүүхэдтэйгээ шударга байх талаар байнга ярилцаж байх нь тэднийг шударга хандлага гаргахад эерэгээр нөлөөлж байна. Эцэг, эхтэйгээ шударга байх талаар "байнга" ярилцдаг хүүхдүүдийн шударга байдлы н түвшин ярилцаж чадахгүй байгаа хүүхдүүдийнхээс өндөр байна. Энэ нь 10 хүүхэд тутмын 3 нь шударга байх талаар эцэг эхтэйгээ маш цөөн удаа, эсхүл огт ярилцаж чадахгүй байна гэсэн үзүүлэлт юм.
- Хүүхдээ шударга бус зүйл хийхэд эцэг, эх ямар хариу үйлдэл үзүүлж байгаа нь тэдний зөв төлөвшилт, шударга байхад нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл, хүүхдээ буруу зүйл хийснийг мэдсэн эцэг, эх хүүхэддээ болохгүй зүйл хийснийг нь ойлгуулах, тайлбарлах шаардлагатай байна.
- Найз нөхдийн хүрээ тухайн хүүхдийн шударга байдлын түвшинд нөлөөлж байна. "Таны найз танаас шударга бус үйлдэл хийхийг хүсдэг үү?" гэсэн асуултад зөвхөн 55.2% нь л "огт үгүй" гэж хариулсан байна.
- Хүүхдийн шударга байдлын түвшинд эерэгээр нөлөөлж байгаа өөр нэг үзүүлэлт бол тухайн хүүхдийг шударга хандсаных нь төлөө бусад хүмүүс тухайн хүүхдийг "магтах, сайшаах, урамшуулах" явдал болох нь харагдлаа.
- Хүүхдүүдэд шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ талаар үйл ажиллагаа зохиох нь тэдний шударга байдлын түвшинд эерэгээр нөлөөлж байгаа нь энэ удаагийн судалгааны дүнгээс харагдлаа. "Танай ангид ямар нэгэн байдлаар шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ төрлийн үйл ажиллагаа зохиогддог уу?" гэсэн асуултад "тийм" гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин "үгүй" гэж хариулсан хүүхдүүдийнхээс 0.16 пунктээр илүү байв.

1 Хүүхдийн шударга байдлын түвшин болон дэд үзүүлэлтийг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд уг үзүүлэлтийн утга 1-д ойртох тусам шударга бус, 5-д ойртох тусам шударга гэж ойлгоно.

- Хүүхдүүд шударга ёсны талаарх мэдээллийг гэр бүл, сургуулийн орчноос авах нь илүү үр дүнтэй байна. Шударга ёсны талаарх мэдээллийг “гэр бүл” болон “сургууль”-аас авдаг хүүхдүүд бусад эх үүсвэрээс мэдээлэл авдаг хүүхдүүдээс илүү шударга байна.

ЗӨВЛӨМЖ

БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬД:
- Суралцагч (бага сургуулиас их, дээд сургууль хүртэлх)-ийн нэгдсэн ёс зүйн дүрмийг батлан, өмчийн бүх хэлбэрийн сургуулиудад мөрдүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих;
- Бүх шатны сургуулиудад шударга ёс (ёс зүй), авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх талаар хичээл оруулах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгах;
- Хүүхдүүдийн ил тод, шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор шударга үйл хийсэн хүүхдүүдийг шалгаруулан урамшуулах, шагнах зэрэг арга хэмжээг тогтмол зохион байгуулж, олон нийтэд мэдээлж байх.

ЭЦЭГ, ЭХ БОЛОН БУСАД ХҮМҮҮСИЙН ХУВЬД:
- Эцэг, эх болон бусад хүмүүсийн хувьд шударга байдлаараа гэр бүл, үр хүүхдүүддээ үлгэр жишээч байх;
- Хүүхдүүдийн гаргасан шударга бус үйлдлийг буруутгах, зэмлэл хүлээлгэх, эсхүл хайхрахгүй байхаас илүүтэй тэдэнд буруу зүйл хийснийг нь ойлгуулж, тайлбарлах. Хэрэв шударга үйл хийсэн бол тэднийг урамшуулж, сайшааж байх.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬД:
- Хүүхдүүд шударга ёсны талаарх мэдээллийг телевиз, радио болон интернетээс авч байгаа бөгөөд ялангуяа, телевиз, радиогоор хүүхдийн шударга ёсыг дэмжсэн, сонирхол татахуйц хөтөлбөр, нэвтрүүлгийг бэлтгэн хүргэж байх;
- Телевизийн бусад нэвтрүүлгийн хувьд ил тод, шударга байдлыг дэмжсэн агуулга бүхий нэвтрүүлгийг түлхүү гаргах.

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ХУВЬД:
- Ил тод байдал болон авлигатай тэмцэх үйл ажиллагаанд хөндлөнгөөс хяналт тавих үүрэг оролцоогоо нэмэгдүүлэх;
- Хүүхдийн ёс зүй, шударга байдлыг нэмэгдүүлэх талаар санал, санаачилга гаргах, энэ талаар холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх;
- Авлигын эсрэг боловсрол олгох болон шударга ёсны талаарх арга хэмжээг өргөнөөр зохион байгуулах.

БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ТООЦООЛОЛ

Хүүхдийн шударга байдлын судалгааг “Транспрэнси Интернэшнл Солонгос” байгууллагаас боловсруулсан арга зүйн дагуу анх 2008 онд Энэтхэг, Солонгос, Бангладеш, Монгол зэрэг оронд зохион байгуулж байсан билээ. Энэхүү арга зүйн дагуу манай улс Хүүхдийн шударга байдлын судалгааг 5 дахь удаагаа зохион байгуулаад байна.

1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Монгол Улсын ирээдүй болсон хүүхдүүдийн шударга байдлын түвшин, түүний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих болон авлигыг үл тэвчих байдал ямар түвшинд байгааг тодорхойлох, цаашид хүүхдүүдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тогтооход энэхүү судалгааны зорилго оршиж байна.

2. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ТООЦООЛОЛ

Хүүхдийн шударга байдлын судалгааны зорилгын нэг нь хүүхдийн шударга байдлын түвшнийг тодорхойлох бөгөөд судалгааны мэдээлэлд үндэслэн жил бүр хүүхдийн шударга байдлын түвшинг хэмжиж байгаа юм.

Хүүхдийн шударга байдлын түвшинг доорх 12 асуултад тухайн хүүхэд санал нийлж байгаа эсэхийг нь асууж, хариулт бүрийг 1-5 хүртэлх оноогоор үнэлж, үнэлгээний арифметик дунджаар хүүхдийн шударга байдлын түвшин болон дэд үзүүлэлтийг тооцсон болно. Хүүхдийн шударга байдлын түвшин 1-д ойртох тусам шударга бус, харин 5-д ойртох тусам шударга гэж үзнэ.

Хүснэгт 1. Хүүхдийн шударга байдлыг үнэлэхэд ашигласан асуулт

Асуултын дугаар	Асуулт
1.	Сайн найз чинь шалгалт өгөхдөө бусдаас хуулах нь буруу зүйл биш.
2.	Том хүмүүсийн хууль бус үйлдэл нь өөрт чинь ашигтай байвал буруу зүйл биш.
3.	Гэрийн даалгавраа хийхдээ интернет зэрэг бусдын бүтээлээс өөрөө хийсэн мэт ашиглах нь буруу зүйл биш.
4.	Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш.
5.	Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга юм.
6.	Баян байх нь шударга байхаас илүү чухал.
7.	Багш хичээл зааж, сургууль төгсгөснийхөө төлөө сурагчдаас хариу шан харамж, бэлэг хүсэж болно.
8.	Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн нь Таны сайн найз байсан ч багш, эцэг/эх/, дотнын хүндээ мэдэгдэнэ.
9.	Урт дараалалд зогсож байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээнэ.
10.	Хууль сахиулагч хэн нэгэн таны дэргэд /ойр/ байхгүй үед хууль, дүрэм зөрчиж болно.
11.	Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэнэ.
12.	Гэр бүлийнхэн чинь албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь буруу зүйл биш.

Хүүхдийн шударга байдлын түвшний дэд үзүүлэлт болох ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих болон авлигыг үл тэвчих байдлы н үзүүлэлтийг тооцохдоо дээр дурдсан асуултуудын дагуу дэд үзүүлэлтий н дунджийг тооцсон болно. Дэд үзүүлэлт тооцоход ашигласан асуултыг дараахь хүснэгтээс харна уу.

Хүснэгт 2. Хүүхдийн шударга байдлын дэд үзүүлэлтийг тооцсон асуулт, асуултын дугаараар

	Ёс зүй, ёс суртахуун	Зөв төлөвшилт	Хууль сахих	Авлигыг үл тэвчих
Танин мэдэхүйн	3	4	1	2
Нөлөөллийн	6	5	7	8
Зан үйлийн	9	11	10	12

3. ТҮҮВРИЙН ДИЗАЙН

Судалгааны түүврийн хүрээ нь 2013-2014 онд Ерөнхий боловсролы н сургуулийн 7-11 дүгээр ангид сурч буй хүүхдүүд байсан бөгөөд судалгаанд 7 аймаг, нийслэлийн 3 дүүрэг сонгогдсон юм.

Сонгогдсон аймаг, дүүргээс тусгайлан бэлтгэгдсэн асуулгын дагуу ярилцлагын аргаар, 802 хүүхдийг санамсаргүй байдлаар сонгон судалгаанд хамруулсан юм. Энэ удаагийн судалгаанд Хэнтий, Өмнөговь, Завхан, Дорнод, Дорноговь, Ховд, Орхон аймаг болон нийслэлийн Сонгинохайрхан, Сүхбаатар, Налайх дүүргийн хүүхдүүд хамрагдав.

Хүснэгт 3. Судалгааны түүврийн хэмжээ аймаг, дүүргээр

Д/д	Сонгогдсон аймаг, дүүргийн нэр	ЕБС-д суралцаж буй хүүхдийн тоо*, мян. хүүхэд	Түүврийн хэмжээ
1.	Дорноговь	11.1	52
2.	Дорнод	13.1	61
3.	Завхан	14.2	67
4.	Орхон	16.7	78
5.	Өмнөговь	10.4	49
6.	Ховд	17.9	85
7.	Хэнтий	13.3	62
8.	Налайх дүүрэг	5.6	28
9.	Сүхбаатар дүүрэг	31.1	146
10.	Сонгинохайрхан дүүрэг	37.2	174
	Дүн	**159.5**	**802**

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2014 он

4. СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний алба, Хүүхдийн төлөө үндэсний газартай хамтран сонгогдсон аймаг, дүүрэгт зохион байгууллаа. Сонгогдсон аймаг, дүүргээс мэдээллийг цуглуулах ажлыг 2014 оны 04 дүгээр сарын 05-30-ны хооронд зохион байгуулж, судалгааны мэдээллийг 2014 оны 6 дугаар сарын 10-20-ны хооронд компьютерт шивж оруулсан юм.

БҮЛЭГ II. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ХҮҮХДҮҮДИЙН БҮТЭЦ

Хүүхдийн шударга байдлын 2014 судалгаанд хамрагдсан 802 хүүхдийн 48.8% нь эрэгтэй, 51.2% нь эмэгтэй байлаа (Зураг 1).

Зураг 1. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хүйс, анги, дүнд эзлэх хувиар



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг суралцаж буй ангиар нь авч үзвэл 7 дугаар ангийн сурагч 10.3%, 8 дугаар ангийн сурагч 17.6%, 9 дүгээр ангийн сурагч 22.8%, 10 дугаар ангийн сурагч 26.5%, 11 дүгээр ангийн сурагч 22.8% нь байлаа.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг аймаг, нийслэлээр авч үзвэл 56.6% нь нийслэл Улаанбаатар хотоос, 43.4% нь аймгаас хамрагдсан байна.

Зураг 2. Судалгаанд хамрагдсан хүүхдийн дүнд эзлэх хувь, аймаг, нийслэлээр



2. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН

Хүүхдийн шударга байдлын судалгааны мэдээлэлд үндэслэн Хүүхдийн шударга байдлын түвшинг 4 дэд үзүүлэлт (түвшинг ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих, авлигыг үл тэвчих)-ийн хамт тооцдог. Хүүхдийн шударга байдлын түвшин болон дэд үзүүлэлтийг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд уг үзүүлэлтийн утга 1-д ойртох тусам шударга бус, 5-д ойртох тусам шударга гэж ойлгоно (үнэлгээний талаар дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу).

Хүүхдийн шударга байдлын түвшин 2014 оны судалгаагаар 4.03 гэсэн дүнтэй гарлаа. Энэ нь 2010 оныхоос 0.74 пункт, 2012 оныхоос 1.10 пункт, 2013 оныхоос 0.32 пунктээр тус тус өссөн дүн бөгөөд шударга байдлын түвшин нэмэгдсэн байгааг илэрхийлж байна.

Зураг 3. Хүүхдийн шударга байдлын түвшин[2], оноор



Хүүхдүүдийн шударга байдлыг мөн суралцаж буй ангиар нь авч үзвэл 7 болон 8 дугаар ангийн хүүхдийн шударга байдлын түвшин тус бүр 4.11 гэсэн үнэлгээтэй гарсан нь хамгийн өндөр үзүүлэлт болж байгаа бол шударга байдлы н түвшин доогуур нь 10 болон 11 дүгээр ангийн хүүхэд байна.

Зураг 4. Хүүхдийн шударга байдлын түвшин, суралцаж буй ангиар



Хүүхдийн шударга байдлын түвшин мөн хүйсийн хувьд зөрүүтэй байгаа юм. Сүүлийн 2 удаагийн судалгааны дүнгээс харахад эмэгтэй хүүхдийн шударга байдлын түвшин эрэгтэй хүүхдийнхээс өндөр байна. Тухайлбал, 2014 оны байдлаар эмэгтэй хүүхдүүдийн шударга байдлын түвшин эрэгтэй хүүхдүүдийнхээс 0.10 пунктээр өндөр байна.

2 Хүүхдийн шударга байдлын түвшин 1-д ойртох тусам шударга бус, харин 5-д ойртох тусам шударга гэж үзнэ.

Зураг 5. Хүүхдийн шударга байдлын түвшин, хүйсээр



3. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН, ДЭД ҮЗҮҮЛЭЛТЭЭР

Хүүхдийн шударга байдлын түвшинг ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих, авлигыг үл тэвчих гэсэн 4 бүлэг дэд үзүүлэлт тус бүрийн хүрээнд үнэлгээг авч үзэв. Ёс зүй, ёс суртахууны дундаж үнэлгээ нь 4.07, зөв төлөвшилтийн дундаж үнэлгээ нь 4.32, хууль сахих байдлын дундаж 4.04, авлигыг үл тэвчих байдлын дундаж үнэлгээ 3.68 байгаа нь өмнөх жилийнхтэй харьцуулахад эдгээр үзүүлэлт 0.21-0.44 пунктээр нэмэгдсэн эерэг дүнтэй байна. Хүүхдийн шударга байдлын түвшний үнэлгээ болон дэд үзүүлэлт болон тооцооллын дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу.

Хүснэгт 4. Хүүхдийн шударга байдлын түвшин, дэд үзүүлэлтээр

	2010	2012	2013	2014
ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН	3.29	2.93	3.71	4.03
Ёс зүй, ёс суртахуун	3.03	2.73	3.80	4.07
Зөв төлөвшилт	2.51	2.29	3.88	4.32
Хууль сахих	3.54	2.85	3.83	4.04
Авлигыг үл тэвчих	2.98	2.81	3.35	3.68

4. ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Хүүхдийн ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль, дүрэм журмыг дээдлэх болон авлигыг үл тэвчих байдал нь тэднийг тойрон хүрээлж буй эцэг, эх, найз нөхдийн орчин, сургууль болон мэдээллийг хүлээн авч байгаа сувгаас ихээхэн хамаарч байдаг. Энэ удаагийн судалгаагаар хүүхдийн шударга байдлы н түвшин эдгээр хүчин зүйлс (хүүхдийн эцэг, эх, найз, нөхөд, сургууль, мэдээлэл хүлээн авч бус суваг)-ээс хэрхэн хамаарч байгаад шинжилгээ хийсэн юм.

Эцэг, эх:

Энэ удаагийн судалгаагаар хүүхдүүд шударга байх эсэхэд ямар шалтгаан, хүчин зүйл нөлөөлж байгааг тодорхойлохыг зорьсон юм. Энэ хүрээнд хүүхдүүдийн шударга байдалд нөлөөлөгч нэг хүчин зүйл болох эцэг, эхийн нөлөөллийг авч үзлээ. Судалгааны асуулгын дагуу “Шударга байх талаар эцэг, эх тань тантай ярилцдаг уу?” гэсэн асуултыг хүүхдүүдээс асуусан бөгөөд хүүхдүүдийн 27.6% нь “байнга”, 46.1% нь

“заримдаа”, 21.2% нь “маш цөөн удаа”, 5.1% нь огт ярилцдаггүй гэж хариулсан байна. Эндээс харахад дунджаар 10 хүүхэд тутмын 3 нь шударга байх талаар эцэг эхтэйгээ маш цөөн удаа, эсхүл огт ярилцдаггүй байна. Хүүхдүүдтэй ийнхүү эцэг, эхтэйгээ шударга байх талаар ярилцах нь тэдний шударга байдалд хэрхэн нөлөөлж байгааг энэ удаагийн судалгаа харууллаа. “Байнга” ярилцдаг гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин бусад хүүхэд буюу “заримдаа ярилцдаг”, “маш цөөн удаа ярилцдаг” болон “огт ярилцдаггүй” гэж хариулсан хүүхдүүдийнхээс өндөр байгааг доорх зургаар харуулав.

Зураг 6. Хүүхдийн шударга байдлын түвшин, шударга байх талаар эцэг, эхтэйгээ ярилцдаг эсэх, хүйсээр



Эмэгтэй хүүхдүүд эрэгтэй хүүхдүүдээс илүүтэй шударга хандлагатай байна. Эцэг, эх хүүхэдтэйгээ шударга байх талаар байнга ярилцаж байх нь тэднийг шударга хандлага гаргахад эерэгээр нөлөөлж байна.

Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх нь иргэн бүрийн журамт үүрэг билээ. Судалгаагаар “Таныг шударга бус зүйл хийснийг эцэг, эх тань мэдвэл яадаг вэ?” гэж хүүхдүүдээс асуусан бөгөөд хүүхдүүдийн 72.2% нь “болохгүй зүйл хийснийг минь хэлж ойлгуулдаг” гэж хариулсан бол 27.8% нь “ямар ч үйлдэл хийдэггүй”, “сонирхдоггүй”, “зэмлэл хүлээлгэж шийтгэдэг” гэж хариулсан байна. Хүүхдээ шударга бус зүйл хийхэд эцэг, эх ямар хариу үйлдэл үзүүлж байгаа нь тэдний зөв төлөвшилт, шударга байх хандлагад нь хэрхэн нөлөөлж байгааг доорх зургаар харуулав.

“Болохгүй зүйл хийснийг минь хэлж ойлгуулдаг” гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин 4.05 байгаа нь “ямар ч үйлдэл хийдэггүй” гэж хариулсан хүүхдийнхээс 0.34 пунктээр илүү байна.

Зураг 7. Хүүхдийн шударга байдлын түвшин, шударга бус зүйлийн эсрэг эцэг, эхийн гаргаж буй үйлдлээр



Найз, нөхөд бусад хүмүүс:

Хүүхдүүдийн хувьд шударга байх, эсхүл зөв төлөвшилт олж авахад эцэг, эхээс гадна найз, нөхдийн хүрээ нөлөөтэй байдаг. Энэ удаагийн судалгаагаар хүүхдүүдээс “Таны найз танаас шударга бус үйлдэл хийхийг хүсдэг үү?” гэж асуусан бөгөөд судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 2.6% нь “байнга”, 11.6% нь “заримдаа”, 30.5% нь “маш цөөн удаа”, 55.2% нь “огт үгүй” гэж хариулсан байна. Эндээс харахад хүүхдүүдийн найз нөхдийн дунд шударга бус үйлдэл хийхийг хүсэх байдал бага бус байгааг харьж болох юм. Хүүхдүүдийн найз нөхдийн нөлөөлөл тэднийг шударга байхтай ямар хамааралтай байгааг доорх зургаар харуулав.

Зураг 8. Хүүхдийн шударга байдлын түвшин, найз нь шударга бус үйлдэл хийхийг хүсдэг эсэх, хүйсээр



Мөн л ямар нэгэн байдлаар найз нар нь “шударга бус үйлдэл” хийхийг хүсдэггүй хүүхдүүдийн шударга байдлын түвшин ямар нэгэн байдлаар хүсдэг буюу

“байнга”, “заримдаа”, “маш цөөн удаа” гэж хариулсан хүүхдүүдийнхээс өндөр байна.

Хүүхдийн шударга байдлын түвшинд нөлөөлж байгаа өөр нэг үзүүлэлт бол тухайн хүүхдийг шударга хандсаных нь төлөө хүмүүс “магтах, сайшаах, урамшуулах” явдал юм. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс “Шударга хандсаныхаа төлөө сайшаагдаж байсан уу?” гэж асуухад тэдний 69.7% нь “тийм”, 16.3% нь “зарим нь сайшаадаг ч, зарим нь үгүй”, 14.0% нь “үгүй” гэж хариулжээ.

Зураг 9. Хүүхдийн шударга байдлын түвшин, шударга хандсаных нь төлөө сайшаагдаж байсан эсэхээр



Эндээс харахад хүүхдүүд шударга хандсаныхаа төлөө сайшаагдаж байсан буюу “тийм” гэж хариулсан хүүхдүүдэд хамаарах шударга байдлын түвшин 4.06 буюу хамгийн өндөр байгаа бол “зарим нь сайшаадаг ч, зарим нь үгүй” гэж хариулсан хүүхдийнх 4.00, “сайшаагдаж байгаагүй буюу үгүй” гэж хариулсан хүүхдүүдийн 3.89 болж буурчээ.

Сургууль:

Ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилтийн болон авлигыг үл тэвчих үзлийг хүүхдүүдэд бага наснаас нь эхлэн төлөвшүүлэх, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгах шаардлагатай байгаа зэргийг Хүүхдийн шударга байдлы н судалгааны өмнөх жилийн тайлангуудын зөвлөмжид тусгасан байдаг.

Энэ удаагийн судалгаагаар хүүхдүүдээс “Танай ангид ямар нэгэн байдлаар шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ төрлийн үйл ажиллагаа зохиогддог уу?” гэж асуусан бөгөөд хүүхдүүдийн 77.3% нь “тийм”, 22.7% нь “үгүй” гэж хариулсан байна.

Хүүхдүүдэд шударга ёсны талаар хичээл орох, эсхүл шударга ёсны талаар ямар нэгэн үйл ажиллагаа зохиогдож байх нь тэдний шударга байдлын түвшинд нөлөөлж байгаа нь судалгаанаас харагдаж байна. “Танай ангид ямар нэгэн байдлаар шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ төрлийн үйл ажиллага а зохиогддог уу?” гэсэн асуултад “тийм” гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин “үгүй” гэж хариулсан хүүхдүүдийнхээс 0.16 пунктээр илүү байгааг доорх зургаар харуулав.

Зураг 10. Хүүхдийн шударга байдлын түвшин, шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ талаар үйл ажиллагаа зохиогддог эсэхээр



Хүүхдүүдэд ямар нэгэн байдлаар шударга ёсны талаар хичээл орох нь тэдний шударга байдлын түвшинг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх боломжтой байгааг энэ удаагийн судалгааны дүн дахин харууллаа.

Мэдээллийн орчин:

Судалгааны дүнгээс харахад хүүхдүүдийн ихэнх хэсэг нь шударга ёсны талаарх мэдээллийг сургууль (27.1-27.2%), гэр бүл (20.6-22.4%), телевиз, радио (12.8-17.4%)-гоос хүлээн авч байна. Хэдий тийм ч, цөөнгүй тооны хүүхэд найз нөхөд, интернет болон бусад эх үүсвэрээс мэдээлэл хүлээн авч байна.

Зураг 11. Шударга ёсны талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?, хувиар



Хүүхдүүд шударга ёсны талаарх мэдээллийг гэр бүл, сургуулийн орчноос авах нь илүү үр дүнтэй байна. Шударга ёсны талаарх мэдээллийг “гэр бүл” болон “сургууль”-аас авдаг хүүхдүүд бусад эх үүсвэрээс мэдээлэл авдаг хүүхдүүдээс илүү шударга байгааг мөн судалгаа харууллаа.

Зураг 12. Хүүхдийн шударга байдлын түвшин, хүүхдүүдийн мэдээлэл хүлээн авч буй эх үүсвэрээс хамаарч буй байдал



Тухайлбал, гэр бүл, сургуулиасаа шударга ёсны талаар мэдээлэл авдаг хүүхдийн шударга байдлын түвшин хамгийн өндөр буюу 4.09-4.10 байгаа бол сонин хэвлэл, найз нөхөд, интернетээс мэдээлэл авдаг гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин доогуур буюу 3.84-3.88 гэсэн үзүүлэлттэй гарчээ.

5. ХҮҮХДҮҮДИЙН ОЙЛГОЛТ, ҮЗЭЛ БОДОЛ

Хүүхдийн шударга байдлын түвшинг тооцоход ашигласан үндсэн 12 асуултын хүрээнд хүүхдийн ойлголт, үзэл бодлыг тодорхой харуулахын тулд сүүлийн хоёр удаагийн судалгааны дүнг харьцуулсан байдлаар энэ хэсэгт авч үзлээ.

Судалгаагаар “баян байх”, эсхүл “шударга байх”-ын алийг нь хүүхдүүд илүүд үзэж байгааг тодорхойлохыг зорьсон юм. 2014 оны байдлаар хүүхдүүдийн 80.7% нь “шударга байх”-ыг илүүд үзэж байгаа ч 6.9% нь “баян байх”-ыг илүүд үзсэн бол мөн 12.5% нь “мэдэхгүй” хариулт өгсөн байна.

Зураг 13. “Баян байх”, эсхүл “шударга байх”-ын алийг нь илүүд үзэх вэ?



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс “урт дараалалд зогсож байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээх” эсэхийг асуусан юм. Сүүлийн хоёр удаагийн судалгаагаар хүүхдүүдийн 68.5-72.9% нь урдуур нь дайрахгүй гэж хариулсан бол үлдсэн хэсэг болох 27.1-31.5% нь буюу 10 хүүхэд тутмын 3 нь урдуур нь дайрах, эсхүл ямар үйлдэл гаргахаа мэдэхгүй байгаагаа илэрхийлсэн байна.

Зураг 14. Урт дараалалд зогсож байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээх үү?



“Хүүхдүүд гэрийн даалгавраа хийхдээ, интернет зэрэг бусдын бүтээлээс өөрөө хийсэн мэт авч ашиглах нь зөв” эсэхийг тодруулсан. Сүүлийн 2 удаагийн судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 63.1-70.6% нь “буруу” хэмээн үзсэн бол 29.4-36.9% нь “зөв”, эсхүл “мэдэхгүй” гэж хариулсан байна

Зураг 15. Гэрийн даалгавраа хийхдээ, интернет зэрэг бусдын бүтээлээс өөрөө хийсэн мэт авч ашиглах нь зөв үү?



Хүүхдүүдийн үзэл бодлыг тодорхойлохын тулд “ямар нэгэн байдлаар багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга” гэдэгтэй санал нийлж байгаа эсэхийг нь тодруулсан юм. Хүүхдүүдийн дийлэнх хэсэг буюу 74.6-87.5% нь энэ аргатай санал нийлэхгүй гэж хариулсан байгаа ч мөн “санал нийлж байгаа”, “мэдэхгүй” гэж хариулсан хүүхэд 12.5% буюу ойролцоогоор 10 хүүхэд тутмын 1 нь энэ аргыг хүлээн зөвшөөрсөн хариулт өгчээ.

Зураг 16. Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга гэдэгтэй санал нийлэх үү?



“Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэх ёстой” гэдэгтэй хүүхдүүдийн 77.3% нь санал нийлж байгаа бол 7.9% нь мэдэхгүй, 14.8% нь санал нийлэхгүй гэж хариулсан байна. “Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэх ёстой” гэж үзэж байгаа хүүхдийн хувийн жин өмнөх судалгааныхаас 15.4 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 17. Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэх ёстой гэдэгтэй санал нийлэх үү?



Судалгаанд хамрагдсан 7-11 дүгээр ангийн хүүхдүүдийн үзэж байгаагаар сайн найз нь шалгалт өгөхдөө бусдаас хуулах нь “буруу” гэдэгтэй 52.5% нь санал нийлж байгаа бол үлдсэн хэсэг болох 47.5% буюу дунджаар 2 хүүхэд тутмын 1 нь “зөв”, эсхүл “мэдэхгүй” гэж хариулсан байгаа нь өндөр дүн болж байна.

Зураг 18. Таны сайн найз чинь шалгалт өгөхдөө бусдаас хуулах нь зөв үү?



Багш нар хүүхдүүдээс ямар нэгэн байдлаар бэлэг авах явдал нь буруу гэж хүүхдүүд үзэж байна. Сүүлийн 2 удаагийн судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 73.3-74.3% нь багш хичээл зааж, сургууль төгсгөснийхөө төлөө сурагчдаас хариу шан харамж, бэлэг хүсэх нь буруу гэж үзэж байна. Багшдаа бэлэг өгөхийг буруу гэж үзэж байгаа хүүхдүүд нэлээд байгаа ч хүүхдүүдийн 25.8-26.7% нь “мэдэхгүй”, эсхүл “зөв” гэж үзсээр байгааг анхаарах шаардлагатай байна.

Зураг 19. Багш хичээл заах, сургууль төгсгөснийхөө төлөө сурагчдаас хариу шан харамж, бэлэг хүсэх нь зөв үү?



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 85.9% нь хууль сахиулагч хэн нэгэн дэргэд /ойр/ байхгүй үед ч хууль зөрчих нь буруу гэж хариулсан нь өмнөх оны дүнгээс 19.5 пунктээр нэмэгдсэн эерэг үзүүлэлт болж байна.

Мөн 2014 оны судалгаагаар хүүхдүүдийн 4.7% нь хууль сахиулагч хэн нэгэн дэргэд байхгүй үед хууль зөрчих нь “зөв”, 9.4% нь “мэдэхгүй” гэсэн хариултыг өсөн байна.

Зураг 20. Хууль сахиулагч хэн нэгэн таны дэргэд /ойр/ байхгүй үед хууль, дүрэм зөрчиж болох уу?



“Том хүмүүсийн хууль бус үйлдэл өөрт чинь ашигтай байвал буруу зүйл мөн үү?” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 74.2% нь “тийм”, 7.2% нь “үгүй” гэж хариулсан байна. Гэвч энэ байдалд эргэлзсэн буюу мэдэхгүй гэж 18.6% нь хариулсан байна.

Зураг 21. Том хүмүүсийн хууль бус үйлдэл өөрт чинь ашигтай байвал буруу зүйл мөн үү?



Хүүхдүүдийн хувьд шударга байдлын талаарх төсөөллийг үнэлэхэд ашигласан өөр нэг асуулт бол “Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн Таны сайн найз байсан ч багш, эцэг, эх, дотнын хүндээ мэдэгдэх үү?” гэсэн асуулт байв.

Сүүлийн 2 удаагийн судалгааны дүнгээр дээрх асуултад хүүхдүүдийн 39.5-44.8% нь “үгүй”, 22.4-28.0% нь “тийм” гэсэн хариулт өгсөн байна. Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргээс судалгаанд хамрагдсан 13 настай нэгэн хүүхэд “хүүхдүүд аав, ээждээ зэмлүүлэхгүй, эсхүл дүнгээ ахиулахын тулд шалгалтаа хуулдаг” гэж ярьсан юм. Үнэхээр эцэг, эх хүүхдээ зэмлэх, зарим зүйлийг шаардах зэрэг нь тухайн хүүхдийг шалгалтаа хуулах, эсхүл хууль бус үйлдэл гаргахад нь нөлөөлж байж болох юм.

Зураг 22. Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн Таны сайн найз байсан ч багш, эцэг, эх, дотнын хүндээ мэдэгдэх үү?



“Танай гэр бүлийн хэн нэгэн албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь зөв үү?” гэсэн асуултад хүүхдүүдийн 77.8% нь “буруу” гэж хариулсан бол 6.1% нь “зөв”, 16.1% нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Зураг 23. Танай гэр бүлийн хэн нэгэн албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь зөв үү?



Аливаа шударга бус үйлдлийг үл тэвчих байдлыг тодорхойлох зорилгоор хүүхдүүдээс шударга бус үйлдлийн талаар олон нийтэд мэдээлж байх нь зөв эсэхийг тэднээс асуусан юм. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 79.8-81.0% нь шударга бус үйлдлийн талаар олон нийтэд мэдээлэх нь зөв гэж үзэж байгаа бол 19.0-20.2% нь буруу гэж үзсэн байна.

Зураг 24. Шударга бус үйлдлийн талаар олон нийтэд мэдээлэх нь зөв үү?



Багш нарын зүгээс шударга бус үйлдэл гаргаж, хүүхдүүдтэй зохисгүй харилцсан тохиолдолд хэнд хандахыг нь тодруулсан юм. Судалгаагаар эрэгтэй хүүхдүүдийн 24.7% нь сургуулийн захиргаанд, 23.5% нь эцэг эхдээ, 18.7% нь ангийн багшдаа хандана гэж хариулсан бол эмэгтэй хүүхдүүдийн 30.7% нь эцэг, эхдээ, 20.0% нь сургуулийн захиргаанд, 18.1% нь ангийн багшдаа хандана гэсэн үзүүлэлттэй байна. Үүнээс гадна, судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хамгийн бага хувь буюу 2.1-2.5% нь хүүхдийн утас “1979”-д хандана гэсэн байгаа нь хүүхдүүд энэ утасны талаар мэдээлэл муутай байдагтай холбоотой байж болох юм.

Зураг 25. Багш нарын зүгээс шударга бус үйлдэл гаргаж, хүүхдүүдтэй зохисгүй харилцсан тохиолдолд хэнд хандах вэ?



ХАВСРАЛТ

Хавсралт 1. Хүүхдийн шударга байдлын түвшин дэд үзүүлэлтээр[3]

Д/д	Үзүүлэлт		Үнэлгээ			
			2010	2012	2013	2014
ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН			**3.29**	**2.93**	**3.71**	**4.03**
А. Ёс зүй, ёс суртахууны дэд үзүүлэлт			**3.03**	**2.73**	**3.80**	**4.07**
	Танин мэдэхүйн	Гэрийн даалгавраа хийхдээ интернет зэрэг бусдын бүтээлээс өөрөө хийсэн мэт ашиглах нь буруу зүйл биш.	3.20	2.72	3.66	3.94
	Нөлөөллийн	Баян байх нь шударга байхаас илүү чухал.	2.70	2.49	3.91	4.28
	Зан үйлийн	Урт дараалалд зогсож байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээнэ.	3.20	2.99	3.82	3.99
Б. Зөв төлөвшилтийн дэд үзүүлэлт			**2.51**	**2.29**	**3.88**	**4.32**
	Танин мэдэхүйн	Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш.	2.20	1.85	3.99	4.45
	Нөлөөллийн	Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга юм.	2.20	1.94	4.08	4.48
	Зан үйлийн	Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэнэ.	3.10	3.10	3.57	4.02
В. Хууль сахих байдлын дэд үзүүлэлт			**3.54**	**2.85**	**3.83**	**4.04**
	Танин мэдэхүйн	Сайн найз чинь шалгалт өгөхдөө бусдаас хуулах нь буруу зүйл биш.	4.42	3.61	3.63	3.63
	Нөлөөллийн	Багш хичээл зааж, сургууль төгсгөснийхөө төлөө сурагчдаас хариу шан харамж, бэлэг хүсэж болно.	3.40	2.96	4.02	4.10
	Зан үйлийн	Хууль сахиулагч хэн нэгэн таны дэргэд /ойр/ байхгүй үед хууль, дүрэм зөрчиж болно.	2.80	1.98	3.83	4.38
Г. Авлигыг үл тэвчих байдлын дэд үзүүлэлт			**2.98**	**2.81**	**3.35**	**3.68**
	Танин мэдэхүйн	Том хүмүүсийн хууль бус үйлдэл нь өөрт чинь ашигтай байвал буруу зүйл биш.	2.70	2.34	3.69	4.15
	Нөлөөллийн	Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн нь Таны сайн найз байсан ч багш, эцэг/эх/, дотнын хүндээ мэдэгдэнэ.	3.35	3.11	2.73	3.29
	Зан үйлийн	Гэр бүлийнхэн чинь албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь буруу зүйл биш.	2.90	2.97	3.65	4.19

3 Хүүхдийн шударга байдлын түвшин 1-д ойртох тусам шударга бус, харин 5-д ойртох тусам шударга гэж үзнэ.

Хавсралт 2. 2014 оны судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн асуултад хариулсан байдал, дүнд эзлэх хувиар

Асуулт	Санал огт нийлэхгүй	Санал нийлэхгүй	Эргэлзэж байна/ мэдэхгүй	Санал нийлж байна	Санал бүрэн нийлж байна	ДҮН
Сайн найз чинь шалгалт өгөхдөө бусдаас хуулах нь буруу зүйл биш.	29.1%	23.4%	32.0%	12.7%	2.7%	100.0%
Том хүмүүсийн хууль бус үйлдэл нь өөрт чинь ашигтай байвал буруу зүйл биш.	51.4%	22.8%	18.6%	4.2%	3.0%	100.0%
Гэрийн даалгавраа хийхдээ интернет зэрэг бусдын бүтээлээс өөрөө хийсэн мэт ашиглах нь буруу зүйл биш.	43.5%	27.1%	13.7%	11.0%	4.7%	100.0%
Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш.	66.1%	22.1%	5.9%	3.1%	2.9%	100.0%
Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга юм.	66.7%	20.8%	7.9%	2.9%	1.7%	100.0%
Баян байх нь шударга байхаас илүү чухал.	58.4%	22.3%	12.5%	2.9%	4.0%	100.0%
Багш хичээл зааж, сургууль төгсгөснийхөө төлөө сурагчдаас хариу шан харамж, бэлэг хүсэж болно.	49.4%	23.9%	16.0%	8.9%	1.9%	100.0%
Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн нь Таны сайн найз байсан ч багш, эцэг/эх/, дотнын хүндээ мэдэгдэнэ.	20.1%	19.5%	38.0%	14.6%	7.9%	100.0%
Урт дараалалд зогсож байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээнэ.	39.7%	33.3%	15.7%	9.0%	2.4%	100.0%
Хууль сахиулагч хэн нэгэн таны дэргэд /ойр/ байхгүй үед хууль, дүрэм зөрчиж болно.	57.6%	28.3%	9.4%	3.6%	1.1%	100.0%
Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэнэ.	9.0%	5.9%	7.9%	28.6%	48.8%	100.0%
Гэр бүлийнхэн чинь албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь буруу зүйл биш.	49.5%	28.3%	16.1%	3.6%	2.5%	100.0%

УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН 2014 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН 2014 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ОРШИЛ

Төрөөс авч хэрэгжүүлж байгаа авлигын эсрэг тэмцлийн нэг хэсэг нь авлигын нөхцөл байдал, цар хүрээ, шалтгаан, хэлбэрийг бодитой, үнэн зөвөөр тогтоох явдал юм. Энэ хүрээнд Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг судалгаануудын нэг нь “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн судалгаа” юм.

Энэхүү судалгааг жил бүр зохион байгуулж явуулах чиг үүргийг Улсын Их Хурлын 2008 оны 13 дугаар тогтоолоор Авлигатай тэмцэх газарт даалгасан бөгөөд судалгааны үр дүн нь Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтийг үнэлэх нэг шалгуур болдгоороо онцлог юм.

Олон нийтэд толилуулж буй энэхүү судалгааны тайлан Монгол Улс дахь авлигын нөхцөл байдал, ялангуяа “том авлига” гэж онцлон нэрлэдэг улс төрийн хүрээний авлигын талаар

тодорхой дүр зураг, төсөөлөл өгнө гэдэгт найдаж байна.

2014 оны улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига буюу “өндөр” түвшний авлигын талаархи шинжээчдийн үнэлгээг гаргах судалгааг шинэчилсэн аргачлалын дагуу зохион байгууллаа.

Судалгааны үр дүнг авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажилд бодитой ашиглах, авлигын нөхцөл байдлын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх нь судалгааны нэг чухал хэсэг юм.

Судалгааны үр дүнг илүү чанартай, өгөөжтэй, бодитой болгох, цаашид судалгааны арга зүй, аргачлалыг сайжруулах талаарх саналаа тус газарт ирүүлэхийг хүсье.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2014 оны Монгол Улс дахь “Өндөр” түвшний авлигын төсөөллийн үнэлгээ

Монгол Улсын улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига буюу “өндөр” түвшний авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн 2014 оны үнэлгээ **3.58** гарлаа. Энэхүү үзүүлэлт нь Монгол Улсад “өндөр” түвшний авлига түгээмэл байгааг илэрхийлж байна.

Зураг 1. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига буюу “өндөр” түвшний авлигын төсөөллийн үнэлгээ



АВЛИГЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВ

Сүүлийн 1 жилийн хугацаанд Монгол Улсад авлига хэр түгээмэл байсан гэж Та үзэж байна вэ?

Судалгаагаар Монгол Улсын улс төр, шүүх, хууль сахиулах байгууллагын хүрээн дэх авлига буюу “өндөр” түвшний авлигын түвшинг тодорхойлохоос гадна Монгол улс дахь авлигын түвшинг ерөнхий байдлаар тодорхойлох зорилгоор *1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их* гэсэн үзүүлэлтийг ашиглан шинжээчдээр үнэлүүлэв.

Зураг 2. 2014 оны авлигын ерөнхий түвшин



Шинжээчдийн 48.5 хувь нь Монгол Улсын авлигын ерөнхий түвшинг их, 24.3 хувь нь дунд зэрэг, 16.6 хувь нь маш их, 7.6 хувь нь бага зэрэг гэж үзсэн бөгөөд 3 хувь нь мэдэхгүй гэж хариулсан бол огт үгүй гэсэн хариултыг сонгоогүй байна.

2014 оны Монгол Улс дахь авлигын ерөнхий түвшин 3.77 буюу авлига их байна.

Сүүлийн нэг жилийн хугацаанд дараахь хүрээнд авлига хэр түгээмэл байсан гэж Та үзэж байна вэ?

Судалгаагаар Монгол Улсын улс төр, шүүх, хууль сахиулах байгууллагын хүрээн дэх авлига буюу “Өндөр” түвшний авлигын түвшинг тодорхойлохоос гадна Монгол улс дахь нийтийн алба болон үйл ажиллагаагаараа нийтийн албатай холбоотой улс төрийн нам, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага дахь авлигын түвшинг ерөнхий байдлаар тодорхойлох зорилгоор *1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их* гэсэн үзүүлэлтийг ашиглан шинжээчдээр үнэлүүлэв.

Зураг 3. Нийгмийн салбар, хүрээн дэх авлигын түвшин



Шинжээчдийн 65 хувь нь орон нутгийн төрийн захиргааны байгууллагын удирдлагын үйл ажиллагаанд, 66.6 хувь нь Засгийн газар, яам, агентлагийн үйл ажиллагаанд, 53 хувь нь улс төрийн намуудын үйл ажиллагаанд, 56 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд, 45 хувь нь Улсын Их

Хурлын үйл ажиллагаанд, 48.5 хувь нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд, 40.9 хувь нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд авлига их буюу маш их байсан гэж үзжээ.

Сүүлийн нэг жилийн хугацаанд Монгол Улсын авлигын түвшинд нөлөөлсөн гол шалтгаан нөхцөлийг Та юу гэж үзэж байна вэ?

Шинжээчид 2014 оны өндөр түвшний авлигад нөлөөлсөн дараахь шалтгаан нөхцөлүүдийг нэрлэв.

- ✓ албан тушаалтнуудын ёс зүйгүй байдал, ёс зүйн доройтол,
- ✓ төрийн албан дахь хүнд суртал, олон шат дамжлага, ил тод бус байдал, ашиг сонирхлын зөрчил, ах дүүсэг, танил талсаг байдал,
- ✓ ядуурал,
- ✓ ажилгүйдэл,
- ✓ баян ядуугийн ялгаа, орлогын тэгш бус хуваарилалт
- ✓ сул эрх зүйн орчин,
- ✓ хууль тогтоомж хэрэгждэггүй,
- ✓ бага цалин, орлого,
- ✓ улс төрийн болон сонгуулийн тогтолцооны гажиг,
- ✓ нэг намд төвлөрсөн эрх мэдэл,
- ✓ нам доторх бүлэглэлүүдийн тэмцэл,
- ✓ төрийн үйлчилгээний, үүнд ялангуяа эрүүл мэнд, боловсролын салбар дахь хүртээмжгүй байдал,
- ✓ хяналтын сул механизм,
- ✓ эдийн засгийн орчин муудсан,
- ✓ улс төрийн томилгоо,
- ✓ улс төрчдийн авлигатай тэмцэх хүсэл зориг сул,
- ✓ төрийн албан дахь улс төрийн намын нөлөөлөл

- ✓ амьжиргааны доогуур түвшин
- ✓ улс төр, бизнесийн бүлэглэлийн үйл ажиллагаа
- ✓ Төрийн өндөр албан тушаалтнууд эрх мэдэл, нэр нөлөөгөө худалддаг байдал
- ✓ Төрийн алба, улс төр дэх дур зоргоороо аашилж авирлах нь байдал
- ✓ Төрийн албаны тогтворгүй байдал
- ✓ Төрийн албан тушаалтныг улс төрийн, садан төрлийн, нутаг орны, найз нөхдийн хэлхээ холбоогоор томилж байна
- ✓ Иргэдийн авлигын талаарх үзэл бодол, ухамсар төлөвшөөгүй
- ✓ Хууль тогтоомж уялдаагүй, зөрчил, хийдэл, давхардалтай
- ✓ Хувийн хэвшлийн үйл ажиллагаан дахь төрийн оролцоо их
- ✓ Эдийн засгийн буруу бодлого

“ӨНДӨР” ТҮВШНИЙ АВЛИГЫН ЦАР ХҮРЭЭ: ТАРХАЛТ

Сүүлийн 1 жилийн хугацаанд Монгол Улсын улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлига хэр түгээмэл байсан гэж Та үзэж байна вэ?

2014 онд Монгол Улсын улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлига хэр түгээмэл байсан талаар *1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их* гэсэн үзүүлэлтийг ашиглан шинжээчдээр үнэлүүлэв.

Зураг 4. Улс төрийн хүрээний авлигын түвшин



Монголын улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлига маш их болон их түгээмэл байна гэж үзсэн шинжээчдийн хувь хэмжээ 65.1%

Шинжээчдийн 42 хувь нь “өндөр” түвшний авлига их байна гэж үзсэн бол 23 хувь нь маш их байна гэж үзсэн байна.

Тэдний 21 хувь нь дунд зэрэг, 9 хувь нь бага зэрэг гэж тус тус дүгнэсэн байна.

ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГЫН ЦАР ХҮРЭЭ: ӨӨРЧЛӨЛТ

Сүүлийн нэг жилийн хугацаанд Монгол Улсын улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига өмнөх жилийн түвшингээс хэр өөрчлөгдсөн гэж Та үзэж байна вэ?

Монгол Улсын улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига 2014 онд өмнөх оныхоос хэр өөрчлөгдсөн талаар *1 – маш их буурсан, 2 – багассан, 3 – өөрчлөгдөөгүй, 4 – нэмэгдсэн, 5 – маш их нэмэгдсэн* гэсэн үзүүлэлтийг ашиглан шинжээчдээр үнэлүүлэв.

Шинжээчдийн **42.4** хувь буюу тал шахам хувь нь өөрчлөгдөөгүй гэж үзсэн бол **24.2** хувь нь буюу ¼ нь 2014 онд авлига өмнөх оны түвшингээс буурсан гэж үзжээ.

Харин шинжээчдийн **18.2** хувь буюу 1/5 шахам хувь нь авлига нэмэгдсэн гэж, **9.1** хувь нь маш их нэмэгдсэн гэж үзжээ. 2014 онд авлига өмнөх оны түвшингээс маш их буурсан гэсэн хариултыг шинжээчид сонгоогүй байна.

Судалгаанд оролцсон шинжээчдийн **6.1** хувь нь энэ асуултад мэдэхгүй гэж хариулжээ. Энэхүү үнэлгээний дундаж үзүүлэлт нь **3.13** байна.

Зураг 5. Улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын түвшний өөрчлөлт



ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГЫН ЦАР ХҮРЭЭ: САЛБАР, ХҮРЭЭГЭЭР

Сүүлийн нэг жилийн хугацаанд дараахь салбар, хүрээнд авлига тархсан цар хүрээг тодорхойлно уу?

2014 онд Монгол Улсын улс төрийн хүрээний болон хууль сахиулах байгууллагуудад авлига тархсан цар хүрээг *1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их* гэсэн үзүүлэлтийг ашиглан шинжээчдээр үнэлүүлэв.

Зураг 6. Улс төрийн хүрээ, хууль сахиулах байгууллагад авлига тархсан байдал

Шинжээчдийн 65 хувь нь аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт, 62 хувь нь Засгийн газар, яам, агентлагт, 50 хувь нь улс төрийн намд, 53 хувь нь нутгийн өөрөө удирдах байгууллагад, 42 хувь нь Улсын Их хуралд, 34.8 хувь нь Цагдаагийн байгууллагад, 30.3 хувь нь прокурорын байгууллагад, 30.3 хувь нь шүүхэд, 24 хувь нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад өндөр түвшний авлига их болон маш их байсан гэж үзсэн байна. Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний газар, шүүхийн шинжилгээний байгууллага, Ерөнхийлөгчийн засаглалын хүрээ, хил хамгаалах байгууллага, тахарын албанд өндөр түвшний авлига дунд зэрэг байсан гэж шинжээчид үзжээ.

ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГЫН ЦАР ХҮРЭЭ: УЛС ТӨРИЙН НАМУУД

Монгол Улсад улс төрийн аль нам авлигад хамгийн ихээр автсан бэ?

2014 онд улс төрийн намуудын үйл ажиллагаан дахь авлигын цар хүрээг *1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их* гэсэн үзүүлэлтийг ашиглан шинжээчдээр үнэлүүлэв.

Зураг 7. Улс төрийн намуудын авлигад автсан байдал



Шинжээчдийн 54.56 хувь нь Ардчилсан намыг, 33.56 хувь нь Монгол Ардын Намыг, 23.98 хувь нь Монгол Ардын Хувьсгалт Намыг авлигад хамгийн ихээр автсан гэж үзсэн байна.

Харин шинжээчдийн 6.34 хувь нь Иргэний зориг-Ногоон Намыг, 4.8 хувь нь Монголын Үндэсний Ардчилсан Намыг, 0.6 хувь нь Монголын Ногоон Намыг авлигад хамгийн ихээр автсан гэж үзсэн байна.

ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГЫН ЦАР ХҮРЭЭ: ҮЙЛ АЖИЛЛАГААГААР

Сүүлийн нэг жилийн хугацаанд нийтийн алба /төрийн байгууллага/-ны дараахь үйл ажиллагаанд авлига ямар хэмжээнд байсан гэж Та үзэж байна вэ?

2014 онд Монгол Улсын улс төрийн хүрээний болон хууль сахиулах байгууллагуудын голлох үйл ажиллагаанууд дахь авлигын цар хүрээг *1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их* гэсэн үзүүлэлтийг ашиглан шинжээчдээр үнэлүүлэв.

Зураг 8. Улс төрийн хүрээний болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаан дэхь авлигын цар хүрээ

Шинжээчдийн 77.3 хувь нь худалдан авах ажиллагаа, тендер шалгаруулалтанд, 68.2 хувь нь албан тушаалын томилгоонд, 69.7 хувь нь тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах үйл ажиллагаанд авлига маш их болон их байсан гэж үзэж байна. Төсвийн хөрөнгийг захиран зарцуулахтай холбоотой үйл ажиллагаа, тухайлбал тусгай сангийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, төсвийн зарцуулалт зэрэг үйл ажиллагаанд авлига маш их болон их байсан гэж шинжээчдийн 51.5 –аас 57.6 хувь нь үзсэн байна.

> **“Чингис, Самурай бондын хөрөнгө хяналтгүй зарцуулагдаж байна, төсвийн зарцуулалт ил тод бус, хяналт сул байна”**
>
> **Шинжээчийн хариултаас**

ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГЫН ЦАР ХҮРЭЭ: ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАР

Сүүлийн нэг жилийн хугацаанд улс төрийн хүрээний авлига дараахь салбар болон үйл ажиллагаанд хэр зэрэг чиглэгдсэн гэж Та төсөөлж байна вэ?

2014 онд Монгол Улсад улс төрийн хүрээний авлига нийгэм, эдийн засгийн тодорхой салбар, хүрээний үйл ажиллагаанд чиглэгдсэн байдлыг *1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их* гэсэн үзүүлэлтийг ашиглан шинжээчдээр үнэлүүлэв.

Зураг 9. Нийгэм, эдийн засгийн тодорхой салбар, хүрээний үйл ажиллагаан дахь авлигын цар хүрээ

Шинжээчид барилга, дэд бүтэц, уул уурхай, ашигт малтмалын салбарт улс төрийн хүрээний буюу "өндөр" түвшний авлига илүүтэй чиглэсэн гэж үзжээ.

Гэвч судалгаанд хамруулсан бусад салбарын хувьд ч байдал сайнгүй байна. Олон нийтэд хүчтэй нөлөө үзүүлдэг хэвлэл мэдээллийн салбар, улс орны амьдралын амин чухал асуудлуудыг бүхэлд нь зохицуулдаг хууль тогтоох, шийдвэр гаргах үйл ажиллагаа, татвар төлөгчдийн мөнгөөр санхүүждэг төрийн албаны үйл ажиллагаанд авлига оршсон хэвээр байгааг судалгааны дүн харуулж байна.

> **"Төрийн албыг мөнгө олох хэрэгсэл гэж бодсон хүмүүс төрийн албанд орж байна"**
>
> **Шинжээчийн хариултаас**

ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГЫН ХЭЛБЭР: ШИЙДВЭР ГАРГАХАД НӨЛӨӨЛӨХ

Сүүлийн нэг жилийн хугацаанд улс төрийн хүрээ, шүүх, хууль сахиулах байгууллагын хүрээнд албан тушаалтнаар өөрт ашигтай, давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахад дараахь хэлбэрүүдийг хэр түгээмэл ашигласан гэж Та бодож байна вэ?

Аливаа хуулийн этгээд, хувь хүн, албан тушаалтан, бизнес эрхлэгчдийн зүгээс өөрийн ашиг сонирхолд нийцсэн шийдвэр гаргуулахын тулд Монгол Улсын төрийн албан тушаалтанд нөлөөлөх олон арга хэрэгслийг ашигладаг. Эдгээрийг *1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их* гэсэн үзүүлэлтийг ашиглан шинжээчдээр үнэлүүлэв.

Зураг 10. Авлигын хэлбэр

Шинжээчдийн 68.2 хувь нь ажил, албан тушаалд томилох, оруулах, 60.6 хувь нь ашиг, орлогоо хуваалцах, 51.5 хувь нь бэлэн мөнгө өгөх, 37.9 хувь нь аялал жуулчлалын зардал төлөх, 39.4 хувь нь гадаад арга хэмжээний зардал төлөх, 39.4 хувь нь шагнал, цол, тэмдгээр шагнах, 31.9 хувь нь сургалтын зардал төлөх, 25.7 хувь нь өрийг нь төлөх, 39.4 хувь нь үнэтэй бэлэг өгөх, 28.8 хувь нь эмчилгээ, сувилгааны зардал төлөх, 25.7 хувь нь ажил, үйлчилгээний төлбөрийн хөнгөлөлт эдлүүлэх, 18.1 хувь нь гадаадын банканд данс нээж өгөх, 18.2 хувь нь хувьцаа өгөх зэрэг нөлөөллийн арга, хэрэгслийг маш их болон их хэмжээгээр хэрэглэсэн гэж үзжээ.

ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГЫН ХЭЛБЭР: НӨЛӨӨЛЛИЙН АРГА ЗАМ

Сүүлийн нэг жилийн хугацаанд улс төрчид, өндөр албан тушаалтнууд хувийн зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөхийн тулд дараахь хэлбэрүүдийг хэр хэрэглэсэн гэж Та тодорхойлох вэ?

2014 онд Монголын улс төрчид, төрийн өндөр албан тушаалтнуудын зүгээс хувийн эрх ашгаа гүйцэлдүүлэхийн тулд төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлсөн арга замуудыг *1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их* гэсэн үзүүлэлтийг ашиглан шинжээчдээр үнэлүүлэв.

Зураг 11. Авлигын хэлбэр

Шинжээчдийн 78.8 хувь нь улс төрчид, төрийн өндөр албан тушаалтнуудын зүгээс төрийн албан тушаалтнуудад улс төрийн намын хэлхээ холбоог ашиглан нөлөөлөх явдал маш их болон их хэмжээтэй байсан гэж үзжээ.

Шинжээчдийн 65.1 хувь нь нутаг орны хэлхээ холбоог ашиглах арга замыг, 65.1 хувь нь найз нөхөд, танил талын хэлхээ холбоог ашиглах арга замыг, 60.6 хувь нь садан төрлийн хэлхээ холбоог ашиглах арга замыг,

54.5 хувь нь дарамт шахалт үзүүлэх арга замыг, 51.5 хувь нь амлалт өгөх арга замыг, 43.9 хувь нь хүсэлт тавих арга замыг, 33.3 хувь нь албадах арга замыг маш их болон их хэмжээгээр ашигласан гэж үзжээ.

Төрийн жинхэнэ албан хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ хуулийг чанд баримтлах бөгөөд албан тушаалынхаа эрх мэдлийг аль нэг намын эрх ашигт нийцүүлэн ашиглахыг хориглоно.

Улс төрийн намын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2

Нөгөө талаас төрийн албан тушаалтнууд ийнхүү бусдын нөлөөнд автаж байгаа нь тэднийг ёс зүйн доройтол, зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага хүлээлгэдэггүй, түүнчлэн албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж их байгаатай холбоотой гэж дүгнэж байна.

ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГЫН ХЭЛБЭР: УЛС ТӨРИЙН ОРЧИНД

Сүүлийн нэг жилийн хугацаанд дараахь нөхцөл байдал байгаа гэдэгтэй Та санал нийлэх үү?

Улс төрчид, шүүгчид, хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд болон бизнесийн бүлэглэлүүдийн хоорондын холбоо сүлбээ нь Монголын улс төрийн орчинд зарим сөрөг нөхцөл байдлыг үүсгээд байгаа бөгөөд эдгээр нөхцөл байдлын түвшнийг *1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их* гэсэн үзүүлэлтийг ашиглан шинжээчдээр үнэлүүлэв.

Зураг 12. Авлигын хэлбэр



Улс төрийн нэгдмэл ашиг сонирхол бүхий бүлэг болон бизнесийн нэгдмэл ашиг сонирхол бүхий бүлэглэлүүд хоорондоо нэгдэж, улс төр болон бизнесийн нөхцөл байдалд нөлөөлөх болсон нь Монгол дахь улс төрийн хүрээний буюу “өндөр” түвшний авлигын нэг хэлбэр болтлоо ноцтой байдалд хүрсэн болохыг судалгааны дүн харуулж байна.

Улс төрийн авлига илүү их, эсвэл маш их далд хэлбэрт шилжсэн болохыг шинжээчдийн 62.1 хувь нь хүлээн зөвшөөрчээ.

ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГЫН ХЭЛБЭР: ХЭЛБЭРҮҮДИЙН ТАРХАЛТ

Сүүлийн нэг жилийн хугацаанд улс төрийн хүрээнд авлигын дараахь хэлбэр хэр тархсан гэж Та төсөөлж байна вэ?

Улс төрийн хүрээн дэх авлига нь олон хэлбэрээр илрэн гардаг бөгөөд эдгээрийн түвшнийг *1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их* гэсэн үзүүлэлтийг ашиглан шинжээчдээр үнэлүүлэв.

Зураг 13. Авлигын хэлбэр



Шинжээчид судалгааны асуулгад тусгасан авлигын хэлбэрүүдийн нэгээс бусдыг нь их хэмжээгээр тархсан байна гэж үзсэн бөгөөд эдгээрээс төрийн албан тушаалтнууд албан тушаал, эрх мэдлээ хэтрүүлэх, урвуулан ашиглах, хувийн ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, бусад албан тушаалтанд нөлөөлж өөрийн хувийн ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргуулах, аж ахуйн нэгжид давуу байдал олгох зэрэг үйл ажиллагааг хамгийн их явуулдаг гэж үзсэн байна. Эдгээр нөхцөл байдал нь өндөр түвшний авлигад хамгийн ихээр нөлөөлж байгаа хүчин зүйлүүд болох намын харьяаллаар төрийн албаны томилгоог хийж байгаа байдал болон төрийн албан хаагчдын ёс зүйн доройтол, албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж өргөн байгаатай холбоотой болохыг судалгааны дүн харуулж байна.

ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГЫН ХЭЛБЭР: ХЭЭЛ ХАХУУЛИЙН АРГА

Сүүлийн нэг жилийн хугацаанд улс төрийн хүрээнд хээл хахууль өгөх, авах дараахь аргуудыг хэр хэрэглэсэн гэж Та төсөөлж, таамаглаж байна вэ

Улс төрчид, төрийн өндөр албан тушаалтнууд, шүүх, хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудаас өөрийн албан тушаалын эрх мэдлийг хувийн зорилгоор ашиглах нь олон хэлбэрээр илрэн гардаг бөгөөд эдгээр хэлбэрүүдийн түгээмэл байдлын түвшнийг *1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их* гэсэн үзүүлэлтийг ашиглан шинжээчдээр үнэлүүлэв.

Зураг 14. Авлигын хэлбэр.

Шинжээчдийн 47 хувь нь улс төрчид, төрийн өндөр албан тушаалтнууд, шүүх, хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудын гэр бүлийн гишүүд, ойр дотнын хүмүүс, тэдний өмчлөлийн аж ахуйн нэгжид давуу байдал олгох нь тэдэнд хээл хахууль өгч буй их хэмжээгээр болон маш их хэмжээгээр хэрэглэгдсэн хэлбэр гэж үзсэн байна. Түүнчлэн шинжээчдийн үзэж байгаагаар төрийн өндөр албан тушаалтнууд хээл хахууль авахдаа аливаа үйл ажиллагааны зардлыг төлүүлэх, төлбөр хийлгэх, өмч хөрөнгийг зах зээлийн үнээс илүү үнээр худалдах зэрэг аргыг их хэмжээгээр болон маш их хэмжээгээр ашигласан байна.

ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ: УЛС ТӨРИЙН ХҮРЭЭНИЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Сүүлийн нэг жилийн хугацаанд дараахь хүчин зүйлс “өндөр” түвшний авлигад хэр зэрэг нөлөөлсөн гэж Та үзэж байна вэ?

Дээд түвшний авлигад нөлөөлж буй улс төрийн хүрээний тодорхой хүчин зүйлсийн нөлөөллийг *1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их* гэсэн үзүүлэлтийг ашиглан шинжээчдээр үнэлүүлэв.

Зураг 15. Авлигын шалтгаан нөхцөл

Шинжээчдийн 83.3 хувь нь нам доторх болон улс төрийн албан дахь албан тушаалын томилгоо болон намын санхүүжилтийн механизм зэрэг хүчин зүйлс нь 2014 онд өндөр түвшний авлигад маш их болон их хэмжээгээр нөлөөлсөн хүчин зүйл гэж үзжээ. 80.3 хувь нь сонгуулийн санхүүжилтийн тогтолцоо, 71.2 хувь нь улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил, 65.1 хувь нь Улсын Их Хурлын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил, 63.6 хувь нь Засгийн газрын үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил, 57.6 хувь нь төрийн байгууллагын үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил, 54.5 хувь нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил, 60.6 хувь нь сонгуулийн өнөөгийн тогтолцоо өндөр түвшний авлигад их болон маш их нөлөөлсөн гэж үзсэн байна.

ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ: ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сүүлийн нэг жилийн хугацаанд нийтийн алба / төрийн байгууллагын үйл ажиллагаанд оршиж буй дараахь дутагдал, доголдол авлигын түвшинд хэр нөлөөлсөн гэж Та үзэж байна вэ?

Төрийн байгууллагын үйл ажиллагааны ямар дутагдал доголдол авлигад хэр зэрэг нөлөөлж байгааг *1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их* гэсэн үзүүлэлтийг ашиглан шинжээчдээр үнэлүүлэв.

Зураг 16. Авлигын шалтгаан нөхцөл



Шинжээчдийн үзэж байгаагаар судалгааны асуулгад тусгасан бүх нөхцөл байдал буюу төрийн байгууллага, нийтийн албаны үйл ажиллагаанд оршиж байгаа дутагдал доголдол бүгд өндөр түвшний авлигад маш их болон их хэмжээгээр нөлөөлж байна.

Эдгээрээс төрийн албан хаагчдын ёс зүйгүй байдал, аливаа асуудлыг өөрсдийн үзэмжээр шийдвэрлэх боломж, түүнчлэн тэдний гаргасан алдаа дутагдалд ямар нэг хариуцлага хүлээлгэлгүй өнгөрөөдөг байдал илүү их ноцтой байна.

ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ: БҮЛЭГЛЭЛҮҮД

Сүүлийн нэг жилийн хугацаанд Таны бодлоор Монгол Улсад дараахь бүлэглэлүүд хэр хүчтэй байна вэ?

Өндөр түвшний авлигад хүчтэй нөлөөлж буй нэг хүчин зүйл бол монголын нийгэмд бодитойгоор оршин байгаа, тодорхой ашиг сонирхлууд дээр үндэслэгдсэн албан бус хүрээлэл, бүлэглэлүүдийн үйл ажиллагаа юм. Эдгээрийн нөлөөллийн түвшинг *1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их* гэсэн үзүүлэлтийг ашиглан шинжээчдээр үнэлүүлэв.

Зураг 17. Авлигын шалтгаан нөхцөл



Шинжээчдийн 77.3 хувь нь хувийн эрх ашгийг илүүд үзсэн бөгөөд улс төрийн нам тойрсон хүрээлэл, 71.2 хувь нь улс төрийн намуудыг дамнасан хүрээлэл, 69.7 хувь нь нутаг, нэг аймаг гэсэн сонирхол дээр төвлөрсөн хүрээлэл, 60.6 хувь нь бизнесийн ашиг сонирхол дээр төвлөрсөн хүрээлэл, 56 хувь нь нэг хүний ашиг сонирхол дээр төвлөрсөн хүрээлэл, 53 хувь нь найз нөхдийн нэгдмэл ашиг сонирхол дээр төвлөрсөн хүрээллүүд маш их болон их хүчтэй, нөлөөтэй байсан гэж үзсэн байна.

Нийтийн эрх ашгийн төлөө бий болсон хүрээлэл маш их хүчтэй, нөлөөтэй байсан гэж шинжээчдийн 3 хувь нь, их хүчтэй, нөлөөтэй байсан гэж 10.6 хувь нь, дунд зэргийн нөлөөтэй байсан гэж 22.7 хувь нь, бага зэрэг нөлөөтэй байсан гэж 40.9 хувь нь, огт хүчгүй, нөлөөгүй байсан гэж 7.6 хувь нь үзсэн байна.

ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГЫН ХЭМЖЭЭ: ХУВИАР

Сүүлийн нэг жилийн хугацаанд Таны төсөөллөөр бизнес эрхлэгчид дараахь үйл ажиллагааны явцад нийт үнийн дүнгийн хэдэн хувийг авлигад зарцуулсан бэ?

Дээд түвшний авлигын үед нэг талаас төрийн өндөр албан тушаалтнууд албан тушаалын эрх мэдлээ өөрт ашигтай байдлаар ашигладаг бөгөөд нөгөө талаас бизнес эрхлэгчид албан тушаалтанд хээл хахууль өгч, эсхүл амлаж тэдний үйл ажиллагаа, шийдвэрт нөлөөлөхийн зэрэгцээ тэдэнд хувьдаа ашиг олох боломж олгодог. Бизнес эрхлэгчид төрийн байгууллагын ямар төрлийн үйл ажиллагааны үед хэдий хэмжээний хөрөнгийг авлигад зарцуулдаг болох талаар шинжээчдээр үнэлүүлэв.

Зураг 18. Авлигын хэмжээ, хувиар

Судалгааны дүнгээс үзвэл бизнес эрхлэгчид 2014 онд төрийн байгууллагаас зарласан тендерт ялахын тулд тендерийн үнийн дүнгийн 15 шахам хувийг, төрийн байгууллагаас тусгай зөвшөөрөл авахын тулд холбогдох үйл ажиллагааны үнийн дүнгийн 14.7 хувийг зарцуулсан гэж шинжээчид үзсэн нь хамгийн өндөр хувь болж байна.

ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГЫН ХЭМЖЭЭ: ДУНДАЖ ДҮНГЭЭР

Сүүлийн нэг жилийн хугацаанд дараахь зорилгоор хээл хахуульд хэдэн төгрөг зарцуулсан гэж Та төсөөлж байна вэ?

Улс төр, шүүх, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны хүрээнд улс төрчид, шүүгч, хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудад өгсөн хээл хахууль 2014 онд хэр хэмжээтэй байсан талаархи шинжээчдийн төсөөллийг мөнгөн дүнгээр тодорхойлууллаа.

Зураг 19. Авлигын хэмжээ, сая төгрөгөөр

Шинжээчдийн үзэж байгаагаар 2014 онд улс төрийн хүрээнд төрийн өндөр албан тушаалтнуудад өгсөн хээл хахуулийн хэмжээ нь дунджаар 22.1 сая төгрөг байна.

Зорилгоосоо хамаарч хээл хахуулийн хэмжээ янз бүр байгаа ба ашиг сонирхолдоо нийцсэн хууль тогтоомж, шийдвэр гаргуулахад дунджаар 37.8 сая төгрөг, шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход дунджаар 31.7 сая төгрөг зарцуулсан гэж шинжээчид үзжээ.

ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГЫН ХОР УРШИГ

Сүүлийн нэг жилийн хугацаанд улс төрийн хүрээний авлига буюу төрийн өндөр албан тушаалтнуудын авлигын улмаас учирсан хор уршиг, сөрөг үр дагаврын түвшинг тодорхойлно уу?

Дээд түвшний авлигын улмаас нийгэм, эдийн засагт учирч байгаа хор хохирол, үр дагаварыг бодитоор тооцож тодорхойлох нь бараг боломжгүй зүйл юм. Гэвч улс төрийн авлигын үр дагаварыг тодорхойлохгүйгээр түүний нөхцөл байдлыг тогтоох нь өрөөсгөл болно. Тиймээс нийгэм, эдийн засагт үүсээд байгаа сөрөг нөхцөл байдлууд нь авлигатай хэр хамааралтай болохыг *1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их* гэсэн үзүүлэлтийг ашиглан шинжээчдээр үнэлүүлэв.

Зураг 20. Авлигын хор уршиг

Шинжээчдийн 74.2 хувь нь нийгэм дэх баялгийн хуваарилалтын тэгш бус байдал нэмэгдэхэд, 71.2 хувь нь улс орны эдийн засгийн хүч чадал сулрахад, 78.8 хувь нь шударга ёс алдагдахад, 74.2 хувь нь төрийн албаны чадавхи сулрахад, 69.7 хувь нь хуулийн хэрэгжилт сулрахад, 69.7 хувь нь ёс суртахууны үнэт зүйл алдагдахад, 72.7 хувь нь инфляци нэмэгдэхэд, 63.6 хувь нь гадаадын хөрөнгө оруулалт буурахад, 66.6 хувь нь ядуурал нэмэгдэхэд өндөр түвшний авлига маш их эсвэл их хамааралтай байсан гэж үзжээ. Түүнчлэн улс оронд бий болсон бусад сөрөг нөхцөл байдлууд авлигаас ихээхэн хамааралтай болохыг судалгааны үр дүн харуулж байна.

ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГЫН ҮР ДАГАВАР

Сүүлийн нэг жилийн хугацаанд улс төрчид, төрийн өндөр албан тушаалтнууд авлигын замаар олсон хөрөнгөө хэрхэн зарцуулсан гэж Та төсөөлж, таамаглаж байна вэ?

Улс төрчид болон төрийн өндөр албан тушаалтнууд авлигын замаар олсон, ялангуяа хээл хахуульд авсан зүйлээ янз бүрийн байдлаар хувьдаа зарцуулдаг бөгөөд эдгээр хэлбэрүүдийг *1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их* гэсэн үзүүлэлтийг ашиглан шинжээчдийн төсөөлөл дээр үндэслэн үнэлүүлэв.

Зураг 21. Авлигын үр дагавар

Шинжээчдийн 57.5 хувь нь дотоодод орон сууц, барилга байгууламж бариулах хэлбэр, 50 хувь нь гадаадад орон сууц, үл хөдлөх хөрөнгө худалдан авах, 50 хувь нь дотоодод үл хөдлөх хөрөнгө, орон сууц худалдан авах, 48.5 хувь нь хурдан морь худалдан авах, 47 хувь нь гадаадын оффшор банк, санхүүгийн байгууллагад хадгалах, 48.5 хувь нь гадаадын банканд хадгалах, 48.5 хувь нь гэр бүлийн өмчлөлийн компанид хувь оруулах, 36.4 хувь нь зугаа цэнгэл, мөрийтэй тоглоомд зарцуулах зэрэг хэлбэрүүд 2014 онд маш их болох их түгээмэл байсан гэж үзсэн байна.

ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Авлигыг бууруулахад дараахь арга хэмжээ хэр шаардлагатай гэж Та үзэж байна вэ?

Өндөр түвшний авлигыг бууруулахад шаардлагатай тодорхой арга хэмжээнүүдийг асуулгад тусгаж, тэдгээрийн ач холбогдлыг *1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их* гэсэн үзүүлэлтийг ашиглан үнэлүүлэв.

Зураг 22. Авлигатай тэмцэх үйл ажиллагаа

Шинжээчид асуулгад тусгасан арга хэмжээг бүгдийг нь хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн бөгөөд төрийн албан тушаалтнуудыг ур чадварт нь үндэслэн ажил, албан тушаалд томилох, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, улс төрийн намын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, намын санхүүжилтийн тогтолцоог өөрчлөх нь хамгийн чухал ач холбогдолтой гэж үзжээ.

ДҮГНЭЛТ

- ✓ 2008 оноос 2013 оны хооронд хийгдсэн судалгаанд ашигласан аргачлал, удирдамж, асуулгыг өөрчлөн сайжруулах шаардлагатай болсон учир 2014 онд тэдгээрийг шинээр баталсан. Хэдийгээр судалгааны үнэлгээний шатлал өөрчлөгдөөгүй боловч үнэлгээний үндэслэл болох асуулгууд нь өөрчлөгдсөн тул 2014 оны судалгааны дүнг өмнөх онуудын судалгааны дүнтэй шууд харьцуулан үзэх боломжгүй юм.
- ✓ Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн 2014 оны судалгааны дүн 3.58 гэсэн үзүүлэлттэй гарсан нь Монгол Улсад “өндөр” түвшний авлига түгээмэл байгааг илэрхийлж байна.
- ✓ Судалгааны явцад зөвхөн “өндөр” түвшний авлига төдийгүй Монгол Улс дахь авлигын ерөнхий төлөв байдлыг бүхэлд нь болон зарим салбар, хүрээнд үнэлүүлэв. Авлигын ерөнхий түвшин өндөр байгаа нь нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, төрийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, эрх зүйн орчин, улс төрийн тогтолцоо, үйл ажиллагаа зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай болохыг судалгааны дүн харуулж байгаа бөгөөд үүнээс улс төрчид, төрийн өндөр албан тушаалтнуудын ёс зүйн доройтол, улс төрийн намын болон сонгуулийн тогтолцооны гажуудал, улс төрийн намын нөлөө, улс төр- бизнесийн бүлэглэлийн ашиг сонирхол болон нийтийн эрх ашиг, сонирхлын зөрчил зэргийг онцлон тэмдэглэх шаардлагатай.
- ✓ Монгол Улсад албан ёсны бүртгэлтэй улс төрийн намуудаас парламентад суудалтай, түүнчлэн 2014 онд засгийн эрх барьж байсан Ардчилсан нам, мөн парламентад суудалтай Монгол Ардын Нам, Монгол Ардын Хувьсгалт Нам авлигад хамгийн ихээр автсан байгаа нь монголын улс төрийн хүрээний үйл ажиллагаа хувийн эрх ашгаа улс төрийн намын ашиг сонирхлын дор далдалсан нэг нам, эсхүл намууд дамнасан бүлэглэл, хүрээллүүдийн үйл ажиллагаа болж хувирсантай холбоотой гэж дүгнэж болохоор байна.
- ✓ Төрийн худалдан авах ажиллагаа, тендер шалгаруулалт, төрийн албан тушаалын томилгоо, төрөөс тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах үйл ажиллагаа, тусгай сангийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэлт, төсвийн өмч, хөрөнгийн зарцуулалт зэрэг ихэнхдээ хөрөнгийн зарцуулалттай холбоотой үйл ажиллагаанд авлига их хэмжээтэй байгаа нь намын харьяаллаар болон авлигын замаар томилогдсон албан тушаалтнууд албан тушаалаа мөнгө олох хэрэгсэл болгож байгаатай холбоотой гэж үзэж болох юм. Өндөр түвшний авлигад хамгийн хүчтэй нөлөөлж буй хүчин зүйлс нь албан тушаалын томилгоо, намын болон сонгуулын санхүүжилтийн механизм, улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил болоод байгаа нь үүний нотолгоо юм.
- ✓ Ажил хэргийн мэдлэг, ур чадвар, ёс зүйн шалгуураар бус намын харьяалал, танил тал, садан төрлийн хэлхээ холбоог ашиглаж, эсхүл авлига, хээл хахууль өгч төрийн албанд орсон хүмүүсийн ёс зүйн дорой байдал, амин хувийн ашиг бодсон үзэл бодол, хууль журам, нийтийн эрх ашиг, сонирхлыг уландаа гишгэсэн шийдвэр, үйл ажиллагаанд тавих хяналт, хүлээлгэх хариуцлага сул, албан тушаалтан өөрийн үзэмжээр, хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн шийдвэр гаргах боломж, бололцоо өргөн, хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул, төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа ил тод бус, ойлгомжгүй зэрэг нөхцөл байдал нь өндөр түвшний авлигыг улам даамжруулах хөрс суурь болж байна. Эдгээр

нөхцөл байдлаас улбаалан төрийн албан тушаалтан албан тушаал, эрх мэдлээ хэтрүүлэх, урвуулан ашиглах, ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, хувийн компани, аж ахуйн нэгж, бизнесийн бүлэглэлд давуу тал олгох, тэдний захиалга, шахалтаар хууль, эрх зүйн акт санаачлах, батлахыг дэмжих, хээл хахууль авах, өгөх, зуучлах зэрэг өндөр түвшний авлигын хэлбэрүүд түгээмэл болж нийгмийн амьдралын ердийн хэм хэмжээ болоход ойрхон байна.

- ✓ Өндөр түвшний авлигын улмаас учирч буй хор уршиг, сөрөг үр дагавар нь эргээд авлигыг өдөөгч хүчин зүйл болж сөрөг эргэх холбоо үүсгэж байна. Тухайлбал, авлигын улмаас өмч хөрөнгийн тэгш бус байдал буюу баялгийн шударга бус хуваарилалт нэмэгдэж үүний улмаас нийгмийн баялгаас илүү ихийг хүртсэн цөөн хэсэг нь мэдэлдээ байгаа өмч хөрөнгийг төрийн эрх мэдэл, эдийн засгийн ноёрхол болгоход ашиглаж байна. Ийнхүү ашиглах арга зам нь улс төрийн авлига буюу өндөр түвшний авлига гэж үзэж болохоор байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- ✓ Монгол Улсын улс төрийн, хууль хяналтын байгууллагын хүрээнд өндөр түвшний авлига түгээмэл байгаа төдийгүй авлигын нөхцөл байдал улам даамжран гүнзгийрч байгааг улс төрийн хүрээнд, ялангуяа төрийн өндөр албан тушаалтнууд хүлээн зөвшөөрөх шаардлагатай байна.
- ✓ Өндөр түвшний авлигад нөлөөлж буй улс төрийн намын санхүүжилтийн тогтолцоо, эрх зүйн зохицуулалт, сонгуулийн санхүүжилтийн тогтолцоог өөрчлөх,
- ✓ Төрийн албыг улс төрөөс ангид байлгах, төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх;
- ✓ Төрийн албан тушаалтныг улс төрийн намын харьяалал, танил тал, садан төрлийн хэлхээ холбоогоор томилдог байдлыг зогсоох арга хэмжээг шийдвэртэй авах,
- ✓ Томоохон компаниудын зүгээс хууль тогтоох эрх мэдэлд хууль бусаар нөлөөлж байгаа байдлыг таслан зогсоох, улс төр-бизнесийн бүлэглэлүүдийн үйл ажиллагааг хязгаарлах,
- ✓ Нийгмийн ёс зүй, зан суртахуун, үзэл санаанд хүчтэй нөлөө үзүүлж байгаа тул төрийн өндөр албан тушаалтнууд болон улс төрд нөлөө бүхий хүмүүсийн ёс зүй, үйлдэл, үйл ажиллагаанд тавих хяналт, хүлээлгэх хариуцлагыг бодитой, үр нөлөөтэй болгох.

ХАВСРАЛТ

Авлигатай тэмцэх газрын даргын 2014 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн А/104 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

УЛС ТӨР, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГААНЫ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТООЦООНЫ АРГАЧЛАЛ

1. Аргачлалын зорилго

1.1. Авлигатай тэмцэх газраас Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа (цаашид “Судалгаа” гэх)-ны үзүүлэлтийн тооцооллыг хийхэд энэхүү аргачлал (цаашид “Аргачлал” гэх)-ыг мөрдөнө.

2. Нэр томъёо

2.1. Аргачлалд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. *“авлига”* гэж Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасныг;

2.1.2. *“улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөлөл”* гэж “Мянганы хөгжлийн 9 дэх зорилгын шалгуур үзүүлэлтийн арга зүй, суурь мэдээлэл”-ийн “Суурь хэмжигдэхүүн, хяналт-шинжилгээ, үнэлгээний механизм”-ын талаарх 6 дугаар бүлгийн 11 дэх хэсэгт тодорхойлсноор “Монголын улс төрийн хүрээн дэх авлигын цар хүрээ, авлигад ихээр өртсөн салбар, байгууллага, авлигын түгээмэл хэлбэр, эдийн засгийн хор уршиг зэрэг төрийн улс төрийн болон тусгай, захиргааны удирдлагын дээд шатан дахь авлигын талаарх бизнес, санхүүгийн салбарын болон иргэний нийгмийн шинжээчдийн төсөөллийг тоон утгаар буюу үнэлгээний дундаж оноогоор илэрхийлсэн, монголын нийгмийн дээд (өндөр) түвшин дэх *“grand”* буюу **“том”** гэж нэрлэдэг авлигын түвшинг хэмжих үзүүлэлт”-ийг;

2.1.3. *“улс төрийн хүрээ”* гэж Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан бөгөөд удирдах албан тушаал хашиж буй этгээд албан тушаалын эрх мэдэл, нэр нөлөөгөө албаны болон хувийн зорилгоор хэрэгжүүлж, ашиглаж байгаатай холбоотой нийгмийн харилцааг;

2.1.4. *“хууль хяналтын байгууллагын хүрээ”* гэж хууль сахиулах чиг үүрэг гүйцэтгэж буй шүүх, прокурор, цагдаа, тахарын алба, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээ, авлигатай тэмцэх, тагнуул, хил хамгаалах, иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийгмийн харилцааг.

3. Аргачлалын зарчим

3.1. Судалгааны үзүүлэлтийн тооцооллыг гаргахад дараахь зарчмыг мөрдөнө:

3.1.1. үзүүлэлтүүд хоорондоо холбоо хамаарал, уялдаатай байх;
3.1.2. шинжлэх ухааны үндэслэл бүхий байх;
3.1.3. мэдээллийн эх үүсвэр тодорхой байх;
3.1.4. мэдээлэл нь үнэн бодитой байх;
3.1.5. хэмжих, дүгнэх боломжтой байх;
3.1.6. үзүүлэлтүүд тодорхой байх.

4. Судалгааны үзүүлэлт

4.1. Судалгааг дараахь үзүүлэлтүүдээр тооцоолно:
4.1.1. авлигын төсөөллийн ерөнхий үнэлгээ;
4.1.2. авлигын цар хүрээ, тархалтын үнэлгээ;
4.1.3. авлигад өртөмтгий удирдлагын түвшин, салбар, байгууллага;
4.1.4. авлигын хэлбэрийн үнэлгээ;
4.1.5. авлигын шалтгаан, нөхцөлийн үнэлгээ;
4.1.6. авлигын хор уршгийн үнэлгээ;
4.1.7. авлигатэй тэмцэх үйл ажиллагаанд анхаарах чиглэл.

4.2. Авлигын төсөөллийн ерөнхий үнэлгээг энэхүү аргачлалын 4 дүгээр зүйлийн 4.1.2- 4.1.6 дахь заалтуудын дунджаар тооцож гаргана.

4.3. Авлигын цар хүрээний үнэлгээ нь улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын тархалтыг илэрхийлнэ.

4.4. Авлигын цар хүрээний үнэлгээг улс төрийн хүрээний байгууллага, албан тушаалтны үйлдэл, үйл ажиллагаа, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээний байгууллага, албан тушаалтны үйлдэл, үйл ажиллагаа тус бүрээр гаргаж, тэдгээрийн дунджаар тооцно.

4.5. Авлигын хэлбэрийн үнэлгээ нь улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын илрэн гарч буй хэлбэрийг илэрхийлнэ.

4.6. Авлигын хэлбэрийн үнэлгээг дараахь чиглэлээр тооцоолно:
4.6.1. авлигын хэлбэр тус бүрээр болон тэдгээрийн дунджаар;
4.6.2. салбар, байгууллага, түвшин тус бүрээр болон тэдгээрийн дунджаар.

4.7. Авлигын шалтгаан, нөхцөлийн үнэлгээг дараахь чиглэлээр тооцоолно:
4.7.1. нийгэм, эдийн засгийн шинжтэй;
4.7.2. хууль, эрх зүйн шинжтэй;
4.7.3. улс төрийн шинжтэй;
4.7.4. ёс суртахуун, заншлын шинжтэй.

5. Үнэлгээ тооцох арга зүй

5.1. Үнэлгээг дараахь эрэмбэ бүхий 5 оноогоор тооцно.
5.1.1. огт үгүй / байхгүй – 1
5.1.2. бага – 2
5.1.3. дунд зэрэг – 3
5.1.4. их – 4
5.1.5. маш их – 5

5.2. Нийт үнэлгээг дээрх үнэлгээний дундаж үзүүлэлтээр тооцох ба дараахь томъёог ашиглана:
5.2.1. Асуулгын үнэлгээ тооцон гаргах томъёо:

$$Y = \frac{A_1 \times 5 + A_2 \times 4 + A_3 \times 3 + A_4 \times 2 + A_5 \times 1}{A_1 + A_2 + A_3 + A_4 + A_5}$$

Y- Үнэлгээ
A_1 –маш их гэж хариулсан шинжээчийн тоо
A_2 –их гэж хариулсан шинжээчийн тоо

A_3 –дунд зэрэг гэж хариулсан шинжээчийн тоо
A_4 –бага гэж хариулсан шинжээчийн тоо
A_5 –огт үгүй / байхгүй гэж хариулсан шинжээчийн тоо

5.2.2. Үзүүлэлт тус бүрийн үнэлгээ, нийт үнэлгээ, ерөнхий үнэлгээг таслалаас хойш 2 орны түвшинд гаргана. Жишээлбэл, 3.00 гэх мэт.

5.3. Ерөнхий үнэлгээний тоон илэрхийлэл нь дараахь агуулгатай байна:
5.3.1. хамгийн эерэг утга - 1;
5.3.2. бага зэрэг авлигатай - 2;
5.3.3. авлига дунд зэрэг байна - 3;
5.3.4. авлига их байна - 4;

6. Аргачлалд нэмэлт, өөрчлөлт оруулах

6.1. Аргачлалд байгууллагын даргын тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ-2015

ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ-2015

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ШБҮ - Шударга Байдлын Үнэлгээ
ГШБҮ - Гадаад Шударга Байдлын Үнэлгээ
ДШБҮ - Дотоод Шударга Байдлын Үнэлгээ
БОҮ - Бодлогод Оролцогчдын Үнэлгээ ЗДТГ – Засаг Даргын Тамгын Газар

ХУРААНГУЙ

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу “авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх”; мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийг тус тус хэрэгжүүлдэг. Уг чиг үүргийн хүрээнд төрийн байгууллагын Шударга байдлын үнэлгээг гаргаад байна.

Шударга байдлын үнэлгээ (ШБҮ) гэж тухайн байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ, дотоод шударга байдлын үнэлгээ, бодлогод оролцогчдын үнэлгээнд үндэслэсэн үнэлгээ юм.

Үнэлгээг 0-100 хүртэл оноогоор гаргах бөгөөд үнэлгээний утга 100-тай тэнцүү бол хамгийн шударгыг илэрхийлэх бөгөөд ШБҮ-2015-д 62 төрийн байгууллага (яам, засгийн газрын агентлаг, аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар)-ыг хамруулсан.

ШБҮ-ний мэдээлэл цуглуулах судалгаанд нийтдээ 4340 нэгжийг хамруулсан бөгөөд үүнээс ГШБҮ-нд 2330 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, ДШБҮ-нд 1390 төрийн албан хаагч, бодлогод оролцогчдын үнэлгээнд 620 шинжээчийг хамруулсан болно.

Төрийн байгууллагууд ШБҮ-ээр 100 оноо авахаас дунджаар **73.8** оноо авсан байна. ШБҮ-ний дүнгээс харахад байгууллагын ДШБҮ-ний оноо 81.9 гарсан байгаа бол ГШБҮ болон БОҮ-ний оноо тус бүр 69.8 гэсэн дүнтэй гарчээ (Байгууллага бүрээр Хүснэгт 1.-д харуулав).

Зураг 1. ШБҮ, 2015 он



Байгууллагын төрлөөр нь авч үзвэл яамдын ШБҮ-ний дундаж оноо 72.4 гарсан бөгөөд үүнээс, Барилга, хот байгуулалтын яамны ШБҮ-ний оноо 65.8, Эрүүл мэнд, спортын яамны ШБҮ-ний оноо 66.1, Зам тээврийн яамны ШБҮ-ний оноо 69.0, Байгаль, орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны ШБҮ-ний оноо 69.3 гарсан нь оноо багатай яам болж байна.

Харин Засгийн газрын агентлагийн хувьд ШБҮ-ний дундаж оноо **75.5** гарсан бөгөөд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (67.3), Ашигт малтмалын газар (68.2), Гаалийн ерөнхий газар (68.9), Татварын ерөнхий газар (69.2)-ын ШБҮ-ээр бага оноотой үнэлэгдсэн байна.

Зураг 2. ШБҮ, байгууллагын төрлөөр



Мөн аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ШБҮ-ний дундаж оноо **72.9** байгаа бөгөөд Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газар (65.5), Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар (66.2), Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар (66.6), Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар (67.6) бага оноотой байгууллага болж байна.

ШБҮ-ний дундаж 2015 оны байдлаар **73.8** гарсан бөгөөд **10 яам** (Барилга, хот байгуулалтын яам, Эрүүл мэнд, спортын яам, Зам тээврийн яам, Байгаль, орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Уул уурхайн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Хууль зүйн яам, Аж үйлдвэрийн яам, Хөдөлмөрийн яам) дунджаас бага оноо авсан байна. Засгийн газрын агентлагийн хувьд 2015 оны дунджаас бага оноо авсан **8 агентлаг** (Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ашигт малтмалын газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Мал эмнэлэг, үржлийн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар) байгаа бол дунджаас бага оноотой **14 аймаг** (Баян-Өлгий аймгийн ЗДТГ, Завхан аймгийн ЗДТГ, Дундговь аймгийн ЗДТГ, Өмнөговь аймгийн ЗДТГ, Хэнтий аймгийн ЗДТГ, Дархан-Уул аймгийн ЗДТГ, Төв аймгийн ЗДТГ, Ховд аймгийн ЗДТГ, Дорнод аймгийн ЗДТГ, Орхон аймгийн ЗДТГ, Архангай аймгийн ЗДТГ, Өвөрхангай аймгийн ЗДТГ, Баянхонгор аймгийн ЗДТГ, Сэлэнгэ аймгийн ЗДТГ) болон Нийслэлийн засаг Даргын тамгын газар байв (Зураг 3).

Зураг 3. ШБҮ, байгууллагаар



Хүснэгт 1. ШБҮ-ний эрэмбэ, дэд үзүүлэлт, байгууллагаар

Эрэмбэ	Төрийн байгууллагын нэр	ГШБҮ	ДШБҮ	БОҮ
1	Цаг уур, орчны шинжилгээний газар	74.4	86.1	83.8
2	Дорноговь аймгийн ЗДТГ	81.9	86.1	75.9
3	Нийгмийн даатгалын ерөнхий газар	68.4	93.3	77.3
4	Увс аймгийн ЗДТГ	78.3	81.4	78.6
5	Оюуны өмчийн газар	77.9	84.4	76.0
6	Тахарын ерөнхий газар	73.6	83.2	81.2
7	Стандартчилал, хэмжил зүйн газар	76.8	83.1	77.8
8	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар	76.5	85.8	74.6
9	Хөвсгөл аймгийн ЗДТГ	77.7	88.0	71.1
10	Батлан хамгаалах яам	76.4	81.2	79.1
11	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	76.5	85.3	73.8
12	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	74.3	86.6	73.3
13	Онцгой байдлын ерөнхий газар	76.1	82.6	74.7
14	Газрын тосны газар	78.4	87.9	66.5
15	Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар	73.7	84.0	74.8
16	Худалдан авах ажиллагааны газар	71.3	83.3	77.2
17	Гадаад хэргийн яам	69.6	84.8	77.3
18	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	70.1	87.1	74.3
19	Сүхбаатар аймгийн ЗДТГ	72.7	85.2	73.5
20	Цагдаагийн ерөнхий газар	76.5	84.3	70.4
21	Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар	70.5	90.1	69.9
22	Хөрөнгө оруулалтын газар	67.1	85.7	76.5
23	Говь-Алтай аймгийн ЗДТГ	77.7	82.5	68.6
24	Хүүхдийн төлөө үндэсний газар	75.8	76.1	75.1
25	Сангийн яам	71.8	82.7	72.3
26	Эрчим хүчний яам	71.6	84.8	69.7
27	Архивын ерөнхий газар	75.3	74.0	76.7
28	Булган аймгийн ЗДТГ	73.5	81.6	70.8
29	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	75.1	77.2	69.4
30	Улсын бүртгэлийн ерөнхий газар	65.7	85.3	70.1
31	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	66.6	79.3	74.9
32	Хөдөлмөрийн яам	71.2	86.4	62.9
33	Мал эмнэлэг, үржлийн газар	77.9	73.2	69.0
34	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар	62.6	81.6	75.1
35	Баянхонгор аймгийн ЗДТГ	67.0	79.9	72.1
36	Нийслэлийн ЗДТГ	57.8	83.9	76.6
37	Аж үйлдвэрийн яам	59.1	81.3	77.4
38	Өвөрхангай аймгийн ЗДТГ	69.2	85.5	63.1
39	Иргэний нисэхийн ерөнхий газар	-	74.2	70.3
40	Хууль зүйн яам	58.8	85.3	72.7
41	Архангай аймгийн ЗДТГ	67.5	79.3	70.0
42	Орхон аймгийн ЗДТГ	61.5	83.5	71.7
43	Хүнс, хөдөө аж ахуйн яам	67.8	85.8	60.5
44	Дорнод аймгийн ЗДТГ	69.6	84.4	60.0
45	Ховд аймгийн ЗДТГ	68.2	79.3	66.5
46	Уул уурхайн яам	65.5	80.6	67.8
47	Төв аймгийн ЗДТГ	73.9	77.3	62.6
48	Дархан-Уул аймгийн ЗДТГ	69.4	79.5	63.8
49	Хэнтий аймгийн ЗДТГ	62.3	82.3	67.8
50	Хүн амын хөгжил, нийгмийн хамгаллын яам	62.4	86.7	60.9
51	Байгаль, орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яам	63.3	80.5	64.2
52	Татварын ерөнхий газар	64.2	78.3	65.1
53	Зам тээврийн яам	68.7	77.7	60.7
54	Гаалийн ерөнхий газар	53.9	81.2	71.6
55	Ашигт малтмалын газар	64.3	80.9	59.4
56	Өмнөговь аймгийн ЗДТГ	68.3	77.8	56.7
57	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	62.2	83.4	56.2
58	Дундговь аймгийн ЗДТГ	65.4	69.2	65.1
59	Завхан аймгийн ЗДТГ	58.5	73.2	66.8
60	Эрүүл мэнд, спортын яам	68.5	77.3	52.6
61	Барилга, хот байгуулалтын яам	70.6	73.6	53.3
62	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	67.4	70.3	58.8

Тайлбар: Дэд үзүүлэлтийн үнэлгээ

80-аас дээш оноотой
70-80-ын хооронд
70-хүртэлх оноотой

ҮНЭЛГЭЭНИЙ БҮТЭЦ

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу “авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх”; мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийг тус тус хэрэгжүүлдэг.

Уг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор “Авлигын индекс тооцох аргачлал”- ыг Авлигатай тэмцэх газрын дарга болон Үндэсний Статистикийн хорооны даргын 2009 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 76/(06/69) тоот хамтарсан тушаалаар, “Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх аргачлал”- ыг Авлигатай тэмцэх газрын даргын 2010 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 59 дугаар тушаалаар тус тус батлан эдгээр аргачлалын дагуу Авлигын индексийг 2009, 2011, 2013 онд, Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг 2010, 2012, 2013 онуудад тооцож, олон нийтэд мэдээлсэн болно. Улмаар дээрх аргачлалыг баталж байсан цаг үеэс хойш Улсын Их Хурлаас авлигатай тэмцэх эрх зүйн орчинг төгөлдөржүүлэх талаар бодит өөрчлөлт хийн холбогдох хуулиудыг баталж, Засгийн газар авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тодорхой шийдвэрүүдийг гарган хэрэгжүүлж байна. Яам, агентлаг, орон нутгийн түвшинд авлигын эсрэг санал, санаачилгыг өрнүүлэн тусгайлсан төлөвлөгөө батлан олон талт үйл ажиллагааг зохион байгуулж байна. Эдгээр хууль тогтоомж, үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлж дүгнэх, нөхцөл байдлыг тогтооход дээрх аргачлал төдийлөн шаардлага хангахгүй болсон юм.

Мөн дэлхийн улс орнууд авлигын нөхцөл байдлыг судлан тогтоох, авлигыг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, эдгээр үйл ажиллагааныхаа үр дүнг үнэлэх, дүгнэх талаар ахиц дэвшил гарч, тэргүүн туршлага нэвтрүүлж байгаагийн зэрэгцээ ялангуяа, судалгааны аргачлал, арга зүйн хувьд харьцангуй боловсронгуй болж байна.

Иймд дээрх шаардлагын дагуу “Авлигын индекс тооцох аргачлал”, “Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх аргачлал”-ыг нэгтгэн Авлигатай тэмцэх газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/123 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Шударга байдлын үнэлгээний аргачлал”-ын батлан мөрдөж эхлээд байна.

ШБҮ гэж тухайн байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ, дотоод шударга байдлын үнэлгээ, бодлогод оролцогчдын үнэлгээний 62 дэд үзүүлэлтэд тулгуурласан үнэлгээ юм. Үүнд:

- Гадаад шударга байдлын үнэлгээ (ГШБҮ) гэж тухайн байгууллагын шударга байдалд үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн өгч буй үнэлгээг;
- Дотоод шударга байдлын үнэлгээ (ДШБҮ) гэж тухайн байгууллагад ажиллаж буй албан хаагчдын зүгээс байгууллагынхаа талаар өгч буй үнэлгээг;
- Бодлогод оролцогчдын үнэлгээ (БОҮ) гэж тухайн байгууллагын шударга байдлын талаарх бодлого боловсруулах, төлөвлөх үе шатанд оролцогчдын өгсөн үнэлгээг хэлдэг.

Зураг 4. Шударга байдлын үнэлгээ, үзүүлэлтийн систем



ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ		
1. ГАДААД ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ		
	Ил тод, хариуцлагатай байдлын индекс	
	1.1	Ил тод байдал
	1.2	Хариуцлагатай байдал
	Авлигын индекс	
	1.3	Авлигын талаарх төсөөлөл
	1.4	Авлигын шууд тохиолдол
	1.5	Авлигын шууд бус тохиолдол
2. ДОТООД ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ		
	Соёлын индекс	
	2.1	Албан бус хэм хэмжээ
	2.2	Авлигын эсрэг тогтолцоо
	Ажлын байран дахь шударга байдлын индекс	
	2.3	Хүний нөөц
	2.4	Төсвийн зарцуулалт
	2.5	Үүрэг даалгаврын шударга байдал
	2.6	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх
	2.7	Удирдлагын хүсэл эрмэлзэл
3. БОДЛОГОД ОРОЛЦОГЧДЫН ҮНЭЛГЭЭ		
	3.1	Авлигын талаарх төсөөлөл
	3.2	Авлигыг хянах механизм
	3.3	Авлигын бодит тохиолдол
	3.4	Удирдлагын хүсэл эрмэлзэл

Хүснэгт 2. ШБҮ-ний дэд үзүүлэлт

Ил тод, хариуцлагатай байдлын индекс		
1.1	Ил тод байдал	Үйл ажиллагаа; хүний нөөц; төсөв, санхүү; төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байсан талаарх үнэлгээ
1.2	Хариуцлагатай байдал	Төрийн байгууллагын албан хаагч үйлчилгээг үзүүлэхдээ ёс зүйтэй, хариуцлагатай байсан эсэх талаарх үнэлгээ
Авлигын индекс		
1.3	Авлигын талаарх төсөөлөл	Төрийн байгууллагын албан хаагч үйлчилгээг үзүүлэхдээ бусдад дарамт, шахалт үзүүлдэг, ах дүү, танил талынхаа нөлөөнд автдаг, бусдад хууль бусаар давуу байдал олгодог, шан харамж авдаг, хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдэлдэг эсэх талаарх төсөөлөл

1.4	Авлигын шууд тохиолдол	Төрийн байгууллага, албан хаагчаас үйлчилгээ авсныхаа төлөө нэмэлт төлбөр, хураамж, бэлэг, хандив, бусад санхүүгийн туслалцаа өгсөн эсэх, хэрэв тийм бол хэдэн удаа, хэдий хэмжээний үнэ өртөг бүхий зүйл өгсөн бодит тохиолдол
1.5	Авлигын шууд бус тохиолдол	Төрийн үйлчилгээг авсан этгээдийн найз нөхөд, хамт ажиллагсад, ойр дотны хэн нэгэн тухай байгууллагаас үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, хураамж, бэлэг, хандив, бусад санхүүгийн туслалцаа өгсөн эсэх, хэрэв тийм бол хэдэн удаа, хэдий хэмжээний үнэ өртөг бүхий зүйл өгсөн тохиолдол
Соёлын индекс		
2.1	Албан бус хэм хэмжээ	Тухайн байгууллагын албан хаагч ил тод бусаар албан үүргээ гүйцэтгэх, хувийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих, ах дүү, танил талынхаа нөлөөнд автах, эсхүл бусдад дарамт, шахалт үзүүлэх, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах зэрэг
2.2	Авлигын эсрэг тогтолцоо	Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг дотоод дүрэм, журмынхаа хүрээнд хамгаалсан эсэх, зөрчил гаргасан этгээдэд холбогдох хариуцлагыг хүлээлгэдэг эсэх, дотоод хяналтын механизм бүрдсэн эсэх
Ажлын байран дахь шударга байдлын индекс		
2.3	Хүний нөөц	Шинээр ажилд орох, албан тушаал ахих, өөр ажилд шилжих, дэмжлэг авах, үйл ажиллагааны үр дүнгээ үнэлүүлэхийн тулд мөнгө, бусад үнэ бүхий зүйлс өгөх явдал байдаг эсэх, хэрэв тийм бол хэдэн удаа, хэдий хэмжээний үнэ өртөг бүхий зүйл өгсөн талаарх үнэлгээ
2.4	Төсвийн зарцуулалт	Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах явдал байдаг эсэх, хэрэв тийм бол хэдэн удаа, хэдий хэмжээний үнэ өртөг бүхий зүйл өгсөн талаарх үнэлгээ
2.5	Үүрэг даалгаврын шударга байдал	Удирдах алба хаагчид хариуцлагаас зайлсхийх, хийх ёстой зүйлээ хийхгүй байх, эсхүл хууль бус үүрэг даалгавар өгөх явдал байдаг эсэх талаарх үнэлгээ
2.6	Гадаад орчин дахь авлигатай тэмцэх	Тухайн байгууллагад хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчдад, эсхүл бусад байгууллагад хяналт тавихдаа мөнгө, үнэ бүхий зүйлс өгсөн, авсан эсэх
2.7	Удирдлагын хүсэл эрмэлзэл	Тухайн байгууллагын удирдлага болон дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл
Бодлогод оролцогчдын үнэлгээ		
3.1	Авлигын талаарх төсөөлөл	Тухайн байгууллагад авлига болон ашиг сонирхлын зөрчил, эсхүл бусдад хууль бусаар нөлөөлөх, бусдын нөлөөнд автах, хийх ёстой үйлдлийг хийхгүй, хийх ёсгүй үйлдлийг хийх явдал хэр түгээмэл байгаа зэрэг
3.2	Авлигыг хянах механизм	Авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан этгээдэд холбогдох хариуцлагыг хүлээлгэдэг эсэх, энэ талын мэдээллийн нууцлалыг хангасан эсэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэр үр дүнтэй байгаа талаарх үнэлгээ
3.3	Авлигын бодит тохиолдол	Тухайн байгууллагын албан хаагчид албан үүрэгтэй нь холбоотойгоор нэмэлт төлбөр, хураамж, бэлэг, хандив, санхүүгийн тусламж зэрэг үнэ бүхий зүйлс өгсөн эсэх талаар
3.4	Удирдлагын хүсэл эрмэлзэл	Тухайн байгууллагын удирдлага болон дунд түвшний менежерүүдийн авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл

ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ БАЙГУУЛЛАГААР

Сангийн яам



ШБҮ

Он	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	75.6	4/15	25/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	71.8	2/15	24/61
-ДШБҮ	82.7	8/15	31/62
-БОҮ	72.3	6/15	26/62

Сангийн яам нь ШБҮ-ээр 2015 онд 75.6 оноо авч үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас 25, яамдаас 4 дүгээрт жагссан байна. ШБҮ-ний дэд үзүүлэлтээр авч үзвэл төрийн байгууллагуудаас ГШБҮ-ээр 24, ДШБҮ-ээр 31, БОҮ-ээр 26 дугаар байрт тус тус эрэмбэлэгджээ. Цаашид авлигыг хянах механизм, ил тод байдал, хариуцлагатай байдал, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай.



Хууль зүйн яам

ШБҮ

Он	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	72.2	8/15	40/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	58.8	15/15	58/61
-ДШБҮ	85.3	5/15	17/62
-БОҮ	72.7	5/15	25/62

Хууль зүйн яам нь ШБҮ-ээр 2015 онд 72.2 оноо авч үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас 40, яамдаас 8 дугаарт эрэмбэлэгдсэн байна. ШБҮ-ний дэд үзүүлэлтээр авч үзвэл төрийн байгууллагуудаас ГШБҮ-ээр 58, ДШБҮ-ээр 17, БОҮ-ээр 25 дугаар байрт тус тус оржээ. Цаашид ил тод байдал, хариуцлагатай байдал, авлигын эсрэг үйл ажиллагаагаа олон нийтэд таниулах, авлигыг хянах механизм бүрдүүлэх талаар анхаарал хандуулах шаардлагатай байна.



Барилга, хот байгуулалтын яам



ШБҮ

Он	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	65.8	15/15	61/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	70.6	5/15	28/61
-ДШБҮ	73.6	15/15	58/62
-БОҮ	53.3	14/15	61/62

Барилга, хот байгуулалтын яам нь ШБҮ-ээр 2015 онд 65.8 оноо авч үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас 61, яамдаас 15 дугаарт жагссан байна. ШБҮ-ний дэд үзүүлэлтээр авч үзвэл төрийн байгууллагуудаас ГШБҮ-ээр 28, ДШБҮ-ээр 58, БОҮ- ээр 61 дүгээр байрт тус тус оржээ. Цаашид авлигыг хянах механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, ил тод, хариуцлагатай байдал зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.



Зам тээврийн яам

ШБҮ

Он	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	69.0	13/15	53/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	68.7	8/15	35/61
-ДШБҮ	77.7	13/15	51/62
-БОҮ	60.7	12/15	54/62

Зам тээврийн яам нь ШБҮ-ээр 2015 онд 69 оноо авч үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас 53, яамдаас 13 дугаарт эрэмбэлэгдсэн байна. ШБҮ-ний дэд үзүүлэлтээр авч үзвэл төрийн байгууллагуудаас ГШБҮ-ээр 35, ДШБҮ-ээр 51, БОҮ-ээр 54 дүгээр байрт тус тус оржээ. Цаашид авлигыг хянах механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, авлигын эсрэг үйл ажиллагаагаа олон нийтэд таниулах зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай.



Эрчим хүчний яам



ШБҮ

Он	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	75.4	5/15	26/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	71.6	3/15	25/61
-ДШБҮ	84.8	7/15	20/62
-БОҮ	69.7	7/15	37/62

Эрчим хүчний яам нь ШБҮ-ээр 2015 онд 75.4 оноо авч үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас 26, яамдаас 5 дугаарт жагссан байна. ШБҮ-ний дэд үзүүлэлтээр авч үзвэл төрийн байгууллагуудаас ГШБҮ-ээр 25, ДШБҮ-ээр 20, БОҮ-ээр 37 дугаар байрт тус тус эрэмбэлэгджээ. Цаашид удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, авлигыг хянах механизм, авлигын эсрэг үйл ажиллагаагаа олон нийтэд таниулах зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.



Байгаль, орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яам



ШБҮ

Он	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	69.3	12/15	51/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	63.3	12/15	51/61
-ДШБҮ	80.5	12/15	43/62
-БОҮ	64.2	9/15	48/62

Байгаль, орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яам нь ШБҮ-ээр 2015 онд 69.3 оноо авч үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас 51, яамдаас 12 дугаарт эрэмбэлэгдсэн байна. ШБҮ-ний дэд үзүүлэлтээр авч үзвэл төрийн байгууллагуудаас ГШБҮ-ээр 51, ДШБҮ-ээр 43, БОҮ-ээр 48 дугаар байрт тус тус оржээ. Цаашид авлигыг хянах механизм, ил тод байдал, хариуцлагатай байдал, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай юм.



Хөдөлмөрийн яам



ШБҮ

Он	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	73.5	6/15	32/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	71.2	4/15	27/61
-ДШБҮ	86.4	3/15	8/62
-БОҮ	62.9	10/15	51/62

Хөдөлмөрийн яам нь ШБҮ-ээр 2015 онд 73.5 оноо авч үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас 32, яамдаас 6 дугаарт жагссан байна. ШБҮ-ний дэд үзүүлэлтээр авч үзвэл төрийн байгууллагуудаас ГШБҮ-ээр 27, ДШБҮ-ээр 8, БОҮ-ээр 51 дүгээр байрт тус тус оржээ. Цаашид авлигыг хянах механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, ил тод, хариуцлагатай байдал зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.



Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам



ШБҮ

Он	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	70.0	11/15	50/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	62.4	13/15	53/61
-ДШБҮ	86.7	2/15	6/62
-БОҮ	60.9	11/15	53/62

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам нь ШБҮ-ээр 2015 онд 70 оноо авч үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас 50, яамдаас 11 дүгээрт эрэмбэлэгдсэн байна. ШБҮ-ний дэд үзүүлэлтээр авч үзвэл төрийн байгууллагуудаас ГШБҮ-ээр 53, ДШБҮ-ээр 6, БОҮ-ээр 53 дугаар байрт тус тус оржээ. Цаашид авлигыг хянах механизм, ил тод байдал, хариуцлагатай байдал, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай.



Эрүүл мэнд, спортын яам



ШБҮ

Он	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	66.1	14/15	60/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	68.5	9/15	36/61
-ДШБҮ	77.3	14/15	52/62
-БОҮ	52.6	15/15	62/62

Эрүүл мэнд, спортын яам нь ШБҮ-ээр 2015 онд 66.1 оноо авч үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас 60, яамдаас 14 дүгээрт жагссан байна. ШБҮ-ний дэд үзүүлэлтээр авч үзвэл төрийн байгууллагуудаас ГШБҮ-ээр 36, ДШБҮ-ээр 52, БОҮ- ээр 62 дугаар байрт тус тус эрэмбэлэгджээ. Цаашид авлигыг хянах механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, ил тод байдал, хариуцлагатай байдал зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.



Хүнс, хөдөө аж ахуйн яам



ШБҮ

Он	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	71.4	9/15	43/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	67.8	10/15	40/61
-ДШБҮ	85.8	4/15	12/62
-БОҮ	60.5	13/15	55/62

Хүнс, хөдөө аж ахуйн яам нь ШБҮ-ээр 2015 онд 71.4 оноо авч үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас 43, яамдаас 9 дүгээрт эрэмбэлэгдсэн байна. ШБҮ-ний дэд үзүүлэлтээр авч үзвэл төрийн байгууллагуудаас ГШБҮ-ээр 40, ДШБҮ-ээр 12, БОҮ-ээр 55 дугаар байрт тус тус оржээ. Цаашид авлигыг хянах механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, ил тод байдал, хариуцлагатай байдал зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай.



Гадаад хэргийн яам



ШБҮ

Он	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	77.2	2/15	17/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	69.6	7/15	32/61
-ДШБҮ	84.8	6/15	19/62
-БОҮ	77.3	3/15	8/62

Гадаад хэргийн яам нь ШБҮ-ээр 2015 онд 77.2 оноо авч үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас 17, яамдаас 2 дугаарт жагссан байна. ШБҮ-ний дэд үзүүлэлтээр авч үзвэл төрийн байгууллагуудаас ГШБҮ-ээр 32, ДШБҮ-ээр 19, БОҮ-ээр 8 дугаар байрт тус тус оржээ. Цаашид ил тод, хариуцлагатай байдал, авлигыг хянах механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.



Уул уурхайн яам



ШБҮ

Он	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	71.3	10/15	46/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	65.5	11/15	47/61
-ДШБҮ	80.6	11/15	42/62
-БОҮ	67.8	8/15	42/62

Уул уурхайн яам нь ШБҮ-ээр 2015 онд 71.3 оноо авч үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас 46, яамдаас 10 дугаарт эрэмбэлэгдсэн байна. ШБҮ-ний дэд үзүүлэлтээр авч үзвэл төрийн байгууллагуудаас ГШБҮ-ээр 47, ДШБҮ-ээр 42, БОҮ-ээр 42 дугаар байрт тус тус оржээ. Цаашид авлигыг хянах механизм, ил тод байдал, хариуцлагатай байдал, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, авлигын эсрэг үйл ажиллагаагаа олон нийтэд таниулах зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай.



Батлан хамгаалах яам



ШБҮ

Он	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	78.9	1/15	10/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	76.4	1/15	12/61
-ДШБҮ	81.2	10/15	40/62
-БОҮ	79.1	1/15	3/62

Батлан хамгаалах яам нь ШБҮ-ээр 2015 онд 78.9 оноо авч үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас 10, яамдаас 1 дүгээрт жагссан байна. ШБҮ-ний дэд үзүүлэлтээр авч үзвэл төрийн байгууллагуудаас ГШБҮ-ээр 12, ДШБҮ-ээр 40, БОҮ-ээр 3 дугаар байрт тус тус эрэмбэлэгджээ. Цаашид авлигыг хянах механизм, ил тод, хариуцлагатай байдал, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.



Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам



ШБҮ

Он	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	77.2	3/15	18/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	70.1	6/15	30/61
-ДШБҮ	87.1	1/15	5/62
-БОҮ	74.3	4/15	21/62

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам нь ШБҮ-ээр 2015 онд 77.2 оноо авч үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас 18, яамдаас 3 дугаарт эрэмбэлэгдсэн байна. ШБҮ-ний дэд үзүүлэлтээр авч үзвэл төрийн байгууллагуудаас ГШБҮ-ээр 30, ДШБҮ-ээр 5, БОҮ-ээр 21 дүгээр байрт тус тус оржээ. Цаашид ил тод байдал, хариуцлагатай байдал, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, авлигыг хянах механизм зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай.



Аж үйлдвэрийн яам



ШБҮ

Он	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	72.6	7/15	37/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Яамдын эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	59.1	14/15	57/61
-ДШБҮ	81.3	9/15	38/62
-БОҮ	77.4	2/15	6/62

Аж үйлдвэрийн яам нь ШБҮ-ээр 2015 онд 72.6 оноо авч үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас 37, яамдаас 7 дугаарт жагссан байна. ШБҮ-ний дэд үзүүлэлтээр авч үзвэл төрийн байгууллагуудаас ГШБҮ-ээр 57, ДШБҮ-ээр 38, БОҮ-ээр 6 дугаар байрт тус тус оржээ. Цаашид ил тод, хариуцлагатай байдал, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.



Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар



ШБҮ

Он	Оноо	Агентлаг-ийн эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	79.0	6/25	8/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Агентлаг-ийн эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	76.5	5/24	10/61
-ДШБҮ	85.8	6/25	11/62
-БОҮ	74.6	13/25	20/62

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар нь ШБҮ-ээр 2015 онд 79 оноо авч үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас 8, Засгийн газрын агентлагуудаас 6 дугаарт жагссан байна. ШБҮ-ний дэд үзүүлэлтээр авч үзвэл төрийн байгууллагуудаас ГШБҮ-ээр 10, ДШБҮ-ээр 11, БОҮ-ээр 20 дугаар байрт тус тус оржээ. Цаашид авлигыг хянах дотоод механизмыг бүрдүүлэх, ил тод байдал, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл зэргийг нэмэгдүүлэх талаар анхаарал хандуулах шаардлагатай.



Хөрөнгө оруулалтын газар



ШБҮ

Он	Оноо	Агентлаг-ийн эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	76.4	14/25	22/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Агентлаг-ийн эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	67.1	18/24	43/61
-ДШБҮ	85.7	7/25	13/62
-БОҮ	76.5	7/25	12/62

Хөрөнгө оруулалтын газар нь ШБҮ-ээр 2015 онд 76.4 оноо авч үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас 22, Засгийн газрын агентлагуудаас 14 дүгээрт эрэмбэлэгдсэн байна. ШБҮ-ний дэд үзүүлэлтээр авч үзвэл төрийн байгууллагуудаас ГШБҮ-ээр 43, ДШБҮ-ээр 13, БОҮ-ээр 12 дугаар байрт тус тус жагссан байна. Цаашид ил тод байдал, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагааныхаа талаар олон нийтэд мэдээлж байх зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай байна.



Онцгой байдлын ерөнхий газар



ШБҮ

Он	Оноо	Агентлаг-ийн эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	77.8	8/25	13/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Агентлаг-ийн эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	76.1	7/24	13/61
-ДШБҮ	82.6	16/25	32/62
-БОҮ	74.7	12/25	19/62

Онцгой байдлын ерөнхий газар нь ШБҮ-ээр 2015 онд 77.8 оноо авч үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас 13, Засгийн газрын агентлагуудаас 8 дугаарт жагссан байна. ШБҮ-ний дэд үзүүлэлтээр авч үзвэл төрийн байгууллагуудаас ГШБҮ-ээр 13, ДШБҮ-ээр 32, БОҮ-ээр 19 дүгээр байрт тус тус оржээ. Цаашид авлигыг хянах дотоод механизм, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, ил тод байдал зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай.



Мэргэжлийн хяналтын ерөнхий газар



ШБҮ

Он	Оноо	Агентлаг-ийн эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	67.3	25/25	57/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Агентлаг-ийн эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	62.2	23/24	55/61
-ДШБҮ	83.4	12/25	27/62
-БОҮ	56.2	25/25	60/62

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь ШБҮ-ээр 2015 онд 67.3 оноо авч үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас 57, Засгийн газрын агентлагуудаас 25 дугаарт эрэмбэлэгдсэн байна. ШБҮ-ний дэд үзүүлэлтээр авч үзвэл төрийн байгууллагуудаас ГШБҮ-ээр 55, ДШБҮ-ээр 27, БОҮ-ээр 60 дугаар байрт тус тус оржээ. Цаашид удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, авлигыг хянах дотоод механизмыг бүрдүүлэх, ил тод байдал, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагааныхаа талаар олон нийтэд байнга мэдээлж байх зэрэгт анхаарал хандуулах шаардлагатай байна.



Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар



ШБҮ

Он	Оноо	Агентлаг-ийн эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	73.9	17/25	29/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Агентлаг-ийн эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
-ГШБҮ	75.1	10/24	16/61
-ДШБҮ	77.2	21/25	54/62
-БОҮ	69.4	20/25	38/62

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь ШБҮ-ээр 2015 онд 73.9 оноо авч үнэлгээнд хамрагдсан төрийн байгууллагуудаас 29, Засгийн газрын агентлагуудаас 17 дугаарт жагссан байна. ШБҮ-ний дэд үзүүлэлтээр авч үзвэл төрийн байгууллагуудаас ГШБҮ-ээр 16, ДШБҮ-ээр 54, БОҮ-ээр 38 дугаар байрт тус тус оржээ. Цаашид авлигыг хянах дотоод механизмыг бүрдүүлэх, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, ил тод байдлыг нэмэгдүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай байна.



Стандартчилал, хэмжил зүйн газар



ШБҮ

Он	Оноо	Агентлаг-ийн эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
2015	79.2	5/25	7/62

ШБҮ-ний дэд үзүүлэлт

Дэд үзүүлэлт	Оноо	Агентлаг-ийн эрэмбэ	Төрийн байгууллагын эрэмбэ
Хүүхдийн шударга байдлын түвшинд эерэгээр нөлөөлөх нэг чухал үзүүлэлт бол тухайн хүүхдийг шударга зүйл хийснийх нь төлөө эцэг,эх, багш, ойр дотны хүмүүс сайшааж, урамшуулж байх явдал юм. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс “Шударга хандсаныхаа төлөө сайшаагдаж байсан уу?” гэж асуухад тэдний 66.2% нь “тийм”, 16.3% нь “зарим нь сайшаадаг ч, зарим нь үгүй”, 17.5% нь “үгүй” гэж хариулжээ.

Шударга хандсаны төлөө сайшаагдаж байсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин 4.04 байгаа нь огт сайшаагдаж байгаагүй хүүхдүүдийн шударга байдлын түвшин 3.84 гэсэн үзүүлэлтээс 0.2 пунктээр илүү байна (Зураг 10).

Зураг 10. Хүүхдийн шударга байдлын түвшин, шударга хандсаных нь төлөө сайшаагдаж байсан эсэхээр



Сургууль:

Бидний ирээдүй, хойч үе болсон хүүхдүүдэд бага наснаас нь эхлэн ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилтийн болон авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд эцэг, эх, найз нөхдийн нөлөөллөөс гадна цэцэрлэг болон сургуулийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд энэ талаар тодорхой тусгах шаардлагатай байгааг жил жилийн судалгааны үр дүн харуулдаг.

Энэ удаагийн судалгаагаар хүүхдүүдээс “Танай ангид ямар нэгэн байдлаар шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ төрлийн үйл ажиллагаа зохиогддог уу?” гэж асуусан бөгөөд хүүхдүүдийн 76.6% нь “тийм”, 23.4% нь “үгүй” гэж хариулсан байна.

Шударга ёсны талаар хичээл орох эсхүл энэ төрлийн үйл ажиллагаа зохиогддог гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин 4.02 байна. Харин шударга ёсны талаар хичээл ордоггүй, энэ төрлийн үйл ажиллагаа зохион байгуулагддаггүй гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин 3.89 байгаа нь 0.13 пунктээр бага байна (Зураг 11).

Зураг 11. Хүүхдийн шударга байдлын түвшин, шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ талаар үйл ажиллагаа зохиогддог эсэхээр



Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс “Багш нарын зүгээс шударга бус үйлдэл гаргаж, хүүхдүүдтэй зохисгүй харилцсан тохиолдолд хэнд хандах”-ыг нь тодруулахад 29.2% нь эцэг,эхдээ, 22.3% нь ангийн багшид, 21.5 хувь нь сургуулийн захиргаанд хандана гэж хариулсан байгаа нь өндөр үзүүлэлт болж байна.

Харин 10% нь найз, нөхөддөө, 9% нь хүүхдийн эрхийн байгууллагад хандах талаар хариулсан байгаа бол хүүхдийн тусламжийн утас-108 болон бусад газарт хандана гэж хариулсан хариулт тус бүр 4 % байна. (Зураг 12).

Зураг 12. Багш нарын зүгээс шударга бус үйлдэл гаргаж, хүүхдүүдтэй зохисгүй харилцсан тохиолдолд хэнд хандах вэ?



Мэдээллийн орчин:

Шударга ёсны талаарх мэдээллийг хаанаас авч байгаа талаар судалгаанд оролцсон хүүхдүүдээс асуухад тэдгээрийн дийлэнх нь сургууль (27.4-32.3%), гэр бүл (23.1-26.8%), телевиз, радио (12.3-13.7%)-гоос хүлээн авч байна. Цөөн тооны хүүхдүүд найз нөхөд, интернет болон бусад эх үүсвэрээс мэдээлэл хүлээн авдаг гэж хариулжээ (Зураг 13).

Зураг 13. Шударга ёсны талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?, хүйсээр,



Хүүхдүүд шударга ёсны талаарх мэдээллийг гэр бүл, сургууль, сонин хэвлэл болон бусад эх үүсвэрээс авч байгаа хүүхдүүдийн шударга байдлын түвшин дунджаас дээгүүр буюу 4.03-4.04 байна.

Харин энэ талаарх мэдээллийг найз нөхөд, телевиз, радио болон интернетээс авч байгаа хүүхдүүдийн шударга байдлын түвшин 3.84-3.92 байгаа нь дунджаас доогуур үзүүлэлт байна (Зураг 14).

Зураг 14. Хүүхдийн шударга байдлын түвшин, хүүхдүүдийн мэдээлэл хүлээн авч буй эх үүсвэрээс хамаарч буй байдал

Аливаа шударга бус үйлдлийг үл тэвчих байдлыг тодорхойлох зорилгоор шударга бус үйлдлийн талаар олон нийтэд мэдээлж байх нь зөв эсэхийг асуухад 79.1-79.2% нь олон нийтэд мэдээлэх нь зөв гэж үзэж байгаа бол 20.8-20.9% нь буруу гэж үзсэн байна (Зураг 15).

Зураг 15. Шударга бус үйлдлийн талаар олон нийтэд мэдээлэх нь зөв үү?



5. ХҮҮХДҮҮДИЙН ОЙЛГОЛТ, ҮЗЭЛ БОДОЛ

Хүүхдийн шударга байдлын түвшинг тооцоход ашигласан үндсэн 12 асуултын хүрээнд хүүхдийн ойлголт, үзэл бодлыг тодорхой харуулахын тулд асуулт тус бүрээр тэдний үнэлгээг доох байдлаар гаргалаа.

1. Судалгаагаар “баян байх”, эсхүл “шударга байх”-ын алийг нь хүүхдүүд илүүд үзэж байгааг тодорхойлоход нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 80.9% нь “шударга байх”-ыг илүүд үзэж байгаа ч 7.2% нь “баян байх”-ыг илүүд үзжээ. Харин 11.9% нь “мэдэхгүй” хариулт өгсөн байна (Зураг 16).

Зураг 16. “Баян байх”, эсхүл “шударга байх”-ын алийг нь илүүд үзэх вэ?



2.Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс “урт дараалалд зогсож байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээх нь зөв” эсэхийг асуухад 73.3% нь “үгүй”, 17.2% нь “мэдэхгүй” гэж хариулсан бол 9.5 хувь нь “тийм” гэж хариулжээ (Зураг 17).

Зураг 17. Урт дараалалд зогсож байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээх үү?



3. “Хүүхдүүд гэрийн даалгавраа хийхдээ, интернет зэрэг бусдын бүтээлээс өөрөө хийсэн мэт авч ашиглах нь зөв” эсэхийг асуухад судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 70.1% нь “буруу” хэмээн үзсэн бол 14.6-15.3% нь “зөв”, эсхүл “мэдэхгүй” гэж хариулсан байна (Зураг 18).

Зураг 18. Гэрийн даалгавраа хийхдээ, интернет зэрэг бусдын бүтээлээс өөрөө хийсэн мэт авч ашиглах нь зөв үү?



4. Хүүхдүүдийн шударга байдлын талаарх үзэл бодлыг тодорхойлохын тулд “багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга” гэдэгтэй санал нийлж байгаа эсэхийг нь тодруулахад судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 84.6% нь “санал нийлэхгүй” гэж хариулсан байгаа бол 10.3% нь “мэдэхгүй”, 5.1% нь “санал нийлж байгаа” гэж хариулсан байна (Зураг 19).

Зураг 19. Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга гэдэгтэй санал нийлэх үү?



5. Судалгаанд оролцсон хүүхдүүдээс “Хууль зөрчсөн, авлигын болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэх ёстой” гэдэгтэй хүүхдүүдийн 73.4% нь санал нийлж байгаа бол 8.4% нь мэдэхгүй, 18.2% нь санал нийлэхгүй гэж хариулсан байна (Зураг 20).

Зураг 20. Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэх ёстой гэдэгтэй санал нийлэх үү?



6. Судалгаанд хамрагдсан 7-11 дүгээр ангийн хүүхдүүдийн үзэж байгаагаар “Сайн найз нь шалгалт өгөхдөө бусдаас хуулах нь зөв” эсэх талаар асуухад “буруу” гэдэгтэй 58.3% нь санал нийлж байгаа бол 26.2% нь “мэдэхгүй”, 15.5.% нь “зөв” гэж хариулсан байна (Зураг 21).

Зураг 21. Таны сайн найз чинь шалгалт өгөхдөө бусдаас хуулах нь зөв үү?



7. “Багш нар хүүхдүүдээс ямар нэгэн байдлаар бэлэг авах явдал нь буруу” гэж хүүхдүүд үзэж байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 72.9% нь багш хичээл зааж, сургууль төгсгөснийхөө төлөө сурагчдаас хариу шан харамж, бэлэг хүсэх нь буруу гэж хариулсан байгаа бол 18% нь “мэдэхгүй”, 8.1% нь “зөв” гэж хариуллаа (Зураг 22).

Зураг 22. Багш хичээл зааж, сургууль төгсгөснийхөө төлөө сурагчдаас хариу шан харамж, бэлэг хүсэх нь зөв үү?



8. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 81.7% нь хууль сахиулагч хэн нэгэн дэргэд байхгүй үед ч хууль зөрчих нь “буруу” гэж хариулсан бол 11% нь энэ талаар “мэдэхгүй”, 7.2% нь “зөв” гэж хариулжээ (Зураг 23).

Зураг 23. Хууль сахиулагч хэн нэгэн таны дэргэд байхгүй үед хууль, дүрэм зөрчиж болох уу?



9. “Том хүмүүсийн хууль бус үйлдэл өөрт чинь ашигтай байвал буруу зүйл мөн” эсэхийг асуухад судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 76.5% нь “тийм”, 6.2% нь “үгүй” гэж хариулсан байна. Гэвч энэ байдалд эргэлзсэн буюу мэдэхгүй гэж 17.3% нь хариулсан байна (Зураг 24).

Зураг 24. Том хүмүүсийн хууль бус үйлдэл өөрт чинь ашигтай байвал буруу зүйл мөн үү?



10. Хүүхдүүдийн хувьд шударга байдлын талаарх төсөөллийг үнэлэхэд ашигласан “Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүүхэд таны сайн найз байсан ч багш, эцэг, эх, дотнын хүндээ мэдэгдэх үү?” гэсэн асуулт байв. Энэ талаар “мэдэгдэнэ” гэж эерэг хариулт өгсөн 22.3%, “мэдэхгүй” гэж хариулсан 35%, “мэдэгдэхгүй” гэж сөрөг хариул өгсөн хүүхэд хамгийн өндөр буюу 42.7%-ийг эзэлж байна (Зураг 25).

Зураг 25. Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн Таны сайн найз байсан ч багш, эцэг, эх, дотнын хүндээ мэдэгдэх үү?



11. “Танай гэр бүлийн хэн нэгэн албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь зөв үү?” гэсэн асуултад хүүхдүүдийн 75.9% нь “буруу” гэж хариулсан бол 9.1% нь “зөв”, 15% нь мэдэхгүй гэж хариулсан байна (Зураг 26).

Зураг 26. Танай гэр бүлийн хэн нэгэн албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь зөв үү?



12. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс “Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл” мөн эсэхийг асуухад 85.6% нь “буруу”, 6.4% нь “зөв” гэж хариулсан байгаа бол 8% нь “мэдэхгүй” гэжээ (Зураг 27).

Зураг 27. Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь зөв үү?



Хүснэгт 9. 2015 оны судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн асуултад хариулсан байдал, дүнд эзлэх хувиар

Асуулт	Санал огт нийлэхгүй	Санал нийлэхгүй	Эргэлзэж байна/ мэдэхгүй	Санал нийлж байна	Санал бүрэн нийлж байна	ДҮН
Найз чинь шалгалт өгөхдөө бусдаас хуулах нь буруу зүйл биш.	34.3%	24%	26.2%	11.3%	4.2%	100.0%
Том хүмүүсийн хууль бус үйлдэл нь өөрт чинь ашигтай байвал буруу зүйл биш.	49%	27.5%	17.3%	4.2%	2%	100.0%
Гэрийн даалгавраа хийхдээ интернет зэрэг бусдын бүтээлээс өөрөө хийсэн мэт ашиглах нь буруу зүйл биш.	42.5%	27.6%	15.4%	10.2%	4.4%	100.0%
Ангийн дарга болохын тулд ангийнхандаа бэлэг өгөх нь буруу зүйл биш.	60.7%	25%	8%	3.7%	2.6%	100.0%
Багшдаа бэлэг өгөх нь дүнгээ ахиулах сайн арга юм.	60.2%	24.4%	10.3%	3.2%	1.9%	100.0%
Баян байх нь шударга байхаас илүү чухал.	54.9%	26%	11.9%	4.5%	2.7%	100.0%

Багш хичээл зааж, сургууль төгсгөснийхөө төлөө сурагчдаас хариу шан харамж, бэлэг хүсч болно.	47.5%	25.4%	18%	6.5%	2.6%	100.0%
Шалгалтаа бусдаас хуулж байгаа хүн нь Таны сайн найз байсан ч багш, эцэг/эх/, дотнын хүндээ мэдэгдэнэ.	20.4%	22.3%	35.0%	14.6%	7.7%	100.0%
Урт дараалалд зогсож байснаас урдуур нь дайрч кинондоо хурдан орохыг хичээнэ.	42.2%	31%	17.2%	7.1%	2.5%	100.0%
Хууль сахиулагч хэн нэгэн таны дэргэд /ойр/ байхгүй үед хууль, дүрэм зөрчиж болно.	53%	28.7%	11%	4.1%	3.2%	100.0%
Авлига болон бусад гэмт хэрэг үйлдсэн хүнийг холбогдох байгууллагад мэдэгдэнэ.	11.1%	7.1%	8.4%	30.7%	42.7%	100.0%
Гэр бүлийнхэн чинь албан тушаалаа ашиглах буюу хууль зөрчих замаар баян болох нь буруу зүйл биш.	47.9%	28%	15%	4.2%	4.9%	100.0%

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Авлигатай тэмцэх газар Хүүхдийн шударга байдлын түвшин буюу ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих болон авлигыг үл тэвчих байдал ямар түвшинд байгааг тодорхойлох, цаашид хүүхдүүдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ, шударга бус хандлагаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тогтоох зорилгоор “Хүүхдийн шударга байдал-2015” судалгаа”-г 6 дахь удаа Хүүхдийн төлөө үндэсний газартай хамтран зохион байгууллаа. Энэ удаагийн судалгааг “Surveymonkey” судалгааны программыг ашиглан цахим хэлбэрээр, 21 аймаг, 9 дүүргийн 7-11 дүгээр ангийн 1929 сурагчдыг хамруулан явуулсан тул судалгааны үр дүнг өмнөх судалгааны үр дүнтэй шууд харьцуулах боломжгүй гэдгийг анхаарах нь зүйтэй юм. Энэ удаагийн судалгааны дүнд үндэслэн дараахь дүгнэлт, зөвлөмжийг өгч байна.

2015 оны судалгаагаар Хүүхдийн шударга байдлын түвшин 3.99[2] гэсэн дүнтэй гарсан байна.

Хүүхдийн шударга байдлын түвшний дэд үзүүлэлт болох “ёс зүй, ёс суртахууны” дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 4.08, “зан төлөвшлийн” дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 4.21, “хууль сахих байдлын” дэд үзүүлэлтийн дундаж үнэлгээ 4.02 гарсан нь дунджаас дээгүүр эерэг үзүүлэлт байгаа бол “авлигыг үл тэвчих байдлын” дэд үзүүлэлт 3.65 буюу дунджаас доогуур дүнтэй гарчээ.

Хүүхдүүдийн “авлигыг үл тэвчих байдлын” дэд үзүүлэлт дунджаас доогуур түвшинд үнэлэгдсэн нь хүүхдүүд авлигын талаар ойлголт муутай, шударга ба шударга бус зүйлийг ялгаж чадахгүйгээс шударга бус зүйлийг дэмжих, сургууль, эцэг эхийн зүгээс гаргаж буй шударга бус хандлага, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй мэдээ, мэдээлэл нийтлэл, нэвтрүүлгийн бодлого нь хүүхдүүдийн ёс зүй, зан суртахууны байдалд сөргөөр нөлөөлж байгааг харуулж байна. Үүнийг ерөнхий боловсролын сургуулийн хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил төдийлөн үр дүнтэй хэрэгжихгүй байгаатай холбон дүгнэж болох юм.

Шударга байх талаар эцэг эхтэйгээ ярилцдаг эсэхийг асуухад “байнга” эсхүл, “заримдаа” ярилцдаг гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин 4.05-4.13 буюу дунджаас дээгүүр гарсан бөгөөд энэ нь хүүхдүүдийг шударга иргэн

2 Хүүхдийн шударга байдлын түвшин болон дэд үзүүлэлтийг 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд уг үзүүлэлтийн утга 1-д ойртох тусам шударга бус, 5-д ойртох тусам шударга гэж ойлгоно.

болж төлөвшихөд чухал нөлөө үзүүлж байгааг харуулж байна. Тиймээс эцэг, эхийн хувьд хүүхдүүдтэйгээ шударга байх талаар, аливаа зүйлд шударга хандсанаар амьдралд нь хэрхэн эерэгээр нөлөөлж болохыг байнга тайлбарлан ярилцаж байх нь чухал юм. Өөрөөр хэлбэл, хүүхдээ шударга бус зүйл хийснийг мэдсэн эцэг, эх хүүхэддээ болохгүй зүйл хийснийг нь ойлгуулж, тайлбарласнаар тэднийг ирээдүйд зөв төлөвшилтэй, шударга иргэн болоход зохих нөлөө үзүүлдгийг судалгааны дүн харуулж байна.

Хүүхдийн шударга байдлын түвшинд эерэгээр нөлөөлж байгаа өөр нэг үзүүлэлт бол тухайн хүүхдийг шударга хандсаных нь төлөө тэдгээрийг “сайшаах, урамшуулах” явдал юм. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс шударга хандсаныхаа төлөө сайшаагдаж байсан гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин 4.04, “зарим нь сайшаадаг ч, зарим нь үгүй” гэж хариулсан хүүхдүүдийнх 3.91, “сайшаагдаж байгаагүй буюу үгүй” гэж хариулсан хүүхдүүдийнх 3.84 болж буурч байна. Иймд эцэг эх, сургуулийн зүгээс хүүхдүүдийг шударга зүйл хийсэн бол байнга сайшааж, урамшуулж байх, тэдний ил тод, шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор шударга үйл хийсэн хүүхдүүдийг шалгаруулан урамшуулах, шагнах зэрэг арга хэмжээг тогтмол зохион байгуулж, хамт олон, олон нийтэд мэдээлж байх шаардлагатай.

Найз нөхдийн хүрээ тухайн хүүхдийн шударга байдлын түвшинд хэрхэн нөлөөлж байгааг харуулсан “Таны найз танаас шударга бус үйлдэл хийхийг хүсдэг үү?” гэсэн асуултад 52.6% нь л “огт үгүй” гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин 4.11 байгаа нь дунджаас дээгүүр үзүүлэлт болж байна. Харин шударга бус зүйл хийхийг шаарддаг гэж хариулсан хүүхдүүд зохих хувийг эзэлж байгаа нь шилжилтийн насны хүүхдүүд аливаа зүйлд сонирхол татагдах, эсхүл хэн нэгний нөлөөнд орж шударга бус зүйлийг дэмжих хандлага гаргах магадлал өндөр байгааг илэрхийлж байх тул эцэг, эх болон сургуулийн зүгээс тэдэнд багаас нь зөв хүмүүжил олгох тал дээр анхаарч, өөрсдөө эерэг үлгэр дуурайлал байнга үзүүлж, анхаарал тавьж байх хэрэгтэй.

Хүүхдүүдэд шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ талаар үйл ажиллагаа зохиох нь тэдний шударга байдлын түвшинд эерэгээр нөлөөлж байгааг энэ удаагийн судалгааны дүн харууллаа. Судалгаанд хамрагдсан сурагчдаас “Танай ангид ямар нэгэн байдлаар шударга ёсны талаар хичээл орох, эсхүл энэ төрлийн үйл ажиллагаа зохиогддог уу?” гэж асуухад “тийм” гэж хариулсан хүүхдүүдийн шударга байдлын түвшин “үгүй” гэж хариулсан хүүхдүүдийнхээс 0.13 пунктээр илүү байна. Хүүхдүүд сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсрол эзэмших явцдаа ямар бие хүн болж төлөвших нь хамаардаг тул цэцэрлэгийн ахлах бүлгээс эхлэн авлигын эсрэг дархлааг тогтоож, аливаа шударга ба шударга бус зүйлд өөрсдөө анализ хийж, зөв бурууг ялгах төлөвшлийг бий болгохын тулд суралцагчийн ёс зүйн нэгдсэн дүрмийг батлан, өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, сургуулиудад мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавих, мөн шударга ёс, ёс зүй, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх хичээл оруулах талаар сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгах нь зүйтэй.

Хүүхдүүд шударга ёсны талаарх мэдээллийг гэр бүл, сургууль, сонин хэвлэлээс хүлээн авч байгаа хүүхдүүдийн шударга байдлын түвшин дунджаас дээгүүр буюу 4.03-4.04, харин энэ талаарх мэдээллийг найз нөхөд, телевиз, радио болон интернетээс авч байгаа хүүхдүүдийн шударга байдлын түвшин 3.84-3.92 байгаа нь дунджаас доогуур үзүүлэлт байна. Хүүхдүүд шударга ёсны талаарх мэдээллийг гэр бүл, сургуулийн орчин, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээс авч байгаа нь тэдний шударга байдлын түвшин эерэг гарахад чухал нөлөө үзүүлж байна. Иймд шударга ёс, ил тод байдлыг дэмжсэн агуулга бүхий мэдээ, мэдээлэл, нийтлэл, нэвтрүүлэг, богино хэмжээний кино зэргийг бэлтгэн, сонин сэтгүүл, телевиз, радиогоор хүргэхийн

зэрэгцээ нийгмийн мэдээллийн сүлжээ, цахим хуудсанд байршуулан түгээх чиглэлээр боловсролын болон холбогдох бусад байгууллагууд анхаарах шаардлагатай байна.

Судалгаагаар хүүхдүүдийн шударга байдлын ерөнхий үнэлгээ өссөн ч зарим үзүүлэлт анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл, шударга бус явдалтай санал нийлсэн, эргэлзсэн, шударга хандлагад сөргөөр нөлөөлөхүйц хариулт өгсөн хүүхдүүдийн тоо жил бүрийн судалгаанд зохих хувийг эзэлсээр байна. Энэ нь тэдгээрийн шударга ёсны ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, төлөвшүүлэх, авлига, шударга бус явдлын хор хөнөөл, үр дагаврыг таниулах чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүнд төдийлөн ахиц гараагүй, хангалттай үр нөлөө үзүүлж чадаагүйтэй холбоотой гэж дүгнэж болохоор байна. Иймд хүүхдүүдийг ёс зүйтэй, шударга иргэн болгон хүмүүжүүлэх, төлөвшүүлэх чиглэлээр улсын хэмжээнд нэгдсэн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих механизмыг бүрдүүлэх, аливаа байгууллагаас гарсан санал санаачилгыг дэмжин хамтран ажиллах боломж нөхцөлөөр хангахад анхаарах нь зүйтэй.

УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН 2015 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛС ТӨР, ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН 2015 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 13 дугаар тогтоолоор “Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх” Мянганы хөгжлийн 9 дэх зорилгын шалгуур үзүүлэлтүүдийг шинээр тодорхойлон баталсан. Энэ тогтоолын дагуу “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөлөл”-ийн судалгааг Авлигатай тэмцэх газар зохион байгуулах, улмаар судалгааны үр дүнг Мянганы хөгжлийн 9 дэх зорилтын “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх” 24 дүгээр зорилтын хэрэгжилтийг үнэлж дүгнэхэд хэрэглэхээр заасан юм.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгааг 2008 оноос хойш 8 дахь удаагаа зохион байгуулаад байна. Судалгааг тусгайлан зориулж боловсруулсан аргачлалын дагуу зохион байгуулдаг бөгөөд 2008 – 2013 оны судалгаанд хэрэглэгдсэн аргачлалыг 2014 онд шинэчлэн боловсруулж түүний дагуу 2014, 2015 оны судалгааг явуулсан болно. Тухайлбал, 2008 - 2013 онд судалгааны явцад нийтдээ 26 шинжээчийг оролцуулж байсан бол 2014 оноос эхлэн шинжээчдийн тоог 66 болгож нэмсэн. Түүнчлэн шинжээчдийг дотор нь улс төрийн хүрээний ба хууль хяналтын хүрээний гэж зааглан, тус бүрд нь ялгаатай асуулт өгч хариулт авч байсан бол 2014 оноос шинжээчдийг нийтийн алба, шүүх, хууль сахиулах, хэвлэл мэдээллийн салбар, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллагын төлөөлөл, бодлогын судалгаа, олон нийтийн санаа бодлын судалгааны байгууллага, бизнесийн салбар, мөн иргэдийн төлөөлөл гэсэн нийт 8 хүрээнээс сонгон судалгаанд оролцуулж байна. Гэхдээ нийт шинжээчдэд тавигдах асуулт нэг ижил байхаар зохицуулсан болно.

Энэхүү судалгаа нь үндсэндээ Монгол Улс дахь улс төрийн авлигын хэмжээг тодорхойлох зорилготой бөгөөд үндсэн шалгуурууд нь улс төрийн авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгаан нөхцөл, хор уршгийг тодорхойлох явдал юм. Эдгээр нөхцөл байдлыг тодорхойлохын тулд “1”-ээс “5” гэсэн үнэлгээг ашигладаг бөгөөд “1” нь авлига огт байхгүй байгааг илэрхийлдэг бол “5” нь авлигын хамгийн өндөр түвшинг илэрхийлдэг.

Судалгааг анх зохион байгуулсан 2008 онд үр дүн нь 4.09 гарсан бөгөөд энэ нь өнгөрсөн 8 жилийн хугацаан дахь хамгийн өндөр үзүүлэлт юм.

Дараагийн жил нь 3.95 болж буурсан боловч 2010 онд 4.07 болж өссөн. 2011

онд энэ үзүүлэлт өөрчлөгдөөгүй хэвээр байсан боловч 2012 онд 3.93, 2013 онд 3.68 болж 2008 оны түвшингээс 0.41 пунктээр буурсан байна.

Хэдийгээр шалгуур үзүүлэлтийн илэрхийлэл нь хэвээр боловч аргачлалд өөрчлөлт орсноос 2013 хүртэлх үр дүнг дараа дараагийн жилүүдийн үр дүнтэй шууд харьцуулан үзэх боломжгүй юм. Тиймээс 2008-2013 оны хооронд хийгдсэн судалгааг нэг үе шат болгон үзэж, харин 2014 оноос эхлэн судалгааны 2 дахь үе шат гэж үзэж болох юм. 2014 оны судалгааны дүнгээр Монгол Улс дахь улс төрийн авлигын түвшин 3.58 болж хэмжигдсэн.

1. 2015 ОНЫ УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТҮВШИН

2015 оны судалгааны дүн 3.65 гарсан нь өнгөрсөн оны түвшингээс 0.07 пунктээр өссөн үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл, манай улс дахь улс төрийн авлигын хэмжээ өнгөрсөн оны түвшингээс бага зэрэг нэмэгдсэн болохыг энэ үзүүлэлт илэрхийлж байна.

Зураг 1. Улс төрийн авлигын түвшин, 2008-2015 онд



ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол Улс дахь улс төрийн авлигын түвшинг үндсэн дөрвөн шалгуур үзүүлэлтээр авч үзсэн бөгөөд эдгээр нь улс төрийн авлигын цар хүрээ, улс төрийн авлигын хэлбэр, улс төрийн авлигын шалтгаан нөхцөл, улс төрийн авлигын хор уршиг, үр дагавар зэрэг хүчин зүйлүүд юм.

2015 онд улс төрийн авлигын шалтгаан нөхцөлийн үзүүлэлт 3.80 болж өмнөх оны үзүүлэлтээс 0.14 пунктээр буурсан боловч улс төрийн авлигын цар хүрээний үзүүлэлт 3.63 болж өмнөх оны үзүүлэлтээс 0.25 пунктээр нэмэгдсэн, мөн түүнчлэн улс төрийн авлигын хэлбэрийн үзүүлэлт 3.58, хор уршиг, үр дагаврын үзүүлэлт 3.64 болж өмнөх оны үзүүлэлтүүдээс тус бүр 0.08 болон 0.06 пунктээр өссөн байгаа нь улс төрийн авлигын ерөнхий түвшин нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Эдгээр өөрчлөлт нь улс төрийн авлигад нөлөөлж байгаа нөхцөл байдал эерэг тал руугаа бага зэрэг өөрчлөгдсөн боловч улс төрийн авлигын цар хүрээ улам бүр тэлж, хэлбэр нь нэмэгдэж, учруулж байгаа хор аюулын хэмжээ нь ихэссэнийг илэрхийлж байна.

Зураг 2. Шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ



ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 1. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ЦАР ХҮРЭЭ

Улс төрийн авлигын цар хүрээний үзүүлэлт 2015 онд 3.63 болж өмнөх үеийнхээс 0.25 пунктээр нэмэгдсэн байна.

Улс төрийн авлигын цар хүрээг нийтдээ 5 дэд үзүүлэлтээр тодорхойлов. Үүнд:

- тухайн онд улс төр, хууль сахиулах байгууллагын хүрээнд улс төрийн авлига хэр түгээмэл байсан;
- улс төрийн авлигын түвшин өмнөх оны түвшингээс хэр хэмжээгээр өөрчлөгдсөн;
- төрийн тодорхой институцид улс төрийн авлига тархсан байдал;
- төрийн үйл ажиллагааны тодорхой чиглэлүүдэд улс төрийн авлига тархсан байдал;
- нийгэм, эдийн засаг, төрийн тодорхой салбар, хүрээнд улс төрийн авлига нөлөөлж байгаа байдал зэрэг болно.

2015 онд улс төрийн авлигын цар хүрээний эдгээр 5 дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ өмнөх оныхоос бүгд өссөн дүнтэй гарсан нь авлигын цар хүрээний үзүүлэлт нэмэгдэх, улмаар улс төрийн авлигын түвшин сөрөг тал руугаа өөрчлөгдөхөд нөлөөлсөн байна.

Зураг 3. Улс төрийн авлигын цар хүрээний үнэлгээ



Дэд үзүүлэлт 1. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТҮГЭЭМЭЛ БАЙДАЛ

Улс төрийн авлигын түгээмэл байдлын үнэлгээ 4.02 гарч өмнөх оныхоос 0.19 пунктээр нэмэгдсэн байна.

Уг асуудлаар үнэлгээ хийсэн шинжээчдийн 50.8 хувь нь 2015 онд Монгол Улсад улс төрийн авлига их тархсан гэж үзсэн бол 30.5 хувь нь маш их тархсан байсан гэж үзжээ. Шинжээчдийн 10.2 хувь нь улс төрийн авлига бага тархсан гэж үзсэн бол 8.5 хувь дунд зэрэг тархсан байсан гэж үзсэн байна.

Зураг 4. Улс төрийн түгээмэл байдал



Дэд үзүүлэлт 2. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТҮВШНИЙ ӨӨРЧЛӨЛТ

2015 оны улс төрийн авлигын түвшний өөрчлөлтийн үнэлгээ 3.26 болж өмнөх оны үзүүлэлтээс 0.19 пунктээр нэмэгджээ.

Улс төрийн авлигын түвшний өөрчлөлтийг үнэлсэн шинжээчдийн 40.4 хувь нь 2015 онд улс төрийн авлигын түвшин нэмэгдсэн гэж үзсэн нь хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бол 29.8 хувь нь өөрчлөгдөөгүй гэж үзжээ. Уг асуудлаар үнэлгээ хийсэн шинжээчдийн 17.5 хувь нь улс төрийн авлигын түвшин багассан гэж дүгнэсэн байна. Мөн шинжээчдийн 7 хувь нь 2015 онд улс төрийн авлигын түвшин маш их нэмэгдсэн гэж хариулсан бол 5.3 хувь нь үүний эсрэгээр буюу маш их буурсан гэж хариулжээ.

Зураг 5. Улс төрийн авлигын түвшний өөрчлөлт



Дэд үзүүлэлт 3. ТӨРИЙН ИНСТИТУЦ ДЭХ УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТАРХАЛТЫН ЦАР ХҮРЭЭ

Улс төрийн намууд, Улсын Их Хурал, Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага буюу аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, шүүх, прокурор, цагдаагийн байгууллага зэрэг тодорхой 16 институц дэх улс төрийн авлига тархсан байдлын дундаж үнэлгээ өмнөх оныхоос 0.30 пунктээр нэмэгдэж 3.52 болсон нь цар хүрээний үзүүлэлт дотор хамгийн их хэмжээгээр нэмэгдсэн үзүүлэлт болж байна.

Институц тус бүрд улс төрийн авлига тархсан байдлын үнэлгээг авч үзвэл Засгийн газар 3.96, улс төрийн намууд 3.91, Улсын Их хурал 3.80 гэсэн үнэлгээтэй байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байгаа бол Тахарын алба 2.82, Хил хамгаалах байгууллага 3.06, тагнуулын байгууллага 3.21 үнэлгээтэй гарсан нь хамгийн бага үзүүлэлтүүд болж байна.

Институц тус бүрийн үнэлгээний өмнөх оны үнэлгээнээс хэрхэн өөрчлөгдснийг авч үзвэл нутгийн өөрөө удирдах байгууллага буюу аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үнэлгээ 0.27 пунктээр, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үнэлгээ 0.24 пунктээр буурсан нь эерэг үзүүлэлт болсон боловч бусад 14 субъектийн үзүүлэлт 0.16 пунктээс 0.75 пунктээр нэмэгдсэн байна. Тухайлбал, ерөнхийлөгчийн засаглалын хүрээний үзүүлэлт 0.75 пунктээр, тахарын албаны үзүүлэлт 0.69 пунктээр, хил хамгаалах байгууллагын үзүүлэлт 0.61 пунктээр, прокурорын байгууллагын үзүүлэлт 0.57 пунктээр, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үзүүлэлт 0.53 пунктээр тус тус нэмэгдсэн нь хамгийн их өссөн үзүүлэлт болж байна.

Зураг 6. Төрийн институц дэх улс төрийн авлигын тархалтын цар хүрээ



Дэд үзүүлэлт 4. ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТАРХАЛТЫН ЦАР ХҮРЭЭ

Төрийн үйл ажиллагааны тодорхой чиглэлүүд дэх улс төрийн авлигын тархалтын дундаж үнэлгээ өмнөх оныхоос 0.28 пунктээр нэмэгдэж 3.64 болсон ба ийнхүү нэмэгдэхэд эдгээр 16 төрлийн үйл ажиллагааны нэгээс бусад үйл ажиллагаан дахь авлигын тархалтын 2015 оны үзүүлэлт нь өмнөх оны үзүүлэлтээс 0.02- оос 0.62 пунктээр тус бүр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Тухайлбал, гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаан дахь улс төрийн авлигын тархалтын үнэлгээ 0.62 пунктээр, хил хамгаалах үйл ажиллагаан дахь улс төрийн авлигын тархалтын үнэлгээ 0.59 пунктээр, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх үйл ажиллагаан дахь улс төрийн авлигын тархалтын үнэлгээ 0.56 пунктээр, прокурорын хяналтын үйл ажиллагаан дахь улс төрийн авлигын тархалтын үнэлгээ 0.45 пунктээр нэмэгдсэн нь хамгийн их өссөн үзүүлэлт болжээ.

Эдгээр 16 төрлийн үйл ажиллагаанаас худалдан авах ажиллагаа, тендерийн үйл

ажиллагаан дахь улс төрийн авлигын тархалтын үзүүлэлт 4.30 гарсан нь хамгийн өндөр үзүүлэлт болсон бөгөөд өмнөх оны үзүүлэлтээс 0.04 пунктээр өссөн байна. Төрийн байгууллага дахь албан тушаалын томилгоон дахь улс төрийн авлигын тархалтын үзүүлэлт 4.14 гарч өмнөх оны үзүүлэлтээс 0.14 пунктээр нэмэгдсэн байна. Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах үйл ажиллагаан дахь улс төрийн авлигын тархалтын үнэлгээ 4.02 болсон ба өмнөх оны үзүүлэлтээс 0.06 пунктээр нэмэгджээ.

Зураг 7. Улс төрийн авлигын тархалтын цар хүрээ

Дэд үзүүлэлт 5. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН НӨЛӨӨЛӨЛ

Тодорхой салбар, хүрээний үйл ажиллагаанд улс төрийн авлига нөлөөлж байгаа байдлын үнэлгээний үзүүлэлт 3.74 гарсан нь өмнөх оны үзүүлэлтээс 0.17 пунктээр нэмэгдсэн байна.

Уул уурхай, ашигт малтмалын салбар дахь улс төрийн авлигын үнэлгээ 4.23, барилгын салбар дахь улс төрийн авлигын үнэлгээ 3.93, төрийн албан дахь улс төрийн авлигын үнэлгээ 3.92, дэд бүтцийн салбар дахь улс төрийн авлигын үнэлгээ 3.91, гадаадын хөрөнгө оруулалт дахь улс төрийн авлигын үнэлгээ 3.82 гарсан нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

Дэд бүтцийн салбар, барилгын салбар, хэвлэл мэдээллийн салбар, бизнес, хувийн хэвшил дэх улс төрийн авлигын үзүүлэлт өмнөх оны түвшингээс 0.06 - 0.13 пунктээр буурсан бол судалгаанд хамруулсан бусад 7 салбар, үйл ажиллагаан дахь улс төрийн авлигын үзүүлэлт өсчээ. Тухайлбал, гадаадын хөрөнгө оруулалт дахь улс төрийн авлигын түвшин өмнөх оны үзүүлэлтээс хамгийн их хэмжээгээр буюу 0.53 пунктээр нэмэгдсэн бол хууль тогтоох, шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь улс төрийн авлигын түвшин хамгийн бага хэмжээгээр буюу 0.05 пунктээр нэмэгджээ. Бусад 5 салбар, үйл ажиллагаан дахь улс төрийн авлигын хэмжээ 0.27 - 0.39 пунктээр нэмэгдсэн байна.

Асуулгад хамруулсан 4 салбар, үйл ажиллагаан дахь улс төрийн авлигын түвшин дунджаар 0.09 пунктээр буурч, 7 салбар, үйл ажиллагаан дахь улс төрийн авлигын түвшин дунджаар 0.31 пунктээр нэмэгдсэн нь улстөрийн авлигын нөлөөллийн дэд үзүүлэлтийн түвшин нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Зураг 8. Улс төрийн авлигын нөлөөллийн үнэлгээ



ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 2. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХЭЛБЭР

Улс төрийн авлигын нөхцөл байдлыг үнэлж дүгнэх нэг шалгуур үзүүлэлт нь улс төрийн авлигын хэлбэрийн талаарх үнэлгээ бөгөөд 2015 онд энэ үзүүлэлт 3.58 гарч өмнөх оны түвшингээс 0.08 пунктээр нэмэгдсэн байна.

Хэдийгээр бага хэмжээгээр боловч сөрөг тал руу өөрчлөгдсөн нь улс төрийн авлигын хэлбэрийг үнэлэх үнэлгээний 5 дэд үзүүлэлтийн гурван дэд үзүүлэлтийн үнэлгээ сөрөг тал руугаа нэмэгдсэн нь нөлөөлжээ. Зөвхөн нэг дэд үзүүлэлтийн үнэлгээ өмнөх оныхоос буурч, үлдсэн нэг үзүүлэлтийн үнэлгээ өмнөх оны түвшингээс өөрчлөгдөөгүй байна.

Улс төрийн авлигын хэлбэрийн үзүүлэлтийг дараах дэд үзүүлэлтүүдээр үнэлдэг. Үүнд:

- Хээл хахуулийн хэлбэрийн үнэлгээ;
- Улс төрийн авлига дахь хууль бус нөлөөллийн хэлбэрийн үнэлгээ;
- Улс төрийн нам, бүлэглэл болон бизнесийн, ашиг сонирхлын бүлэглэлүүдийн хоорондын харилцан хамаарлын үнэлгээ;
- Улс төрийн авлигын хэлбэрийн үнэлгээ;
- Хээл хахууль дамжуулах арга замын үнэлгээ зэрэг болно.

Зураг 9. Улс төрийн авлигын хэлбэрийн үнэлгээ



Дэд үзүүлэлт 1. ХЭЭЛ ХАХУУЛИЙН ХЭЛБЭР

Улс төрийн авлигын хүрээнд хээл хахуулийн олон хэлбэр хэрэглэгддэгээс хамгийн түгээмэл гэж үзсэн 13 хэлбэрийг сонгон асуулгад багтаасан бөгөөд эдгээрийн дундаж үзүүлэлт нь 2015 онд 3.55 гарсан нь өмнөх оны түвшингээс 0.10 пунктээр нэмэгдсэн байна.

Авлига, хээл хахууль авагчийн ашиг сонирхолд нийцүүлэн өөрийг нь, эсхүл ашиг сонирхол нэгтэй этгээдийг нь ажил, албан тушаалд томилох, оруулах хэлбэрээр хээл хахууль өгөх хэлбэрийн үнэлгээ 4.04 гарсан нь хамгийн өндөр үзүүлэлт болж байгаа бөгөөд авлигын энэ хэлбэр түгээмэл харуулж байна. Энэ хэлбэрийн үзүүлэлт өмнөх онд 4.02 байснаас үзвэл энэхүү нөхцөл байдал төдийлөн өөрчлөгдөөгүй байна.

Хээл хахууль авагчид бэлэн мөнгө өгөх, олсон ашиг, орлогоосоо хувь, шан хүртээх, аялал жуулчлалын зардлыг нь төлөх, гадаад арга хэмжээнд оролцох зардлыг нь төлөх, үнэ цэнэтэй эд зүйлээр бэлэг өгөх зэрэг хэлбэрүүд түгээмэл байгааг эдгээр хэлбэрүүдийн үнэлгээ 3.73 – 3.82 гарснаас харагдаж байна.

Эмчилгээ, сувилгааны зардлаа төлүүлэх, сургалтын зардлаа төлүүлэх, ажил, үйлчилгээний төлбөрийн хөнгөлөлт эдлэх, шагнал, цол, тэмдгээр шагнуулах хэлбэрээр хээл хахууль авах явдал мөн түгээмэл байгаа нь 3.36 – 3.54 гэсэн үнэлгээнээс харагдаж байна. Өр, зээлээ төлүүлэх замаар хээл хахууль авах хэлбэрийн үнэлгээ 3.06, өөрийн нэр дээр хувьцаа авах болон гадаадын банк, санхүүгийн байгууллагын нэр дээр данс нээлгэх замаар хээл хахууль авах хэлбэрүүдийн үнэлгээ тус бүр 2.88 болон 2.89 байгаа нь дундаж хэмжээнд байгааг илэрхийлж байна.

Өмнөх оны түвшингээс өөрчлөгдсөн байдлыг авч үзвэл нийт 13 хэлбэрийн үзүүлэлтээс 3 хэлбэрийн үзүүлэлт буурч, 10 хэлбэрийн үзүүлэлт өссөн нь нийт дүн сөрөг тал руу өөрчлөгдөхөд хүргэсэн байна. Ашиг, орлогоо хуваалцах хэлбэрийн үнэлгээ 0.15 пунктээр буурсан бол гадаадын банкинд данс нээх болон өр, зээлийг нь төлөх хэлбэрийн үнэлгээ тус тус 0.28 болон 0.26 пунктээр буурсан байна. Үнэ цэнэтэй бэлэг өгөх хэлбэрийн үнэлгээ 0.51 пунктээр нэмэгдсэн нь сөрөг талруугаа хэлбийсэн хамгийн их өөрчлөлт болжээ.

Зураг 10. Хээл хахуулийн хэлбэрийн үнэлгээ

Дэд үзүүлэлт 2. ХУУЛЬ БУС НӨЛӨӨЛЛИЙН ХЭЛБЭР

Улс төрчид, төрийн өндөр албан тушаалтнууд хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхийн тулд төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллийн хэлбэрүүдийн дундаж үнэлгээ нь 3.62 гарсан бөгөөд өмнөх оны үзүүлэлтээс 0.09 пунктээр буурсан байна.

Энэ үзүүлэлт нь нийт 9 дэд үзүүлэлттэй бөгөөд эдгээрээс 3 дэд үзүүлэлтийн түвшин дунджаар 0.05 пунктээр нэмэгдсэн боловч үлдэх 6 үзүүлэлтийн түвшин дунджаар 0.16 пунктээр буурсан нь дундаж үзүүлэлт эерэг тал руугаа өөрчлөгдөхөд нөлөөлсөн байна. Нутаг орны хэлхээ холбоог ашиглан нөлөөлөх хэлбэрийн үзүүлэлт 0.45 пунктээр буурсан нь хамгийн их хэмжээний өөрчлөлт болжээ.

2015 онд улс төрчид, төрийн албан тушаалтнуудаас намын хэлхээ холбоог ашиглан нөлөөлөх хэлбэрийн үнэлгээ 4.07 байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болсон бол албадах, амлалт өгөх хэлбэрүүдийн үнэлгээ 3.10 болон 3.16 байгаа нь хамгийн бага үзүүлэлт юм. Бусад хэлбэрүүд, үүнд дарамт шахалт үзүүлэх, садан төрлийн хэлхээ холбоог ашиглах, найз нөхөд, танил талын хэлхээ холбоог ашиглах, нутаг орны хэлхээ холбоог ашиглах, амлалт өгөх, хүсэлт тавих зэрэг хэлбэрээр нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ 3.55 – 3.87 байна.

Зураг 11. Хууль бус нөлөөллийн хэлбэрийн үнэлгээ



Дэд үзүүлэлт 3. УЛС ТӨРИЙН НАМ, БҮЛЭГЛЭЛ, УЛС ТӨР, БИЗНЕС, ГЭМТ ХЭРГИЙН БҮЛЭГЛЭЛҮҮДИЙН ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Төрийн өндөр албан тушаалтнууд, улс төрчид болон улс төрийн нам, бүлэглэл болон гадаад, дотоодын бизнесийн бүлэглэл, гэмт бүлэглэлийн харилцан хамаарлын үнэлгээ нь 3.40 гарсан бөгөөд өмнөх оны түвшингээс 0.09 пунктээр нэмэгджээ.

Нийт 11 нөхцөл байдлын үзүүлэлтээс 4 үзүүлэлтийн үнэлгээ 0.04 – 0.19 пунктээр буюу дунджаар 0.11 пунктээр буурсан хэдий боловч бусад 7 үзүүлэлтийн үнэлгээ 0.08 – 0.39 пунктээр буюу дунджаар 0.25 пунктээр нэмэгдсэн нь энэхүү дэд үзүүлэлтийн үнэлгээ сөрөг тал руугаа өөрчлөгдөхөд нөлөөлсөн байна.

Улс төрийн авлига илүү далд хэлбэрт шилжсэн, улс төр, бизнесийн бүлэглэл нэгдсэн, улс төрчид шүүгч, хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудтай хууль бус ашиг сонирхлоор нэгдсэн, бизнесийн бүлэглэл улс төрчдийг эрхшээлдээ оруулсан зэрэг нөхцөл байдлуудын үнэлгээ 3.87 – 4.00 гарсан байгаа нь бусад үзүүлэлтүүдээс харьцангуй өндөр түвшинд байна. Түүнчлэн эдгээр нөхцөл байдлын үнэлгээ өмнөх онд мөн л харьцангуй өндөр түвшинд байснаас үзэхэд эдгээр нөхцөл байдал улс төрийн авлигын хүрээнд бугшмал байдалд, тогтвортой оршиж байна гэж дүгнэж болохоор байна.

Улс төрчид, улс төрийн нам, бүлэглэл бизнесийн болон гэмт бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан, гаднын улс төрийн болон бизнесийн бүлэглэл монголын улс төрийн нам, бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан, эсхүл хоорондоо нэгдсэн зэрэг нөхцөл байдлын үнэлгээ 2.90- 3.39 гарсан нь дундаж хэмжээнд тооцогдохоор байгаа боловч эдгээр нөхцөл байдлын үнэлгээ нь өмнөх оныхоос 0.08 – 0.39 пунктээр буюу дунджаар 0.26 пунктээр нэмэгдсэн нь анхаарал татахаар байна.

Гэмт бүлэглэл улс төрийн нам, бүлэглэлийг эрхшээлдээ оруулсан байдлын үнэлгээ хамгийн бага буюу 2.61 үнэлгээтэй гарсан нь өмнөх оны түвшингээс 0.14 пунктээр буурсантай холбоотой юм.

Зураг 12. Улс төр, бизнес, гэмт бүлэглэлийн харилцан хамаарал



Дэд үзүүлэлт 4. УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХЭЛБЭР

Улс төрийн хүрээн дэх улс төрийн авлигын хэлбэрийн үнэлгээ 3.82 гарч өмнөх оны үнэлгээнээс 0.22 пунктээр нэмэгджээ. Нийт 15 дэд үзүүлэлтийн 13 дэд үзүүлэлтийн үнэлгээ 0.07 – 0.50 пунктээр буюу дунджаар 0.27 пунктээр нэмэгдсэн нь энэ үзүүлэлтийн үнэлгээ сөрөг тал руугаа өөрчлөгдөхөд нөлөөлсөн байна. Ялангуяа, сонгогчдын саналыг худалдан авах, аж ахуйн нэгжийг хууль бусаар дампууруулах, төрийн өмчийг хууль бусаар хувьчлах зэрэг нөхцөл байдлын үнэлгээ харьцангуй ихээр нэмэгджээ.

Улс төрийн хүрээнд албан тушаал, эрх мэдлээ хэтрүүлэх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хувийн ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулах явдал харьцангуй их байгаа боловч бусад нөхцөл байдлын үнэлгээ эдгээрээс хол зөрүүгүй байна.

Зураг 13. Улс төрийн авлигын хэлбэрийн үнэлгээ



Дэд үзүүлэлт 5. УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ ХЭЭЛ ХАХУУЛЬ ӨГӨХ, АВАХ АРГА

Асуулгад тусгасан улс төрийн хүрээнд хээл хахууль өгөх, авах зарим нэг түгээмэл аргуудын дундаж үнэлгээ нь 3.38 гарсан бөгөөд өмнөх оны дундаж үнэлгээнээс өөрчлөгдөөгүй байна. Энэ нь нийт 11 дэд үзүүлэлтийн 6 дэд үзүүлэлтийн үнэлгээ 0.02 – 0.24 пунктээр буюу дунджаар 0.14 пунктээр буурч, 5 дэд үзүүлэлтийн үнэлгээ 0.04 – 0.19 пунктээр буюу дунджаар 0.13 пунктээр нэмэгдсэнтэй холбоотой юм.

Хээл хахууль авагчийн ойр дотны хүмүүс, гэр бүлийн гишүүд, тэдний өмчлөлийн компани, аж ахуйн нэгжид хууль бус давуу байдал олгох хэлбэрээр авлига өгөхтэй холбоотой дэд үзүүлэлтийн үнэлгээ 3.83 байгаа нь хамгийн сөрөг үнэлгээ болсон бол өмгөөлөгчөөр дамжуулан хээл хахууль өгөхтэй холбоотой дэд үзүүлэлт хамгийн бага буюу 2.88 гарсан бөгөөд бусад 9 дэд үзүүлэлт нь 2.88 –аас 3.83-ын хооронд дунджаар 0.095 пунктын зөрүүтэйгээр эрэмблэгдсэн байна.

Зураг 14. Улс төрийн хүрээн дэх хээл хахуулийн аргуудын үнэлгээ



ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 3. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ШАЛТГААН НӨХЦӨЛ

Улс төрийн авлигын шалтгаан нөхцөлийн үнэлгээ 3.80 гарснаар энэхүү шалгуур үзүүлэлтийн үнэлгээ өмнөх оны үнэлгээнээс 0.14 пунктээр буурсан байна.

Улс төрийн авлигын шалтгаан нөхцөлийн үнэлгээг улс төрийн авлигад нөлөөлсөн хүчин зүйлс, улс төрийн авлигын түвшинд нөлөөлсөн дутагдал доголдол, улс төр дэх бүлэглэлүүдийн нөхцөл байдал гэсэн гурван үзүүлэлтээр үнэлсэн ба эдгээр үзүүлэлтүүдийн үнэлгээ нь өмнөх оны үнэлгээнээс 0.07 – 0.19 пунктээр буурсан нь дундаж үнэлгээ буурахад нөлөөлжээ.

Зураг 15. Улс төрийн авлигын шалтгаан нөхцлийн үзүүлэлтүүдийн үнэлгээ



Дэд үзүүлэлт 1. УЛС ТӨРИЙН АВЛИГАД НӨЛӨӨЛСӨН ХҮЧИН ЗҮЙЛС

Улс төрийн авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үнэлгээ 3.86 гарч өмнөх оны үнэлгээнээс 0.07 пунктээр буурчээ.

Нийт 11 дэд үзүүлэлтээс хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчлийн түвшинг илтгэх дэд үзүүлэлтийн үнэлгээ 0.12 пунктээр, хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явцын түвшинг илтгэх дэд үзүүлэлтийн үзүүлэлтийн үнэлгээ 0.19 пунктээр нэмэгдсэн хэдий ч бусад 9 дэд үзүүлэлтийн үнэлгээ 0.01 – 0.34 пунктээр буюу дунджаар 0.16 пунктээр буурсан нь энэхүү үзүүлэлтийн дундаж үнэлгээ буурахад нөлөөлсөн байна.

Улс төрийн нам болон төрийн албаны албан тушаалын томилгоо болон улс төрийн намын санхүүжилтийн тогтолцоо нь улс төрийн авлигад нөлөөлж байгаа хамгийн хүчтэй хүчин зүйлүүд болох нь эдгээр дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ харуулж байна. Гэвч бусад хүчин зүйлүүдийн үнэлгээ эдгээрээс хол зөрүүгүй байгаа бөгөөд хамгийн бага үнэлгээ нь хамгийн өндөр үнэлгээнээс 1 пунктээс бага буюу 0.83 байгаа нь энэхүү үзүүлэлтийн 11 дэд үзүүлэлт бүгд улс төрийн авлигад нөлөө ихтэй байгааг харуулж байна.

Зураг 16. Улс төрийн авлигад нөлөөлсөн хүчин зүйлсийн үнэлгээ



Дэд үзүүлэлт 2. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ТҮВШИНД НӨЛӨӨЛЖ БУЙ ТӨРИЙН АЛБАН ДАХЬ ДУТАГДАЛ, ДОГОЛДОЛ

Төрийн үйл ажиллагаанд оршиж байгаа дутагдал, доголдол нь улс төрийн авлигад тодорхой нөлөө үзүүлж байгаа бөгөөд энэ байдлыг тодорхойлох үзүүлэлтийн дундаж үнэлгээ нь 3.82 гарсан нь өмнөх оны үзүүлэлтээс 0.17 пунктээр бага байна.

Энэ оны үзүүлэлт буурахад тухайн үзүүлэлтэд хамаарах 12 дэд үзүүлэлтийн 9 дэд үзүүлэлтийн үнэлгээ нь 0.08 – 0.40 пунктээр буюу дунджаар 0.27 пунктээр буурсан нь нөлөөлсөн байна. Зөвхөн төрийн үйл ажиллагаан дахь хүнд суртал, төрийн үйлчилгээний хүртээмжгүй байдал болон төрийн үйл ажиллагааны мэдээлэл нээлттэй, ил тод бус байдал гэсэн 3 дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ өссөн байна.

Өмнөх оны түвшингээс өсөлт, бууралттай байгаа хэдий ч нийт 12 дэд үзүүлэлтийн үнэлгээ 3.62 – 4.02 байгаа нь эдгээр нөхцөл байдал бүгд улс төрийн авлигад их хэмжээгээр нөлөөлж байгааг харуулж байна.

Зураг 17.Төрийн үйл ажиллагаан дахь дутагдал, доголдол улс төрийн авлигад нөлөөлж буй байдлын үнэлгээ



Дэд үзүүлэлт 3. УЛС ТӨРИЙН ХҮРЭЭН ДЭХ ХҮРЭЭЛЛҮҮДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Улс төрийн хүрээн дэх тодорхой эрх ашиг, сонирхолд хөтлөгдсөн хүрээллийн нөхцөл байдлын дундаж үнэлгээ нь 3.69 гарсан бөгөөд өмнөх оны үзүүлэлтээс 0.19 пунктээр буурсан байна. Энэ нь нийт 7 үзүүлэлтийн 5 үзүүлэлтийн үнэлгээ 0.06 – 0.80 пунктээр буурсантай холбоотой юм.

Хувийн эрх ашгийг илүүд үзсэн бөгөөд намын эрх ашиг, сонирхол дээр төвлөрсөн хүрээллийн үнэлгээ төдийлөн өөрчлөгдөөгүй бол хувийн эрх ашгийг илүүд үзсэн бөгөөд нэг хүний ашиг сонирхол дээр төвлөрсөн хүрээллийн үнэлгээ 0.18 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 18. Улс төрийн хүрээн дэх хүрээллүүдийн нөхцөл байдал

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ 4. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХОР УРШИГ, ҮР ДАГАВАР

Улс төрийн авлигын шалгуур үзүүлэлтүүдийн нэг болох хор уршиг, үр дагаварын үнэлгээ өмнөх оны түвшингээс 0.06 пунктээр нэмэгдэж 3.64 болсон байна. Энэхүү шалгуур үзүүлэлтийг улс төрийн авлигын хор уршгийн үзүүлэлт болон улс төрийн авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын үзүүлэлт гэсэн хоёр үзүүлэлтээр дүгнэж үздэг.

Зураг 19. Улс төрийн авлигын хор уршиг, үр дагаварын үнэлгээ



Дэд үзүүлэлт 1. УЛС ТӨРИЙН АВЛИГЫН ХОР УРШИГ

Улс төрийн авлигын хор уршгийн үзүүлэлтийн үнэлгээ 3.90 болж нэмэгджээ.

Тухайн үзүүлэлтэд хамаарах 16 дэд үзүүлэлтээс дөрвөн дэд үзүүлэлтийн үнэлгээ 0.04 – 0.55 пунктээр буюу дунджаар 0.22 пунктээр буурсан, 12 дэд үзүүлэлтийн үнэлгээ 0.02 – 0.50 пунктээр буюу дунджаар 0.28 пунктээр өссөн нь энэ үзүүлэлтийн үнэлгээ нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Улс төрийн авлига болон инфляцийн хамаарлын дэд үзүүлэлтийн үнэлгээ

0.55 пунктээр буурсан, улс төрийн авлига болон Монгол улсын олон улсын хэмжээн дэх нэр хүнд, дотоодын ядуурал, ажилгүйдлийн хамаарлыг илтгэх дэд үзүүлэлтүүдийн үнэлгээ 0.34 – 0.50 пунктээр нэмэгдсэн зэрэг өөрчлөлтүүд гарсан боловч нийт 16 дэд үзүүлэлтийн үнэлгээ бүхэлдээ 3.43 – 4.14 байгаа нь улс төрийн авлигын улмаас бий болж байгаа сөрөг үр дагаврыг түвшин жигд өндөр байгааг харуулж байна.

Зураг 20. Улс төрийн авлигын хор уршгийн үнэлгээ, 2014, 2015 онд



Дэд үзүүлэлт 2. УЛС ТӨРИЙН АВЛИГААР ОЛСОН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Улс төрийн авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын үнэлгээ 3.35 гарсан нь өмнөх оны түвшингээс өөрчлөгдөөгүй байна. Уг үзүүлэлтэд хамаарах 19 дэд үзүүлэлтийн 9 дэд үзүүлэлтийн үнэлгээ 0.07 – 0.29 пунктээр буюу дунджаар 0.17 пунктээр буурсан бол 10 дэд үзүүлэлтийн үнэлгээ 0.01 – 0.46 пунктээр буюу дунджаар 0.17 пунктээр нэмэгдсэн байна.

Авлигаар олсон хөрөнгөө гадаадын оффшор банк, санхүүгийн байгууллага болон гадаадын банкинд хадгалах, гадаадад орон сууц, үл хөдлөх хөрөнгө худалдаж авах, дотоодод орон сууц, барилга байгууламж бариулах замаар зарцуулах үзүүлэлтийн түвшин харьцангуй өндөр байгаа бол авлигаар олсон хөрөнгөнөөсөө хандив, тусламж өгөх болон ийм хөрөнгөө дотоодын банкинд хадгалах үзүүлэлтийн түвшин хамгийн доогуур байна.

Зураг 21. Улс төрийн авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын үнэлгээ, 2015 онд



2. ШИНЖЭЭЧДИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Шинжээчдийн дундаж нас- 40, үүнээс 25 – 30 настай 13.6 хувь, 31 – 35 настай 13.6 хувь, 36 – 40 настай 34.8 хувь, 41 – 45 настай 16.7 хувь, 46 – 50 настай 12.1 хувь, 51 – 55 настай 7.6 хувь, 56 – аас дээш настай 1.5 хувь байна.

Зураг 22.Шинжээчдийн нас, хүйсний байдал



Төрийн байгууллагад ажиллагсад 34.8 хувь, хувийн хэвшилд 24.2 хувь, судлаач 21.2 хувь, төрийн бус байгууллагад ажиллагсад 10.6 хувь, олон улсын байгууллагад ажиллагч 9.1 хувь.

Зураг 23. Шинжээчдийн ажиллаж буй салбар



ДҮГНЭЛТ

Монгол Улс дахь улс төрийн авлигын түвшин 2011 – 2014 онд жил дараалан буурч ирсэн боловч 2015 онд энэхүү хандлага өөрчлөгдөж эргээд өссөн дүнтэй гарлаа.

Хэдийгээр улс төрийн авлигад нөлөөлж буй шалтгаан, нөхцөл өөрчлөгдөөгүй боловч улс төрийн авлигын илрэн гарч буй хэлбэр, түүнчлэн нөлөөллийн цар хүрээ нэмэгдэж, учруулж буй хор уршиг, сөрөг үр дагавар ихэссэн байна.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагаа, Улсын Их Хуралд суудалтай улс төрийн намуудын үйл ажиллагаа, түүнчлэн Улсын Их Хурлын хууль тогтоох болон бусад үйл ажиллагаан дахь улс төрийн авлигын түвшин төрийн бусад институт дэх түвшингээс харьцангуй өндөр байгаа нь төрөөс улс орны амьдралын амин чухал асуудлуудыг хэлэлцэх, шийдвэрлэх, хэрэгжүүлэх бүхий л үе шатанд улс төрийн авлигын нөлөөлөл их байна гэж дүгнэж болохоор байна.

Эрх мэдэл, албан тушаалын хуваарилалт болон төсвийн хөрөнгийн зарцуулалтад улс төрийн авлига харьцангуй өндөр түвшинд тархсан, албан тушаалтан албаны эрх мэдлээ хэтрүүлэх, урвуулан ашиглах, нийтийн ашиг сонирхолд бус хувийн ашиг сонирхолд үндэслэн шийдвэр гаргах байдал дээгүүр түвшинд байна. Энэ нь төрийн албан тушаалтнуудын төсвийн хөрөнгө, нөөцийг захиран зарцуулах эрх мэдлээ хэрэгжүүлж байгаа сэдэл, зорилго, үйл ажиллагаа нь улс төрийн авлига гэх энэхүү “нийгмийн хорт хавдар”-ыг тэжээх хөрс болж байгааг илэрхийлж байна.

Улс төрийн авлигын нөлөөгөөр бий болсон тогтолцооны улмаас нийтийн тус тулд зарцуулагдах ёстой мөнгөн хөрөнгө, нөөц улс төр, бизнесийн бүлэглэлийн мэдэлд хуримтлагдаж байгаа болон улс төрийн авлига нь төрийн албаны үйл ажиллагаанаас гадна уул уурхай, барилга, дэд бүтцийн салбарт нөлөөлж байгаагаас улс орны эдийн засгийн хүчин чадал суларч, өмч хөрөнгийн тэгш бус байдал өсч байна.

Улс төрийн авлига нь төрийн албаны үйл ажиллагаа, улс орны эдийн засгийн хүчин чадлыг сулруулаад зогсохгүй улмаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөнд нөлөөлж ноцтой хор уршиг бүхий үр дагаварт хүргэж болзошгүй байна.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР